



ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬ  
СОЛОНГОС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

С.ТУЯА  
И ДАЕ ХАК

# БНСУ-ЫН АРДЧИЛЛЫН ЗАМНАЛ БА СУРГАМЖ

УЛААНБААТАР ХОТ  
2025 ОН



Олон улсын Улаанбаатарын их сургууль  
СОЛОНГОС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

С.ТУЯА  
И ДАЕ ХАК

## БНСУ-ЫН АРДЧИЛЛЫН ЗАМНАЛ БА СУРГАМЖ

УЛААНБААТАР ХОТ  
2025 он

이 논문은 2022 년 대한민국 교육부와 한국학중앙연구원 (한국학진흥사업단) 의 해외한국  
학종책대학육성사업의 지원을 받아 수행된 연구임

(AKS-2022-OLU-2250006)

This work was supported by the Core University Program for Korean Studies of Ministry of  
Education of Republic of Korea and the Korean Studies Promotion Service at the Academy of  
Korean Studies.

(AKS-2022-OLU-2250006)

*Судалгааны ажлыг гүйцэтгэсэн:*

**С.Туяа (Ph.D), дэд профессор**

ШУТИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн сургууль

Сургалт, чанарын албаны дарга

s.tuya@must.edu.mn +976 99181432

**И Дае Хак (Ph.D)**

БНСУ-ын Хангүг Гадаад Судлалын Их Сургууль

Тусгай лекцийн профессор

Daehaklee12@gmail.com +82 1093770191

**ISBN 978-9919-0-5719-0**

ННА 60 ДАА 300 Т-727

## ГАРЧИГ

|                                                                            |    |
|----------------------------------------------------------------------------|----|
| ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ                                                        | 4  |
| ЗУРГИЙН ЖАГСААЛТ                                                           | 4  |
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ                                                   | 5  |
| <br>                                                                       |    |
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ БА ТОЙМ                               | 6  |
| 1.1 Судалгааны үндэслэл                                                    | 6  |
| 1.2 Судалгааны зорилго                                                     | 7  |
| 1.3 Судалгааны арга зүй                                                    | 7  |
| 1.4 Судлагдсан байдал                                                      | 8  |
| 1.5 Судалгааны хязгаарлагдмал тал                                          | 11 |
| <br>                                                                       |    |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ. АРДЧИЛЛЫН ТАЛААРХ ОНОЛЫН СУДАЛГАА                        | 12 |
| 2.1 Ардчилсан үзэл баримтлалын талаарх ойлголт                             | 13 |
| 2.2 Ардчилагдах үйл явцын талаарх ойлголт                                  | 19 |
| 2.3 Ардчилсан хөдөлгөөний талаарх ойлголт                                  | 27 |
| Бүлгийн дүгнэлт                                                            | 30 |
| <br>                                                                       |    |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ. БНСУ-ЫН АРДЧИЛЛЫН ТУХАЙ СУДАЛГАА                        | 32 |
| 3.1 БНСУ-ын ардчиллын түүх                                                 | 32 |
| 3.2 БНСУ-ын ардчиллын шилжилт бат тогтсон нь                               | 40 |
| 3.3 БНСУ-ын ардчилалд хувь нэмэр оруулсан хөдөлгөөн бусад хүчнүүд          | 48 |
| 3.4 БНСУ-ын ардчиллын дүгнэлт, даалгавар ба ирээдүй                        | 58 |
| Бүлгийн дүгнэлт                                                            | 64 |
| <br>                                                                       |    |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛЫН АРДЧИЛЛЫН ТУХАЙ СУДАЛГАА                       | 65 |
| 4.1 Монголд ардчилал эхэлсэн түүх ба шилжих үйл явц                        | 65 |
| 4.2 Монгол улсад ардчилал баттай тогтох нь                                 | 74 |
| 4.3 Монголын ардчилалд нөлөөлсөн хүчин зүйлс                               | 75 |
| 4.4 Монгол улсын ардчиллын дүгнэлт, даалгавар ба ирээдүй                   | 82 |
| Бүлгийн дүгнэлт                                                            | 83 |
| <br>                                                                       |    |
| ТАВДУГААР БҮЛЭГ. БНСУ-ЫН АРДЧИЛЛЫН ЗАМНАЛ,<br>МОНГОЛ УЛСАД ӨГЧ БҮЙ СУРГАМЖ | 85 |
| 5.1 Монголын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлд үзүүлэх нөлөө             | 85 |
| 5.2 Ардчиллын гол хүчин болох оюутны хөдөлгөөний тухайд                    | 87 |
| 5.3 Монголын ардчилалд өгч буй сургамж                                     | 90 |
| <br>                                                                       |    |
| ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ                                                            | 94 |
| НОМ ЗҮЙ                                                                    | 95 |

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

|                                                                                |    |
|--------------------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт 1. Ардчиллын үзэл баримтлалын талаарх эрдэмтдийн тодорхойлолт          | 14 |
| Хүснэгт 2. Эрх мэдлээр хуваасан ардчиллын үзэл баримтлалын түүх                | 16 |
| Хүснэгт 3. Hans Vorlander-ын ардчиллын гурван үеийн ангилал                    | 16 |
| Хүснэгт 4. Жу Сон Дэ-гийн ардчилсан үзэл баримтлалын ангилал                   | 17 |
| Хүснэгт 5. Ардчилсан үзэл баримтлалын үндсэн зарчмын талаарх тодорхойлолт      | 19 |
| Хүснэгт 6. Ардчилсан үзэл баримтлалын үндсэн зарчим                            | 19 |
| Хүснэгт 7. Ардчилсан шилжилт, ардчилагдах үйл явц хэмээх ойлголтын харьцуулалт | 20 |
| Хүснэгт 8. Ардчилагдах үйл явцын талаарх судлаачдын тодорхойлолт               | 20 |
| Хүснэгт 9. Ардчилагдах үйл явц бий болох нөхцөл байдал - 1                     | 23 |
| Хүснэгт 10. Ардчилагдах үйл явц бий болох нөхцөл байдал - 2                    | 26 |
| Хүснэгт 11. Ардчиллын гурван давалгаа                                          | 28 |
| Хүснэгт 12. Ардчиллын дөрвөн давалгаа                                          | 29 |
| Хүснэгт 13. БНСУ-ын ардчиллын түүхийн гурван үе                                | 33 |
| Хүснэгт 14. Цэргийн дарангуйллын гурван үе                                     | 36 |
| Хүснэгт 15. 1948-1987 оны ерөнхийлөгчид ба онцлог үйл явдал                    | 38 |
| Хүснэгт 16. 1987-1988 оны ардчилалд шилжихэд нөлөөлсөн үйл явдал               | 42 |
| Хүснэгт 17. БНСУ-ын 1987 оны ардчиллаас хойших үеийн ерөнхийлөгчид             | 45 |
| Хүснэгт 18. 1987 оны ардчиллын дараах үеийн УИХ-ын сонгууль                    | 46 |
| Хүснэгт 19. 1980-аад оны үед ардчилсан хөдөлгөөнд                              | 48 |
| Хүснэгт 20. Сөүлийн их сургуулийн оюутнуудын хөдөлгөөний түүхэн үе             | 50 |
| Хүснэгт 21. 1964-1980-аад оны ардчиллын төлөөх нам бус хүчнүүд                 | 53 |
| Хүснэгт 22. БНСУ-ын ардчиллын үзэл баримтлалын даалгавар                       | 61 |
| Хүснэгт 23. Монгол Улсын Ерөнхийлөгчид                                         | 70 |
| Хүснэгт 24. 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн дүн                              | 71 |
| Хүснэгт 25. Солонгос болон Монголын оюутан залуусын хөдөлгөөн                  | 94 |

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

|                                                                              |    |
|------------------------------------------------------------------------------|----|
| Зураг 1. Ардчилсан хөдөлгөөн, ардчилагдах үзэл баримтлалын харилцан хамаарал | 12 |
| Зураг 2. БНСУ-ын ардчилсан хөдөлгөөний гол хүчин                             | 52 |
| Зураг 3. Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2021 он ( хувиар)                | 70 |
| Зураг 4. 1994-2024 оны УИХ-ын сонгуулийн үр дүн                              | 72 |
| Зураг 5. Монгол дахь шашны сүм хийд ба итгэгчид (шашны үзэл баримтлалаар)    | 87 |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|        |                                           |
|--------|-------------------------------------------|
| АИХ    | Ардын их хурал                            |
| АН     | Ардчилсан нам                             |
| АСХ    | Ардчилсан социалист холбоо                |
| БНАСАУ | Бүгд найрамдах ардчилсан Солонгос ард улс |
| БНМАУ  | Бүгд найрамдах Монгол ард улс             |
| БНСУ   | Бүгд найрамдах Солонгос улс               |
| БНХАУ  | Бүгд найрамдах Хятад ард улс              |
| БНЧУ   | Бүгд найрамдах Чех улс                    |
| ДНБ    | Дотоодын нийт бүтээгдэхүүн                |
| НҮБ    | Нэгдсэн үндэстний байгууллага             |
| ЗХУ    | Зөвлөлт холбоот улс                       |
| МАН    | Монгол ардын нам                          |
| МАХН   | Монгол ардын хувьсгалт нам                |
| МоАХ   | Монголын ардчилсан холбоо                 |
| МОХ    | Монголын оюутны холбоо                    |
| МУИС   | Монгол улсын их сургууль                  |
| МЭӨ    | Манай эриний өмнөх                        |
| ИТХ    | Иргэдийн төлөөлөгчдийн хурал              |
| СЕХ    | Сонгуулийн ерөнхий хороо                  |
| УБИС   | Улсын багшийн их сургууль                 |
| УИХ    | Улсын их хурал                            |
| ХҮН    | Хөдөлмөрийн үндэсний нам                  |
| ПДС    | Политехникийн дээд сургууль               |
| ШДХ    | Шинэ дэвшилт холбоо                       |
| IMF    | International Monetary Fund               |

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

### СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ БА ТОЙМ

#### 1.1 Судалгааны үндэслэл

БНСУ нь институцийн хөгжлөөрөө, ардчиллын амжилтаараа Азийн бүс нутагт тэргүүлдэг улс орны нэг билээ. Түүхэн хөгжлийн хувьд цэргийн дэглэмтэй дарангуйллаас оюутан залуус, нийгмийн дундаж давхрагын иргэд болон нам бус хүчний оролцоогоор ардчилалд шилжиж, өдгөө чанартай ардчиллын загвар болсон хэмээн олон улсад үнэлэгдэж байна.

1990-ээд оны үеэс Монгол улс нэг намын тогтолцооноос ардчиллын тогтолцоонд шилжихдээ Зүүн Азийн орнуудын амжилттай туршлагууд тэр дундаа БНСУ-ын ардчиллын туршлага, хөгжлийн загвараас суралцаж ирсэн нь бодитой юм. 1948 оны 5 сарын 10-нд Үндэсний Ассемблейн анхны сонгууль явагдаж, 21-ээс дээш насны бүх иргэд тэгш эрхтэйгээр оролцсоноор 7 сарын 17-ний өдөр улсаа байгуулсан түүхтэй билээ. Анхны ерөнхийлөгчөөр И Сын Маны засаглал дарангуйллын шинжтэй байсан учраас 1961 онд Пак Жон Хи цэргийн эргэлтээр эрх мэдэлд хүрч, улс орныг аж үйлдвэржүүлэх замаар хурдацтай хөгжүүлэх суурийг тавьсан юм. Улмаар 1987 оны 6 дугаар сарын хөдөлгөөнөөр Чо Ду Хуанийн дарангуйллын дэглэмийг нурааж ардчилсан шинэ үндсэн хуулийн зарчмаар ерөнхийлөгчийг ард түмнээс шууд сонгох улс төрийн институцын маш том эргэлт хийжээ. Хууль бус сонгууль, цэргийн дэглэм, хүний эрхийн зөрчил, эрх чөлөөгүй байдлыг эсэргүүцсэн ардчиллын төлөөх хөдөлгөөнд иргэд оюутнуудаас гадна нийгмийн бүх давхрагынхан гол үүрэг гүйцэтгэсэн юм. Институци, авилга, цэргийн дэглэм, хүний эрхийн зөрчлийн эсрэг иргэний нийгмийн идэвхтэй тэмцэл нь ардчиллыг бэхжүүлэх томоохон сургамж болж байна. Өнөөг хүртэл БНСУ ардчиллын төлөөх шилжилтийг хийж, үйл явц, өрнөлөөр тогтвортой хөгжлийг бий болгохдоо улс төр, нийгмийн институцын өөрчлөлт, сонгуулийн тогтолцоо, шүүх засаглалын хараат бус байдлыг эдийн засгийн шинэчлэлтэй ямагт уялдуулж байгаа онцлогтой байна. 2024 оны байдлаар нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 34653 ам доллар болж дэлхийд 34 дүгээрт эрэмблэгджээ. Ард иргэдийн амьжиргаа, эдийн засаг сайжирч, орлогын тэгш бус байдал ялгаа эрс багассан нь ардчиллын үр өгөөж хэмээн үнэлсээр байна.

Монгол улсын хувьд ардчилсан шилжилтийн түүхийг бүтээгээд 35 жилийг үдсэн. 1921-1990 оны үеийн 70 жилийн түүхэндээ социалист нийгмийн байгууллыг бүтээхдээ нэг хүний дарангуйлал, тоталитари дэглэмтэй улс орон болсон билээ. Харин 1989 онд улс төрийн тавцанд өөрчлөн байгуулалт, олон ургальч үзэл оюун санааны шинэ давалгаа эхэлж, Монгол улсад ардчилсан иргэний нийгмийн байгууллын үндсийг тавьсан, тайван замаар шилжсэн гэдгийг хүн бүр мэдэх юм. Монгол дахь ардчиллын хөгжлийн асуудал өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй хэвээр бөгөөд Монгол дахь ардчилал хөгжлийнхөө аль үед явж байна, ардчиллын хөгжлийг хэрхэн хэмжиж болох вэ? Бүрэн төгс хөгжлөө хараахан олоогүй гэвэл юу нь дутуу байна? зэрэг олон асуудал тулгарсаар байна (Д.Ганбат, 2008). Тухайлбал УИХ-ын Д.Бум-Очир Шведийн Gothenburg-ийн их сургуулийн V-Dem (Varieties of Democracy) хүрээлэнгээс гаргадаг сэтгүүлд Монгол улсыг ардчиллаас алдаа хэмээн бичсэн талаар

УИХ-ын танхимд мэдэгдсэн байдаг. Тэрээр “2021 оноос хойш Монгол улс ардчиллаас ухраад байна. 2021-2025 онд 84 дугаар байруудад байгаа бөгөөд 1990 онд олж авсан хамгийн чухал үнэт зүйлийн нэг болох ардчилалаа алдаж автократ ангилалд албан ёсоор орсон” хэмээжээ (focus.mn, 2025). Тодруулбал, Монгол улсыг “сонгуулийн автократ” хэмээн ангилсан нь сонгууль байдаг ч ардчиллын гол зарчим болох шударга өрсөлдөөн, эрх чөлөө, хараат бус институцийн утга учир алдагдаж байгааг онцолсон (V-Dem, 2025). Монгол улс ардчиллыг сайжруулахын тулд сайн засаглалтай уялдуулснаар нийгмийн сайн сайхан байдал, хөгжлийг бий болгохоор чармайж байгаа ч нийгмийн хамгаалал, оюун санааны хүрээ, иргэний нийгмийн төлөвшил, хуулийн үйлчлэл гол хүчин зүйлс сул байгааг судлаачид өдгөө анхааруулсаар байгаа (Болорсүх Б, 2012).

Дэлхийн түүхээс харвал ардчиллыг бэхжүүлэх, бат суурьтай тогтоох нь амаргүй олон даваатай байна. Азидаа өндөр хөгжилтэй орны нэгд багтсан, Монгол улстай хамгийн ойр харилцаатай “гуравдагч” хөрш болох Солонгос улсын ардчиллын үйл явц ч хэдий бэрхшээлтэй талуудтай ч бидэнд сургамж болох туршлага ч ихтэй билээ. Ардчиллыг хамгаалах, бэхжүүлэхийн төлөөх өнөөдөр ч тасралтгүй өрнөсөөр байгаа тэмцэл хөдөлгөөн, үр дүнгээс тэдний цуцашгүй, эв нэгдэлтэй, тууштай байдлыг бид мэдээллийн олон сувгаас мэдэж, хардаг билээ. Энэ утгаараа ардчиллын замнал, үнэт зүйлсийг судалж, Монголын ардчилалд авч болох сургамжтай тал буйг тодруулах нь ач холбогдолтой хэмээн үзлээ.

## **1.2 Судалгааны зорилго**

Энэхүү судалгааны ажлын зорилго нь БНСУ-ын ардчиллын шилжилт, бат суурьтай тогтох үйл явцад онол, эмпирик талаас нь шинжилгээ хийж, Монголын ардчилалд өгч буй нөлөө, сургамжийн талаар судлахад оршино. Зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- Ардчилал, ардчилсан үзэл баримтлал, ардчилсан хөдөлгөөний талаарх онолын судалгааг хийх;
- Хоёр улсын ардчиллын түүх, шилжих үйл явц, бэхжиж бат тогтоход нөлөөлсөн гол хүч болох оюутны хөдөлгөөн, нийгмийн дундаж давхрага, ардчиллын төлөөх нам бус хүчнүүд, шашны институцийн оролцоо, хувь нэмрийг судлах;
- Монголын ардчилалд үзүүлэх нөлөө, сургамжийг тодорхойлох;

*Судалгааны асуултууд:*

- БНСУ-ын ардчиллын шилжилт, баттай тогтох бэхжихэд ямар хүчин зүйлс нөлөөлсөн бэ?
- Монголын ардчиллын шилжилт, бэхжилтэд БНСУ-ын туршлага хэрхэн нөлөөлж байна вэ?
- Монголын ардчиллын чанарыг сайжруулахад БНСУ-ын замналаас авч болох ямар сургамж байна вэ?

## **1.3 Судалгааны арга зүй**

Уг судалгааны ажлын хүрээнд дараах чанарын аргуудыг ашиглав. Үүнд:

1. Баримт бичгийн шинжилгээ – БНСУ-ын болон Монгол улсын судалгааны институт, хүрээлэнгийн судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, архивын болон бусад

тайлан, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийв. Үүнд:

БНСУ-ын ардчиллын түүх, үзэл баримтлалын талаарх Үндэсний ардчилсан хөдөлгөөнийг дурсах үйл ажиллагааны нийгэмлэг, Үндэсний хууль зүйн мэдээллийн төв, БНСУ-ын ардчилсан хөдөлгөөнийг дурсах нийгэмлэг, Шударга ёсны төлөөх Католик санваартнуудын холбоо, Солонгосын Христийн нийгмийн асуудал судалгааны хүрээлэн, Эх орончид, ахмад дайчдын хэрэг эрхлэх үндэсний яам <https://www.mpva.go.kr>, Солонгосын соёлын нэвтэрхий толь бичиг <https://encykorea.aks.ac.kr>, Кембридж болон Британика толь бичиг, Бидний түүхийн сүлжээ <https://contents.history.go.kr>, Зүүн Хойд Азийн түүхийн сүлжээ <http://contents.nahf.or.kr>, NoCut мэдээний суваг <https://www.nocutnews.co.kr>, Сонгуулийн ерөнхий хороо, Цахим сонгуулийн түүхийн музей <https://museum.nec.go.kr>, Хөх ордны ерөнхийлөгчийн архив, Үндэсний архивын порталын мэдээлэл <http://18president.pa.go.kr>, Үндэсний Ассамблейн нээлттэй мэдээллийн суваг <https://open.assembly.go.kr>, Монгол улсын гадаад харилцааны яамны цахим хуудас <https://www.consul.mn>, Конрад-Аденауер сан <https://www.kas.de/mn>, Монголын үндэсний архивын газар, Монгол улсын Сонгуулийн ерөнхий хороо, Нээлттэй Нийгэм хүрээлэнгийн цахим хуудас <https://forum.mn>, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан <http://www.1212.mn>, Төрийн төв архив, Хуулийн цахим хуудас <https://legalinfo.mn> цахим сайтуудын судалгаа мэдээлэл, мэргэжлийн судлаачид олон улсын байгууллагын судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэг хоёрдогч мэдээлэл;

2. Тематик (thematic analysis) шинжилгээний арга - энэ нь чанарын аргаар цуглуулсан өгөгдөлд системтэй шинжилгээ хийх, хүний зан үйл, үзэл бодол, туршлага, үнэт зүйлтэй холбоотой утга санаа, төрхийг олж тогтоох, илрүүлэх боломжтой нийгмийн судалгаанд өргөн хэрэглэгддэг утга, сэдвийн шинжилгээний арга юм. Судалгаанд хагас бүтэцлэгдсэн асуултуудын хүрээнд Монголын их дээд сургуулийн нийгмийн ухааны салбарын багш судлаач 10, оюутан залуус 15 оролцогчоос ярилцлага авсан ба дараах таван үе шатыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- (1) Өгөгдөл мэдээлэл цуглуулах, бичвэрт оруулах;
- (2) Чанарын аргаар цуглуулсан өгөгдлийг кодлох;
- (3) Кодуудыг судлан, нэгдмэл төрхийг тогтоон тема буюу сэдэв үүсгэх;
- (4) Тема буюу сэдвүүдийг хянаж сайжруулах;
- (5) Тема бүрийн нэрийг эцэслэн үр дүн тодорхойлох;

Уг судалгааны мэдээллийг 2025 оны 1 сарын 31-8 сарын 30 хооронд цуглуулж боловсруулалт хийлээ.

#### **1.4 Судлагдсан байдал**

БНСУ-ын ардчиллын үйл явц Монгол улсад хэрхэн, ямар байдлаар нөлөөлсөн талаар судалгааны бүтээл ховор байна. Харин БНСУ-ын ардчилал, түүний бэхжилт, бат тогтох үйл явцтай холбоотой Солонгос Монголын эрдэмтэд, судлаачдын хийсэн бүтээл багагүй байгаа нь судалгааны эх сурвалж болсон юм. Эдгээр бүтээл нь ардчиллын түүхэн хүчин зүйл, үзэл баримтлалын төлөвшил, бэхжилт, нийгэм, эдийн засаг, соёлын өөрчлөлт, ардчиллын үйл явц, хэрэгжилт, алдаа дутагдал зэрэг өргөн хүрээнд хийгджээ. Бид энэхүү судалгааны хүрээнд авч үзсэн ажлыг тоймлон танилцуулж байна. Үүнд:

- Михал Клима “Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу” (2017) бүтээлдээ

ардчилсан тогтолцооны чанар, тогтвортой байдлын судалгааг хийж байхдаа улс төрийн нам, ашиг сонирхлын бүлэглэл, хэвлэл мэдээллийг хамруулсан дэд системийн давхрага нь ардчилсан чанарыг тодорхойлоход зонхилох үүрэгтэй бөгөөд нийгэм, улс төрийн, соёлын чанаргүй орчин нь гажуудсан ардчиллын хэлбэрийг үүсгэдэг хэмээн үзэж тоталитари дэглэмтэй байсан улс орнуудын институцийн хөгжлийг судалсан байна.

- Сонь Хо Чол судлаач (2003) “Ардчиллын хөдөлгөөн, ардчилагдах ардчилсан үзэл баримтлал-БНСУ-ын жишээн дээр” эрдэм шинжилгээний бүтээлдээ ардчиллыг ойлгохын тулд ардчилсан хөдөлгөөн үйл явц, үзэл баримтлалын хоорондын холбоог харах нь маш чухал болохыг онцлоод ардчилалд шилжих үйл явц хэрхэн өрнөдөг, нөлөөлөх хүчин зүйлсийн хувьд бүтцийн болон ардчилсан хөдөлгөөн чухал үүрэгтэй болохыг баталсан юм. Үүний үр дүнд нийгэмд хүний эрх, эрх чөлөө хэрэгжиж, хууль ёсыг дээдлэх, нийгэм, эдийн засгийн эрх чөлөө зэрэг ардчиллын үнэт зүйлд суурилсан тогтолцоо бий болно гэжээ. Тэрээр ардчилагдах үйл явц бий болохын тулд эдийн засгийн, нийгмийн, соёлын, олон улсын гэсэн дөрвөн үндсэн нөхцөл бүрдсэн байх ёстойг онцолсон.
- Andrew Heywood (2010) “Улс төр судлал” бүтээлдээ ардчиллын үзэл баримтлал хэмээх ойлголтын дотор найман утга агуулга байгааг судалсан ба ардчилал гэдэг нь энгийн ард олон эрх мэдэлтэй байх, өөрсдөө захирах улс төрийн системтэй байх, нийгэмд хэн нэгэн бусдаас онцгой эрх мэдэлтэй байх биш тэгш эрх, хувь хүний давуу талд үндэслэсэн нийгэм, нийгмийн хамгаалал, ердийн сонгуулиар өрсөлдөх аргаар улс төрийн албан тушаалыг хаших гэх мэт шинж агуулгыг тодорхойлсон юм.
- Ким Ху Ги судлаач (2007) “6 сарын ардчиллын хөдөлгөөний 20 жил: Солонгосын ардчиллын өсөлт ба сорилт” бүтээлдээ 1987 оны ардчиллын төлөөх тэмцлийг БНСУ-ын эргэлтийн цэг байсан гэдгийг онцолсон юм. Олон нийтийн хүсэл зорилго, эв нэгдлээр бүтээсэн иргэний нийгмийн энэхүү хөдөлгөөн нь түүхэнд хамгийн чухал хүч байсан хэмээн дүгнэсэн байна.
- Жон Тэ Ил судлаач (2012) “1980 оны Солонгосын ардчиллын төлөөх хөдөлгөөн ба улс төрийн бүтцийн өөрчлөлт” сэдэвт эрдэм шинжилгээний бүтээлд 6 сарын Гуанжугийн ардчиллын төлөөх хөдөлгөөн улс даяар өрнөсөн нийгмийн хөдөлгөөн байсан учраас нийгмийн дундаж давхрага, оюутан залуусын дэмжлэг оролцоотойгоор амжилт олсон хэмээн үзсэн.
- Ким Ён Тэ судлаач (2006) “Солонгос дахь ардчиллын шилжилт ба бэхжилтийн дүн шинжилгээ” эрдэм шинжилгээний бүтээлдээ ардчилалд шилжих хамгийн чухал алхам бол улс төрийн дарангуйлагчийг төрийн эрх барих суудлаас буулгаж, ардчилсан сонгуулиар шинэ засаглалыг бий болгох бөгөөд ардчилал бат тогтох үе шатанд ардчилсан систем, хууль дүрэм тогтоох, ардчиллыг тогтворжуулах, нийгмийн бүхий л салбарын үйл ажиллагаа ардчиллын зарчимд суурилсан байх нь чухал хэмээн онцолсон байна.
- У Хён Жин ба Жу Ин Бөм судлаачид (2018) “Ардчиллын дараах Солонгосын ардчиллын үзэл баримтлалын чанар: Тогтолцооны өөрчлөлт ба ардчиллын үзүүлэлтийн дүн шинжилгээ” хэмээх илтгэлдээ улс төрийн системийн өөрчлөлтийг дүгнэж, Солонгос улсад ардчиллын үзэл баримтлал бат тогтож байгаа боловч засаж шинэчлэх зүйл байгаа хэмээжээ. Ардчиллын дараах 30 жилийн хугацаанд бүхий л

системийн өөрчлөлтийг төрийн эрх барих өрсөлдөөн, түүний хэрэгжилт талаас нь ардчилсан системийн маш том өөрчлөлт дэвшил байсан гэж дүгнэсэн байна. Тэрээр төрийн эрхийг хэрэгжүүлэхийн тухайд хууль тогтоох, шүүх эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэл тэгш бус, ерөнхийлөгч болон гүйцэтгэх засаглал давуу эрх мэдэлтэй, гүйцэтгэх засаглалд хяналт сул, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарласан зэрэг асуудал байгаа гэж үзсэн.

- Жон Хэ Гү, Жон Жү Шин судлаачид (2022) “Солонгосын ардчиллын хөдөлгөөнд их сургуулийн оюутнуудын үүрэг: Пусан-Масан дахь ардчилсан тэмцлийн жишээн дээр” бүтээлд ардчилсан хөдөлгөөний төвд оюутан, залуус үргэлж байсан гэдгийг онцолдог. 1980 оны ардчилсан хөдөлгөөнд асар том нөлөө үзүүлсэн гол хүчин зүйлийг оюутны хөдөлгөөн, улс төрийн сөрөг хүчний нам, шашны хүчин, ардчиллын төлөөх нам бус хүчинтэй холбож үзжээ. Ихэнх тэмцлийн ард оюутан залуучуудын гал халуун зүрх сэтгэл, шударга хандлага байсан учраас дарангуйллын дэглэмийг дуусгаж, ард олны үзэл бодлыг ч өөрчлөхөд асар их хэмээн үзсэн. Судлаачид оюутны хөдөлгөөн агуулгад шинжилгээ хийж дүгнэсэн байна.
- Юү Юун Тэ судлаач (2020) “Оюутнуудын бүтээсэн Солонгосын орчин үеийн түүх: Сөүлийн үндэсний их сургуулийн оюутны хөдөлгөөний 70 жил 1 дүгээр боть номын агуулгын жишээн дээр” бүтээлд оюутны хөдөлгөөний анхны зорилго ардчиллын хөдөлгөөн хувьсгалд оролцохоор хэрхэн идэвхжсэн, нийгмийн бусармаг явдал, коммунист үзэл суртлыг эсэргүүцэн өрнөж, улс төр нийгмийн нөхцөл байдлыг өөрчилсөн талаар таван үед хуваан авч үзжээ.
- И Жон Хи (1999) “Талбар дахь улс төрийн бүлгүүдийн ардчиллын төлөөх хөдөлгөөн: Улс төрийн үзэл баримтлал, эрх мэдэл, улс төрийн тойргийн харилцааны жишээн дээр” бүтээлдээ БНСУ-ыг ардчиллын түүхэнд ардчиллын төлөөх нам бус хүчнүүд маш том үүрэг гүйцэтгэсэн, ялангуяа ерөнхийлөгчийн сонгууль, Японтой дипломат харилцааг сэргээхийн эсрэг тэмцэлд том үүрэгтэй байсныг онцлон судалжээ.
- И Чан Гын (2024) “Солонгосын дундаж давхрага гэж хэн бэ?” бүтээлдээ 1980-аад оны үед нийгмийн дундаж давхрага болох хүн амын 70 орчим хувийг эзэлж байсан хөдөлмөрчид, ажилчид ардчилсан тэмцэлд олноороо идэвхитэй оролцох болсноор ардчиллын шинэ үеийг нээсэн бөгөөд 1987 оны тэмцлийг хүчирхэгжүүлсэн хэмээн дүгнэжээ.
- Э.Саранцэцэг (2013) судлаач “Бүгд Найрамдах Солонгос улсын дэглэмийн өөрчлөлт ба эдийн засгийн хөгжил” өгүүлэлдээ тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа тунхаглаж, ардчилсан нийгмийн бүтээж буй Солонгосын ард түмний амжилтын гол түлхүүрийг ард түмний хөдөлмөрч, хичээнгүй зан чанар, хүчирхэг төрийн тогтолцоотой холбон үзжээ. Эдийн засгаа босгохын тулд арвигч, хямгач зан чанараараа баялаг бүтээж, улс төр, эдийн засгийн хүч нөлөөгөө олон улсад өсгөж байгаа хэмээх дүгнэлтийг хийсэн юм.
- Ц.Ганболд, Б.Батдэлгэр (2013) нарын “Монгол дахь ардчиллын бэхжилт, хөгжлийн хандлага” эрдэм шинжилгээний өгүүлэлдээ Монголын ардчиллын бэхжилт, чанарын асуудлыг онолын үзэл баримтлалд тулгуурлан хөгжлийн чиг хандлагыг тодорхойлжээ. Тэрээр Монголын ардчиллын өнөөгийн төлөв байдал нь байгууллагажсан бүтэц хэлбэрүүд зохион байгуулалтын хувьд бий болсон боловч нийгэм ардчилсан болсныг илэрхийлэхгүй Монгол улсын ардчилалд томоохон

сорилт тулгарч байгаа хэмээн үзсэн.

- Д.Бат-Эрдэнэ (2008) судлаач “Асар их үнээр олдсон Ардчиллын ололтоо хайрлаж яваарай” хэмээх бүтээлдээ Монголын ардчилсан хувьсгалын гол хүчин нь тухайн үед гадаад болон дотоодын их дээд сургуулийн оюутан залуус бөгөөд ЗХУ-д эхлүүлсэн өөрчлөн байгуулалт, ил тод байдал, олон ургальч үзлийг анх эхлүүлсэн хэмээн тэмдэглэжээ. 1989-1990 оны ардчилсан хувьсгалаар нийгмийн шинэчлэлийг хөдөлгөөнийг урагшлуулах том хувь нэмрийг их дээд сургуулийн багш, оюутан, залуус оруулсан байна.
- Г.Чулуунбаатар, Ш.Батсүх, Б.Ганцоож (2021) нарын судлаачид “Монголын ардчилал: Төлөөллийн ардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж” бүтээлдээ 1980-аад оны эхэн үеэс эхэлсэн өөрчлөн байгуулалтын үзэл санаа Монгол оронд идэвхтэй өрнөж, нам засгийн төв хэвлэл сонин сэтгүүлүүдэд нийгмийн тогтолцоог боловсронгуй болгон өөрчлөх, ардчилал, ил тод байдлыг дэлгэрүүлэх, үзэл санааны чөлөөт байдлыг хязгаарлахын эсрэг нийтлэлүүд нь нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж, өөрчлөн байгуулалтын үзэл санаа сэргэхэд нөлөөлсөн хэмээн дүгнэжээ.

Ардчиллын тухай, БНСУ болон Монголын ардчиллын талаарх дээрх судлагдсан байдлаас харвал, ардчиллын талаарх үзэл баримтлал, хөгжил, бэхжилт нь тодорхой үе шатуудыг даван нийгмийн бүхий л хүрээнд бат суурьтай өөрчлөлтийг авчирснаар чанар гүнзгийрч нийгмийн ухамсрыг өөрчилдөг байна. Эдгээр өөрчлөлтийг ил тод засаглал, улс төрийн институт, сонгуулийн систем, шүүх болон гүйцэтгэх засаглалын хүрээнд хийж буй өөрчлөлт, нийгэм эдийн засгийн өсөлт хөгжилд гарч буй эерэг нөхцөл байдал талаас нь авч үзсэн судалгааны ажлууд олон байна. Харин нийгмийн өөрчлөлтийн томоохон хүч болох оюутны хөдөлгөөн, нийгмийн дундаж давхрагыг бүрдүүлж буй олон нийт, сэхээтэн, шашны бүлгийнхэн, ардчиллын төлөөх улс төрөөс ангид бусад хүчний хувь нэмэр оролцооны талаарх мэдээлэл, харьцуулсан судалгаа дутагдалтай байна гэж үзлээ.

Энэхүү судалгаа нь өмнөх судалгаанаас ялгаатай онцлог байдлыг дараах байдлаар тодорхойлж байна. Нэгдүгээрт, хоёр улсын ардчиллын түүхэн үйл явдал, нөлөөлөх хүчин зүйлсийг оюутны хөдөлгөөн, нийгмийн дундаж давхрагын оролцоо, шашны байгууллага, зүтгэлтнүүдийн оруулсан хувь нэмэр, ардчиллын төлөөх нам бус хүчин гэсэн дөрвөн хүрээнд судалсан. Хоёрдугаарт, БНСУ-ын ардчилал үйл явц Монгол улсын ардчилалд ямар сургамж өгч байгаа талаар тодруулахыг хичээсэн болно.

### **1.5 Судалгааны хязгаарлагдмал тал**

Тухайн судалгааны ажлын хүрээнд хоёр улсын ардчиллын төлөөх оюутан залуусын хөдөлгөөн, нийгмийн дундаж давхрагын оролцоо, ардчиллын төлөөх нам бус хүчин болон шашныхны оролцооны түүхэн хөгжлийг авч үзлээ. Мөн зарим өгөгдөл мэдээлэл, архивын материалд нэвтрэх боломж хязгаарлагдмал байв.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ.


### АРДЧИЛЛЫН ТАЛААРХ ОНОЛЫН СУДАЛГАА

Ардчилагдах үйл явцыг авч үзэхийн өмнө ардчиллын талаарх тодорхойлолт, утга учир, хөгжил, шилжилт, баттай тогтож бэхжих болон ардчилалтай шууд холбоотой үйл явц, хөдөлгөөний тухай эрдэмтдийн үзэл баримтлал онолын судалгаа хийх зайлшгүй шаардлагатай.

1950-иад оны үед Габриел Алмонд (Gabriel Almond) дэлхий даяарх ардчилсан тогтолцооны чанар, тогтвортой байдлын судалгааг хийж байхдаа улс төрийн нам, ашиг сонирхолын бүлэглэл, хэвлэл мэдээллийг хамруулсан дэд системийн давхрага нь ардчилсан чанарыг тодорхойлоход зонхилох үүрэгтэй гэжээ (Клима, 2017:19). БНЧУ-ын Прага хотын Эдийн засгийн дээд сургуулийн улс төр судлалын профессор Михал Климагийн үзсэнээр нийгмийн идэвх хангалтгүй, хяналт дутагдсаны улмаас юуны өмнө улс төрийн намууд, цаашлаад улс төрийн систем тэр чигтээ далд бизнесийнхний олз болж, нийгэм улс төрийн соёлын чанаргүй орчин нь гажуудсан ардчиллын хэлбэрийг үүсгэдэг байна. Ардчиллын нөхцөл байдлыг В.Меркель 2001 оны байдлаар Латин Америк, Зүүн Европ, Ази хэмээн гурван бүсэд хувааж үзсэн ба нийт 40 шинэ ардчиллын 72.5 хувийг гажуудсан ардчиллын эгнээнд багтаасан, зөвхөн 22.5 хувийг либерал ардчиллын бүлэгт оруулсан байна (Wolfgang, 2004). 2024 оны Economist Intelligence Unit- Democracy Index-ийн мэдээллээр дэлхийн эдийн засаг, засгийн газрын тогтвортой байдал зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан эдгээр бүс нутгуудад гажуудсан ардчиллын орнуудын тоо хэлбэлзэлтэй байна.

БНСУ-ын эрдэмтэн Сонь Хо Чол нь ардчиллыг ойлгохын тулд ардчиллын хөдөлгөөн, үйл явц, үзэл баримтлалын хоорондын харилцаа холбоог тодорхой харах нь маш чухал гэдгийг онцолж байна. Тэрээр ардчиллын хөдөлгөөн нь ардчилагдах үйл явцыг бий болгох ба ардчилагдах үйл явц нь ардчилсан үзэл баримтлалыг бүтээдэг гэжээ. Тус харилцаа холбоог дараах зургаас (Зураг 1) харах боломжтой (손호철, 2003).

Зураг 1. Ардчилсан хөдөлгөөн, ардчилагдах үзэл баримтлалын харилцан хамаарал



Эх сурвалж: Сонь Хо Чол (2003), “Ардчиллын хөдөлгөөн, үйл явц, үзэл баримтлал-ойлголт ба БНСУ-ын онцлог”.

Энэхүү зургаас ардчилалд шилжих үйл явц хэрхэн өрнөдөг, ямар хүчин зүйлс нөлөөлдөг болохыг харж болох юм. Гол төлөв хоёр хүчин зүйл буюу “бүтцийн нөлөөлөл”, “ардчилсан хөдөлгөөн” нь ардчиллын үйл явцыг тодорхойлдог аж. Анхны нийгмийн бүтцийн болон үйл ажиллагааны нөхцөлд системийн өөрчлөлт бий болж ардчиллын хөдөлгөөн үүсдэг ба энэхүү хөдөлгөөний зорилготой болон зорилгогүй үр дагавар нь ардчилагдах үйл явцад хүргэдэг байна. Ардчилал руу шилжих нь олон хүчин зүйл болон үйл явцын харилцан үйлчлэлийг үзүүлж байгаа бөгөөд төрийн систем буюу (тогтолцооны бүтэц), ард түмний тэмцэл, эсэргүүцэл (хөдөлгөөн) нь ардчиллын хөгжилд маш чухал үүрэгтэй хэмээн үзжээ. Өөрөөр хэлбэл, анхны байдал гэдэг нь тухайн улс орны нийгэм, улс төрийн анхны бүтэц, нөхцөл буюу авторитар засаглал, цэргийн дэглэм байж болно. Улс төр, нийгэм эдийн засгийн бүтэц өөрчлөгдөх нөхцөл нь эдийн засгийн хямрал, гадаад дарамт шахалт, дотоодын хагарал бөгөөд энэ нь ардчилалд шилжих нөхцөлийг бий болгох юм. Иргэд, оюутнууд, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс ардчилсан эрх, эрх чөлөөг шаардан эсэргүүцэл, тэмцэл, жагсаал цуглаанаар дамжуулан хөдөлгөөнийг үүсгэж, ардчиллын эхлэлийг авчирдаг байна. Эдгээр үйл явцаас засгийн газар, төрийн институциуд эсэргүүцлийн хөдөлгөөнд өөрчлөлт хийх эсвэл дарангуйлал үзүүлэх гэх мэтээр хариу арга хэмжээ авах үед систем өөрчлөгдөх нөхцөл бүрдэнэ.

Ардчилагдах үйл явц нь бүтэц хөдөлгөөний харилцан үйлчлэл, үр дагаварын нийлбэрийн үр дүнд бий болдог нийгмийн өөрчлөлт ба эцсийн зорилго нь ардчилсан нийгэм байгуулах явдал юм. Үүний үр дүнд нийгэмд хүний эрх, эрх чөлөө биелэлээ олж, хууль ёсыг дээдлэх, олон ургалч үзэл баримтлал дэлгэрэх, сонгуулийн болон нийгэм эдийн засгийн эрх чөлөө зэрэг ардчиллын үнэт зүйлсэд суурилсан тогтолцоо бий болно.

Энэхүү загвар нь хувьсгалын үйл явцыг тайлбарлахад тохиромжтой хэмээн судлаачид үздэг бөгөөд ардчилалд хөтөлсөн гол хүчин зүйлсийг нэгд, ардчилсан үзэл баримтлал, хоёрт, ардчилагдах үйл явц, гуравт, ардчиллын төлөөх хөдөлгөөн гэсэн дарааллаар авч үзлээ.

## **2.1 Ардчилсан үзэл баримтлалын талаарх ойлголт**

Ардчилагдах үйл явцын тухай ойлгохын тулд юуны өмнө ардчилсан үзэл баримтлалын талаар ойлгох ёстой. Учир нь ард олны эрх чөлөө, эрх ашгийг хязгаарлан дарамталж, ардчиллын эсрэг улс төрийн хүчин, түүний бүтээсэн нэг намын эсвэл нэг хүний дарангуйлал зэрэг авторитар системээс ардчилсан үзэл баримтлалд шилжих үйл явцыг хамардаг учраас энэхүү үзэл баримтлалын талаар зайлшгүй ойлгох хэрэгтэй.

Ардчилсан үзэл баримтлалыг зөв ойлгохын тулд эрдэмтдийн тодорхойлолт, түүх, стандарт, шаардлага, үндсэн зарчмыг танилцуулна.

### **(1) Ардчилсан үзэл баримтлалын талаарх тодорхойлолт**

Ардчилсан үзэл баримтлалыг зөв ойлгохын тулд эхлээд Britannica болон Cambridge толь бичигт хэрхэн тодорхойлсныг авч үзье.

Britannica толь бичигт үгийн утгаар болон түүхэнд үндэслэж ардчиллын үзэл баримтлалын тодорхойлолтыг М.Э.Ө 5-р зууны дунд үед “dēmos(ард олон) ба kratos(захиргаа) dēmokratia” гэдэг үгээс гаралтай бөгөөд тухай үед Грекийн зарим хот ялангуяа Афины төрийн системийг илэрхийлэх үг” хэмээн тодорхойлжээ (Britannica, 2025).

Харин Cambridge толь бичигт дараах гурван зүйлтэй холбон тайлбарлаж байна (Dictionary, 2025). Үүнд:

- . Ард олон чөлөөтэй сонгох, ард олноор шууд сонгогдсон төлөөлөгчид эрх мэдлийг барьдаг улс төрийн систем;
- . Ард олон чөлөөтэй сонгож, шууд сонгогдсон төлөөлөгчид захирах эрх мэдэлтэй улс үндэстэн;
- . Ард олон шийдвэр гаргах үйл явцад оролцох эрх мэдэлтэй бөгөөд өөрсдийн санаа бодлыг сонсох байгууллага эсвэл улс төрийн хүчний аргаар захирах систем гэжээ.

Эртний Грек Ромын философич Аристотель (Aristotle) нь нийгмийн олон янзын бүлгээс бүрдсэн улс үндэстнийг захирах улс төрийн системийг ардчиллын үзэл баримтлалтай болон олигархи хэмээн хуваасан ба ардчилсан үзэл баримтлалтай болохын тулд олон нийт нь эзэн байж, хуулиар захирах системийг бүтээх тухай тайлбарыг хийжээ. Дараах хүснэгт 1-ээс ардчиллын үзэл баримтлалын тодорхойлолтыг харна уу.

Хүснэгт 1. Ардчиллын үзэл баримтлалын талаарх эрдэмтдийн тодорхойлолт

| Эрдэмтэд                               | Утга                                                                                                                                                                                                                                                                                                    |
|----------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Эртний Грек Ромын философич Аристотель | "Ардчиллын үзэл баримтлалд олон төрлийн хэлбэр маяг байдаг боловч хуулийн дагуу захирах ба ард олон нь улс төрийн гол эзэн болох үед жинхэнэ ардчилал болно. Ард олны хууль бус шийдвэрийг улс үндэсний хамгийн дээд эрх мэдэл гэж үздэг систем бол ардчилсан гэж хэлэхэд хэцүү юм" (아리스토텔레스, 2024:218) |
| Сон Сөг Чунь                           | Ардчиллын үзэл баримтлал бол эртний үеийн Афины үеэс эхэлсэн ба Грекээр “demokratia” буюу ард олны эрх мэдлээр захирах аргыг хэлнэ (손석춘, 민주주의 특강, 2024:70).                                                                                                                                             |
| Чой Дун Хуан                           | Улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх хэлбэр нь "нэгдүгээрт, дангаараа эрх мэдэлтэй байдаг дарангуйлал, хоёрдугаарт, цөөнхи хүмүүс эрх мэдэлтэй олигархи, гуравдугаарт, ард олон эрх мэдэлтэй ардчиллын үзэл баримтлал" (최동환, 2016:42).                                                                    |
| Ким Вон Шиг                            | Ардчилсан үзэл баримтлал гэдэг нь чөлөөт шударга сонгууль, бусад арга хэлбэрээр ард олны оролцоотой нийтээр захирах утга (김왕식, 2008:33).                                                                                                                                                                |
| Andrew Heywood                         | Ардчиллын үзэл баримтлал нь ард олноор захирах гэсэн утга                                                                                                                                                                                                                                               |
| Nicole Bibbins Sedaca                  | Ардчиллын үзэл баримтлал гэдэг нь олонхийн саналаар захирах зарчим төдийгүй ард олны хүсэл, зөвшөөрөлд үндэслэсэн, бүх нийтийн хариуцлагыг онцолдог, хууль дүрмийг бат сахих, хүний эрхийг хүндэтгэн дээдэлдэг систем (Nicole Bibbins Sedaca, 2025).                                                    |

Andrew Heywood -ны хувьд ардчиллын үзэл баримтлал нь ард олны захирах утга хэмээн үзэж дараах найман утга байдаг гэж тодорхойлж байна (앤드류 헤이우드, 2010:138-139). Үүнд:

- . Энгийн ард олон захирах;
- . Шууд, үргэлжлэх мэргэжлийн улс төрч ба албаны хүмүүсийн туслалцаа дэмжлэггүйгээр ард олон өөрсдөө захирах улс төрийн систем;
- . Хэн нэгэн бусдаас онцгой эрх мэдэлтэй бус, тэгш эрх, хувь хүний давуу талд үндэслэсэн нийгэм;
- . Нийгмийн тэгш бус байдлыг багасах зорилгоор нийгмийн хамгаалал ба эрх ашгийг зөв хуваах систем;
- . Ард олны захирах зарчимд үндэслэсэн шийдвэр гаргалтын бүтэц;
- . Олны эрх мэдлийг хянаж, цөөнхийн эрх мэдэл, ашиг сонирхлыг хамгаалдаг систем;
- . Сонгуулиар өрсөлдөх аргаар улс төрийн албан тушаалыг хаших арга;
- . Ард олны оролцоогүйгээр тэдний эрх ашигт үйлчилдэг улс төрийн систем зэрэг юм.

Дээрх толь бичиг, эрдэмтэн судлаачдын тодорхойлолтоос харвал ардчилсан үзэл баримтлалд суурилсан сонгуулиар улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд ард олон шууд оролцож, эрх мэдлийг хэрэгжүүлснээр улс төрийн гол эзэн болж шууд ба шууд бус аргаар захирах боломжтой систем юм. Энэ утгаар ард олон засаглалын гол эзэн болж шууд эрх мэдэл авах боломжтой. Харин ардчилал бол хувь хүн ба аль нэгэн улс төрийн хүчний ёс зарчим, зорилго, хүсэл эрмэлзэл, ашиг сонирхлоор бус хуулийн дагуу улс төрийн бүх үйл ажиллагааг явуулах ёстой байна.

## **(2) Ардчилсан үзэл баримтлалын түүх**

Ардчилсан үзэл баримтлал түүх хүн төрөлхтөн дэлхийд оршин амьдрах болсон цагаас эхэлсэн гэж үздэг судлаач байдаг боловч ихэнх нь эртний Грекийн Афин хоттой холбодог юм. Рожер Осборн (Rojer Osborne) нь М.Э.Ө 4-5 зууны өмнө ч ардчилсан нийгэм байсан боловч жинхэнэ ардчилсан үзэл баримтлал эртний Грекийн Афин хотоос эхэлсэн гэдэгтэй санал нийлдэг (오스본, 2011:28-29). Эртний Афин хотын соёл нь 200 жилийн түүхтэй хэмээн тэмдэглэгдсэн байна. Энэ нь өнөөдрийн олон улс үндэстний түүхээс ч илүү урт хугацаа гэхэд хилсдэхгүй. Үнэндээ Афин хот бол М.Э.Ө 507 оноос 323 он хүртэл ардчиллыг хэрэгжүүлж байжээ. Түүхэн баримт их биш боловч тогтвортой, бүрэн ардчиллыг хэрэгжүүлсэн гэдэг судалгаа олон байна. Түүнээс өмнө ард олны шийдвэр, сонгуулиар захирч байсан өөр нийгэм байсан гэх боловч Афин хот бол бидний мэддэг анхны ардчилсан нийгэм байсан юм. Энэ талаар Хан Хоу Сог нь М.Э.Ө 5-р зууны эрт Грекийн Афин хот бол ардчилсан үзэл баримтлалын хамгийн анхны алхам байсан бөгөөд 17-р зууны үеийн хувьсгалаар ардчиллын хөгжлийн үндсийг, 19-р зууны аж үйлдвэржилтийн хувьсгалаар ардчилсан эдийн засгийн суурийг тавьсан гэж үзэж байна.

Сон Сөг Чүнь нь ардчилсан үзэл баримтлалын түүхийг эрх мэдэл (sovereignty)-ээр нь дараах үеүдэд хуваасан (손석춘, p. 58~62를 필자가 표로 재구성하였다., 2024:58-62). Энэ тухай хүснэгт 2-оос харна уу.

Хүснэгт 2. Эрх мэдлээр хуваасан ардчиллын үзэл баримтлалын түүх

| Үе                    | Цаг                                                  | Эрх мэдэл                                                 |
|-----------------------|------------------------------------------------------|-----------------------------------------------------------|
| Нэгдүгээр үе - Үүсэл  | Хүн төрөлхтний соёл эхэлсэн<br>-17-р зуун            | Хаанчлал<br>Хаан эрх мэдлийг ганцаараа авах               |
| Хоёрдугаар үе - Гарах | 1688 оны Англи хувьсгал<br>- 1848 оны Европ хувьсгал | Аж үйлдвэрийн эзэн ба худалдаачид<br>хүчтэй гарч ирсэн.   |
| Гуравдугаар үе - Өсөх | 1848 оны Европ хувьсгал<br>-1991 Коммунизм нурах     | Үйлдвэрийн ажилчид ба ард олон<br>хүчтэй гарч ирсэн.      |
| Дөрөвдүгээр үе - Аюул | 1991 Коммунизм нурах - Өнөө<br>үе                    | Аж үйлдвэрийн эзэн ба<br>капиталистууд хүчтэй гарч ирсэн. |

Нэгдүгээр үед хаан ганцаараа авсан эрх мэдэл байсан бол хоёрдугаар үед аж үйлдвэрийн эзэн, худалдаачид, гуравдугаар үед үйлдвэрийн ажилчид, ард олон хүчтэй гарч ирсэн юм. Харин дөрөвдүгээр үед үйлдвэрийн эзэд, капиталистуудын эрх мэдэл хүчтэй ноёрхжээ.

Түүнчлэн Ханс Ворландер (Hans Vorlander) ардчилсан үзэл баримтлалын түүхийг эртний үе, шинэ үе, орчин үе хэмээн 3 ангилж байна (한스 포어랜드, 2023). Тэрээр М.Э.Ө 5-р зууны Эртний Афинд ардчилсан үзэл баримтлал нь хууль тогтоох засаглал, засаг захиргааны байгууллага болон шүүх засаглалыг бүрэн утгаар нь хэрэгжүүлсэн хэмээн үзсэн. Цаашлаад шинэ үе буюу 18-19-р зууны Европ болон Америкт чөлөөт сонгуулийн системийг хэрэгжүүлж эрх мэдлийг хуваарилан төлөөлөгчдийг сонгодог байсан бол 20-р зуунаас хойш ардчилалд олон асуудал үүсэж түүнийг улс орнууд даван туулж явааг онцолжээ.

Хүснэгт 3. Hans Vorlander-ын ардчиллын гурван үеийн ангилал

| Үе       | Онцлог                                                                                                                                      |
|----------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Эрт үе   | - М.Э.Ө 5-р зууны Грекийн Афин хот<br>- Ард олон хууль тогтоох засаглал, засгийн газар, захиргаа, хууль шүүх засаглалыг бүрэн хэрэгжүүлсэн. |
| Шинэ үе  | - 18-19-р зууны Европ ба Америк<br>- Эрх мэдэл хуваах, чөлөөт сонгуулиар төлөөлөгчид сонгох<br>- Хөгжлийн үе                                |
| Орчин үе | - 20-р зуун<br>- Ардчиллын эсрэг олон асуудлыг даван туулж байна.                                                                           |

Жу Сон Дэ судлаач Ханс Ворландер-ийн адилаар ардчилсан үзэл баримтлалын түүхийг эрт, шинэ үе, орчин үе хэмээн хуваан үзэж он цагийн болон түүхэн үйл явдлын хувьд ялгаатай байгааг хэлжээ.

Хүснэгт 4. Жу Сон Дэ-гийн ардчилсан үзэл баримтлалын ангилал

| Үе       | Онцлог                                                                                                                                                |
|----------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Эрт үе   | - Грекийн Афин хотын ардчилал<br>- Ромын эзэнт гүрний ардчилал                                                                                        |
| Шинэ үе  | - 16-р зууны хүмүүнлэгийн хувьсгал, шашны шинэчлэл<br>Аж үйлдвэржилтийн хөгжил, Америк тивийг нээсэн.<br>- Эгоизм буюу хувиа хичээх үзэл газар авсан. |
| Орчин үе | - 20-р зуун<br>- Ард олны эрх ашиг, Дэлхийн 2-р дайны дараах олон шинэ улс байгуулагдсан.                                                             |

Ийнхүү ардчилсан үзэл баримтлалын түүх хүн төрөлхтөн энэ дэлхийд оршин амьдрах болсон цагаас эхэлсэн боловч ард олон шууд эрх мэдлийг хэрэгжүүлэх ардчилал эхэлсэн цаг хугацааг М.Э.Ө 5-р зууны Грекийн Афин хоттой холбон үзсэн юм. Гэвч ардчилал 16-р зууны үед дахин сэргэх хүртэл 2,000 жил орчим харанхуйн үе байсан. 16-р зууны гуманизм, шашны шинэчлэлээр хүний эрх, эрх чөлөө, үнэ цэн, ард олны эрх ашиг дахин сэргээгдсэн болно. Европоос эхлэн Америк цаашлаад дэлхий бүх улс үндэстний дунд ардчилал хөгжиж байна.

### (3) Ардчилсан үзэл баримтлалын нөхцөл байдал ба стандартууд

Ардчилсан үзэл баримтлалыг хөгжүүлэхэд шаардагдах нөхцөл байдал, стандартуудыг энэ хэсэгт авч үзье.

Шин Жон Хёны үзэж буйгаар ардчилсан үзэл баримтлалын үнэт зүйлс болох эрх чөлөө, тэгш байдал, эрх ашиг, шударга зэргийг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэхийн тулд дараах нөхцөл байдал шаардлагатай хэмээн үзсэн (신정현, 제 3세계의 민주화 과정, 1993). Үүнд:

- ☐ Ард олон ардчилсан үзэл баримтлалын үндсэн зарчмаар өөрсдийгөө хөгжүүлэх, хүн бүр чадвар, онцлог чанараа илэрхийлэх боломжтой сайн нөхцөл байдлыг бүрдүүлэх хэрэгтэй.
- ☐ Улс төрийн эрх мэдэл, хүч нөлөөг улс үндэстний хэмжээнд дур зоргоор ашиглахаас болгоомжлох, хувийн амьдрах нөхцөл байдлыг хамгаалах ёстой.
- ☐ Ард олон хамтран нэгдэж эвсэх, нийгэмд сайн дурын эвсэл, иргэний байгууллага олноор бий болгох нөхцөл байдлыг бүрдүүлэх ёстой.
- ☐ Ашиглах боломжтой бүх нөөц боломжид тулгуурлан эдийн засгийг хөгжүүлэх ба баян ядуугийн ялгаралыг багасгах ёстой.

Энэ талаар Роберт Алан Дахл (Robert Alan Dahl) ардчилсан үзэл баримтлалын үндсэн шаардлагыг онцолсон байна (로버트 달, 2015:66). Үүнд:

- ☐ Идэвхтэй оролцоо
- ☐ Сонгуулийн тэгш байдал
- ☐ Ардчиллын тухайн ойлголт
- ☐ Шийдвэрлэх асуудлыг зөв тогтоох зарчим
- ☐ Ард олны хүлээн зөвшөөрөл юм.

Тэрээр ардчилсан үзэл баримтлалд зайлшгүй шаардлагатай хүчин зүйлсийг дараах байдлаар дэлгэрүүлэн тайлбарласан юм. Үүнд:

|                                                         |                                                                      |
|---------------------------------------------------------|----------------------------------------------------------------------|
| Ардчилсан үзэл баримтлалд зайлшгүй шаардах хүчин зүйлс: | Төрийн албан хаагчдад тавигдах цэрэг, цагдаагийн байгууллагын хяналт |
|                                                         | Ардчилалд итгэх итгэл ба улс төрийн соёл                             |
| Ардчилсан үзэл баримтлалд сайнаар нөлөөлөх хүчин зүйлс: | Ардчиллын эсрэг хүчин ба хяналтгүй байдал                            |
|                                                         | Орчин үеийн зах зээл ба нийгэм                                       |
|                                                         | Соёл ба олон талт үзлийг хүлээн зөвшөөрөх байдал                     |

Ханс Ворлендер ардчиллын үзэл баримтлалыг тогтвортой хөгжүүлэхийн тулд дараах нөхцөл байдал бүрдэх ёстойг онцолж байна (포어랜드, 2023:145-147). Тухайлбал:

- ☐ Улс төрийн бүлэглэл хэт том биш- Ард олон өөр хоорондоо ойлголцож, эв нэгдэлтэй байх хэрэгтэй.
- ☐ Соёлын нэгдмэл байдал- Бусдыг өөртэйгөө адилтгах үзэл хандлага, улс төрийн эрх ашиг, ертөнцийг үзэх үзэл улс төрийн үйл ажиллагаанд муугаар нөлөөлөхгүй байх хэрэгтэй.
- ☐ Нийгэм ба эдийн засгийн тэгш бус байдал- Улс төрд ч маш муу нөлөөтэй.
- ☐ Ард олны ёс суртахууны хэм хэмжээ, чанар- Энэ нь олон нийтийн нийтлэг эрх ашгийг хамгийн түрүүнд тавих хандлага, үйл хэрэг болно.
- ☐ Ардчиллын орчин нөхцөл, сайн зохион байгуулалт тогтвортой ардчилалд шаардлагатай зүйл юм.
- ☐ Сайн дурын, ашгийн бус, хүчтэй иргэний нийгэм хэрэгтэй.

Им Хёг Бэ нь ардчилсан үзэл баримтлалыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд нэгд, ард олны оролцоогоор (participation) бүрдсэн засгийн газар, хоёрт, хариуцлагын тогтолцоо (accountability) хамгийн чухал гэжээ (임혁배, 1999:6).

Ардчилсан үзэл баримтлалыг тогтвортой хөгжүүлэхийн тулд зайлшгүй шаардах зүйлс бол олон нийт улс төрийн гол хүчин ба эзэн гэдгийг ойлгож, өөрсдийн эрх чөлөө, эрх ашгийг баталгаажуулахын тулд идэвхтэй оролцох хүсэл зорилготой байх нь чухал. Өөрсдийнхөө үнэ цэн, эрх мэдлийг мэдэхгүй, оролцохгүйгээс болж, ардчилал хөгжих боломжгүй болно. Үүний тулд эрх ашгийнхаа төлөө эвсэн нэгдэх, ардчиллын талаарх ойлголт мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх ёстой.

#### **(4) Ардчилсан үзэл баримтлалын зарчим**

Ардчилсан үзэл баримтлалыг зөв хэрэгжүүлж, хөгжүүлэх үндсэн зарчмын талаарх хүснэгт 5-аас тоймлон харна уу.

Хүснэгт 5. Ардчилсан үзэл баримтлалын үндсэн зарчмын талаарх тодорхойлолт

| Эрдэмтэд                | Үндсэн зарчим                                                                                                                                                                                                                                                                        |
|-------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Им Хёг Бэ               | Эрх чөлөөтэй олон нийт бий болгох (liberal constitutionalism)<br>Олон нийтийн оролцоо ба сонголтоор байгуулагдсан засгийн газар<br>Төлөөлөх засаг захиргааны хариуцлага(democratic accountability)<br>Төрийн албан хаагчдад ардчиллын зарчмаар хяналт тавих байдал (임혁배, 1999:7-17). |
| Жөн Вон Гюү             | Олон нийтийн эрх мэдэл<br>Олонхийн саналаар шийдвэр гаргах (정원규, 2002).                                                                                                                                                                                                              |
| И Ён Ае                 | Бүх эрх мэдэл нь олон нийтэд<br>Ердийн сонгууль<br>Олонхийн саналын дагуу шийдэх (이영애, 1990).                                                                                                                                                                                        |
| Walt Whitman            | Тэгш байдлын зарчим (the principle of equality) ба<br>Хувь хүний зарчим (the principle of individuality) (서윤교, 2018).                                                                                                                                                                |
| Ким Уан Шиг             | Ард олны эрх мэдэл, тэгш байдал, хамт олны эрх ашиг, олонхийн саналын зарчим (김왕식, 2008:38-58).                                                                                                                                                                                      |
| БНСУ-ын Боловсролын яам | Олон нийтийн эрх мэдэл<br>Олон нийтийн сайн дурын засаглал<br>Үндсэн хуулийн үзэл баримтлалын<br>Төрийн эрх мэдлийн төвлөрлийг сааруулах зарчим (교육부, 2025).                                                                                                                         |

Дээрх олон тайлбараас дүгнэвэл ардчилсан үзэл баримтлалыг тогтвортой хэрэгжүүлэх, хөгжүүлэхийн үндсэн зарчим бол олон нийтийн эрх мэдэл юм. Олон нийт өөрсдийн эрх мэдлийг чөлөөтэй, тэгш хэрэгжүүлэх нөхцөл байдлыг бүрдүүлэх бөгөөд чөлөөт сонгууль, олонхийн саналаар шийдвэрлэх зарчим чухал байна. Ардчилсан үзэл баримтлалыг зүй зохистой хэрэгжүүлэхийн тулд төрийн эрхийг зөв хуваарилах, үндсэн хуулийн эрх мэдлийн зарчим ч зайлшгүй хэрэгтэй. Дээрхээс үндэслээд ардчиллын үндсэн зарчмыг дараах дөрвөн хэсэгт ангилж байна.

Хүснэгт 6. Ардчилсан үзэл баримтлалын үндсэн зарчим

| Үндсэн зарчим                                                | Тайлбар                                    |
|--------------------------------------------------------------|--------------------------------------------|
| Олон нийтэд эрх мэдэл байдаг.                                | Ардчиллын үндсэн зарчим                    |
| Чөлөөт ба тэгш байдал                                        | Олон нийт эрх мэдлийг хэрэгжүүлэх зарчим   |
| Ардчилсан сонгууль<br>Олонхийн саналын зарчим                | Олон нийт эрх мэдлийг хэрэгжүүлэх арга зүй |
| Эрх мэдлийг хуваах зарчим<br>Үндсэн хуульд захирагдах зарчим | Ардчилал зөв хэрэгжүүлэх зарчим            |

## 2.2 Ардчилагдах үйл явцын талаарх ойлголт

Энэхүү хэсэгт ардчилагдах үйл явцын тухай онолын судалгааг (1) Тодорхойлолт, (2) Шаардлага ба учир шалтгаан, (3) Өрнөх үе шат, (4) Ардчиллын арга зам гэсэн агуулгаар авч үзье.

### (1) Ардчилагдах үйл явцын талаарх тодорхойлолт

Ардчилсан шилжилт болон ардчилагдах үйл явц хэмээх ойлголт нь ойролцоо утгатай боловч ялгаатай юм. Ардчилсан шилжилт (Democratic Transition) нь авторитар, тоталитар, цэргийн дэглэмээс ардчилсан дэглэмд богино хугацаанд шилжих улс төрийн үйл явц бөгөөд тодорхой үе шаттайгаар, ихэвчлэн улс төрийн хувьсгал, хүчтэй өөрчлөлтийн үр дүнгээс эхэлдэг онцлогтой байна. Харин ардчилагдах үйл явц (Democratization) гэдэг нь ардчилсан институт, үнэт зүйл, соёл, хэвшил зэрэг тогтвортой хөгжиж төлөвшдөг урт хугацааны үйл явц юм. Өөрөөр хэлбэл энэ нь ардчилсан тогтолцоог бэхжүүлэх, гүнзгийрүүлэх үе шат бөгөөд иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хүний эрх, шүүхийн хараат бус байдал, шударга сонгуулиар бэхжинэ.

Хүснэгт 7. Ардчилсан шилжилт, ардчилагдах үйл явц хэмээх ойлголтын харьцуулалт

| Үзүүлэлт | Ардчилсан шилжилт                   | Ардчилагдах үйл явц                                       |
|----------|-------------------------------------|-----------------------------------------------------------|
| Төрөл    | Богино хугацааны хувьсгалт өөрчлөлт | Удаан хугацааны тасралтгүй үйл явц                        |
| Төвлөрөл | Улс төрийн тогтолцоо солигдох       | Ардчиллыг гүнзгийрүүлэн тогтворжуулах                     |
| Хугацаа  | Богино хугацаанд өрнөнө             | Урт хугацаанд өрнөнө                                      |
| Жишээ    | 1990 оны Монголын хувьсгал          | Иргэний нийгмийн өсөлт, хөгжил, шүүхийн шинэчлэл гэх мэт. |

Cambridge толь бичигт "улс үндэстэн эсвэл байгууллага ардчиллын бус байдлаас ардчиллын арга замаар шийдвэр гаргахад шилжиж буй үе шат" гэсэн бол (Cambridge Dictionary, 2025) Britannica толь бичигт үзсэнээр "ардчиллын үйл явц гэдэг нь улс төрийн систем ардчилсан систем болох үйл явдал" хэмээн тайлбарласан байна (Britannica Dictionary, 2025). Харин эрдэмтэд судлаачдын авч үзсэн тодорхойлолтыг дараах хүснэгт 8-аас нэгтгэн харуулж байна.

Хүснэгт 8. Ардчилагдах үйл явцын талаарх судлаачдын тодорхойлолт

| № | Эрдэмтэд судлаачид | Судалгааны үр дүн ба тодорхойлолт                                                                                                                                        |
|---|--------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сон Ху Чон (2003)  | Авторитаризм эсвэл Фашизмтай адил нөхцөл байдлаас гарч ардчилсан системд шилжих үйл явц (손호철, 2023:3)                                                                    |
| 2 | Шин Жон Хён (1992) | Ардчилагдах гэдэг нь ардчилсан системээр өөрчлөгдөх үйл явц бөгөөд урт удаан цаг хугацаа шаардлагатай, алдаа оноо багагүйг туулах, үнэ төлөөстэй үйл явц (신정현, 1992:108) |
| 3 | Хун Дөг Пью        | Улс төрийн авторитаризм үгүй болж иргэний нийгмийн улс төрийн үр нөлөө, хүч нэмэгдэх үйл явц                                                                             |
| 4 | Ким Юун Чол (2023) | Авторитар системээс ардчилсан системд шилжих, өөрчлөгдөх үйл явц (김용철, 2023)                                                                                             |
| 5 | И Жон Чон (2021)   | Ардчилсан засаг захиргаа бий болсны дараа авторитаризм дахин бий болохгүй байх, солигдохгүй байх үйл явц (이종철, 2021)                                                     |

Ким Юун Чол нь ардчилагдах үйл явц нь гурван үе шатыг дамжин төлөвшин тогтдог хэмээжээ.

Ардчилагдах үйл явц(democratization) гэдэг нь авторитар системээс ардчилсан систем руу шилжих, өөрчлөгдөх үйл явц бөгөөд 1) ардчилсан системд шилжих, 2) ардчилал бат суурьтай тогтох, 3) ардчилал чанарын хувьд гүнзгийрэх зэрэг үйл явцаар хэрэгжинэ. Ардчилсан системд шилжих (democratic transition) гэдэг нь авторитар систем нурах, шинэ засаг захиргаа гарч ирэх, системийг бүтээх үйл явц гэжээ. Ардчилал бат суурьтай болох(democratic consolidation) гэдэг нь шинэ хууль дүрэм ба зохион байгуулалт тогтоох тогтвортой үргэлжлэх үйл явцыг хэлнэ. Ардчилал чанарын хувьд гүнзгийрэх(democratic deepening) гэдэг нь бат суурьтай тогтсон ардчилал агуулга, чанар, бодит байдлаар хэлбэржин гүнзгийрэх үйл явцыг хэлнэ.

Өөрөөр хэлбэл толь бичиг болон эрдэмтдийн тодорхойлолтыг дүгнэвэл ардчилагдах үйл явц гэдэг нь эрх мэдэлгүй аливаа нэгэн улс үндэстэн, байгууллага ард олон авторитар системээс гарч ардчилалд шилжин хөгжих үйл явцыг хэлэх бөгөөд ардчилалд шилжих, бат суурьтай тогтох, гүнзгийрэх гэсэн үе шатыг дамжин хөгждөг байна.

Жон С.Дризек (John S. Dryzek) судлаач олон эрдэмтдийн санал бодлыг нэгтгэн дүгнэж, “Ардчилсан үзэл баримтлал нь сонгуулийн өрсөлдөөн, иргэний үндсэн эрх чөлөө, хүний эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэх, хүндэтгэлтэй хэрэгжилтийн үүднээс тодорхойлогдоно” (Dryzek, 2013:3) хэмээн үзэж байна.

Харин Сеймур Мартин Липсет (Seymour Martin Lipset) нь ардчилал болон эдийн засгийн хөгжлийн хоорондын хамаарлыг авч үзээд (Seymour Martin Lipset, 2013:270) аливаа улс орон ардчиллыг үр дүнтэй хадгалан хэрэгжүүлэх боломжтой эсэх нь эдийн засгийн хөгжлийн түвшинтэй хамааралтайг баталж байна. Эртний Грекийн философич Аристотелоос эхлээд өнөөг хүртэл олон иргэд өөрсдийн амьдралд нь тодорхой хэмжээнд хяналт тавьдаг, хувь хүний оролцоо бүхий нийгэмд л ардчилал үр дүнтэй хэрэгждэг гэж үзсээр иржээ. Харин ядуурал ихтэй, боловсролгүй хүн амын эзлэх хувь өндөр нийгэмд улс төрийн үйл явцад үр ашигтайгаар оролцох, хариуцлагатай сонголт хийх иргэдийн чадвар сул байдаг тул ардчиллыг хадгалахад хүндрэлтэй хэмээн Липсет үзсэн. Түүнчлэн ядууралд өртсөн иргэдийн болон давуу эрхтэй элит хооронд хуваагдсан нийгэм нь олигарх (жижиг дээд давхаргынхны засаглал) эсвэл дарангуйлалд (олонхид суурилсан) хөтөлдөг хэмээжээ.

Лоренс Вайтхед (Laurence Whitehead) ардчиллын талаар “өргөн хүрээтэй тодорхой ойлголт хэрэгтэй бөгөөд нийгмийн урт хугацааны бүрэлдэхүүн үйл явц хэмээн үзэх нь хамгийн зөв юм” (Whitehead, 2004:6) хэмээн тайлбарласан.

Харин Жозеф Вонг (Joseph Wong) -ийн хувьд Солонгос болон Тайвань улсын ардчиллын үйл явцын ололт амжилтыг харьцуулан шинжлэхдээ дараах дүгнэлтийг хийсэн байна (Wong, 2004:173). Үүнд:

- Ардчилсан өөрчлөлт нь төрийг сэргээж, улам бүр хүчирхэг болгосон.
- Ардчиллыг зайлшгүй бий болгох шаардлага нь төрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх бөгөөд эдийн засгийн даяаршил, дарамтаас үл хамааран төрийн шинэчлэл, чадавхийг сэргээсэн.

- Шинэ тогтолцооны үр дүнд илүү их эрх мэдэлтэй болсон иргэд улс төр, бодлого боловсруулах үйл явцад оролцох боломжтой болсон.
- Ардчилсан төрийг сэргээн босгоход иргэд маш их цаг хугацаа, хүч хөдөлмөр зарцуулсны үр дүнд төр хууль ёсны засаглалыг хэрэгжүүлэхдээ иргэдийн зөвшөөрлийг авах шаардлагатай болсон. Цаашилбал, төрийн хариуцлага, иргэдийн улс төрийн оролцоо нь ардчилал оршин тогтноход зайлшгүй шаардлагатай гэсэн утгатай юм.

Нөгөө талаас ардчилал хэр чанартай байгаа асуудлыг ч хөндсөн судалгаа цөөнгүй байна. Тухайлбал Ханнес Б.Мослер (Hannes B. Mosler) нь бусад судлаачийн хамт 1987 оны ардчиллын шилжилтээс хойш Өмнөд Солонгосын ардчиллын чанарыг дараах найман хэмжигдэхүүнээр шинжилжээ (Hannes B. Mosler, 2017:305). Эдгээрт хуулийн засаглал, дээдлэх ёс; сонгуулийн хариуцлага; институт хоорондын хариуцлага; улс төрийн оролцоо; улс төрийн өрсөлдөөн; эрх чөлөө; тэгш байдал; хариу арга хэмжээ багтаж байна. Судалгааны үр дүнд:

- Өмнөд Солонгосын ардчилал эхний 10 жилийн хугацаанд (1987-1997) үндсэн сууриа тавьсан.
- 1998 онд анхны либерал ерөнхийлөгч Ким Дэ Жунг засгийн эрхэнд гарсны дараа дахин үсрэнгүй өөрчлөлт хийснээр ардчиллын чанар гүнзгийрсэн.
- 2008 онд консерватив үзэлтэй Ли Мён Пак засгийн эрхэнд гарснаас хойш ардчиллын чанар аажмаар буурч эхэлсэн.
- 2016 онд “Чой Сүн Шил”-ийн дуулиан ба ерөнхийлөгч Пак Гын Хэгийн огцролтоор оргилдоо хүрсэн гэсэн дүгнэлтийг хийжээ.

Чарльз К.Армстронг (Charles K. Armstrong)-ийн тэмдэглэснээр 1980-аад оны Солонгосын ардчилсан хөдөлгөөн, 1987 оны 6 сард онцгой нөхцөл байдал, үйл явдлаар оргилдоо хүрч, олон мянган иргэд Чун Ду Хуваны дэглэмийг эсэргүүцэн гудамжинд гарсан ба нийгмийн олон бүлэг, ажилчид, анги давхаргынхан өргөнөөр оролцож эв нэгдлийг бий болгосон юм (Armstrong, 2002:3). Оюутнууд, сэхээтэн, шашны удирдагчид авторитар дэглэмийг эсэргүүцэн жагсаалд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Дундаж давхрагын цагаан захтнууд, мэргэжлийн хүмүүс оролцож, улс төр, эдийн засгийн эрх, ялангуяа үйлдвэрчний эвлэл байгуулах эрхийг шаардаж байв.

Т, J. Lah, Yijia Jing, Peter. T. Y. Cheung нар 1970-1980-аад оныг улс төрийн хямралыг үл харгалзан эдийн засгийн өсөлт тогтвортой үргэлжилсэн үе хэмээн үнэлсэн. 1989 онд Пак Чун Хи алагдсанаар дарангуйлал эцэс болсон ч генерал Чун Ду Хван тэргүүтэй цэргийн дэглэм ардчиллын боломжийг хойш татсан (Т, J. Lah & Yijia Jing, Peter. T. Y. Cheung, 2017:62) хэмээн үзсэн билээ.

Петр Бурнелл, Лизе Ракнер (Peter Burnell and Lise Rakner) нар ардчилсан үйл явцыг үзэл баримтлалын хувьд улс төрийн либералчлал, ардчилсан шилжилт, бэхжих үйл явц хэмээн хувааж болох ч зайлшгүй шаардлагатай юмуу эмх цэгцтэй дараалал байхгүй хэмээн тайлбарласан (Peter Burnell & Lise Rakner, 2014:211). Түүнчлэн Поул Э.Зигмунд (Poul E. Sigmund) ардчилал дахь Католик сүмийн оролцоог Латин Америкийн жишээнээс иш татан “Ядуу хүмүүс чамтай хамт байна (Матай 26:11), бүх эрх мэдэл Бурханаас тогтоогдсон (Ром 26:11)

хэмээх уламжлалт авторитар үзлийг хамгаалахаас илүүтэйгээр консерватизмаас эхлээд либерализм, радикал зэрэг улс төрийн үзэлд шашныг хууль ёсны болгож өгсөн” (Poul E. Sigmund, 1993:354) гэжээ.

## (2) Ардчилагдах үйл явц бий болох нөхцөл байдал, учир шалтгаан

Ардчилагдах үйл явц нь ямар нөхцөл байдал, учир шалтгаантай бий болдог вэ? Ямар нэгэн улс төрийн хүчин, систем тийм ч амархан нурж унадаггүй байна. Ялангуяа нэг хүн эсвэл нэг намын дарангуйлал, авторитаризмаас ардчилалд шилжих үйл явц нь ямар ч учир шалтгаангүйгээр бий болдоггүй юм. Ардчилагдах үйл явц бий болохын тулд зайлшгүй урьдач нөхцөл байдал, учир шалтгаан байдаг гэж эрдэмтэд үздэг. Тухайлбал Сон Хо Чол нь эдийн засгийн, нийгмийн, соёлын, олон улсын гэсэн дөрвөн үндсэн нөхцөл байдал бүрдсэн байх ёстойг онцолсон юм (손호철, 2003:110-117).

Хүснэгт 9. Ардчилагдах үйл явц бий болох нөхцөл байдал - 1

| Ардчилагдах үйл явц бий болох нөхцөл байдал | Тайлбар                                                                                                                                                                               |
|---------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Эдийн засгийн                               | - Эдийн засгийн хөгжил улс төр, нийгмийн өөрчлөлт шинэчлэлийг шаарддаг.<br>- Эдийн засгийн хөгжил нийгмийн давхаргыг өөрчилдөг.<br>- Эдийн засгийн хөгжил авторитаризмыг эсэргүүцдэг. |
| Нийгмийн                                    | - Нийгмийн дундаж давхарга бий болдог.<br>- Нийгмийн давхарга эвсэн нэгдэх, хамтрах байдал бий болно.<br>- Олон нийтийн сайн дурын хөдөлгөөн, хариуцлага бий болно.                   |
| Оролцооны соёлын                            | - Төрийн үйлчилгээ ба бодлогыг хянах<br>- Улс төрийг шинэчлэх хүсэл зорилготой болох<br>- Ард олон улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох                                        |
| Олон улсын                                  | - Нэгэн улс үндэстний ардчилагдах үйл явц хөрш, ойр байрлах улс үндэстэнд нөлөөлөх<br>- Зам тээвэр, харилцаа холбооны хөгжил                                                          |

И Жон Чол нь улс төрийн дарангуйлал унаж ардчилагдах үйл явц бий болох учир шалтгааныг эрх баригч хүчин болон сөрөг хүчний харилцаа холбоогоор тайлбарлаж байна. Хоёр гол хүчний нөхцөл байдал, хүч нөлөө хэр байгаагаас ардчилагдах үйл явц өөр байдаг хэмээн үзсэн юм. Тэрээр улс төрийн дарангуйлал нь сөрөг хүчний нөхцөл байдал, хүч нөлөө, эвсэн нэгдэх байдлаас болж тайван ардчилалд шилжих эсвэл хүнд ширүүн маргаан тэмцэл болж болно. Үүний үр дүнд дараах нөхцөл байдал бүрдэх магадлалтай гэжээ (이종철, 2021). Тухайлбал:

- ☐ Сөрөг хүчин сул дорой, эрх баригчид эв нэгдэлгүй байвал улс төрийн дарангуйлал унахгүй.
- ☐ Сөрөг хүчин хүчтэй эвсэн нэгдсэн, эрх баригчдын хагарал их байвал улс төрийн дарангуйлал унаж, ардчилагдах үйл явцад шилжих боломжтой.
- ☐ Сөрөг хүчин ч хүчтэй түүнчлэн эрх баригчид ч эвсэн нэгдэж хүчтэй байвал улс төрийн нөхцөл ширүүсэх, хүнд байдал үүсэж болно.

Ардчилагдах үйл явц бий болох талаар Серенсон (Georg Serensen) мөн авч үзсэн бөгөөд дараах учир шалтгаан байдаг хэмээн тайлбарласан юм (쇼렌센, 1994:64-67).

- ☐ Орчин үежих, эд баялагийн өсөлт нь ардчилалд байнга эерэгээр нөлөөлдөг.
- ☐ Улс төрийн үйл ажиллагааны үнэ цэн ба зорилго бол улс төрийн соёлыг бий болгоно.
- ☐ Нийгмийн бүтэц буюу нийгмийн давхраажилт
- ☐ Гадны нөлөө буюу улс төр, эдийн засаг, үзэл бодол зэрэг нь зөвхөн нэг улс үндэстэнд бус олон улсын харилцаанд нөлөөлдөг гэжээ.

Харин Ким Тэ Люун-аар БНСУ-ын ардчилагдах үйл явцад хамгийн их нөлөөлсөн таван учир шалтгаан байна (김태룡, 2010) хэмээн үзжээ. Үүнд:

- ☐ Эдийн засгийн өсөлт, эд баялаг, орлого нэмэгдэх;
- ☐ Нийгмийн дундаж давхарга өсөх;
- ☐ Иргэний нийгэм хүчирхэгжих;
- ☐ Соёл тогтох;
- ☐ Олон улсын нөлөө(foreign intervention) зэрэг юм.

Ийнхүү дотоодод улс төр, нийгэм, эдийн засгийн олон учир шалтгааныг бүрдүүлснээр ардчилагдах үйл явц бодит биелэл болдог юм. Гадаад орчны нөлөө ч ардчилагдах үйл явц бий болоход зайлшгүй нөлөөлдөг чухал учир шалтгаан билээ.

Улс төрийн талаасаа ардчилсан хүчин эвсэн нэгдсэнээр хүчтэй болох, олон нийт хүсэл зорилготой, оролцооны соёлтой байх ёстой. Эдийн засгийн талаасаа ард олны орлого нэмэгдэж, нийгмийн дундаж давхарга бий болох, хүрээгээ тэлэх хэрэгтэй. Нийгмийн талаасаа олон нийт сайн дураараа эвсэн нэгдэж иргэний нийгэм байгуулж, нийтийн эрх ашгийн төлөө тэмцэх хэрэгтэй болно. Эцэст нь гадаад нөлөө буюу олон улсын туслалцаа дэмжлэг, оролцоо ч хэрэгтэй гэдгийг дээр дурьдсан билээ.

### **(3) Ардчилагдах үйл явц өрнөх үе шат**

Авторитар улс төрийн систем нурж, ардчилалд шилжих үе шат нь нэгд, шилжих, хоёрт, бат суурьтай тогтох, гуравт, чанар дээшилж гүнзгийрэх үе шатыг дамждаг болохыг дээр өгүүлсэн. Ардчилалд шилжих гэдэг нь авторитар дэглэм нуран унаснаар нийгэм эдийн засаг, улс төрийн систем өөрчлөгдөх, ардчилал бат суурьтай тогтох гэдэг нь шинэ систем тогтвортой хөгжих үйл явц болохыг дахин дурьдаж байна.

Хон Дөг Пью нь ардчилагдах үйл явцыг хэлбэр талаас нь систем бат суурьтай тогтох, агуулгийн талаасаа чанар дээшлэх явдал хэмээн дараах тайлбар өгч байна (홍득표, 1996:311).

Систем бат суурьтай тогтох нь ① Авторитаризмын гол хүчин болох цэргийн дарангуйлал үгүй болох ② Ардчилсан засгийн газар байгуулагдах ③ Эрх баригч нам болон сөрөг хүчний хооронд эрх мэдлийг энх тайвнаар шилжүүлэх ④ Үргэлжлэн эрх баригч нам болон сөрөг хүчний хооронд улс төрийн эрх мэдэл солигдох зэргээр ардчилагдах үйл явц нь тайван тогтвортой явагдах ёстой.

Ардчиллын чанар дээшлэх гэдэг нь ① Авторитаризм үгүй болох ② Хуулиар захирах зарчим бат суурьтай тогтох ③ Иргэний нийгмийн эрх чөлөө ба идэвхтэй байдал нэмэгдэх үйл явц юм.

Ким Ён Тэ судлаачийн үзэж буйгаар ардчилагдах үйл явцыг ардчилалд шилжих, бат тогтох үе шат хэмээн ангилж, энэ нь ардчилсан бус засгийн газрыг хөөн гаргахаас эхэлж байна. Өөрөөр хэлбэл ардчилал бат тогтох нь ардчиллыг бүрэн агуулгаар байгуулах үе шат мөн. Авторитар засаг захиргаа нуран унах, шинэ засгийн газар байгуулж, ардчиллыг бүх салбарт гүнзгийрүүлэх, улмаар системтэй болсноор бат тогтоно гэжээ (김영태, 2008:238-239).

Линз (J. Linz) ба Альфред Степан (Alfred C. Stepan) нь ардчиллыг бат суурьтай тогтоохын тулд:

- . Иргэний нийгмийн талбарт: эвсэн нэгдэх ба харилцаа холбоо байгуулах эрх чөлөө
- . Улс төрийн талбарт: Чөлөөт сонгууль
- . Хуулийн талбарт: Үндсэн хуулийн зарчим
- . Улс үндэстний нөхцөл байдал: Хууль, төрийн албан хаагчдын шударга зарчим
- . Эдийн засгийн талбарт: Чөлөөт зах зээл гэсэн чухал зүйл бий болох ёстой (J. 린즈 & A.드테판) хэмээн тайлбарласан нь бий.

Шин Жон Хён нь ардчилагдах үйл явц нь улс үндэстний онцлог нөхцөл байдлаас хамааран ялгаатай боловч нэгд, улс төрийн эрх мэдлийг хуваах байдал хоёрт, сонгуулийн систем батлагдах гуравт, хоёроос илүү улс төрийн намтай дөрөвт, улс төрийн соёл бий болох зэрэг нь чухал нөлөөтэйг онцолж байна (신정현, 1992:120-123).

Ийнхүү ардчилагдах үйл явцыг шилжих болон бат суурьтай тогтох гэсэн хоёр агуулгаар тайлбарлаж байна. Тодруулбал, авторитар засгийн газар, дэглэм нуран үгүй болж шинэ ардчилсан засгийн газар байгуулагдаж шилждэг бол ардчилал бат тогтох нь шинээр байгуулагдсан засгийн газар тогтвортой өсөн хөгжих үйл явц бөгөөд урт удаан цаг хугацааг шаарддаг. Энэ цаг хугацаанд олон алдаа дутагдал, шийдвэрлэх асуудал, хүнд нөхцөл байдал тохиолдох ч даван туулах ёстой болно. Харамсалтай нь ардчилалд шилжсэн боловч авторитар дэглэмд эргэж буцах улс үндэстэн ч цөөнгүй байгаа билээ.

#### **(4) Ардчилагдах үйл явц, арга зам**

Ардчилагдах үйл явц амжилттай хэрэгжихэд авторитар дэглэм буюу ардчиллын үзэл баримтлалгүй засаг захиргаа нь нурж, шинэ үзэл баримтлалтай засаг захиргаа гарч ирэх олон арга зам байдаг.

Ким Ён Тэ нь бусад судлаачдын үзэлд тулгуурлан ардчилагдах үйл явц, арга замыг ардчиллын тэмцлийг удирдах гол хүчин болон тэдний ашиглах стратегитай холбон дараах тайлбар өгч байна (김영태, 2008:240).

- . Авторитар засаг захиргаа нуран ардчилалд шилжих явдлыг Самуэл Хантингтон (Samuel Huntington) нь “Өөрчлөгдөх(replacement)”, S. Mainwaring нь “Нуран унах (breakdown, collapse)”

- . Авторитар засаг захиргааны дотор шинэчлэлийн бүлэг бий болж ардчилалд шилжих явдлыг Самуэл Хантингтон “Солигдох(transformation)”, Майнворинг (S. Mainwaring) нь “тохиролцох(transaction)”
- . Авторитар засаг захиргаа ба эсрэг ардчиллын хүчин хоорондын харилцан зөвшөөрч ардчилалд шилжих явдлыг Самуэл Хантингтон “Солих(transplacement)”, Майнворинг “Гарах(extrication)” хэмээн тус тус тайлбарлажээ.

Шин Жон Хён нь дэлхийн гуравдагч орны жишээгээр ардчилагдах үйл явц бий болох хоёр арга замын талаар танилцуулсан. Үүнд:

- . Радикал арга буюу хувьсгал, цэргийн эргэлт зэрэг хүчирхийлэл ашиглаж тайван бус аргаар систем нуран унах- Энэ үед хуучин засаг захиргаа маш хурдан унаж, шинэ засаг захиргаагаар солигддог.
- . Ардчилагдах үйл явц удаан үргэлжлэх арга буюу эрх баригч хүчин ард олны санаа бодол, эсэргүүцлийг хүлээн зөвшөөрч өөрөө өөрийгөө шинэчлэх зам- Энэ нь эрх баригчид доороос гарсан эсэргүүцэл тэмцлийг хүлээж авснаар шинэчлэгдэх явдал (신정현, 1992:119) юм.

Хон Дөн Пью нь ардчилагдах үйл явцыг удирдах хүчин ба гол субъектийг иргэний нийгэм хэмээн үзээд таван арга замын тухай дараах тайлбарыг хийсэн байна (홍득표, 1996:312). Үүнд дээрээс нь удирдах хувьсгал, нийгмийн хувьсгал, улс төрийн шинэчлэл, доороос шинэчлэх, харилцан тохиролцох гэх мэт аргуудын дурьдаж болно.

Хүснэгт 10. Ардчилагдах үйл явц бий болох нөхцөл байдал - 2

| Ардчилагдах үйл явц, арга зам | Утга                                                                                                                                                   |
|-------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Дээрээс нь удирдах хувьсгал   | Эрх баригчид иргэний нийгмийг эсэргүүцэж, ардчиллыг өөрсдийн зорилгоор шууд хэрэгжүүлэх                                                                |
| Нийгмийн хувьсгал             | Эрх баригчид иргэний нийгэм ба олон нийтийн шаардлагыг цэрэг, цагдаагийн хүчээр дарсанаас болж эсэргүүцэл, тэмцэл улам хүчтэй өрнөн ардчилал бий болох |
| Улс төрийн шинэчлэл           | Эрх баригчдын ардчиллын төлөөх хүсэл зорилгыг иргэний нийгэм, олон нийт хүлээн зөвшөөрөх нь хуучин эрх баригчдад ашигтай байх                          |
| Доороос нь шинэчлэх           | Иргэний нийгэм ба ард олны хүсэл зорилгыг эрх баригчид бүрэн хүлээн зөвшөөрөх арга                                                                     |
| Харилцан тохиролцох           | Ардчилагдах үйл явцад эрх баригчид ба иргэний нийгэм харилцан тохиролцох, иргэний нийгмийн хүслийн дагуу замнах                                        |

Ардчилагдах үйл явц нь улс үндэстний онцлог нөхцөл байдлаас шалтгаалж олон арга замаар хэрэгжиж болно. Зарим нь амар тайван удаан үргэлжлэх замаар, зарим нь радикал буюу хүчирхийллийн замаар маш хурдацтай явагдана. Түүнчлэн хуучин эрх баригчдын байр сууриас шалтгаалан дээрээс эсвэл доороосоо ч өөрчлөгдөж болно. Бас хуучин эрх баригчид болон шинэ хүчнүүд харилцан тохиролцож ардчиллын замаар замнах хэлбэр байгааг хүснэгтээс харж болно. Ийнхүү олон арга замаар хэрэгжиж жинхэнэ утгаараа ардчилалд шилждэг байна.

## **2.3 Ардчилсан хөдөлгөөний талаарх ойлголт**

Олон нийт өөрсдөө улс төрийн гол хүчин болж эрх ашиг, тэгш байдал, эрх чөлөө зэрэг үнэ цэнийг хүлээн авч, хуулийн дагуу шударгаар эрх мэдлийг хэрэгжүүлэх нь ардчилсан үзэл баримтлалын илрэл юм. Энэ эрх ашгийг хязгаарладаг авторитар дэглэмийг унагаж, ардчилсан үзэл баримтлалыг сэргээх үйл явцыг ардчилагдах хэмээн үздэг байна. Ардчилагдах үйл явцыг бодитой болгохын тулд тэд хүчээ нэгтгэж, хөдөлгөөнийг үүсгэдэг. Ардчилсан үзэл баримтлал ба үйл явц, хөдөлгөөн гурав хоорондоо шууд холбоотой чухал ач холбогдолтой гэдгийг анхаарах нь зүйтэй.

Иймээс энэ хэсэгт ардчилсан хөдөлгөөний талаарх тодорхойлолт, түүх, үүсэн бий болох учир шалтгааны тухай авч үзье.

### **(1) Ардчилсан хөдөлгөөний талаарх тодорхойлолт**

Ардчилсан хөдөлгөөн гэж юу вэ? Энэ нь ардчиллыг бүтээн байгуулахын тулд бүх систем, засаг захиргааны бүхий л эд эсийг ардчиллын үзэл баримтлалаар өөрчлөх хөдөлгөөн, үйл ажиллагаа юм (손호철, 2023:3). Шинь Мён Сүн судлаачийн үзсэнээр зөвхөн улс төрийг авторитаризмаас салгах төдийгүй нийгмийн бүхий л бүтцэд үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор тэмцэж буй хөдөлгөөнийг хэлдэг (신명순, 2016). Хөдөлгөөн бол улс үндэстэнд ардчилсан үзэл баримтлалыг бүтээж хөгжүүлэх бүх хүчин чармайлт хэмээн үзэж болно. Өөрөөр хэлбэл зөвхөн дарангуйлал, авторитаризмтай тэмцэх бус эдийн засаг, нийгмийн бүх салбарт ардчиллын зарчмыг хэрэгжүүлэхийн төлөөх бүхий л хөдөлгөөн багтана. Тухайлбал БНСУ-ын ардчилсан хөдөлгөөн авторитар засаглал, дарангуйллын эсрэг хөдөлгөөн төдийгүй ард олны эрх чөлөө, эрх ашгийг хамгаалах бүх үйл ажиллагаа мөн хэмээн И Ён Жэ судлаач онцолж байна (이영제, 2021).

2019 оны 5.18-ны өдөр БНСУ-ын их хурлаас баталсан “Ардчилсан хөдөлгөөнд оролцсон хүмүүсийн нэр алдрыг сэргээх, нөхөн төлбөр олгох тухай хууль” -ийн 2.1-т "Ардчилсан хөдөлгөөн гэдэг нь 1964 оны 3.24-ны өдрөөс хойш чөлөөт ардчиллын үндсэн ёс журмыг алдуулж, үндсэн хуульд олгосон олон нийтийн эрх ашгийг хязгаарласан авторитар засаглалын эсрэг үйл ажиллагаа бөгөөд ардчиллыг тогтооход хувь нэмэр оруулж эрх чөлөө, эрх ашгийг сэргээн хамгаалсан бүхий л үйл ажиллагаа мөн" хэмээн заажээ (국가법령정보센터, <https://www.law.go.kr/>, 2024).

Дээрх тодорхойлолтоос дүгнэж үзвэл ардчилсан хөдөлгөөн гэдэг нь ард олны эрх чөлөө, эрх ашгийг дээдэлдэггүй, дарангуйллын засаг захиргаатай тэмцэж ардчилсан үзэл баримтлалыг бүтээн байгуулахын төлөөх хувь хүн, байгууллагын бүхий л тэмцэл үйл ажиллагааг хэлж байна.

### **(2) Ардчилсан хөдөлгөөний түүх**

Дэлхий даяар өргөн хүрээтэй өрнөсөн ардчилсан хөдөлгөөний түүхийг судлах нь тийм ч амар бус бөгөөд энэ талаар эрдэмтэн судлаачдын олон үзэл, тайлбар байдаг. Ерөнхийдөө хүн төрөлхтний түүхэнд ардчилсан хөдөлгөөн 17-р зууны үед Английн хувьсгалаас эхэлж улмаар Франц, Германд өрнөж өнөөдрийг хүртэл үргэлжилж байна.

Ган Жон Ин-ий үзэж буйгаар Английн ардчилал 17-р зууны сүүлээр гарсан “Нэр алдрын

хувьсгал(Glorious Revolution)”-аас эхэлсэн уламжлалт үзэл санаа байсан. Улмаар 19-р зууны сүүл 20-р зууны эхэнд Англи, Франц, Германд өрнөсөн ардчилал ялгаатай байв. Английн ардчиллыг Либерализм, Франц улсыг бүгд найрамдах үзэл санаагаар удирдан хөтөлдөг байсан юм. Харин Герман улсад өрнөсөн ардчилал Англи, Франц улсаас сул, социализм чухал үүрэг гүйцэтгэж байсан билээ (강정인 & 외 3인, 2010:12-39).

Түүнчлэн С.Хантингтон нь ардчиллын үзэл баримтлал баруунаас 17-р зууны эхэнд бий болсон бөгөөд үүний дараа гурван ч том давалгаа үүссэн гэж үздэг байна. Түүнийхээр эхний давалгаа 1828-1926 он, удаах давалгаа 1943-1962 он, гурав дахь давалгаа 1974 оноос хойших цаг үеийг хамарч байна (사무엘 헌팅턴, 2011:149).

#### Хүснэгт 11. Ардчиллын гурван давалгаа

| Давалгаа     | Он         | Үүссэн байдал              | Ардчиллын зарчим ба нөхцөл                                                                                                                                                    |
|--------------|------------|----------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1-р давалгаа | 1828-1926  | Америк, Францын хувьсгал   | - Насанд хүрсэн хүний 50 хувь нь сонгуульд оролцох эрх мэдэлтэй болсон<br>- Олонхийн саналаар сонгогдсон их хурал<br>- Тогтмол явагдах сонгуулиар засаг захиргаа байгуулагдах |
| 2-р давалгаа | 1943-1962  | Дэлхийн 2-р дайн ба дараах | - Барууны колони төгссөн<br>- Олон улс ардчиллын системтэй болсон<br>- Зарим улсад ардчилал тогтсон                                                                           |
| 3-р давалгаа | 1974- хойш | Португал улсын ардчилал    | - Европ, Ази, Латин америкт 30 орчим улс ардчилалд шилжсэн.<br>- Ардчилсан хөдөлгөөн дэлхий дахинд өрнөх                                                                      |

С.Хантингтон “Freedom House”-аас гаргасан судалгаанд үндэслэн дэлхий даяар ардчилсан хөдөлгөөн хэрхэн өрнөсөн талаар тайлбарлажээ (사무엘 헌팅턴, 2011:149). Тэрээр ардчилсан хөдөлгөөн дэлхий дахинаа энгийн үзэгдэл болсон гэдгийг онцолсон бөгөөд Өмнөд Европт 15 жилийн туршид өрнөж, Латин Америкаар хүчтэй шуурга шиг дэгдэж, Ази тивд нэвтэрсэн төдийгүй хуучин коммунист системийг нураасан гэжээ. 1974 онд Латин Америкийн арван улсаас найм нь ардчилсан бус байсан бол 1990 онд есөн улс нь ардчилсан зарчмаар сонгогдсон засгийн газартай болсон байна. Харин “Freedom House”-аас гаргасан судалгаанаас үзвэл 1973 онд дэлхийн хүн амын 32 хувь нь чөлөөт улсад амьдарч байсан бол 1976 онд 20 хувиар багассан үзүүлэлттэй байжээ. Харин 1990 оноос дэлхийн хүн амын 38 хувь нь чөлөөт ардчилсан улсад амьдарч байна.

Үүний зэрэгцээ Клаус Вон Байме (Klaus Von Beyme) ч “Ардчиллын давалгаа” хэмээн үгийг ашигладаг ба дэлхийд ардчиллын дөрвөн том давалгааны түүх байсан гэж үздэг. Түүний авч үзсэн ардчиллын дөрвөн давалгааны талаар танилцуулбал (클라우스 폰 바이메, 2000:12-14).

| Давалгаа     | Нөхцөл байдал ба улс                                                                                                                                                                                                      |
|--------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1-р давалгаа | - Дэлхийн 1-р дайны дараа<br>- Улс орнууд бүгд найрамдах болж шинэчлэгдсэн. (Герман, Австри, Финлянд, Испани зэрэг)<br>- Хууль дээдлэх зарчим, чөлөөт сонгууль - Герман, Олон үндэстнээс бүрдсэн улс задрах - Орос, Унгар |
| 2-р давалгаа | - 1945 оны дэлхийн 2-р дайны дараа<br>- Фашизм ялагдаж ардчиллын үзэл баримтлал сэргэсэн.<br>- Ялагдсан Герман, Япон улс ардчилсан болох шаардлага үүссэн.                                                                |
| 3-р давалгаа | - Өмнөд Европ ба Латин Америк<br>- Хүчтэй өрнөөгүй, дайны үр дүн бус<br>- Гадаад нөлөөгүйгээр ардчилсан улс болсон.                                                                                                       |
| 4-р давалгаа | - Зүүн Европын коммунист улс нурсан.<br>- Улс төр ба эдийн засаг хамт шинэчлэгдсэн<br>- Ардчилал хөгжих магадлалтай.                                                                                                      |

Ардчилсан хөдөлгөөний хамгийн хүчтэй нөлөөтэй давалгаа нь 1980 оны сүүлийн үеэс 1990 оны эхэнд хуучин ЗХУ тэргүүтэй Зүүн Европ, Дундад Ази, Зүүн Хойд Азийн коммунист улс орнуудыг хамарч нэг нам, нэг хүний дарангуйлал, авторитар системийг нураасан юм. Үүгээр 30-аад улс орон ардчиллын үзэл баримтлал, зах зээлийн системд шилжиж, иргэний нийгмийн байгууллаар замнах болсон билээ.

Дэлхий даяар өрнөсөн ардчилсан хөдөлгөөний давалгаа 2000 оны үеэс ч хойш үргэлжилсээр байна. 2010 онд Африкийн Тунис улсад “Жесминий хувьсгал” болсон ба түүний дараа Африк болон Баруун Азид ч хүчтэй дэлгэрсэн юм. Гэвч Африк, Баруун Азид өрнөсөн давалгаа нь ихэнхдээ амжилтгүй болж байгаа ч өнөөг хүртэл үргэлжилж байна.

### (3) Ардчилсан хөдөлгөөн бий болох шалтгаан

Ардчилсан хөдөлгөөн бий болоход улс орны дотоод улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал төдийгүй гадаад шалтгаан ч нөлөөтэй байдаг. Тухайлбал С.Хантингтон 1970-1980 оны үед авторитар засаглал нуран унаж, хүч сулрахад олон шалтгаан байсныг дараах байдлаар тайлбарлаж байна (사무엘 헌팅턴, 2011:149). Үүнд:

- ☐ Дэлхий даяар олон улс үндэстний дунд ардчиллын үзэл баримтлал өрнөсөн.
- ☐ Нэг намын дарангуйлал, авторитаризмын үзэл суртал үндэс суурьгүй болсон.
- ☐ Цэргийн хүч болон төрийн эрх мэдэл хүч суларсан.
- ☐ Нефтийн үнэ ханш унаж, коммунист улс орнуудын эдийн засгийн бодлого үр дүнгүй болсноор хямрал бий болсон.
- ☐ Эдийн засгийн өсөлт нь нийгэмд шууд нөлөөлж, ард олны оролцоог нэмэгдүүлсэн.
- ☐ Авторитар эрх баригчдын доторх хагарал ихэссэн.
- ☐ Бусад улс үндэстний авторитар засаглал унасан нь нөлөөлсөн.

Энэ талаар судлаачдын үзэл баримтлал ялгаатай байх бөгөөд Шин Мён Сүн-ий үзсэнээр ардчилсан хөдөлгөөн бий болж авторитар засаглал нуран унах шалтгаан нь нэгд, эдийн

засгийн уналт ба хямрал, хоёрт, ард олны улс төрийн оролцоо нэмэгдэх, гуравт, эрх баригчдын доторх хагарал хэмээн дүгнэж эдгээрийн учир шалтгааны холбоог тайлбарласан байна (신명순, 2016:32-33). Тухайбал авторитар систем нь дээрх гурван шалтгааны аль нэгээс нь хамаарч унахгүй харин бүгд бүрэлдэж бий болоход ардчилсан хөдөлгөөн бий болдог гэжээ. Эдийн засгийн хямрал нүүрлэх нь олон нийтийн улс төрийн оролцоог нэмэгдүүлж, эрх баригчдыг зөрчилдөөнд хүргэдэг юм. Түүгээр зогсохгүй нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэхийн төлөөх тэдний эсэргүүцлийг идэвхижүүлэх ба асуудлыг хэрхэн шийдэх талаар эрх баригчдын хагарал үүсэх нөхцөл бий болно. Ийнхүү эдийн засгийн хямрал, нийгмийн асуудал эрх баригчдын дотоод хагарал зөрчлийн шалтгаан болдог. Дээрх гурван шалтгаан нь өөр хоорондоо уялдан холбогдож тус бүрийн нөхцөл байдлаас хамаарч өөр өөр үр дүнг бий болгоно гэжээ.

Цааш нь Ким Жин Баруун Азийн жишээгээр улс төр, эдийн засаг, нийгэм, цэргийн хэмээн шалтгааныг судалж дараах тайлбар өгчээ (김진, 2015). Тухайлбал:

- . Улс төрийн шалтгаан: Урт удаан төрийн эрх барьсан авторитар засаглал авилгыг хөгжүүлж, шударга бус байдал, хүний эрхийг хязгаарлан боомилсон.
- . Эдийн засгийн шалтгаан: Ажилгүйдэл, хоол хүнсний хомсдол, ядуурал, хямрал газар авсан.
- . Нийгмийн шалтгаан: Нийгмийн сүлжээ (SNS)-гээр дамжуулж мэдээ мэдээлэл хурдтай тараагдах болсон.
- . Цэргийн шалтгаан: Цэргийн байгууллага улс төрд оролцохгүй байдал

Дээрхээс харвал хөдөлгөөн үүсэх шалтгаан нь ард олны эрх чөлөө, эрх ашгийг урт удаан хугацаанд хязгаарлан авторитар засаглал дарангуйлах явдал юм. Нөгөө талаас улс төр, эдийн засаг, нийгэм, цэрэг, соёл зэрэг маш олон хүчин зүйлтэй холбоотой байна. Иймээс ардчилсан хөдөлгөөн аливаа нэгэн асуудлаас бус олон шалтгаантай холбоотойгоор бий болохоос аргагүй нөхцөл байдал бүрддэг юм.

### **Бүлгийн дүгнэлт**

Энэ бүлэгт хийгдсэн онолын судалгааг дүгнэвэл, хүн төрөлхтний сэтгэлгээний эх өлгий гэгдэх Эртний үеийн сэтгэгчдээс эхлээд өнөөг хүртэл ардчиллын утга учир, хөгжил, шилжилтээс эхлээд батжин бэхжих хүртэл бүх үе шат үйл явцын талаар судалсаар иржээ. Ардчилал хэмээх үзэгдэл нь ардчилсан хөдөлгөөн, үзэл баримтлалын үрээр бие биедээ нөлөөлж, цааш тэлж нийгмийн бүхий л эд эсэд шингэснээр биелэлээ олдог байна. Судлаач Сонь Хо Чолийн үзсэнээр ардчиллыг ойлгохын тулд ардчилсан үзэл баримтлал, ардчилсан хөдөлгөөн, ардчилагдах үйл явцын холбоо хамаарлыг тодорхойлох нь чухал юм. Судлаачдын тодорхойлолтыг нэгтгэвэл ардчилал гэдэг нь ард түмэн засаглах, ард түмэнд эрх мэдэл, хуулиар захирах, өөрөөр хэлбэл энд олонхийн саналаар захирах зарчим үйлчилж, бүх ард түмний хариуцлагыг онцолдог, хууль дүрмийг бат сахьдаг, хүний эрхийг хүндэтгэн дээдлэх систем юм.

Түүхэн цаг үеийн туршид эрдэмтдийн үзэж буйгаар ардчиллын үзэл баримтлал нь дөрөв хүртэлх үеийг туулсан бөгөөд хүн төрөлхтөн энэ дэлхийд оршин амьдрах болсон цагаас эхэлсэн хэмээн судлаачид үзэж байна. Ард олон шууд захирах эрх мэдлийг хэрэгжүүлсэн ардчилал М.Э.Ө 5-р зууны Грекийн Афин хоттой холбоотой ба хүний эрх, эрх чөлөө, үнэ

цэн, ард олны эрх ашгаар түүхийн явцад дахин сэргээгдэж бүх үндэстний дунд хөгжиж байна. Энэ бүлэгт авч үзсэн гол ойлголтын нэг нь ардчилагдах үйл явц бөгөөд онол, учир шалтгааны тайлбарлал, үе шат олон арга зам талаасаа өргөн судлагджээ. Ерөнхийдөө ардчилагдах үйл явц нь авторитар системээс ардчилсан системд шилжих үйл явц болохыг Сон Ху Чон, Шин Жон Хён, Хун Дөг, Пью, Ким Юун Чол, И Жон, Чон судлаачдын бүтээлээс харж болно. Ардчилагдах үйл явцад эдийн засгийн хөгжил бол хамгийн чухал нөлөөтэй байна. Энэ ардчилал ба эдийн засгийн хоорондын хамаарлыг авч үзсэн судалгаа бүтээлүүдэд өгүүлэхдээ ардчиллыг үр дүнтэй хэрэгжүүлэх, хадгалах боломжтой эсэх нь эдийн засгийн хөгжлөөс хамаардаг, тэр дундаа иргэд өөрсдийн амьдралдаа хяналт тавьдаг хувь хүний оролцоо бүхий нийгэмд л ардчилал амжилттай хэрэгждэг гэжээ. Ядуурал ихтэй, боловсролгүй хүн амын эзлэх хувь өндөр нийгэмд ардчиллын мэдрэмж, улс төрд ашигтайгаар оролцох, хариуцлагын сонголт хийх чадвар сул байх тул ардчиллыг хадгалахад хүндрэлтэй байдаг байна.

Ардчилагдах үйл явц нь нэгд, эрх баригчид иргэний нийгмийг эсэргүүцэж, өөрсдөө зорилгод нийцүүлэн ардчиллыг хэрэгжүүлэх, хоёрт, иргэний нийгэм олон нийтийн шаардлагыг цэрэг, цагдаагийн хүчээр дарж улмаар эсэргүүцсэн тэмцлийн үр дүнд, гуравт, улс төрийн шинэчлэл хийх, дөрөвт, иргэний нийгэм, ард олны хүсэл зоригийг бүрэн хүлээн зөвшөөрөх, тавд харилцан тохиролцох гэсэн арга замаар хэрэгжүүлдэг. Олон улс орнуудад ардчилагдах үйл явцад олон нийтийн хөдөлгөөн маш чухал үүрэг гүйцэтгэсэн байх ба энэ нь улс үндэстэнд ардчиллын үзэл баримтлалыг бүтээн хөгжүүлэх бүхий л хүчин чармайлт хэмээн үзжээ. Дэлхий даяар өргөн хүрээтэй өрнөсөн ардчиллын төлөөх хөдөлгөөний түүх нь арвин их бөгөөд Америк Францын хувьсгалаас эхлээд коммунизм нуран унах хүртэл нийт дөрвөн том давалгааг үүсгэсэн байна. Ардчилсан хөдөлгөөн нь ардчилалд шилжих, түүнийг бэхжүүлэх, хөгжүүлэхэд хамгийн чухал нөлөөтэй үзэгдэл болохыг энэхүү бүлэгт авч үзлээ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.

### БНСУ-ЫН АРДЧИЛЛЫН ТУХАЙ СУДАЛГАА

Өмнөх бүлэгт ардчилсан үзэл баримтлал, үйл явц, хөдөлгөөний талаарх онолын судалгаатай танилцсан бол энэхүү бүлэгт БНСУ-ын ардчиллын талаар авч үзье. Судалгааг (1) ардчиллын түүх (2) ардчилагдах үйл явц, бат тогтох байдал (3) ардчилалд тэргүүлэх хүч (4) ардчиллын ирээдүй гэсэн агуулгаар судлах болно.

#### 3.1 БНСУ-ын ардчиллын түүх

1. 1945 оны 8 сарын 15-ний өдөрт Япон улс мөхсөнөөр дэлхийн 2-р дайн дуусаж, Японы колони байсан БНСУ чөлөөлөгдөн түүхийн шинэ үеийн үүд хаалга нээгдсэн юм. Эрх чөлөөт улс үндэстэн болсноос хойш өнөөг хүртэл ардчиллын төлөөх түүхийг бүтээжээ хэмээн хэлж болохоор. Өнгөрсөн 80 жилийн турш маш олон удаа дайн тулалдаан, аюул, ширүүн тэмцлийг даван туулж, өнөөдөр ардчиллын үзэл баримтлал улам бэхжиж байна. Гэсэн ч шийдэх ёстой олон асуудал байсаар л байна.

Ардчиллын түүхэнд хамгийн чухал болох үйл явдал бол 1960 оны 4.19 ардчилсан хувьсгал, 1980 онд гарсан 5.18 Гуанжүгийн ардчилсан хөдөлгөөн, 1987 оны 6-р сарын ардчиллын төлөөх тэмцэл гэдгийг үгүйсгэх хүн байхгүй бөгөөд Ким Ху Ги судлаач ч хамгийн чухал гурван үйл явдал хэмээн онцолсон юм (김호기, 2007). Тодруулбал цэргийн дарангуйллыг ялсан 6-р сарын ардчиллын төлөөх тэмцэл бол өнгөрсөн 60 жилийн хугацаанд түүхийн эргэлтийн цэг байсан. Энэ нь 1945 оны тэмцэл, И Сон Ман-ы дарангуйллыг унагасан 1960 оны 4 сарын ардчилсан хувьсгал, цэргийн дарангуйллын эсрэг боссон 1980 оны Гуанжүгийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үргэлжлэл байлаа. Түүнчлэн олон нийтийн хүсэл зорилго, эв нэгдлээр бүтээсэн иргэний нийгмийн хөдөлгөөн нь ардчиллын түүхийн тэргүүлэх хүч байсан юм. Энэ талаар Ким Жэ Минь “4.19 ардчиллын хувьсгал, 5.18 ардчилсан хөдөлгөөн бол нийгмийн шинэчлэх эхлэл байсан. 6-р сарын ардчиллын тэмцэл бол өнгөрсөн тэмцлүүдийн хүсэл зориг, үзэл санааны үр дүн бөгөөд ард олны сайн дурын оролцоогоор улс үндэстэн болон нийгмээ өөрчилсөн түүхийн эргэлтийн цэг байсан” хэмээн тайлбарласныг тэмдэглэх нь зүйтэй (김재민, 2017).

Жон Хэ Гү судлаач 1987 оны ардчиллаас өмнөх түүхэн үйл явцыг дараах гурван үед хувааж байна. Түүний тайлбарыг хүснэгт 13-аас үзнэ үү (정해구, 2010).

## Хүснэгт 13. БНСУ-ын ардчиллын түүхийн гурван үе

| Үе     | Цаг хугацаа ба онцлог                                                                                                                                                                                    |
|--------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1-р үе | - 1948 он БНСУ байгуулагдсанаас хойш 1960 оны 4 сарын ардчилсан хувьсгал хүртэл<br>- И Сон Ман засгийн газрын коммунизмын эсрэг 1960 оны 4 сарын ардчилсан хувьсгал<br>- Ардчилсан хөдөлгөөн эхэлсэн цаг |
| 2-р үе | - 1961 оны 5 сарын 16-ний цэргийн эргэлтээс хойш 1980 оны ардчилсан хөдөлгөөн хүртэл<br>- Пак Жон Хи засгийн газрын ба үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, дарангуйлалтай тэмцсэн хөдөлгөөн                  |
| 3-р үе | - Шинээр гарч ирсэн Жон Дү Хуан-ы цэргийн дарангуйллаас 1987 оны 6 сарын ардчилсан тэмцэл хүртэл<br>- Ардчилсан хөдөлгөөний 6 сарын тэмцлээр авторитаризм нурж ардчилал ялсан.                           |

Тэрээр 1-р үед 1948 оноос хойш коммунист дарангуйллын эсрэг ардчилсан хөдөлгөөн эхэлсэн бол 2-р үед үндсэн хуулиа өөрчилж дарангуйлалтай тэмцсэн, 3-р үед ардчилсан хөдөлгөөн хүчирхэгжиж авторитаризм нурсан зэрэг үйл явдлыг онцолсон байна.

Дээрх судлаачдын ангилалд тулгуурлан энэ хэсэгт БНСУ-ын ардчиллын түүхийн эргэлтийн цэг болох 1960 оны 4.19 ардчиллын хувьсгал, 1980 оны 5.18 ардчилсан хөдөлгөөн, 1987 оны ардчиллын төлөөх тэмцэл зэрэг гурван түүхэн үйл явдлаар ардчиллын түүх эхлэх цаг үе, тэмцэх цаг үе, биелэх гэсэн гурван цаг үед хувааж үзье.

### (1) Ардчилсан хөдөлгөөний эхлэл ба 4.19 ардчиллын хувьсгал

1945 оны 8.15-ний өдөр Солонгос улс Японы колониос чөлөөлөгдөж тусгаар тогтнол улс болсноор ардчилал эхэлсэн гэдгийг дурьдсан билээ. Тиймээс 1945 оны 8. 15-ний өдрийг ардчилсан үзэл баримтлалын эхлэл, улс үндэсний бүрэн эрхийг дахин сэргээсэн “Үндэсний эрх чөлөөний баяр” хэмээн жил бүр тэмдэглэдэг. Үндэсний архивт тэмдэглэгдсэнээр энэ өдөр Японы эзэн хаан ялагдалаа хүлээн зөвшөөрч дэлхийн 2-р дайн дууссан, улс үндэстнүүд эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсэн ба дахин гэрэл гэгээтэй болсон өдөр ч гэж нэрлэдэг. Японы колониос чөлөөлөгдсөн төдийгүй өдөр засгийн газар байгуулагдсан өдрийг хамт тэмдэглэх үндэсний баярын өдөр болгосон юм (행정안전부, 2025). Харин 1945 оны Солонгосын эрх чөлөө бол өөрсдийн хүчээр бус Америк болон Орос улсын тусламжтайгаар биелэлээ олсон юм. 38 дугаар хойд өргөрөгөөр хуваагдаж өмнөд Солонгост Америк, хойд Солонгост Орос цэргийн анги нэгтгэл байрлах болсон. Өмнөд Солонгост Америкийн дэмжлэг тусламжаар ардчилсан үзэл баримтлал хөгжсөн бол хойд Солонгост ЗХУ Ким Ил Сонь-ийн коммунист улсыг байгуулсан билээ.

1945 онд Солонгос улс эрх чөлөөгөө олсон ч 1948 он хүртэл тусгаар тогтнол улс болгох талаар олон улсын хэмжээнд маргаан гарсан төдийгүй үндэсний дотоод хүчнүүдийн хагарал гарч маш хүнд байдалтай байсан. Өмнөд Солонгост 3 жилийн хугацаанд Америкийн цэргийн засаглал төгсөж, 1948 онд ардчиллын үзэл баримтлалтай засаг захиргаа байгуулагдсан билээ. 1948 оны 5.10-нд үндэсний хэмжээнд анхны ардчилсан сонгуулиар их хурал байгуулагдаж 5.31-ны өдөр үндсэн хуулийг баталж байв. Үүний дараа

7.17-нд үндсэн хуулийг тунхаглаж, 7.20-нд их хурлаас анхны ерөнхийлөгчөөр И Сон Ман сонгогдов. Улмаар 1948 оны 8.15-ны өдөрт засгийн газар байгуулагдсаныг албан ёсоор тунхаглаж 1-р засгийн газар үйл ажиллагаагаа эхэлж байсан түүхтэй. 1948 оны 7.17-нд тунхаглагдсан анхны үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 1.1-т БНСУ бол бүх эрх мэдэл ард олонд байдаг ардчиллын үзэл баримтлалтай улс гэдгийг тунхаглажээ.

1 дүгээр бүлэг. Ерөнхий зүйл, 1 дүгээр зүйлд:

- . БНСУ бол ардчиллын бүгд найрамдах улс мөн.
- . БНСУ-ын дээд эрх мэдэл нь ард түмэнд байдаг бөгөөд ард түмэн төлөөлөгчид бөгөөд сонгуулиар эрх мэдлээ хэрэгжүүлэх болно (국가법령정보센터, 2025) хэмээн заажээ.

1948 оны 8.15-ний өдөр эхэлсэн И Сон Ман ерөнхийлөгчийн 1-р засгийн газар нь 1960 оны 4.19-ний ардчилсан хувьсгалаар нурах хүртэл 12 жилийн турш засгийн эрх мэдлийг хэрэгжүүлсэн. Энэ хугацаад түүхэнд хамгийн том эмгэнэлт явдал хэмээн тэмдэглэгдсэн хоёр Солонгосын дайн 1950 оны 6.25-ны өдөр эхэлсэн бөгөөд үүнээс гадна том жижиг маш олон түүхэн үйл явдал болсон байдаг.

БНСУ-ын 1-р, 2-р, 3-р ерөнхийлөгчөөр ажилласан И Сон Ман болон 1-р бүгд найрамдах засгийн газрын тухай олон янзын дүгнэлт байдаг. Зарим нь түүнийг ардчилсан үзэл баримтлалтай улс болгох үндсийг тавьсан “тусгаар тогтносон улсыг байгуулсан эцэг” гэх боловч зарим нь түүнийг дарангуйлагч байсан гэж үздэг. И Сон Ман ерөнхийлөгчийн байгуулсан гавъяа, үр бүтээлийн талаар олон янзын тайлбар байна (이승만 대통령기념재단, 2025). Тухайлбал 1948 оны 5 сарын анхны чөлөөт сонгуулиар анхны их хурал байгуулагдаж, И Сон Ман даргаар сонгогдон үндсэн хууль болон засгийн газар байгуулах тухай хуулийг батлах ажлыг удирдав. Анхны үндсэн хуулинд эрх чөлөө, тэгш байдал, төрийн эрх мэдлийг хуваарилж хянах ба эрх мэдлийн тэнцүү байдлыг хангах зэрэг орчин үеийн ардчилсан үзэл баримтлалын үнэ цэнийг баталгаажуулан оруулсан байна. Түүнчлэн ерөнхийлөгчийн засаглал, чөлөөт зах зээлийн нийгмийн хэм хэмжээг тогтоожээ. Энэ үндсэн хуулиар БНСУ ардчилсан бүгд найрамдах улс болох түүхэн замнал эхэлж дараа нь их хурлын 196 гишүүний дотроос 180 гишүүний санал дэмжлэгээр И Сон Ман анхны ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан байна. И Сон Ман НҮБ-аар Солонгосын засгийн газраа хүлээн зөвшөөрүүлсэн бөгөөд 1950 оны хоёр Солонгосын дайны үед ч Америк болон НҮБ-ын цэргийн тусламж дэмжлэгийг авч улс үндэстнийг хамгаалах, ардчиллын үзэл баримтлалаар хөгжүүлэх үйлсийг хийсэн гавьяатай юм.

Харин үндэсний ардчилсан хөдөлгөөнийг дурсах үйл ажиллагааны нийгэмлэгээс И Сон Ман ерөнхийлөгчийн үйл хэргийг сөргөөр дүгнэж байна (민주화운동기념사업회, 2025). Тухайлбал 1-р бүгд найрамдах засгийн газар байгуулсан И Сон Ман төрийн эрхийг урт удаан барих шуналаасаа болж, улс төрийн нөхцөл байдлыг хурцатган ширүүсгэсэн гэжээ. Тэрээр 1948 онд Японы хуулийг дагаж дэглэмийг эсэргүүцэгчдийг дарах зорилгоор үндэсний аюулгүй байдлын тухай хууль баталсан, дараа нь төрийн эрхийг урт удаан хугацаагаар барих зорилгоор үндсэн хуульд өөрчлөлт оруулсан, 1960 оны 3 сарын сонгуулийг шударга бус явуулсан зэрэг олон алдаа дутагдалтай байжээ. Үүнээс болж И Сон Ман ерөнхийлөгчийн засгийн газар 1960 оны 4 сарын 19-ны өдрийн ардчиллын төлөөх хувьсгалаар унахаас өөр аргагүй болсон юм. Гэхдээ анхны ерөнхийлөгчөөр ажиллах

хугацаандаа ардчилсан үзэл баримтлалтай улс байгуулах үндэс суурийг тавьж, 1950 оны хоёр Солонгосын дайнаар ардчиллын үнэт зүйл, үзэл баримтлалыг хамгаалсан гэдгийг дахин тэмдэглэх нь зүйтэй юм. Америк улстай батлан хамгаалах хамтын ажиллагааны гэрээ байгуулснаар үндэсний аюулгүй байдлыг хамгаалсан, дайны дараа унасан эдийн засгийг маш хурдан сэргээн босгосон зэрэг олон гавъяа байгуулсан боловч төрийн эрхийг урт удаан барих зорилгоор шударга бус сонгууль явуулснаас болж өөрөө нурж унасан юм.

И Сон Ман ерөнхийлөгчийн дарангуйллыг дуусгавар болгосон үйл хэрэг бол 4.19 ардчилсан хувьсгал байлаа. 1960 оны 4 сарын 19-ны өдөр түүний дарангуйллын эсрэг их дээд сургуулийн оюутнуудын хөдөлгөөн эхэлсэн ба энэ нь ардчилсан хувьсгал байв. Солонгос үндэсний соёлын их толь бичигт 4.19-ний хувьсгалын тухай ийнхүү тэмдэглэжээ (한국민족문화대백과사전, 2025).

*“4.19-ний ардчилсан хувьсгал нь их дээд сургуулийн оюутнууд гол хүчин болж оролцсон ардчилсан хувьсгал байлаа. 1950-иад оны сүүлээр коммунизмын эсрэг үзэл, цагдаагийн хүчинд найдсан И Сон Ман ерөнхийлөгчийн дарангуйлал нь хот суурин газрын оюутнууд, эрдэмтэд, сэхээтэн хүмүүсийн дунд ардчилсан үзэл баримтлалыг хүсэл зорилгоо болгох, түүний төлөө тэмцэх нөхцөл байдлыг нэмэгдүүлэх болсон юм. Шударга бус сонгуулиас гадна төрийн эрх мэдлийг барих боломжгүй гэж үзсэн эрх баригчид 1960 оны 3 сарын сонгуулийг ил тод шударгаар явуулсан байна. Үүнээс болж оюутнуудаар удирдуулсан ард олны зүрх сэтгэл дэлбэрч бослого гаргах болсон бөгөөд цагдаа нар буу зэвсгийн хүчээр ч зогсоож чадсангүй. Энэ ардчилсан хувьсгалын эцэст И Сон Ман ерөнхийлөгч сайн дураараа огцорч Америкийн Хавай арал руу зугтснаар дууссан боловч төрийн эрхийг барих хүчин сайн бэлтгэгдээгүй, хувьсгалын хүчнүүдийн хагарал зэргээс болж ардчилсан хувьсгал үр дүнгүй болж удахгүй цэргийн эргэлт гарсан юм”.*

4.19 хувьсгалаар И Сон Ман ерөнхийлөгчийн дарангуйлал дууссан боловч харамсалтай нь ардчилалд шилжиж чадсангүй. Тухай үед засгийн газрыг байгуулах хүний нөөц дутуу, нийгмийн нөхцөл байдал, ардчилалд зайлшгүй шаардах хүчин зүйлсийн тохироо сайн бүрдээгүй байна. Пак Хён Чэ нь 4.19-ний ардчилсан хувьсгал үр дүнгүй болсон шалтгаан нь тухайн хувьсгалыг оюутнууд удирдсан явдал хэмээн тайлбарлажээ (박헌채, 1990:213-214).

1960 оны 4.19-ны хувьсгалаар ардчилалд шилжих үйл явц амжилт олоогүй бөгөөд ардчиллыг нэг шат дээшлүүлэхэд нөлөөлсөн зүйл бол 1960 оны үндсэн хууль байлаа. Нэмэлт өөрчлөлт хийгдсэн үндсэн хууль нь засгийн газрын дарангуйллыг амссан ард олны хүсэл зорилгыг шингээсэн хууль байв. Оюутнуудын тэргүүлсэн хувьсгалын хүчээр дарангуйллын эсрэг, шударга бус сонгууль явуулахаас хамгаалах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг хүний эрхийг хамгаалах, авилгын эсрэг дүрэм журмын өөрчлөлтийг ийнхүү үндсэн хуулиар баталгаажуулсан юм (전종익, 2020:20).

1960 оны 4.19-ний ардчилсан хувьсгал бол түүхэнд маш чухал ач холбогдолтой үйл хэрэг байсан бөгөөд 1919 оны 3.1-нд гарсан Японы колончлолын эсрэг эрх чөлөөний тэмцэлтэй адил Солонгосын түүхэн эргэлтийн цэг байсан гэдгийг дахин тэмдэглэж байна. Цааш нь 1987 оны ардчиллын дараа өөрчлөлт оруулсан үндсэн хуулинд ч “БНСУ бол 1919 оны 3.1-ны эрх чөлөөний тэмцлээр байгуулагдсан Солонгосын түр засгийн газрыг залгамжлах ба

хууль бус явдлын эсрэг боссон 1960 оны 4.19-ны хувьсгалын үзэл баримтлалыг үргэлжлүүлж байна” гэжээ (국가법령정보센터, 2025).

## (2) Ардчиллын төлөөх 5.18-ны Гуанжүгийн хөдөлгөөн

1960 оны 4.19-ны өдрийн оюунтууд голлон тэргүүлсэн хувьсгалаар ард түмний ардчиллын хүсэл мөрөөдөл биелэгдээгүй, эсрэгээрээ цэргийн дарангуйлал бий болсон байна. 4.19 хувьсгалын дараа Хо Жөн болон Жан Мён тэргүүтэй түр засгийн газар байгуулагдсан боловч тухайн үеийн засгийн газар, улс төрийн хүчнүүд ардчиллын үзэл баримтлалыг хэрэгжүүлж чадаагүйгээс үндэстний хэмжээнд тогтворгүй байдал үргэлжилсэн юм. Улс төр, нийгмийн тогтворгүй байдал үргэлжилсээр байсан 1961 оны 5.16-ны өдөр залуу офицерууд цэргийн эргэлт гаргасан байдаг. Цэргийн офицер Пак Жөн Хи болон Ким Жон Пил-ээр удирдуулсан залуу офицерууд цэргийн шинэчлэлийн хөдөлгөөнийг байгуулсан бөгөөд эргэлтийн гол хүч болсон юм. Эргэлт амжилттай болсны дараа “Цэргийн хувьсгалын зөвлөл” байгуулагдаж хууль тогтоох, гүйцэтгэх засаглал, шүүх засаглалыг бүрэн захирч “Үндэстнийг сэргээн босгох дээд зөвлөл” болгон нэрээ сольж, цэргийн дарангуйлал ийнхүү эхэлсэн байна. Энэ нь 30-иод жилийн турш үргэлжилсэн энэ дарангуйлал авторитаризмын эхлэлийг тавьсан билээ (한국민족문화대백과사전, 2025). Эрх баригчид Пак Жон Хи, Жон Дү Хуан нараар удирдуулсан цэргийн дарангуйлал 1987 оны 6 сарын тэмцэл өрнөх хүртэл нийт 27 жил үргэлжилсэн юм. 1961-1987 он хүртэл үргэлжилсэн цэргийн дарангуйллын түүхийг гурван үе болгон хувааж үздэг (우리역사넷, 2025).

Хүснэгт 14. Цэргийн дарангуйллын гурван үе

| Ангилал                                                           | Цаг       | Улс төрийн байдал ба зорилго                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|-------------------------------------------------------------------|-----------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 5.16<br>Цэргийн эргэлт<br>ба<br>Пак Жөн Хи<br>ерөнхийлөгч         | 1961-1970 | <ul style="list-style-type: none"> <li>- Хүчтэй ерөнхийлөгчийн засаглал</li> <li>- Төрийн зорилго бол үндэсний орчин үеийн хөгжил</li> <li>- Аж үйлдвэржүүлж эдийн засгийг хурдацтай хөгжүүлэх</li> <li>- Гадаад хөрөнгө оруулалт нэмэгдүүлэх</li> <li>- Япон улстай дипломат харилцааг сэргээх</li> <li>- Үндсэн хууланд өөрчлөлт оруулж гурван удаа ерөнхийлөгчөөр сонгогдох боломжтой болгосон.</li> </ul>                                           |
| Юушин<br>системийн<br>Дарангуйлал<br>Ба Пак Жөн Хи<br>ерөнхийлөгч | 1971-1979 | <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхийлөгчийн эрх мэдлийг улам нэмэгдүүлсэн систем-Вьетнам улс коммунист улс болж үндэсний аюулгүй байдалд анхаарах маш чухал асуудал болсон.</li> <li>- Үндэсний эдийн засгийг улам хөгжүүлэхийн тулд хүчтэй засаглал хэрэгтэй гэж үзсэн.</li> <li>- Ардчилал ба хүний эрхийг хүчээр хязгаарлан дарангуйлсан.</li> <li>- 1979 оны 10 сарын 26-ны өдөр Пак Жон Хи ерөнхийлөгч алагдсанаар дууссан.</li> </ul> |
| Шинэ цэргийн<br>бүлэг ба<br>Жон Дү Хуан<br>ерөнхийлөгч            | 1980-1987 | <ul style="list-style-type: none"> <li>- Жон Дү Хуан тэргүүтэй шинэ цэргийн бүлэглэл гарсан</li> <li>- Төрийн зорилго, нийгмийн шударга байдал бүрдүүлэх ба нийгмийн хамгаалал</li> <li>- Ардчилсан хөдөлгөөн ба хүний эрхийг хязгаарлан дарангуйлсан.</li> <li>- Авилга болон шударга бус үйлдэл гаргасан.</li> <li>- 1987 оны 6 сарын ардчиллын төлөөх тэмцлээр дууссан.</li> </ul>                                                                   |

1961 оноос 1979 он хүртэл 19 жил үргэлжилсэн Пак Жон Хи ерөнхийлөгчийн цэргийн дарангуйлал нь хүчтэй ноёрхлыг бий болгосноор улс төр тогтворжин, аж үйлдвэржилтээр дамжуулан эдийн засгийг хурдацтай хөгжүүлсэн, Япон улстай дипломат харилцааг сэргээсэн гэх мэт олон амжилтыг бүтээсэн юм. Гэвч Пак Жон Хи ерөнхийлөгч цэргийн дарангуйллаар дамжуулан ардчиллын үзэл баримтлалыг ухраасан гэх сөрөг дүгнэлт байдаг боловч “Эдийн засгийг хөгжүүлэх 5 жилийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж үндэсний эдийн засгийг маш хурдацтайгаар өсгөсөн гэж эерэг дүгнэлттэй хүмүүс цөөнгүй. Түүний 4-р бүгд найрамдах засгийн газрын үед буюу 1972 онд нэг хүнд ногдох жилийн орлого 255 ам.доллар байсныг 1980 онд 1481 ам.доллар болгож зургаа дахин нэмэгдүүлсэн юм. Засгийн газар эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөрийг эрчимтэй хэрэгжүүлсэн төдийгүй “Шинэ тосгон бүтээх хөдөлгөөн” өрнүүлж, Солонгос орныг хөгжилгүй газар тариалангийн үндэстнээс аж үйлдвэржсэн улс болгов. Гэсэн хэдий ч ардчилал, хүний эрхийн зөрчил, баян, ядуугийн ялгаа зэрэг нийгмийн олон сөрөг үзэгдэл гарсаар байлаа (동북아 역사넷, 2025).

1979 оны 10.26-ны өдөр Пак Жон Хи ерөнхийлөгч бие хамгаалагчийн албаны даргадаа буудуулж алуулсан үйл явдлаар түүний цэргийн дарангуйлал дууссан билээ. Энэ хүнд нөхцөл байдлын дараа Жон Дүн Хуан тэргүүтэй цэргийн шинэ бүлэглэл дахин сэргэж, хууль бусаар төрийн эрх мэдлийг авах гэж байсан юм. Үүний эсэргүүцэж боссон тэмцэл 1980 оны 5.18-ны өдөр эхэлж, түүхэнд Гуанжүгийн ардчилсан хөдөлгөөн хэмээн тэмдэглэгдсэн байдаг.

5.18-ны Гуанжү хотын хөдөлгөөн нь хамгийн хүнд, цус асгаруулсан үйл явдал төдийгүй түүхэн чухал ач холбогдолтой байсан. Энэ нь 1961 оны 5.16-ны цэргийн эргэлтийн дараа хүчээр ард олны ардчиллын төлөөх хүсэл эрмэлзлийг дарсан үйл явдал байв. Ард олны эсрэг зэвсэг хэрэглэн буудаж, аймшигт түүхэн үнэнийг нуун далдлах гэж байсан нь хамгийн харамсалтай үйл хэргээр тодорч тэмдэглэгдсэн юм (송경재, 2023:836). “5.18-ны ардчилсан хөдөлгөөний гавъяатай хүмүүсийн нийгэмлэг”, “5.18 түүхэн үйл явдлыг дурсах сан” зэрэг дөрвөн байгууллагаас гаргасан албан ёсны мэдээлэл, тоо баримтаас үзвэл 606 хүн нас баржээ. Үүнээс 165 хүн ардчилсан хөдөлгөөнд оролцох үедээ нас барсан, 65 хүн ор сураггүй болсон, гэмтсэн, 376 хүн түүний дараа нас барсан байж болзошгүй гэжээ (노컷뉴스, 2005년 5월 13일 기사, 2025).

1980 оны 5 сард болсон Гуанжүгийн ардчилсан хөдөлгөөн нь түүхэнд ямар ач холбогдолтой үйл явдал байсан бэ?

Гуанжүгийн хөдөлгөөнөөр сонор сэрэмжтэй ард олон ардчилсан нийгмийн гол хүчин гэдгийг харуулсан бөгөөд хууль бус улс төрийн дарангуйлагчийн эсрэг зайлшгүй гарах ёстой үйл явдал гэдгийг баталсан юм. Энэхүү хөдөлгөөн нь цэргийн дарангуйлагчдын булаан авсан төрийн эрх мэдэл хуулийн ямар ч үндэслэлгүй гэдгийг тунхаглаж, ардчиллыг амжилттай болгосон 1987 оны 6 сарын тэмцлийн үндэс суурь болсон байна. Түүнчлэн ард олны тэмцлээр тунхаглаж байсан бие даах, ардчилал, эв нэгдлийн түүхэн уламжлалыг өвлөж авсан төдийгүй ардчиллын үзэл баримтлалын хөгжлийн мартагдашгүй алтан цамхаг болсон ардын тэмцэл гэж бичигдэж байна (국가보훈부 국립, 2025). Гэвч харамсалтай 5.18 Гуанжүгийн ардчилсан хөдөлгөөн шууд ардчиллын үзэл баримтлалтай засаглалд шилжихэд олон саад бэрхшээлтэй тулгарч амжилтгүй дууссан байна. Учир нь Жон Дү Хуан-ны

цэргийн дарангуйлагчид Гуанжүгийн хөдөлгөөнийг буу зэвсгийн хүчээр няцааж, түүний дарангуйлал 1987 оны 6 сарын ардчиллын төлөөх тэмцлээр нурах хүртэл 7 жил үргэлжилсэн.

Анхны ерөнхийлөгчөөс эхлээд 1948-1987 оны үед Жон Дү Хуан ерөнхийлөгчийн үе хүртэл гурван ерөнхийлөгчийн үед авторитар дэглэм ямар хэмжээнд байсныг ойлгох боломжтой. Энэ он жилүүдэд М Сон Ман, Юүн Бо Сон, Пак Жон Хи, Чой Гюү Хуа нар ерөнхийлөгчийн албыг хашиж байсан түүхэн үйл явдлыг доорх хүснэгтээс тоймлон харж болно.

Хүснэгт 15. 1948-1987 оны ерөнхийлөгчид ба онцлог үйл явдал

| Хэд дэх | Овог нэр    | Ажилласан хугацаа | Онцлог, ардчиллын үйл явдал                                  |
|---------|-------------|-------------------|--------------------------------------------------------------|
| 1 - 3   | И Сон Ман   | 1948.7-1960.4     | Анхны ерөнхийлөгч<br>1960.4.19 ардчилсан хувьсгал            |
| 4       | Юүн Бо Сон  | 1960.8-1962.3     | 1961.5.16 цэргийн улс төрийн эргэлт                          |
| 5 - 9   | Пак Жон Хи  | 1963.12-1979.10   | Цэргийн дарангуйлагч 1979.10.26 аллага                       |
| 10      | Чой Гюү Хуа | 1979.12-1980.8    | 1980.5.16 Гуанжү ардчилсан хөдөлгөөн                         |
| 11 - 12 | Жон Дү Хуан | 1980.8-1988.2     | Цэргийн дарангуйлагч<br>1987.6 сарын ардчиллын төлөөх тэмцэл |

### (3) 1987 оны 6 сарын ардчиллын төлөөх тэмцэл

И Сон Ман, Пак Жон Хи, Жон Дү Хуан нарын цэргийн дарангуйллыг давахын тулд 1987 оны 6 сарын тэмцэл өрнөж, амжилтанд хүрсэн юм. Солонгос улс даяар олон сая хүн сайн дураараа цуглаж, ардчиллын төлөө амар тайван аргаар тэмцсэн түүхэн үйл явдал болсон. Энэхүү тэмцлээр 1987 оны 6 сард ерөнхийлөгчийг ард түмэн шууд сонгодог байхаар үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг шаардаж улс орныг хамарсан агуу тэмцэл өрнөжээ. “Ардчилсан үндсэн хуулийг буцааж авах ард түмний хөдөлгөөний төв”-өөс тэмцлийг зохион байгуулсан бөгөөд 6.10-аас Солонгосын бүх хотод өдөрт зуугаас илүү жагсаал цуглаан өрнөсөн байдаг. 6 сарын тэмцэлд оролцсон ард олны тоо 4-5 саяд хүрсэн гэсэн тооцоолол бий. Эцэст нь Жон Дү Хуан-ны засгийн газар буулт хийж 1987 оны 6.29-ны өдөр ардчиллын тунхаг бичиг гаргаж, тэмцлийн шаардлагыг хүлээж авсан байна. Ингэж ард түмний шууд сонгуулиар ерөнхийлөгчийг сонгохоор үндсэн хуульд өөрчлөлт оруулж Солонгос улсад ардчиллын үзэл баримтлалын шинэ эрин үе эхэлсэн юм (한국민족문화대백과사전, 2025).

*6 сарын ардчиллын тэмцэл бол 1987 оны 6. 10-ний өдрөөс 29-ны хүртэл БНСУ даяар гарсан авторитаризм ба дарангуйллын эсрэг ардчилсан хөдөлгөөн бөгөөд 6 сарын ардчиллын тэмцэл, 6.10 ардчиллын тэмцэл, 6 сарын ардчилсан хөдөлгөөн, 6 сарын ард олны эсэргүүцэл гэх мэт олон янзаар нэрлэдэг юм. 1987 оны 4.13 -ны өдөр үндсэн хуульд өөрчлөлт оруулах гэсэн засгийн газрын шийдвэр, Пак Жон Чол-ыг цагдаагийн байцаалт нэрийн дор зэрлэгээр жанчиж алсан, И Хан Ёл жагсаал цуглааны үед алагдсан хэргүүд гал дээр тос нэмсэн бөгөөд 6.10-нд Солонгос улс даяар жагсаал цуглаан хийхэд хүргэсэн юм. Эцэст 6.29-ны өдөр эрх баригч намын дарга Но Тэ Ү ардчиллын тунхаг бичиг гаргаж ерөнхийлөгчийг ард түмэн шууд сонгохоор үндсэн хуульд өөрчлөлт оруулжээ. Үүний дараа 1987 оны 12.16-нд шинэ үндсэн хуулийн дагуу ерөнхийлөгчийн сонгууль болсон байна. Ингээж 1987 оны 6 сарын ардчиллын төлөөх тэмцэл амжилт олсон бөгөөд иргэний ниймийн хөдөлгөөн эрчтэй хөгжих суурь*

Ийнхүү 1960 оны 4.19 ардчиллын хувьсгал, 1980 оны 5.18 Гуанжүгийн ардчилсан хөдөлгөөн нь амжилтгүй дууссан бол 1987 оны 6 сарын ардчиллын тэмцэл нь цэргийн дарангуйлал, авторитаризмыг унагаж ардчилалд шилжих агуу том амжилтыг олсон юм. Энэ талаар Ким Хо Ги судлаач нь 6 сарын тэмцлийн түүхэн чухал ач холбогдлыг ардчилал эхлэх цэг, орчин үеийн улс үндэстэн байгуулсан үйл явдал гэдгээр онцлон тайлбарласан байна. Тэрбээр 6 сарын тэмцлээр Жон Дү Хуан-ний засгийн газрыг унагасан нь ардчиллын шинэ үе болох шинэ улс үндэстэн, нийгмийг байгуулах эхлэл болсон төдийгүй нэгэн улс үндэстэн болоход нөлөөлөх хамгийн чухал зүйл бол ардчилал, аж үйлдвэржилт гэдгийг онцолжээ. Цаашилбал 1960-аад оны үед Пак Жон Хи ерөнхийлөгчийн үеэс аж үйлдвэржилт эхэлсэн ба 1970-аад оны үеэс нийгмийн хөдөлгөөн өрнөж, 1987 оны 6 сарын ардчиллын тэмцлээр улам бүр хөгжсөн билээ. Энэ үед хоёр Солонгосыг нэгдэх асуудал ч том даалгавар байлаа. 2000 онд хоёр Солонгосын төрийн тэргүүний уулзалт болж хуваагдмал байдлыг нурааж нэгдэх шинэ үеийн эхлэлийг тавьсан хэмээн үзжээ (김호기, 2007:157). Түүнчлэн Ким Жэ Мин-ий үзэж буйгаар энэ тэмцэл хүний эрхийг хөгжүүлэхэд том хувь нэмэр оруулсан төдийгүй эдийн засгийг хурдацтай хөгжүүлэхийг нэн тэргүүний зорилго болгон зөвхөн урагшлахын төлөө тэмүүлж байсан нь нийгэмд томоохон өөрчлөлт авчирсан. Хувь хүний эрхийг золиослон улс үндэстний эрх ашгийг онцлож байсан хэмээн буруутгасан нийгмийн уур амьсгал дотор ард түмнийг дарангуйлж байснаа төр, засаг захиргаа ухаарч дахин бодох эргэлтийн цаг болсон юм. Ингэж хүний эрх нь ямар ч нөхцөл байдалд хүндэтгэн үзэх энгийн ерөнхий эрх гэдгийг ухамсарлах болсон билээ. Ардчиллын төлөөх тэмцэл нь эрх чөлөө, шударга ёсны талаар эргэцүүлэн бодоход хүргэсэн бөгөөд нийгэм даяар хүний эрхийн үзэл санаа дээшилсэн юм (김재민, 2017:74-75).

Жон Тэ Ил судлаач 6 сарын тэмцлийг Гуанжүгийн ардчиллын төлөөх хөдөлгөөний үргэлжлэл бөгөөд цэрэг армийн бүлгүүд улс төрөөс ангид байж, түүнд оролцох замыг хаасан гэдгийг онцолдог. Тэрээр улс даяар өрнөсөн нийгмийн хөдөлгөөн байсан учраас ард олны дэмжлэг, оролцоотойгоор амжилт олсон хэмээн талархдаг юм (정태일, 2012:198). Ийнхүү 1987 оны тэмцэл нь 6.29 ардчиллын тунхагаар амжилттай дууссан юм. Жон Дү Хуаны цэргийн засаглалын дараа 1987 оны 6.29-ны өдөр ерөнхийлөгчөөр нэр дэвшин сонгогдсон Ну Тэ Ё ард түмний шууд сонгуулиар ерөнхийлөгчийг сонгодог байхаар үндсэн хуульд өөрчлөлт оруулна хэмээн тунхагласан байна. 6.29 ардчиллын тунхаг нь ард олны тэмцлийг хүлээн зөвшөөрөх улс төрийн тунхаг байсан юм. Үүний дараа удахгүй ард түмний шууд сонгуулиар ерөнхийлөгчийг сонгох нэмэлт өөрчлөлтийг үндсэн хуульд оруулж баталгаажуулсан байна. Үндсэн хуулийн энэхүү заалт нь тухай үед эрх барьж байсан цэргийн дарангуйлагчдын дараа ерөнхийлөгчид нэр дэвшсэн Но Тэ Ё болон тэмцлийн гол төлөөлөгч Ким Ён Сам, Ким Дэ Жүн нарын улс төрийн тохиролцооны үр дүнгээр биелэлээ олжээ. Ган Вон Тэк нь 6.29 ардчиллын тунхаг бичгийн дараах үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар ийнхүү тайлбарлаж байна.

*6.29 ардчиллын тунхаг бичгийн дараа эрх баригч нам болон сөрөг хүчин хамтарч үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар хуралдсан юм. Тухайн үед эрх баригч*

*нам болох Минжсон нам ба 1-р сөрөг хүчин байсан Тонилминжсү намыг төлөөлөх 8 хүн үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлаар уулзалт зохион байгуулсан. Энэ уулзалтын шийдвэрээр УИХ-д үндсэн хуульд өөрчлөлт оруулах түр хороог байгуулж ажилласан бөгөөд 1987 оны 10 сарын 12-нд санал хураалтаар 254 гишүүн дэмжиж, 4 гишүүн татгалзсанаар батласан юм. Үүний дараа 10.27-ны өдөр бүх ард түмний санал хураалт болж иргэдийн 78.2 хувь оролцсон бөгөөд тэдний 93.1 хувь дэмжсэнээр үндсэн хууль хүчин төгөлдөр батлагдсан. 1987 оны үндсэн хууль түүхэнд хамгийн урт удаан 30-аад жил хүчин төгөлдөр байгаа нь эрх баригч ба сөрөг хүчний тохиролцоо, ард түмний дэмжлэг өндөр байсан зэрэг шалтгаантай юм (강원택, 2017).*

Ийнхүү 1987 оны 6 сарын тэмцлээр 6.29 тунхаг бичгийг гаргасан бөгөөд 10.27-нд Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийснээр ардчилалд шилжих үйл явц амжилттай дууссан гэж дүгнэж болно. Ерөнхийдөө 1948 онд засгийн газар байгуулагдсанаас хойш үргэлжилсээр байсан И Сон Ман болон Пак Жон Хи ба Жон Дү Хуан нарын цэргийн дарангуйллыг 1987 оны 6 сарын тэмцлээр унагаснаар авторитаризм төгсөж, БНСУ-д ардчиллын үзэл баримтлалын шинэ эрин үеийн үүд хаалга нээгдсэн билээ.

### **3.2 БНСУ-ын ардчиллын шилжилт бат тогтсон нь**

БНСУ-ын ардчилал 4.19 ардчилсан хувьсгал, 5.18 Гуанжүгийн ардчиллын төлөөх хөдөлгөөн, 1987 оны 6 сарын тэмцлийн үр нөлөөгөөр амжилт олсон юм. Ялангуяа 1987 оны 6 сарын тэмцлийн дараа ардчиллын шилжилт хэрхэн бэхжиж, бат суурьтай хөгжиж байгаа талаар энэ хэсэгт авч үзье.

Өдгөө 1987 оны 6 сарын тэмцлээс хойш 38 жил өнгөрчээ. Энэ цаг хугацаанд Солонгос улс ардчилалд хэрхэн шилжиж, хэрхэн бэхжүүлж байгаа вэ? гэсэн асуулт зүй ёсоор тавигдана. Нэг үгээр энэ асуултад улс орны хэмжээнд ардчилсан үзэл баримтлалыг хөгжүүлэн ардчилалд шилжих, бэхжүүлэх үйл явц үе шаттай амжилттай хэрэгжсэн хэмээн хэлж болно. Энэ талаар судлаачдын байр суурийг авч үзвэл Ким Ён Тэ ардчилалд шилжиж, бэхжүүлэн тогтоох үйл явц хоёр үе шаттайгаар хэрэгжсэн хэмээн үзэж дараах тайлбар өгч байна. Тэрээр ардчилалд шилжилт хийх үе шат нь авторитар засаглал нуран унаж, ардчилсан шинэ засаглал бүрдсэнээр эхэлнэ. Ардчилал бэхжиж, бат тогтох шат нь ардчиллын үзэл баримтлал үндэсний хэмжээний бүхий л салбарт шингэж, үзэл баримтлал гүнзгийрэх, улс төрийн систем бэхжих явдал гэжээ. Түүнчлэн хуучин засаглалыг нураах шат бөгөөд ардчиллын үзэл баримтлалыг бүрэн цогц бүтээх шат мөн. Ардчилалд шилжихэд хамгийн чухал даалгавар бол дарангуйлагчийг төрийн эрх барих суудлаас буулгаж, ардчилсан сонгуулиар шинэ засаглалыг бий болгох явдал. Ардчилал бат тогтох энэ үе шатанд хууль дүрэм тогтоох, ардчиллыг тогтворжуулах, нийгмийн бүх салбарын үйл ажиллагаа ардчиллын зарчимд суурилсан байх нь чухал (김영태, 2006) хэмээн үзэж байна.

Энэ үүднээс авч үзвэл БНСУ ардчилалд шилжих болон бэхжиж бат тогтсон үе нь хэзээнээс эхэлсэн бэ? гэсэн асуулт гарна. Энэхүү судалгаанд 1987 оны 6.29 ардчиллын тунхаг бичиг гарснаар авторитар засаглал дуусаж, ардчилсан сонгуулиар, тайван арга замаар төрийн эрх баригчид солигдох үндэс суурийг тавьсан үеэс ардчилал амжилт олсон гэх өмнөх судлаачтай санал нэг байна. Үүний дараа ардчилалд шилжих үе шат эхэлж улмаар бэхжих үйл явц өрнөх юм. Ардчилалд шилжих, бат тогтох үйл явц, цаг хугацааны талаар эрдэмтэд янз бүрийн байр суурьтай боловч Ким Ён Тэ судлаачийн тайлбарыг авч үзье. Тухайлбал

ардчилалд шилжилт эхэлсэн цаг хугацааг 1987 оны 6.29 ардчиллын тунхагтай холбон үздэг ба улмаар 1993 оны 2 сараас ардчилал бэхжин бат тогтох цаг үе эхэлсэн хэмээн ихэнх судлаачид санал нийлдэг гэжээ. Мөн өөр байр суурь нь Но Тэ Ү ерөнхийлөгч цэрэг армийн генерал төдийгүй хуучин цэргийн дарангуйлагчийн залгамжлагч байсан учраас ардчилалд бүрэн шилжсэн гэж үзэх боломжгүй, харин 1993 оны 2.25-ны өдөр 14 дахь ерөнхийлөгч Ким Ён Сам-ын засаг захиргаа эхэлсэн цаг хугацааг тодорхойлсон байна (상계서, p. 252.).

Энэ талаар Жон Хэ Гү судлаачийн хувьд авторитар систем унаж шинэ ардчилсан засаглал бий болоход 1987 оны 6 сарын тэмцэл, 1987 оны үндсэн хуулийн өөрчлөлт, 1988 онд Но Тэ Ү ерөнхийлөгчийн засаг захиргаа нөлөөлсөн тул энэ үеийг ардчилалд шилжих үе шат хэмээдэг бол(정해구, 2010:38-41) Мүн Бён Жү нь 1993 оны 2 сард Ким Ён Самын засаг захиргаа эхэлсэн цаг үетэй холбож үздэг (문병주, 1996:211). Энэхүү судалгаанд дээрх судлаачдын үзлийг нэгтгэн үзвэл Солонгос улсын ардчилалд уруу шилжих үе нь 1987 оны 6 сарын тэмцэл буюу 6.29 ардчиллын тунхагаас эхлээд 1993 оны 2 сард Ким Ён Сам ерөнхийлөгчийн засаг захиргаа байгуулагдсан цаг үеийг хамарчээ. Ийнхүү 1993 оны 2 сараас өнөөг хүртэл ардчилал бэхжин тогтох үйл явц үргэлжилсээр байна. Учир нь 1988 оны Но Тэ Ү ерөнхийлөгчийн засаг захиргааг цэргийн дарангуйллын үргэлжлэл байсан хэмээн үзэхээс өөр аргагүй. Но Тэ Ү өөрөө цэргийн генерал төдийгүй өмнөх ерөнхийлөгч Жон Дү Хуаны залгамжлагч байсан юм.

#### **(1) БНСУ ардчилалд шилжсэн нь**

1987 оны 6 сарын тэмцэл нь цэргийн дарангуйллын авторитаризм нурж, ардчиллын үзэл баримтлалд шилжсэн түүхэн үйл явдал гэдгийг өмнөх хэсэгт дурьдсан ба үүнийг хүлээн зөвшөөрдөггүй хүн байхгүй билээ. Учир нь 26 жилийн турш үргэлжилсэн цэргийн дарангуйллаас салж, ардчилсан үзэл баримтлалтай засаглалыг бий болгосон юм.

Ким Гүг Хён нь ардчилалд шилжсэн учир шалтгааныг цэргийн дарангуйллыг унагахаас өөр аргагүй байсантай холбон тайлбарладаг. Цэрэг армийн хүчээр улс төрийн эргэлтийг хийж, эрх мэдлийг хэрэгжүүлж байсан дарангуйлал нь ард түмний хүлээн зөвшөөрлийг авч чадахгүй учраас хүч нь сул байхаас өөр аргагүй байсан. Үүнээс болж цэргийн дарангуйлагчид эрх мэдлээ алдахгүй байх, ард түмэнд таалагдах аливаа нэгэн амжилт бүтээлийг үзүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх эсвэл улс төрийн хатуу дарамт хавчлагаар төрийн эрхийг үргэлжлүүлэн барьдаг байсан юм (김국현, 1997:219).

1987 оны 6 сарын турш Солонгос даяар ард түмэн олон саяар цэргийн дарангуйллыг эсэргүүцэж ардчилсан засаглалыг шаардаж асар хүчтэй тэмцэл зохион байгуулсан. Жон Дү Хуан ерөнхийлөгч түүний цэргийн дарангуйлагчид ард олны хүчтэй тэмцэлд бууж өгөхөөс аргагүй болж, 6.29-ны өдөр ардчиллын тунхаг гаргасан байдаг. Энэ нь ардчиллын төлөөх шаардлагийг хүлээн зөвшөөрсөн тунхаг байсан. Түүнчлэн тухайн үед эрх баригч намаас ерөнхийлөгчөөр сонгогдсон Ну Тэ Ү ард түмний шаардсан ёсоор ерөнхийлөгчийг шууд сонгох, улс төрийн маргааныг шийдвэрлэхээр тунхаг бичиг гаргасан юм (한국민족문화대백과사전, 2025). Ийнхүү эрх баригчид болон хөдөлгөөний удирдагчдын хоорондын харилцан тохиролцоонд үндэслэн ардчиллын шилжилт тайван байдлаар хэрэгжсэн билээ.

Жан Хүн-ийн үзэж буйгаар ардчилалд шилжих явдал нь гурван талын харилцан

тохиролцооны үр дүн байсан юм. Үүнд:

- . Авторитаризмаас ардчилсан системд шилжих үе шат нь ямар нэгэн хүч хэрэглэсэн эсвэл нэг талын давуу эрх мэдлээр явагдсан бус хоёр талын харилцан тохиролцоогоор шийдэгдсэн юм.
- . Гол хүчнүүдийн харилцан тохиролцоогоор ардчилал биелэгдсэн бөгөөд үзэл баримтлалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар ч хөдөлгөөний олон бүлгүүд харилцан тохиролцож байсан юм.
- . Дээрх харилцан тохиролцсон үр дүнгээс хамааран ардчилагдах үйл явцдаа ч хууль дүрэм батлах, улс төрийн бүтцийг бий болгох зэрэг ажлыг харилцан тохиролцож шийдвэр гаргаж байсан (장훈, 2007).

1987 оны 6 сарын тэмцлийн үр дүн бол ардчиллын тунхаг бичиг байлаа. Үүний дараа ардчилалд шилжих үйл ажиллагаа маш хурдацтай, тодорхой биелэгдсэн ба 1987-1988 онд болсон үйл явдлыг дараах хүснэгтээс харна уу (<http://19870610.or.kr>, 2025).

Хүснэгт 16. 1987-1988 оны ардчилалд шилжихэд нөлөөлсөн үйл явдал

| Өдөр         | Үйл явдал                                                                                  | Учир утга                                           |
|--------------|--------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------|
| 1987. 1. 14  | Пак Жон Чөл цагдаагийн аймшигт байцаалтаас болж нас барсан.                                | Ардчиллын төлөөх тэмцлийн учир шалтгаан             |
| 1987. 4. 13  | Ерөнхийлөгч Жон Дү Хуан үндсэн хуульд өөрчлөлт оруулахгүй гэдгээ албан ёсоор зарласан.     | Ардчилсан тэмцэлд гал нэмсэн хэрэг болсон.          |
| 1987. 5. 27  | Ардчилсан үндсэн хуулиар өөрчлөлт шинэчлэл хийх бүх ард түмний тэмцлийн төвийг байгуулсан. | Ардчиллыг удирдан төлөөлөх байгууллага              |
| 1987. 6. 10  | Бүх ард түмний ардчиллын тэмцлийн өдөр                                                     | Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тэмцэл               |
| 1987. 6. 29  | Эрх баригчид ардчиллын тунхаг гаргасан.                                                    | Ардчилсан хөдөлгөөний шаардлагыг хүлээж авсан.      |
| 1987. 8. 31  | Үндсэн хуулийн өөрчлөлт оруулах төслийг баталсан.                                          | Хоёр талын 8 төлөөлөгч шийдвэр гаргасан.            |
| 1987. 10. 27 | Үндсэн хуульд өөрчлөлт оруулах талаар бүх ард түмний санал хураалт явуулсан.               | 93.1 хувийн дэмжлэг авсан.                          |
| 1987. 10. 29 | Өөрчлөлт оруулсан үндсэн хуулийг батлан тунхагласан.                                       | Ардчиллын төлөөх тэмцлийн ялалт                     |
| 1987. 12. 16 | 13 дахь ерөнхийлөгчийн чөлөөт сонгууль                                                     | 16 жилийн дараах ард түмний ардчилсан шууд сонгууль |
| 1988. 2. 25  | Но Тэ Ү ерөнхийлөгч тангараг өргөсөн.                                                      | Саарал ардчилал                                     |

Дээрх хүснэгтээс үзвэл ардчиллын шилжилт эрх баригчид болон сөрөг хүчний харилцан тохиролцсон тайван замаар маш эрчтэй явагдсаныг мэдэх боломжтой. Жон Хэ Гү нь 1987 оны тэмцлийн дараа ардчилалд шилжих үйл явц хэрхэн өрнөсөн талаар дараах тайлбар өгч байна.

*1987 онд ардчилалд шилжих үйл явц хэрхэн өрнөсөн бэ? Юуны өмнө ерөнхийлөгчийг ард түмнээс шууд сонгодог байх үндсэн хуулийн өөрчлөлт чухал ач холбогдолтой байсан юм. Үндсэн хуульд өөрчлөлт оруулах харилцан*

*тохиролцоо нь улс төрийн намуудад томоохон үүрэг, эрхийг олгосон байна. Эрх баригч нам, сөрөг хүчний намыг төлөөлөх найман хүний бүрэлдэхүүнтэй хурал үндсэн хуульд өөрчлөлт оруулах ажлыг хариуцаж, 5 жилийн хугацаанд нэг удаа сонгогдох боломжтой ерөнхийлөгчийн засаглалыг хуулиар баталгаажуулах шийдвэр гаргасан. УИХ-аар нэмэлт өөрчлөлт оруулсан шинэ үндсэн хуулийг баталсаны дараа бүх ард түмний санал хураалтаар баталгаажиж 10.29-нд тунхаглагдсан байна. Ингээж ардчиллыг төлөөлөн тэргүүлэх эрх нь ардчилсан хөдөлгөөний удирдагчид бус улс төрийн намуудын эрх мэдэлд шилжсэн (정해근, 2010:39).*

Шинээр батлагдсан үндсэн хуулийн заалтын дагуу Солонгос ард түмэн 16 жилийн хугацаанд хийж байгаагүй шууд сонгуулиар ерөнхийлөгчөө сонгов. Гэвч 1987 оны 12.16-ны өдөр болсон энэхүү ерөнхийлөгчийн сонгуульд ардчилсан хөдөлгөөний хүчнүүдийн хагарал хуваагдлаас болж хуучин цэргийн дарангуйлагчийн эрх баригч нам ялалт байгуулжээ. Энэ удаагийн ерөнхийлөгчийн сонгуульд ардчилсан хүчний төлөөлөгч Ким Ён Сам ба Ким Дэ Жүн нар нэгдэж чадалгүй тус тусдаа нэр дэвшсэн. Эрх баригч намаас Но Тэ Ү болон Ким Жол Пил гэдэг өөр нэр дэвшигч гарч ирсэнээр дөрвөн хүн өрсөлдөх болсон юм. Энэ сонгууль 16 жилийн дараа хийгдэж байгаа учраас ард олны анхаарлын төвд байв. Гэвч бүс нутгаар хуваагдах байдал, худал хуурмаг, авилга, хүчирхийлэл зэрэг хууль бус үйл явдал маш ихээр гарч байсан юм. Сонгуулийн үр дүнгээс харвал бүс нутгийн хуваагдлаас болж Но Тэ Ү 36.6 хувийн санал авч ерөнхийлөгчөөр сонгогдсон байна (중앙선거관리위원회 사이버선거역사관, 2025)

Ардчиллын төлөөх тэмцэл, үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, ард түмний чөлөөт сонгууль зэрэг үйл явдлаар ардчилалд шилжих боломжтой байсан ч хагарал хуваагдлаас шалтгаалан цэргийн дарангуйллыг өвлөгч Но Тэ Ү ерөнхийлөгчөөр сонгодсоноор бүрэн шилжиж чадсангүй. Ингэснээр бүх Солонгосчуудын хүлээн зөвшөөрсөн ардчилалд шилжих үйл явц 5 жил 7 сарын дараа буюу 1993 оны 2.25-ны өдөр анхны ардчилсан ерөнхийлөгч Ким Ён Сам гарч ирэх хүртэл хойшлогдсон юм. 1960 оны 4.19 ардчилсан хувьсгал, 1980 оны Гуанжүгийн хөдөлгөөн амжилтгүй дууссан боловч 1987 оны 6 сарын тэмцэл үр дүнд хүрсэн. Энэ нь улс төр, эдийн засаг, нийгмийн олон учир шалтгаантай байлаа. Тодруулбал Ким Сон Сү судлаач БНСУ-ын ардчилалд шилжсэн энэхүү учир шалтгааныг улс төр, эдийн засаг, нийгэм, шашны талаас нь судлан тайлбар өгч байдаг.

*БНСУ-ын ардчилалд шилжсэн гол шалтгаан бол аж үйлдвэржүүлэлт хөгжсөнөөр эдийн засаг өсөж, улмаар нийгмийн бүтэц өөрчлөгдөхөд ардчиллын төлөө төрийн хүчнүүдийн үүрэг хариуцлага бий болсон явдал мөн. Ялангуяа улс төрийн хувьд ардчилсан үзэл баримтлалын төлөө бүхнээ зориулсан удирдагчид болон ардчилсан үзэл баримтлалаар хөгжсөн гадаад орны үр нөлөө, ард түмний хүсэл эрмэлзэл их нөлөөлсөн юм. Нийгэмд орчин үежих байдал, эдийн засагт өсөлт, хөгжил бий болж, дунд давхаргын эзлэх хувь, дээд боловсролтой хүмүүс нэмэгдсэн, шашны хувьд христос шашинтай хүмүүсийн эзлэх хувь өсөж нийгмийн шударга байдалд идэвхтэй оролцох болсон шалтгаан нь маш их нөлөөсөн хүчин зүйлс байлаа (김성수, 2004).*

Түүнчлэн Ким Гүг Хён-ийн үзэж буйгаар эдийн засгийн дээд өсөлт, дунд түвшний нийгмийн хөгжил, доод түвшний улс төрийн хөгжлийн хооронд тэгш бус байдал үүсэн нийгмийн бүтэц өөрчлөгдөж дундаж давхаргын эзлэх хувь нэмэгдсэн нь цэргийн дарангуйллын авторитар дэглэмийн үед хэрэгжүүлсэн аж үйлдвэржилтийн үр дүн байв. Цэргийн дарангуйлагчид эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлж, ард олноос дэмжлэг авч хүлээн зөвшөөрөгдөхийн тулд үйлдвэр хөгжүүлэхийн төлөө зүтгэж байсан. Харин эдийн засгийн хөгжил нь цэргийн дарангуйлагчдын хүсэж байснаар бус эсрэгээрээ ардчилсан хөдөлгөөний хүчээр бий болсон үйл хэрэг юм. Ингэж ардчилалд шилжихээс аргагүй нөхцөл байдлыг бүрдүүлсэн юм (김국현, 1997:226) гэжээ.

Дүнгэж хэлэхэд ардчилалд шилжих үйл явц нь 1987 оны 6 сарын тэмцлээр эхэлж 1993 оны 2 сард анхны ерөнхийлөгч Ким Ён Сам гарч ирэх хүртэл 5 жил 6 сарын хугацааг туулсан юм. Энэ нь эрх баригчид болон сөрөг хүчний харилцан тохиролцсон тайван аргаар явагдсан бөгөөд хамгийн их нөлөөлсөн учир шалтгаан нь эдийн засгийн хөгжил, нийгмийн бүтэц өөрчлөгдсөн байдал хэмээн дүгнэж болно.

## **(2) БНСУ-д ардчилсан үзэл баримтлал бат тогтсон нь**

1993 оны 2 сард анхны ардчилсан ерөнхийлөгч болох Ким Ён Сан гарснаар өнөөг хүртэл ардчилсан үзэл баримтлал бат тогтсон цаг үе үргэлжилж байна.

Linz and Stepan-ийн үзсэнээр чөлөөт сонгуулийн үр дүнд байгуулагдсан засгийн газрыг бүрдүүлэх талаар амжилттай харилцан тохиролцох боломж бий болсноор Солонгос улс ардчиллын үзэл баримтлал уруу шилжсэн юм. Тэрээр ардчилсан үзэл баримтлалыг сонгохоос өөр аргагүй гурван онцлог нөхцөл байдлын талаар тайлбарлаж байна (박봉민&오현진, 2018). Үүнд:

- ☐ Ард олны ихэнх нь ардчилсан үзэл баримтлалтай улс төрийн систем хамгийн чухал гэдгийг хүлээн зөвшөөрөх соёл;
- ☐ Үндсэн хуулиар нийгэм, эдийн засаг, улс төр гэх мэт бүхий л бүтэц, тогтолцоонд ардчилсан хууль дүрмийг дагаж мөрдөх;
- ☐ Нөхцөл байдлын хувьд улс төрийн эргэлт хийх боломжгүй, үндэсний дотоодод тусгаар тогтнолын эсрэг ямар нэгэн бүлгэм байхгүй байх;
- ☐ Дээрх гурван нөхцөл байдал бүрдэх үед ардчилсан үзэл баримтлалыг сонгохоос өөр арга зам байхгүй буюу ардчилал бат тогтоно хэмээн үзжээ.

J. Diamond-ынхоор ардчилал бат тогтох нь улс төрийн удирдагчид болон ард олон ардчилсан үзэл баримтлалын зарчим, арга зүйг хүлээн зөвшөөрч, үүний төлөө бүхнээ зориулах явдал (상계서, p. 5에서 재인용). Ийнхүү 1987 онд ардчилалд шилжсэний дараа ард түмэн найман удаа ерөнхийлөгчөө төдийгүй улс төрийн эрх баригчдыг тайван аргаар сонгосон нь ардчиллын үзэл баримтлал бат тогтсон гэдгийг харуулж байна. Өнөөдрийг хүртэл хэрэгжсэн ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн ба онцлогийг дараах хүснэгтээс тодруулна уу (청와대 대통령 기록관 자료, 국가기록포털 자료, 2025).

## Хүснэгт 17. БНСУ-ын 1987 оны ардчиллаас хойших үеийн ерөнхийлөгчид

| Хэд дахь | Нэр        | Ажилласан хугацаа | Нам                            | Саналын хувь | Онцлог                                              |
|----------|------------|-------------------|--------------------------------|--------------|-----------------------------------------------------|
| 13       | Но Тэ Ү    | 1988-1993         | Ардчилсан шударга нам          | 34.64        | Цэргийн засаглал                                    |
| 14       | Ким Ён Сам | 1993-1998         | Ардчилсан эрх чөлөө нам        | 41.96        | Анхны ардчилсан засаглал                            |
| 15       | Ким Дэ Жүн | 1998-2003         | Шинэ улс төрийн ард түмний нам | 40.27        | Төрийн эрх баригч нам солигдох                      |
| 16       | Ну Мү Хён  | 2003-2008         | Шинэ милениум ардчилсан нам    | 48.91        | Огцруулсангүй (2014)                                |
| 17       | И Мён Баг  | 2008-2013         | Ханнара нам                    | 48.67        | Төрийн эрх баригч нам солигдох                      |
| 18       | Пак Гон Хэ | 2013-2016         | Сэнүри нам                     | 51.55        | Анхны эмэгтэй ерөнхийлөгч огцруулсан (2016)         |
| 19       | Мүн Жэ Ин  | 2017-2022         | Хамтын ардчилсан нам           | 41.08        | Төрийн эрх баригч нам солигдох                      |
| 20       | Юун Сөг Ёл | 2022-2025         | Ард түмний хүч                 | 48.56        | Төрийн эрх баригч нам солигдох<br>Огцруулсан (2025) |

БНСУ-ын ард түмэн таван жилээр ажиллах ерөнхийлөгчийг шууд сонгуулиар 8 удаа тайван чөлөөтэй сонгосон. 1993 онд цэргийн бус хүн ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараа үндсэн хуулийн дагуу тайван замаар эрх баригч нам дөрвөн ч удаа солигджээ. УИХ-аас ерөнхийлөгчийг огцруулах шийдвэр нийт гурван удаа гаргасан бөгөөд хоёр ерөнхийлөгч нь үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр бүрэн огцорсон байна. 2014 онд УИХ-аас 16 дахь ерөнхийлөгч Но Мү Хён-ийг улс төрийн үзэл, авилгын хэргээр огцруулах шийдвэр гаргасан боловч үндсэн хуулийн цэц хүлээж аваагүйгээс үүрэгт ажлаа үргэлжлүүлэн хугацаандаа дуусгасан байна. Үүний дараа 18 дахь удаагийн сонгуулиар ялсан анхны эмэгтэй ерөнхийлөгч Пак Гон Хэ Чой хэмээх жирийн эмэгтэйд албан ёсны ажилд оролцуулсан болон авилгатай холбоотой шалтгаанаар УИХ хэлэлцсэн гаргасан шийдвэрийн дагуу огцорсон бөгөөд үндсэн хуулийн цэц ч энэхүү шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн. 2025 оны 3 сарын байдлаар 20 дахь ерөнхийлөгч Юу Сон Ёл улс төрийн онцгой байдлыг зарласан хэргээр УИХ-аас огцруулах шийдвэр гаргасан бөгөөд үндсэн хуулийн цэц мөн адил шийдвэрийг хүлээж авснаар үүрэгт ажлаа орхиод байна.

Ингэж эрх баригч нам тайван аргаар солигдох, ерөнхийлөгчийг огцруулах үйл ажиллагаа бүгд ардчилсан зарчмаар үндсэн хуулийн дагуу шийдэгдэж байгаа нь ардчилсан үзэл баримтлалыг бат тогтоож чадсаныг илтгэж байна.

БНСУ-ын хууль тогтоох эрх мэдэлтэй УИХ-ын дөрвөн жил тутам явагддаг сонгууль ч мөн адил 1987 оноос хойш тайван замаар явагдсан юм. Ардчиллын дараах УИХ-ын сонгуулийн талаар хүснэгт 18-аас нэгтгэн харж болно (열린국회정보 및 언론 자료를 토대로 필자가 직접 작성하였다, 2025).

## Хүснэгт 18. 1987 оны ардчиллын дараах үеийн УИХ-ын сонгууль

| Хэд дэх | Он   | Сонгуулийн ирц, хувь | Нийт суудлын тоо ба сонгуулийн дүн                                                                                     |
|---------|------|----------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 13      | 1988 | 75.8                 | Нийт 299 суудал (Ардчилсан шударга нам 125, Амар тайван ардчилсан нам 70, Нэгдсэн ардчилсан нам 59, бусад 45)          |
| 14      | 1992 | 71.9                 | Нийт 299 суудал (Ардчилсан эрх чөлөө нам 149, Ардчилсан нам 97, Нэгдсэн ардчилсан нам 31, бусад 22)                    |
| 15      | 1996 | 63.9                 | Нийт 299 суудал (Шинэ Солонгос нам 139, Шинэ улс төрийн ард түмний нэгдэл 79, Эрх чөлөө ардчилсан нэгдэл 50, бусад 31) |
| 16      | 2000 | 57.2                 | Нийт 273 суудал (Нэг улс нам 133, Шинэ мянганы ардчилсан нам 115, Эрх чөлөө ардчилсан нэгдэл 17, бусад 8)              |
| 17      | 2004 | 60.6                 | Нийт 299 суудал (Нээлттэй бидний нам 152, Нэг улс нам 121, Ардчилсан хөдөлмөрийн нам 10, бусад 16)                     |
| 18      | 2008 | 46.1                 | Нийт 299 суудал (Нэг улс 153, Нэгдсэн ардчилсан нам 81, Эрх чөлөөний хөгжлийн нам 18, бусад 47)                        |
| 19      | 2012 | 54.2                 | Нийт 300 суудал (Сэнүри нам 152석, Ардчилсан нэгдэл нам 127, Нэгдсэн дэвшилийн нам 13, бусад 8)                         |
| 20      | 2016 | 59.0                 | Нийт 300 суудал (Хамтдаа ардчилсан нам 123, Сэнүри нам 122, Ард түмний нам 28, бусад 17)                               |
| 21      | 2020 | 66.2                 | Нийт 299 суудал (Хамтдаа ардчилсан нам 180, Нэгдсэн ирээдүй нам 103, бусад 16)                                         |
| 22      | 2024 | 67.0                 | Нийт 300 суудал (Хамтдаа ардчилсан нам 175, Ард түмний хүч нам 108, бусад 17)                                          |

Ийнхүү 1987 оны ардчилсан үйл явдлаас хойш хэрэгжиж эхэлсэн ерөнхийлөгчийн болон УИХ-ын чөлөөт сонгууль үндсэн хуулийн дагуу бүх ард түмний оролцоотойгоор тайван, шударга явагдах болсноор ардчиллын үзэл баримтлал нь Солонгос улсын бүхий л систем институцын дотор агуулгийн хувьд бат тогтож байна хэмээн дүгнэж болно. 1993 онд ардчилалд шилжих цаг үе дууссаны дараа өдгөө үзэл баримтлал хэрхэн бат тогтож, чанарын хувьд сайжирсныг дүгнэх нь тийм ч амар биш байна. Учир нь үзэл баримтлалын ирээдүйг эерэг болон сөргөөр үзэх судлаачдын дүгнэлт олон байна. Харин олон улсын байгууллагууд хэрхэн үнэлж дүгнэж байгааг авч үзье.

Чой Жин Үг судлаач Freedom House болон Transparency International, Дэлхийн банк зэрэг байгууллагын дүгнэлтэд үндэслэж БНСУ-ын ардчилсан үзэл баримтлалын талаар олон улсад эерэгээр дүгнэж байна хэмээн үзсэн. Тухайлбал Freedom House байгууллага нь 1987 оноос хойш Солонгосыг “Эрх чөлөөт улс (free)” гэж ангилалд багтаадаг бөгөөд авилгын нөхцөл байдал сайжирч байна гэж дүгнэсэн байна (최진욱, 2018:195).

У Хён Жин, Жу Ин Бөм нарын судлаачид ч гэсэн улс төрийн системийн өөрчлөлтийг дүгнэж, Солонгос улсад ардчиллын үзэл баримтлал бат тогтож байгаа боловч засаж шинэчлэх асуудал байгааг хэлж байна (조인영, 2018:66). Тэрээр өнгөрсөн 30 жилийн бүхий л системийн өөрчлөлтийг төрийн эрх барих өрсөлдөөн, түүний хэрэгжилт талаас нь дүгнэж үзвэл системийн маш том өөрчлөлт, дэвшил байсныг харж болно. Төрийн эрх барих өрсөлдөөний хувьд сонгуулийн систем илүү ардчилагдсан, эерэг өөрчлөлт (сонгуулийн хууль, улс төрийн

намуудын тухай хууль, улс төрийн харилцааны хууль, сонгууль санал өгөх насыг өөрчлөх, эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх квотыг өсгөх зэрэг) гарсан байна. Гэвч төрийн эрхийг хэрэгжүүлэхийн тухайд хууль тогтоох, шүүх эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэл нь тэгш бус, ерөнхийлөгч ба гүйцэтгэх засаглал нь давуу эрх мэдэлтэй, гүйцэтгэх засаглалд тавих хяналт сул, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах зэрэг асуудал байна. Энэ нь зөвхөн улс төрийн системийг сайжруулснаар шийдэгдэх боломжгүй бөгөөд хязгаарагдмал нөхцөл байдал байгаа хэмээжээ.

Судлаач Ган Вон Тэкийн үзсэнээр 1987 оны ерөнхийлөгчийн сонгуулиас хойш өнөөг хүртэл 6 хүнийг үндсэн хуулийн дагуу шударга сонгуулиар томилсон байна. Хуучин сонгуулийн үед байсан төрийн байгууллагын лобби, хууль бус оролцоо, мөнгө тараах зэрэг үзэгдэл арилж нөхцөл байдал маш сайжирчээ. Эрх баригчид болон сөрөг хүчний хооронд төрийн эрх солигдох явдал ч тайвар арга замаар хэрэгжих болсон юм. Тухайлбал 1997 онд Ким Дэ Жүн, 2007 онд И Мён Баг нар ерөнхийлөгчөөр сонгогдсон ба 2017 оны ерөнхийлөгчийн сонгуулиар эрх баригч нам солигдсон байна. Ийнхүү Huntington-ны хэлсэнчлэн “Эрх баригч нам хоёр удаа солигдох сорилт (two turnover test)”-ыг даван туулж, ардчиллын үзэл баримтлал бат тогтох зарчмыг амжилттай хэрэгжүүлсэн, амжилт бүтээлтэй улс болсон юм (강원택, 2017:32). Түүнчлэн Жо Вон Бин судлаач ардчилалд шилжсэнээс хойших 30 жилийн турш Солонгос улсад ардчилсан үзэл бат тогтсон гэсэн эерэг дүгнэлт хийж байгаа ч шийдэх ёстой асуудлууд их байгааг сануулсаар байна (조원빈, 2018:257). Тэрээр өнөөгийн ерөнхийлөгчийн засаглалын үед эрх баригч, сөрөг хүчний хооронд гурван удаа тайван арга замаар төрийн эрх солигдон, ард түмний эрх чөлөөт байдал дээшилсэн, халамж нийгмийн хамгаалал хөгжсөн, авторитаризмыг устгахын төлөөх хичээл зүтгэл, ардчилсан хөдөлгөөнөөс хохирол амссан хүмүүст нөхөн төлбөр олгох зэрэг чухал амжилт гарсныг дурьдсан байдаг.

Им Хён Бэк судлаач БНСУ-ын ардчиллыг Латин Америк болон Зүүн Европын ардчилалтай харьцуулж богино хугацаанд үгүй болох юмуу авторитар дэглэмдээ буцаж ухрах асуудал гараагүй гэж дүгнэсэн байна. Ийнхүү ардчилал бат тогтсоны шалтгаан бол нэгдүгээрт, эдийн засгийн хөгжил, хоёрдугаарт, үндэстний хувьд нэгдмэл, гуравдугаарт, шашны эрх чөлөө, дөрөвдүгээрт, үр ашигтай засаглал, тавдугаарт, улс төрд цэрэг армийнхний оролцоо байхгүй болсонтой холбоотой гэжээ (임혁백, 1997:130).

Дүгнэж хэлэхэд 1993 оны Ким Ён Сам ерөнхийлөгчийн ардчилсан засаглал гарснаар ардчилсан үзэл бат тогтож 32 жилийн нүүрийг үзэж байна. Нийт найман удаагийн ерөнхийлөгчийн, арван удаагийн УИХ-ын сонгууль үндсэн хуулийн дагуу тайван арга замаар төрийн эрх баригчид солигдож байсан юм. Гэсэн хэдий ч ерөнхийлөгчийг огцруулах томоохон улс төрийн маргаан гурван удаа гарсан боловч асуудлыг үндсэн хуулийн дагуу мөн л тайван байдлаар шийдвэрлэсэн байна. Энэ бүхнээс Солонгос улсад ардчилсан үзэл баримтлал бат тогтсон хэмээн үзэх нь зүйтэй. Үүний зэрэгцээ олон улсын зүгээс ч эерэг дүгнэлтийг маш олноор хийж байгаа ч ардчилсан үзэл баримтлал, түүний хөгжлийн явцад шийдвэрлэх ёстой олон асуудал байгааг үгүйсгэхгүй.

### 3.3 БНСУ-ын ардчилалд хувь нэмэр оруулсан хөдөлгөөн бусад хүчнүүд

Өмнөх хэсэгт БНСУ-ын ардчиллын түүх, ардчилалд шилжсэн болон хэрхэн бат тогтсон тухай судаллаа. Одоо энэхүү хэсэгт ардчиллыг хөтлөн удирдаж, түүний хөгжил, төлөвшилд хувь нэмэр оруулсан хүчнүүдийн тухай авч үзье. 1960 оны 4.19 ардчилсан хувьсгалаас эхлээд 1987 оны 6 сарын ардчиллын төлөөх тэмцэл хүртэл 30 жилийн туршид ардчиллын төлөө хүчин чармайлт гаргаж тэргүүн эгнээнд тэмцсэн удирдагчид болон ямар хөдөлгөөнүүд байв? Эдгээр удирдагчид, хөдөлгөөнүүд нь хэрхэн бүхнээ зориулж, үүрэг гүйцэтгэж, ардчиллыг амжилттай болгосон бэ?

Судлаач Жон Хэ Гү 1980-аад оны үед ардчилсан хөдөлгөөнд асар том нөлөөлөл үзүүлсэн гол дөрвөн бүлгийн онцлог, хандлагын талаар авч үзжээ (Хүснэгт 19).

Хүснэгт 19. 1980-аад оны үед ардчилсан хөдөлгөөнд нөлөөлсөн бүлэг, онцлог

| Бүлэг                            | Онцлог                                                                                        | Хандлага                           |
|----------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|------------------------------------|
| Оюутны хөдөлгөөн                 | Асар их хүний нөөц<br>Ардчиллын төлөөх хөдөлгөөний дайчид                                     | Радикал<br>Гал халуун              |
| Улс төрийн сөрөг хүчний нам      | Шинэ ардчилсан нам<br>Ардчиллыг хэрэгжүүлэх хөдөлгөөн<br>Улс төрийн нөхцөл байдлыг үзэх       | Харилцан тохиролцох<br>Радикал бус |
| Шашны хүчин                      | Улс даяар тархсан сүлжээ                                                                      | Ёс суртахуунлаг                    |
| Ардчиллын төлөөх нам бус хүчнүүд | Нийгмийн бүх салбар ба улс даяар ардчиллын төлөө нэгдсэн хувь хүн ба иргэний нийгмийн бүлгүүд | Дунд зэрэг                         |

Оюутны хөдөлгөөн нь урам зориг, үнэт зүйлээр цэнэглэгдсэн, тухайн нийгмийн хатуу харгис дэглэмийг эсэргүүцсэн их дээд сургууль, коллежийн олон мянган оюутан залуусыг хамарч, тэд ч гал халуунаар тууштайгаар тэмцсэн онцлогтой. Үүний зэрэгцээ шашны итгэл үнэмшилтэй ард иргэд, тэднийг ёс суртахуунлаг аж амьдралд номлон чиглүүлдэг сүм хийдийнхэн, иргэний нийгмийн бүлэг болон хамгийн гол хүчин болох улс төрийн сөрөг хүчний нам гэсэн дөрвөн хүчин ардчилал биелэлээ олоход маш том хувь нэмрийг оруулсан түүхтэй.

Судалгаанд БНСУ-ын хөдөлгөөнийг тэргүүлж байсан гол чухал хүчнүүд бол оюутны хөдөлгөөн, хувь хүн ба иргэний нийгэм, нийгмийн дундаж давхарга, шашин хэмээн дөрвөн том бүлэгт хуваан авч үзлээ. Ардчиллын хөдөлгөөний гол хүчин болох улс төрийн сөрөг хүчний намын тухай судалгаанд авч үзээгүй. Учир нь улс төрийн намууд нь төрийн эрхийг барих зорилготой бөгөөд улс төрийн нөхцөл байдлыг харгалзаж үзэхээс аргагүй хязгаарлагдмал нөхцөлтэй байдаг юм.

#### (1) Оюутны хөдөлгөөн

1960 оны 4.19 ардчилсан хувьсгалаас 1987 оны тэмцэл хүртэл бүхий л хөдөлгөөнд оюутнууд хамгийн гол хүчин болж тэргүүн эгнээнд явсан билээ.

Юү Юун Тэ болон бусад судлаачдын үзсэнээр 1960-1990-ээд оны дунд үе хүртэл цаг хугацааг “оюутны хөдөлгөөний үе” хэмээн нэрлэсэн юм (유용태 & 2인, 2020:19). Тэрээр энэ цаг

хугацаанд Солонгос улс даяар их дээд сургуулийн оюутнууд хөдөлгөөнд гал халуун идэвхтэй оролцож байлаа. Тухайлбал, 4.19-ний ардчилсан хувьсгал, Япон улстай дипломат харилцаа сэргээх шийдвэрийн эсрэг тэмцэл, Пусан ба Масан хотын тэмцэл, 5.18-ны Гуанжүгийн хөдөлгөөн, 6 сарын тэмцэл зэрэг хөдөлгөөнүүдэд тэд манлайлан оролцсон гэдгийг онцгойлон хэлэх нь зүйтэй. Оюутнууд энэ бүх тэмцлийн гол эзэн байсан бөгөөд маш том золиос гаргасан гэдгийг түүхэн үйл явдал, баримтууд маш тодорхой харуулдаг. Үүний үр дүнд ардчилсан үзэл баримтлал нэг нэг алхмаар урагшилсан учраас оюутны хөдөлгөөнийг ярихгүй байх ямар ч боломжгүй. Жон Жү Шин судлаачийн хувьд ч хөдөлгөөний төвд оюутан, залуучууд үргэлж байсан бодит түүхийг судалж, дараах тайлбар өгч байна (정주신, 2022). Тэрээр ихэнх тэмцлийн ард цэргийн дарангуйлагчид байсан бол ардчиллын төлөөх тэмцэл болгонд оюутан залуучуудын гал халуун зүрх сэтгэл, шударга хандлага байсан учраас авторитаризмыг зогсоохыг, цэргийн дарангуйллыг дуусгахыг, үндсэн хуулийг буруу ашиглахын эсрэг чанга дуу хоолойгоор шаардаж байсан гэжээ. Ингэж залуучууд, оюутнууд гарч ирснээр ард олны үзэл бодол ч өөрчлөгдөж байсан юм. Ухамсарлаж, зүтгэдэг хүмүүс дэлхийг өөрчилдөг шиг оюутнуудын үүрэг, оролцоо улс үндэстний хувь заяаг өөрчлөхөд асар том нөлөөлсөн хэмээн онцолж, түүхэнд оюутны хөдөлгөөнийг дурдахгүй байж болохгүй гэдгийг ард олон болон бүх судлаачид хүлээн зөвшөөрдөг. Оюутны хөдөлгөөн нь зөвхөн сургуулийн дотоодод биш улс төр, нийгмийн бүхий л салбарт өрнөж өргөн хүрээнд хэрэгжсэн билээ.

Судлаачид оюутны хөдөлгөөнийг дараах гурван агуулгад хуваан үздэг. Үүнд:

- Сургуулийн дотоод асуудлыг шийдвэрлэхийн төлөөх хөдөлгөөн
- Сургалтын академик эрх чөлөө буюу сургуулийн бие даасан байдлыг гадны дарамт шахалтаас хамгаалахын төлөөх хөдөлгөөн
- Улс төр, нийгмийн болон сургуулийн гадаад орчны асуудлыг шийдвэрлэх хөдөлгөөн байна (유용태 & 2인, 2020:20).

Ардчиллын түүхэнд гарсан оюутны хөдөлгөөн нь дээрх ангилалын гурав дахь буюу улс төр, нийгмийн сайн сайхны төлөөх, сургуулийн гадаад орчны асуудлыг шийдвэрлэх зорилготой байсан юм. Энэ талаар Ким Мин Чан судлаачийн үзсэнээр “Оюутнууд улс үндэсний хэмжээнд улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л тогтолцооны асуудлыг шийдвэрлэхийн тулд идэвхтэй оролцож, улс төрийн үйл явцад чухал нөлөө үзүүлсэн хөдөлгөөн байлаа”.

Түүнчлэн О Сэ Ён судлаач оюутны хөдөлгөөний түүх ба тэмцлийн нөхцөл байдлын талаар судалсан бөгөөд сургуулийн орчинд эвсэн нэгдэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёл зэрэг бүх салбарын бодит асуудалд хүчтэйгээр идэвхтэй оролцох оюутны оролцоо нь нийгэмд асар том үр нөлөө үзүүлж, авторитаризмын эсрэг улс төр, нийгмийн ардчилалд том хувь нэмэр оруулсан(오세연, 2014:307) хэмээн үнэлжээ. 1980-аад он хүртэл иргэний нийгэм төдийгүй хөдөлмөрчин анги давхрагынхан сул дорой байсан учраас оюутны хөдөлгөөн нь улс төрийн эрх баригчдын эсрэг гол хүч болон гарч ирсэн. Оюутны анхны хөдөлгөөн (김민찬, 2004:31), ардчиллын үзэл баримтлалын хөгжилд түүхэн эргэлтийн цэг хэмээн нэрлэгддэг 1960 оны 4.19-ны хувьсгалаар эхлэн 1993 онд тэмцэл хүртэл улам өргөжин тэлж хөгжлийн эргэх цэг, дараа дараагийн улс төрийн хөгжлийн стандарт болсон байна (최용섭, 1994:101).

1948 онд анхны засгийн газар байгуулагдсанаас хойш авторитаризмын эсрэг тэмцэлд оюутны хөдөлгөөн асар их оролцоотой үүрэгтэй байлаа.

Судлаачид тэр дундаа Юү Юун Тэ судлаач нь тэргүүний гэгдэх Сөүлийн их сургуулийн оюутны хөдөлгөөний түүхийг 1960-1990 он хүртэлх таван үед хувааж үзсэн байна (유용태 & 2인, 2020). Түүнийхээр 1960-аад оноос өмнөх үед оюутны зөвлөл, эрдмийн бүлгээр эхэлж байсан оюутны хөдөлгөөн нь дэлгэрэлтийн үедээ хувьсгалд оролцохоор идэвхжиж, цэргийн дэглэм, улс төрийн эрх мэдлийг урт удаан хугацаанд барих зэрэг бусармаг явдыг эсэргүүцэн өргөжсөн байна. Улмаар 1970-аад оноос коммунист үзэл суртлыг эсэргүүцсэн тэмцэл болж, 1990 он хүртэл улс төр нийгмийн нөхцөл байдлыг бүхэлд нь өөрчилсөн хувьсгалыг хийжээ.

Хүснэгт 20. Сөүлийн их сургуулийн оюутнуудын хөдөлгөөний түүхэн үе

| Цаг             | Үе                     | Оюутны хөдөлгөөний түүх                                                                                                                                                                                                                                                                           |
|-----------------|------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1960 оноос өмнө | Эхлэл үе               | <ul style="list-style-type: none"> <li>- Сөүлийн их сургууль байгуулагдсан</li> <li>- Оюутнуудын зөвлөл, эрдмийн бүлэг байгуулсан</li> </ul>                                                                                                                                                      |
| 1960-аад он     | Дэлгэрэлт үе           | <ul style="list-style-type: none"> <li>- 4.19 ардчилсан хувьсгал</li> <li>- Оюутнуудын үйл ажиллагаа идэвхжил</li> <li>- 5.19 цэргийн улс төрийн эргэлт</li> <li>- Япон улстай дипломат харилцааг сэргээхийн эсрэг тэмцэл</li> <li>- Төрийн эрхийг урт удаан барих явдлыг эсрэг тэмцэл</li> </ul> |
| 1970-аад он     | Сөргөлдөөний үе        | <ul style="list-style-type: none"> <li>- Пак Жон Хи ерөнхийлөгчийн үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг эсэргүүцсэн тэмцэл</li> <li>- Оюутны хөдөлгөөний хавчлага</li> <li>- Онцгой байдлын тухай хуулийг эсэргүүцсэн тэмцэл</li> <li>- Коммунист үзэлтэй эрх баригчдыг эсэргүүцсэн тэмцэл</li> </ul> |
| 1980-аад он     | Хувьсгалын үе          | <ul style="list-style-type: none"> <li>- Цэргийн шинэ дарангуйлагч бүлгийн эсрэг тэмцэл</li> <li>- Оюутны хөдөлгөөний радикал үзэл</li> <li>- Хөдөлмөрчдийн нэгдэл</li> <li>- 6 сарын ардчиллын төлөөх тэмцэл</li> <li>- Хоёр Солонгос нэгдэх асуудалд анхаарал тавих</li> </ul>                  |
| 1990-аад он     | Өөр арга замыг хайх үе | <ul style="list-style-type: none"> <li>- Улс төр ба нийгмийн нөхцөл байдлыг өөрчилсөн</li> <li>- Радикал хөдөлгөөн дууссан</li> <li>- Өөрчлөх арга замыг хайдаг оюутны хөдөлгөөн</li> </ul>                                                                                                       |

1990-аад оноос хойш оюутны хөдөлгөөнийг өөрчилж шинэчлэхээс аргагүй нөхцөл байдалд хүрсэн юм. Өмнөх хөдөлгөөний үйл ажиллагааны гол утга учир нь авторитаризмын эсрэг, төрийн эрхийг урт хугацаанд барих цэргийн дарангуйлагчдын эсрэг байсан бөгөөд 1980-аад оны тэмцлээр өндөрлөсөн юм. Харин ардчилал тогтсоны дараа оюутны хөдөлгөөн өөрчлөгдөх болсон гол шаардлагыг И Сэ Ён нь дараах хүчин зүйлтэй холбон үзэж байна (이세영, 2021). Үүнд:

- . 1990 он хүртэлх олон үйл явдлын нөлөөгөөр их сургуулийн нийгэм, соёл, төдийгүй оюутнуудын оюун санаанд ч маш их өөрчлөлт гарсан.
- . Их сургуульд өрсөлдөөний соёл бүрдэж, оюутнууд сургуулиа төгссөний дараа ажлын байртай болохын тулд цаг заваа илүү зарцуулах нөхцөл

байдалтай тулгарах болсон.

- . Коммунизм нурсан нь оюутнуудын үзэл суртал, оюун санааг их өөрчилсөн ба 1980 оны төгсгөл үеэс хуучин ЗХУ-д коммунист дэглэм нуран унаснаар радикал үзэл боломжгүй болсон.
- . Оюутны хөдөлгөөн дангаараа ирээдүйн замыг сайнаар тодорхойлох боломжгүй юм.

И Сэ Ён-ий үзлийг дэмжиж судлаач Жон Су Хён ч гэсэн оюутны хөдөлгөөн өөрчлөгдөхөөс аргагүй болсон нөхцөл байдлын талаар дараах тайлбар өгч байна (정소흔, 1998). Тэрээр нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж ардчилалд шилжсэний дараа үзэл санаа улам бэхжиж байгаа. Үүний зэрэгцээ иргэний нийгмийн байгууллагууд хүчирхэг нөлөөтэй болж байгаа нөхцөлд оюутны хөдөлгөөн хэт үзэл сурталжих, радикал болох зэрэг сөрөг байдлыг олон нийт ч хүлээн зөвшөөрөхгүй байна. Оюутны хөдөлгөөний тухай шүүмжлэл засаг захиргаа, нийгмийн бүлгүүдээс төдийгүй хөдөлгөөний дотроос ч янз бүрээр гарч байгаа нь бодит үнэн гэжээ.

Ийнхүү 1993 оноос хойш их дээд сургуулийн дотоод, гадаад орчин нөхцөл, уур амьсгал ихээр өөрчлөгдөж, оюутны хөдөлгөөн улс төр, нийгмийн асуудалд оролцох орон зай улам бүр хумигдах болсон юм. Түүнчлэн тэмцлийн үед хөдөлгөөнийг удирдаж байсан хүмүүсээс улс төрийн намд ажиллаж байгаа хүн ч цөөнгүй байна. 2000 оноос хойш улс төр, нийгмийн асуудлыг шийдвэрлэх гол үүрэг оюутны хөдөлгөөнөөс иргэний нийгмийн байгууллагуудад шилжээд байна. Ингэж хөдөлгөөнд оролцох хүмүүс цөөрсөөр улс төрөөс ангид уур амьсгалтай болсоор байна. 1990 он хүртэл хөдөлгөөний зохион байгуулалтын төв байсан оюутны холбоо, эрдмийн бүлэг, сонирхлын сайн дурын бүлгүүдийн үйл ажиллагаа өнөө үед илүү бие даасан, сайн дурын шинжтэй болсон билээ (정다혜, 2021:206).

Дээрхээс дүгнэж үзвэл 1960 оны 4.19-ний ардчилсан хувьсгалаас 1987 оны 6 сарын бүхий л тэмцлийн тэргүүн эгнээнд явсан хамгийн том хүч бол оюутны хөдөлгөөн байсан гэдгийг онцлон тэмдэглэж байна. Оюутнууд маш олуулаа эвсэн нэгдэж, залуу хүний гал халуун зүрх сэтгэлээр шударга бус, ардчилсан бус авторитар дэглэмийн эсрэг зогссон нийгмийн хүч байлаа. Тэд ардчиллын төлөө радикал, заримдаа хүчирхийллийн аргыг ч ашиглаж байсан юм. Харин 1993 оноос ардчилалд шилжсэний дараа хөдөлгөөний зарим удирдагчид улс төрд, иргэний нийгэмд, улс төрөөс ангид ардчиллын хүчин болж ажиллаж байгааг дээр дурьдсан билээ. 2000 оноос хойш оюутны хөдөлгөөний улс төрийн үйл ажиллагаа сулрахаас аргагүй нөхцөл байдалтай болсон юм.

## **(2) Ардчиллын төлөөх нам бус хүчин**


Оюутны хөдөлгөөнөөс гадна түүхэнд маш том үр нөлөө үзүүлсэн гол хүчний нэг бол ардчиллын төлөөх нам бус хүчин байлаа. Энэ талаар И Жон Хи “Түүхэнд ардчиллын төлөөх нам бус хүчин маш том үүрэг гүйцэтгэсэн юм. Тэд Япон улстай дипломат харилцааг сэргээхийн эсрэг, ерөнхийлөгчийн 3 удаа сонгогдох эрхийг үндсэн хуулиар баталгаажуулахын эсрэг, Гуанжүгийн ардчилсан хөдөлгөөн, 6 сарын тэмцэл амжилтай болж ардчилсан засаглал байгуулагдах хүртэл хэцүү хүнд тэмцлийг зохион байгуулсан” гэжээ (이정희, 1999).

Чои Хён Мён ч “Иргэний нийгэм хараахан хөгжөөгүй тухайн нөхцөл байдалд нам бус ардчилсан хүчин онцгой ажиллаж байсан. Тэд нар 1970-аад оны үед нийгмийн онцгой нөхцөл байдлаас болж ажил хөдөлмөр болон газар тариалан эрхэлж байсан хүмүүс төдийгүй бусад хүчнүүдтэй ч эвсэн нэгдэх үзэлтэй байсан юм” хэмээн тэмдэглэжээ (최현명, 2001:13).

Түүнчлэн Жон Хэ Гү нь улс төрийн намуудын гаднах хүчний талаар маш тодорхой тайлбар өгсөн байна (정해구, 2017:65). Нам бус ардчилсан хүчин гэдэг нь зөвхөн улс төрийн сөрөг хүчин бус харин бүх хөдөлгөөнийг хэлэх бөгөөд оюутны болон ажилчид, хөдөлмөрчдийн хөдөлгөөнөөс гадна бусад хүчин багтаж байлаа. Эдгээрт шашны болон сонин хэвлэлийн салбар, зохиолч, хуульч, профессор багш зэрэг мэргэжлийн хүмүүс хөдөлгөөнд идэвхтэй оролцож байсан олон мэргэжилтэн, сэхээтэн, хуучин оюутны хөдөлгөөнд ажиллаж байсан иргэд байсан юм. Энэ талаар Жон Хэ Гү нь “Хөдөлгөөний онцлог бол гол хүчин болох оюутны хөдөлгөөн, сэхээтэн, шашны хүмүүсийг оролцуулсан нам бус ардчилсан хүчнүүд төвлөрсөн тойрог хэлбэртэй байсан гэдэг тайлбар өгч байна (정해구, 2010:36).

Тэрээр тойргийн төвд оюутны хөдөлгөөн оршиж, түүнийг сэхээтэн ба шашны хүмүүс хүрээлж, түүний гадна тойрогт цаг үеийн нөхцөл байдалд аажмаар оролцож байсан иргэний нийгэм ба улс төрийн сөрөг хүчний намууд байв. Энэ тойргийн хамгийн гадна талд ардчилсан хөдөлгөөнд олноороо оролцохоор ирсэн ард түмэн байлаа гэжээ.

Зураг 2. БНСУ-ын ардчилсан хөдөлгөөний гол хүчин



Улс төрийн намуудын гаднах ардчилсан хүчин улс төрийн систем бүтцийн гаднаас нь ажилладаг бөгөөд 1960 оны 4.19 ардчилсан хувьсгал, 1961 оны 5 сарын цэргийн эргэлтийн дараа байгуулагдаж эхэлсэн юм. Хамгийн анхны хүчин бол 1963 онд байгуулагдсан “Япон улстай дипломат харилцааг сэргээхийн эсрэг бүх ард түмний хороо” байлаа. Пак Жон Хи ерөнхийлөгч Япон улстай дипломат харилцааг сэргээх гэж байгааг эсэргүүцэх тэмцэлд сөрөг хүчний нам болон шашин, нийгэм, соёлын байгуулагуудын төлөөлөгчид зэрэг 200 гаруй хүмүүс оролцсон. 1964 оноос хойш 1987 оны 6 сарын тэмцэл хүртэл цэргийн дарангуйллын эсрэг хамгийн том ардчилсан хүчний талаар хүснэгт 21-ээс үзнэ үү (정해구, 2017).

Хүснэгт 21.1964-1980-аад оны ардчиллын төлөөх нам бус хүчнүүд

| Байгуулагдсан цаг | Ардчилсан хүчний нэр                                                                                                         | Зорилго                                                           |
|-------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------|
| 1969. 7           | Ерөнхийлөгчийг дараалан гурван удаа сонгогдох тухай үндсэн хуульд өөрчлөлт оруулахыг эсэргүүцсэн бүх ард түмний тэмцлийн төв | Пак Жон Хи ерөнхийлөгчийн 3 дахь удаа дахин сонгохыг эсэргүүцсэн. |
| 1971. 4           | Ардчиллыг хамгаалах бүх ард түмний эвсэл                                                                                     | Ерөнхийлөгчийн сонгуульд хяналт тавих                             |
| 1978. 7           | Ардчилсан үзэл баримтлалтай бүх ард түмний эвсэл                                                                             | Цэргийн дарангуйллын эсрэг                                        |
| 1979. 3           | Ардчилсан үзэл баримтлал ба хоёр Солонгосыг нэгтгэх бүх ард түмний нэгдэл                                                    | Цэргийн дарангуйллын эсрэг ба хоёр Солонгос нэгдэх                |
| 1984. 6           | Ард олны ардчилсан хөдөлгөөний холбоо                                                                                        | Цэргийн дарангуйлагч шинэ цэргийн бүлгийн эсрэг                   |
| 1984. 10          | Ардчилал ба нэгдлийн бүх ард түмний хурал                                                                                    | Цэргийн дарангуйлагч шинэ цэргийн бүлгийн эсрэг                   |
| 1987. 5           | Үндсэн хуульд өөрчлөлт оруулах бүх ард түмний тэмцлийн төв                                                                   | Ардчилал, хүний эрх                                               |

Ардчилсан хөдөлгөөнийг дурсах нийгэмлэгээс гаргасан “БНСУ-ын ардчиллын хөдөлгөөний түүх” номонд 1980-аад оны хөдөлгөөнд нам бус хүчний үүрэг асар их байсныг тэмдэглэсэн байна (민주화운동기념사업회 한. , 2010:394).

Тэд ардчилал ба хоёр Солонгос нэгдэх бүх ард түмний нэгдлийг 1985 онд, үндсэн хуульд өөрчлөлт оруулах бүх ард түмний тэмцлийн төвийг 1987 оны 5 сард тус тус байгуулж 6 сарын үйл ажиллагааг удирдсан юм. Тиймээс 1987 оны 6 сарын тэмцлийг зохион байгуулж удирдсан гол хүчин бол ардчилсан хүчин байсан гэж үздэг.

Ардчилсан хүчнүүд хөдөлгөөнийг улам эрчтэй болгохын тулд сөрөг хүчний намуудтай ч хамтрах болсноор бүгд эвсэн нэгдэж чадсан байдаг. Ингэж нэгдсэн хөдөлгөөнүүд асар том хүч болж 1987 оны тэмцлийг амжилттай дуусгах чухал үүргийг гүйцэтгэжээ. Ардчилсан хөдөлгөөний түүхэнд анх удаа оюутны хөдөлгөөн, нам бус хүчин, сөрөг хүчний намын Ким Ён Сам, Ким Дэ Жүн нар тухайн үеийн нийгмийн дундаж давхарга, ард олон бүгд хамтдаа нэгдэж тэмцсэн байна (조현연, 2017:110). Энэ үйл явдал дахин давтагдашгүй анхны бөгөөд сүүлийн үйл явдал байлаа.

1960 оны 4.19-ний ардчилсан хувьсгалын дараа авторитаризмын эсрэг ардчилсан хүчнүүд бий болж улмаар 1980-аад онд тэд гол хүчин хэвээр бэхжин ардчиллыг тэргүүлж удирдсан болно.

### (3) Нийгмийн дундаж давхарга

БНСУ-ын ардчилсан хөдөлгөөний 27 жилийн түүхэнд гол хөдөлгөгч нь оюутны хөдөлгөөн болон улс төрийн нам бус ардчилсан хүчин байсан бол 1980-аад оны хөдөлгөөнд дээрх хоёр том хүчнээс гадна ард иргэд буюу нийгмийн дундаж давхаргынхан байлаа.

Ялангуяа ардчилалд шилжих түүхэн эргэх цэг болох 1987 оны ардчилсан хөдөлгөөний хувьд оюутнууд ба хөдөлмөрчид зэрэг уламжлалт эрх баригчдын эсрэг зогссон нийгмийн бүлэг төдийгүй тэдэнд эерэг хандлагатай байсан дундаж давхарга ч идэвхтэй оролцсон нь маш том онцлог байсан юм (김성수, 2003). И Ён Жэ нь 6 сарын ардчилсан тэмцлийн үед дундаж давхаргынхны үзэл бодол, хандлагын өөрчлөлтийн талаар дараах тайлбар өгч байна (이영제, 2010).

6 сарын тэмцэлд чухал үүрэг гүйцэтгэсэн дундаж давхарга нь анхнаасаа хөдөлгөөнд нэгдээгүй байсан юм. Тэд энэхүү тэмцэлд тийм ч сайн зохион байгуулалттай орж чадаагүй олон нийт байсан бөгөөд тэд эгэл жирийн хувь хүн, ард иргэд байжээ. Тэмцлийн эхэн үед оюутнууд болон ардчилсан хүчнийг идэвхгүй дэмжигчид байсан бол яваандаа тэмцэлд идэвхтэй оролцогчид болж өөрчлөгдсөн.

1960-1970 оны сүүл хүртэл 19 жилийн турш төрийн эрхийг барьсан Пак Жон Хи улс төрийн хувьд авторитар дэглэмийн цэргийн дарангуйлагч байсан боловч эдийн засгийн хувьд аж үйлдвэржүүлэлт, орчин үеийн хүнд, хөнгөн үйлдвэрийг маш эрчимтэй хөгжүүлэх бодлогыг амжилттай хэрэгжүүлснээр эдийн засаг маш хурдацтай өссөн. Эдийн засгийн хөгжлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлснээр газар тариалангийн аж ахуй эрхэлдэг улс орноос орчин үеийн аж үйлдвэржсэн улс болтлоо өөрчлөгдсөн ба дундаж давхарга хэмээх нийгмийн шинэ бүлгийг төрүүлсэн.

1980-аад он гэхэд өөрсдийгөө нийгмийн дундаж давхарга хэмээн тодорхойлдог хүмүүсийн тоо нийт хүн амын 70 орчим хувь байсныг мэдээлсэн сонин хэвлэл ч олон байлаа (이창근 & 황수경, 2024:8). Эдгээр хүмүүс тэмцэлд олноороо идэвхтэй оролцох болсоноор ардчиллын шинэ үе нээгдсэн юм. Учир нь хөдөлгөөнд оролцогч оюутнууд болон бусад хүчний оролцогчид тийм ч олон биш байсан аж. Гэвч 1987 оны тэмцэлд хүн амын 60 хувь орчмыг бүрдүүлэгч дундаж давхаргынхан олноор идэвхтэй оролцсоноор ард олны асар их тэмцэл болж хүчигхэгжиж чаджээ. Энэ тухайд Юу Хэ Шин нь дараах тайлбарыг өгч байна (유해신 (2023), 2025). “6 сарын тэмцэл ардчилсан хүчин болон оюутны тэмцлээс хальж нийгмийн дундаж давхарга буюу жирийн ард түмэн маш олноор сайн дураар идэвхтэй оролцсон хөдөлгөөн байв. Ялангуяа зангиатай 20-30 насны “цагаан захтан (white collar)” гэгдэх мэргэжилтэн, ажилтнууд маш олноороо оролцсон. Мёндун Католик сүмд болсон жагсаал цуглаан, суултад зангиатай залуус, дунд давхаргынхан ирж тэмцлийн амжилтанд том хувь нэмэр оруулсан” гэжээ.

И Жүн Хан ч судлаач мөн адил 1987 оны 6 сарын тэмцлийн гол дүр бол дундаж давхаргын иргэд байсан, тэдний идэвхтэй оролцоо ардчиллыг амжилтад хүргэхэд асар том үр нөлөөтэйг онцолжээ (이준한, 2015:5). 1987 оны 6 сарын тэмцэлд улс үндэстнээ хайрлах оюутнуудын золиослол төдийгүй шударга бус засаглалтай тэмцэх зоригтой дундаж давхаргын иргэд олноор оролцсон нь гурав дахь хөдөлгөөний доороос нь эхэлсэн ардчилсан хөдөлгөөний загварын хамгийн том амжилтын жишээ байсан юм. Ийнхүү 1970, 80-аад оны эдийн засгийн хөгжлийн үр дүнд бий болсон нийгмийн дундаж давхаргынхан 6 сарын тэмцлийг амжилттай болгожээ.

Ким Сон Сү нь 1980-аад оны үеийн нийгмийн дундаж давхаргын нөхцөл байдал, үзэл

бодлын өөрчлөлт, хөдөлгөөнд оролцсон талаар дараах тайлбар өгч байна (김성수, 2003:157). 1980-аад оноос өмнө дундаж давхаргад багтаж байсан Солонгос иргэд улс төр, нийгмийн хөдөлгөөнд шууд идэвхтэй оролцож чаддаггүй байсан. Эдийн засгийн хөгжлийн үр дүнд тэдний амьдралын түвшин дээшилж, сэтгэл хангалуун амьдрах боломж бүрдсэн байсан ч ард олны эрх чөлөө, улс төрийн шударга бус байдал зэрэг асуудал, дарангуйлалд дуугүй өнгөрч байсан юм. Гэвч 1987 оны тэмцэлд өмнө нь байгаагүйгээр дундаж давхаргын хүмүүс оролцсон байдаг. Учир нь 1980-аад оноос хойш эдгээр хүмүүсийн улс төрийн үзэл бодол өөрчлөгдөж хүний эрх, эрх чөлөө, шударга бус байдлаас улс төр, нийгмийн асуудалд оролцох оролцоо улам нэмэгдсэн юм. Тэд авторитар засаглал улс төрийн эрх чөлөөг хязгаарлаж, хүний эрхийг зөрчих явдлыг шүүмжилж сөрөг байр суурьтай болсон юм.

Нийгмийн дундаж давхаргын иргэд гэдэг нь орлого болон нийгмийн байр суурийн хувьд дээд болон доод давхаргад багтаагүй хүмүүсийг хэлэх бөгөөд энгийн утгаар баян биш боловч амьдрахад хангалттай санхүү хөрөнгөтэй, өдөр тутмын хоол хүнсэндээ санаа зовохооргүй амьдралын түвшинд багтах хүмүүсийг хэлнэ (황수경&이창근, 2024:3).

Тэгвэл 1980-аад оны үеэс нийгмийн дундаж давхаргын хүмүүс улс төр, нийгмийн асуудалд идэвхтэй оролцох болсон учир шалтгаан нь юу байна вэ? 1980-аад оны үеийн Солонгосын нийгмийн дундаж давхаргын хүмүүсийн үзэл бодлын өөрчлөлт, улс төрийн хандлагыг Хан Сан Жин судлаач дараах гурван өнцгөөс тайлбарлаж байна (한상진, 1986). Үүнд:

- . Юуны өмнө улс төрийг ардчилах, энэ нь ард түмний хүсэл зоригт үндэслэх ёстой бөгөөд төрийн эрх баригчдын дарангуйллыг хянах сөрөг хүчин ба хууль дүрэм хэрэгтэй гэж үзсэн.
- . Сонин хэвлэлийн эрх чөлөө чухал байсан. 1970-аад оны үед сонин хэвлэлээр дамжуулж худал мэдээ түгээх, зөвхөн эрх баригчдад ашигтай мэдээ тараах асуудлыг шүүмжилж байжээ.
- . Нэг хүнд хэт төвлөрсөн улс төрийн эрх мэдэл маш том асуудалтай гэж үзэж байсан юм. Эдийн засгийн хөгжлийн үр дүнд нийгмийн олон талт үзэл хандлага нэмэгдсэн юм.

Ийнхүү нийгмийн дундаж давхаргынхан ардчиллын хөдөлгөөнд оролцсон нь зөвхөн тухайн үеийн үзэгдэл байсан гэж үзэж байгаа судлаачид ч байна. Тухайлбал И Ён Жн нь “1987 оны 6 сарын тэмцэлд дундаж давхаргын хүмүүс идэвхтэй оролцсон нь түр зуурын явдал гэж үзэж болно. Тэд тухайн үеийн сөрөг хүчний улс төрч болох Ким Дэ Жүн ба Ким Ён Самыг дэмждэг хүмүүс байсан бөгөөд түр гарч ирээд алга болсон” хэмээн дүгнэж байна (이영제, 2010:139-140).

Дүгнэж хэлэхэд 1980 оны тэмцлийн түүхэнд нийгмийн дундаж давхаргын иргэдийн үүргийг дутуу үнэлж болохгүй гэж бодож байна. Хэрэв тэмцэлд зөвхөн оюутны хөдөлгөөн, нам бус ардчилсан хүчин оролцсон бол улс даяар хэдэн сая хүн оролцсон тэмцэл асар их хүчийг бий болгож чадахгүй байсан гэж үзэж болно. Нийгмийн дундаж давхаргынхан маш олуулаа, асар их хүчээр оролцсоноор 1987 оны ардчилал амжилттай болсон гэж дүгнэж болно.

#### **(4) Шашны хүчин**

Ардчиллын түүхэнд оюутны хөдөлгөөн, улс төрийн нам бус ардчилсан хүчин, нийгмийн дундаж давхаргынхантай хамт шашныхан ихээр нөлөөлсөн юм. 1960-аад оны үеэс Христос,

Католик, Буддын шашин улс төр, нийгмийн шударга байдал, хүний эрхийг дээшлүүлэх зорилгоор ардчилсан хөдөлгөөнд идэвхийлэн оролцсон түүх бий. Тухайлбал 20-р зууны эхэнд 36 жилийн турш Японы колони байсан Солонгос улс 1919 оны 3.1-нд тусгаар тогтносон улс болохын төлөө бүх ард түмний тэмцлийг хийсэн юм. Энэ тэмцлийн төвд Христос шашны байгууллагууд тэдний хүч байсан юм.

Солонгосын ардчилсан үзэл баримтлалын судалгааны хүрээлэнгээс 1987 оны 6 сарын тэмцлийг 1919 оны 3.1-ийн тусгаар тогтнолын төлөөх тэмцэлтэй төстэй хэмээн онцолсон ба шашны хүчин гол үүргийг гүйцэтгэсэн талаар дараах тайлбар өгч байна (민주화운동기념사업회 한., 2010:394).

6 сарын тэмцэл нь олон талаасаа 3.1-ний тусгаар тогтнолын тэмцэлтэй төстэй байна. Энэ тэмцэлд улс даяар шашны хүчин чухал үүргийг гүйцэтгэсэн бөгөөд чуулган, сүмүүд тэмцлийн төв байсны адил 6 сарын тэмцэлд ч Христос шашин, Католик шашин, Буддын шашны лам, пастор, итгэгчид, сүсэгтнүүд олноороо оролцсон. Эдгээр шашны байгууллагууд зохион байгуулалттайгаар хамт байсан бөгөөд сүм чуулган, бусад шашны төв нь хөдөлгөөний төв байсан юм.

Юү Хэ Шин ч гэсэн 6 сарын тэмцэл бол 3.1 тусгаар тогтнолын тэмцэлтэй төстэй гэж үзсэн бөгөөд шашны хүчин чухал үүргийг гүйцэтгэсэн гэжээ (유해신(2023), 2025). Үүнд:

- . Солонгос даяар бүх ард түмэн тэмцэлд идэвхтэй оролцсон.
- . Чуулган сүмүүд нь тэмцлийн төв байсан бөгөөд Христос, Католик, Буддын шашны лам, пастор ба итгэгчид сүсэгтэн олноор оролцсон тэмцлийн гол субъект байсан.
- . Ард түмэн, цагаан захтан гэгдэх залуу мэргэлжилтнүүд 6 сарын тэмцэлд маш олуулаа идэвхтэй оролцож, иргэний нийгэм бүрдүүлэх гол хүчин болсон.

Ардчилал, хүний эрхийг дээшлүүлэхэд шашныхны үүрэг, үр нөлөө маш их байсан нь тодорхой байна. Авторитар засаглалын үед нийгмийн бүх салбарт хяналт дарамт их байсан ч шашны хувьд ерөнхийдөө чөлөөтэй, аюулгүй газар нь сүм чуулган байсан бөгөөд хөдөлгөөнүүд төвлөн суурьших боломжтой байжээ. Энэ ч утгаараа шашны байгууллагууд ардчилсан, хүний эрхийг дээдлэх хөдөлгөөнд нээлттэй оролцов. Ялангуяа цэргийн дарангуйллын үед хөдөлгөөнүүдэд Христос болон Католик шашныхан маш их дэмжин тусалж байсан юм (정호기, 2013). Энэ талаар үгүйсгэх судлаачид байхгүй билээ.

Ийнхүү 1960 оны 4.19 ардчилсан хувьсгалын үеэс шашны байгууллага ардчиллын төлөөх хөдөлгөөнд оролцож нэг том хүчин болох эхлэл тавигдсан юм. Улс төр, нийгмийн асуудалд Христосынхон оролцох болсон шалтгаан нь шударга нийгмийг байгуулах, хүний эрх чөлөөг дээдэлдэг шашны үзэл сурталтай холбоотой гэж хэлж болно.

Энэ талаар Христос шашны нийгмийн асуудлыг судлах хүрээлэнгээс 1960-аад онд Христ итгэлтнүүд улс төр, нийгмийн асуудалд идэвхтэй оролцох болсон учир шалтгаанд дараах тайлбар өгч байна (한국기독교사회문제연구원, 1983:61). 4.19 хувьсгал ба 5.16 цэргийн эргэлтийн нөхцөл байдлын дунд Христийн шашныхан улс төр, нийгмийн асуудалд чимээгүй байж болохгүйг ухаарсан юм. Энэ үеэс дэлхийн Христосынхон улс төр, нийгмийн асуудалд

оролцохтой холбоотой маш олон төрлийн үзэл суртал бий болж, хөдөлгөөнд маш идэвхтэй оролцох болсон юм (김명배, 2012). 1986 оны 4.13-ны өдөр цэргийн дарангуйлагчид үндсэн хуульд өөрчлөлт оруулахгүй хэмээн зарласны дараа энэ үйл ажиллагааг улам хүчтэй явуулж 1987 оны 6 сарын тэмцлийн үүд хаалгийг нээсэн байна.

Солонгос Христ шашны олон урсгал бүлгүүдээс зарим нь улс төр, нийгмийн асуудлыг шийдвэрлэхийн тулд идэвхтэй оролцдог байсан бол зарим урсгал бүлгүүд нь улс төр, шашин бие биеэ дээдлэх ёстой гэсэн зарчмаар огт оролцдоггүй байлаа. Христ шашны олон урсгал бүлгүүдээс хөдөлгөөнд хамгийн идэвхтэй оролцож байсан нь “Солонгос Христос шашны холбоо(NCCK)” байлаа. Түүнчлэн бүх Католик шашныхны төв болох Мёндон Католик сүм нь 1987 оны 6 сарын ардчилсан тэмцлийн төв болсон бөгөөд тэмцэлд идэвхийлэн оролцсон байдаг.

Юун Сон Жа-ны тэмдэглэснээр 1980-аад оны үеийн Солонгос Католик шашныхны нийгмийн оролцоо нь 1970-аад онтой харьцуулахад маш идэвхжиж өөрчлөгдсөн юм. 1979 оны 10.26, 12.12 үйл хэрэг, 1980 оны 5.18 Гуанжүгийн ардчилсан хөдөлгөөн, 1987 оны 6 сарын тэмцэл хүртэл ардчилал ба хүний эрхийн төлөөх бүхий л үйл ажиллагаанд тэд оролцсоор ирсэн юм. Ялангуяа хамгийн идэвхтэй оролцож, нөлөөлсөн бүлэг Католик шашны лам нараас бүрдсэн “Шударга байдлыг хэрэгжүүлэх Католик шашны лам нарын эвсэл (천주교정의구현전국사제단)” байна (윤선자, 2001).

Энэ талаар Сө Жон Сөг судлаач мөн дэмжсэн ба 1970, 1980-аад оны үед ардчиллын хөдөлгөөний түүхэнд энэ эвсэл нь маш онцгой байр суурийг эзэлж, лам нар оюутны хөдөлгөөнөөс дутахгүй тэргүүн эгнээнд зогсон тэмцэж үйл ажиллагаанд гол үүргийг гүйцэтгэж байсан хэмээн тэмдэглэжээ. Тэрээр цааш нь ардчилалтай холбоотой үйл ажиллагаанд лам нар оролцож байсан нь хамгийн хэцүү хүнд үед олон хүнд зориг өгч, ёс суртахууны хувьд маш сайнаар нөлөөлж байсан гэжээ (서중석, 2007). Үүгээр зогсохгүй 6 сарын тэмцэлд хамгийн идэвхтэй оролцож байсан шашны байгууллага бол “Ардчилсан үндсэн хууль батлахын төлөө тэмцэх буддын шашны хороо(민주헌법쟁취불교공동위원회)” байсан юм. Энэ хороог Жи Сон, Чон Хуа ламтан нар удирдаж, Гу Гуан Жин нарийн бичгийн даргаар ажиллаж байжээ (정승안&박수호, 2014).

1960 оны 4.19 хувьсгалаас эхэлж 1987 оны 6 сарын тэмцэл амжилттай дуусах хүртэл хугацаанд Христос, Католик, Буддын зэрэг шашны хүчин ардчилалд ийнхүү том хувь нэмэр оруулсан байна. Харин эдгээр шашны дотроос цэргийн дарангуйллыг дэмждэг хүмүүс ч байсныг үгүйсгэхгүй. Шашны хүчнүүд нь улс үндэстний шударга байдал, хүний эрхийг хамгаалах, авторитар дэглэмийг нурааж эрх чөлөөтэй нийгэм байгуулах зорилгоор хөдөлгөөнд оролцож байлаа.

1960-аад оноос эхэлсэн цэргийн дарангуйлал, авторитаризм 27 жилийн туршид үргэлжилж хүний эрх, эрх чөлөө, ард түмний эрх ашгийг дарангуйлан хязгаарлах үед шашны хүчнүүд зарим нь идэвхтэй зарим нь идэвхгүй байхаас өөр аргагүй нөхцөл байдалтай байсан юм.

Ингэж ардчилсан хөдөлгөөний тэмцэлд дөрвөн гол хүчин болох оюутны хөдөлгөөн, нам бус ардчилсан хүчин, нийгмийн дундаж давхаргынхан, шашны байгууллага хүч нэгдэн

оролцсон байдаг. Үүний үр дүнд 1987 оны 6 сарын тэмцэл хүчирхэгжиж, урт удаан оршин байсан цэргийн дарангуйллыг унагаж, ард түмний шууд сонгуулиар ерөнхийлөгчийг сонгох зорилгодоо хүрч чадсан юм. Энэ нь ардчилсан хөдөлгөөний түүхэн эргэх цэг байсан бөгөөд 28 жилийн турш амиа золиос болгосон хүмүүсийн хичээл зүтгэл гэж хэлж болно. Түүнчлэн дээрх хүчнүүдээс гадна сөрөг хүчний намууд ч бас том үүрэг гүйцэтгэсэн төдийгүй Солонгосын ард олны хүсэл эрмэлзэл нь биелэгдсэн билээ.

### **3.4 БНСУ-ын ардчиллын дүгнэлт, даалгавар ба ирээдүй**

Өмнөх хэсэгт БНСУ-ын ардчиллын түүх, ардчилалд шилжих ба бат тогтох үе шат, ардчиллын гол хүчнүүдийн талаар авч үзлээ. Энэ хэсэгт ардчиллын талаарх дүгнэлт, даалгавар ба ирээдүйн талаар авч үзье.

БНСУ-ын ардчилал 1948 оны тусгаар тогтнол, бие даасан засгийн газар байгуулагдсанаар эхэлж өнөөдрийг хүртэл 77 жилийн түүхэн үйл явцаар өрнөж байна. 1960 онд И Сон Ман ерөнхийлөгчийн урт удаан дарангуйллыг унагасан 4.19 ардчиллын хувьсгалаас эхэлсэн ардчиллын төлөөх хөдөлгөөн 1987 оны 6 сарын ардчиллын тэмцлээр амжилттай дууссан байдаг. Үүний дараа 1993 оны 2 сард Ким Ён Сам ерөнхийлөгчийн ардчилсан засгийн газар байгуулагдах хүртэл ардчилалд шилжих цаг хугацаа эхэлсэн өнөөг хүртэл ардчилал тогтвортой бэхжиж, бат тогтож байна.

#### **(1) БНСУ-ын ардчиллын талаарх дүгнэлт**

1987 онд амжилтад хүрсэн ардчиллын тухай эерэгээр төдийгүй сөргөөр дүгнэдэг хүмүүс ч байна. БНСУ-ын ардчиллыг гадна талаас нь харвал амжилттай биелсэн гэж дүгнэх боломжтой боловч ардчиллын чанар ба арга зүйн талаасаа өнөөг хүртэл алдаа дутагдалтай зүйл олон байна. Бас үргэлжлүүлэн өөрчлөн шинэчлэх шаардлагатай салбар ч цөөнгүй байгаа учраас янз бүрийн дүгнэлт байгаа нь сонин биш юм.

Robert Deal-ын дүгнэснээр “Ардчиллын үзэл баримтлалын хөгжлийн түүх нь бидэнд урам төдийгүй сануулга ч өгдөг юм. Яагаад гэвэл энэ нь зөвхөн амжилт дэвшлийн биш алдаа уналтын түүх ч байлаа” (로버트 딜, 1999:585). Энэ утгаараа БНСУ-ын ардчиллыг ерөнхийд нь эерэг дүгнэдэг эрдэмтэн судлаачид олон байдаг ч бүрэн биелээгүй, одоо ч засан шинэчлэх, нэмж өөрчлөх зүйл их байгааг онцолж байна. Тухайлбал, И Сам Ёл нь 1987 оны ардчилал амжилттай дууссанаас хойш 2017 он хүртэл 30 жилийн түүхийг дүгнэсэн ба энэ хугацаанд ардчилсан үзэл баримтлал ёс журмын хувьд маш сайн хөгжсөн амжилт дэвшил байгааг тэмдэглэжээ. Гэвч өнөө хүртэл улс төр, эдийн засаг, нийгмийн ялгаварлал, тэгш бус байдал, эрх чөлөөгүй байдал зэрэг бодит асуудал олон байгааг дурьдаж, эдгээрийг шийдэн шинэчлэх даалгавар байгаа нь үнэн хэмээн үзсэн байна (이삼열, 2017:65).

Мөн Ким Хо Ги судлаач БНСУ-ын ардчиллын 20 жилийн түүхийг дүгнэж амжилт, ололт, бүтэлгүйдэл хамт байсан гэдгийг онцолсон юм. Тэрээр “ардчиллын өнгөрсөн 20 жилийн түүхийг эргэж харвал амжилт, бүтэлгүйтэл хамт байсан билээ. Шударга улс төрийг бүтээсэн, хүний эрхийг дээдэлж, жендэрийн тэгш байдал сайжруулан өнгөрсөн үеийн хууль бус явдлыг засах зэрэг нийгмийн ардчилалд том амжилт гарсан юм. Харин даяаршилын цохилтын дунд эдийн засгийн ялгаварлал, ядуурлыг арилгахад багагүй асуудал гарч байгааг (김호기, 2007) анхааруулсан юм.

Харин Ан Бён Үг судлаач “БНСУ ардчиллын үзэл баримтлалыг ерөнхийдөө өндөр түвшинд хэрэгжүүлж байна. Дэлхийн түвшинтэй харьцуулахад дутагдалтай, шинэчлэх олон даалгавар байдаг боловч өнөө цагт цэргийн дарангуйлал эсвэл эрх баригчдын урт удаан дарангуйлал зэрэг авторитар засаглалын аюул, төрийн эрх баригчдын хүчирхийлэл ч байхгүй” хэмээн эерэгээр дүгнэж байна (안병욱, 2010). Тэрээр үргэлжлүүлэн ардчилсан хөдөлгөөнөөр дамжуулж ардчилсан үзэл баримтлал биелсэн үйл явц, түүний онцлогийн талаар дараах тайлбар өгч байна. Үүнд:

- . БНСУ-ын ардчилсан үзэл баримтлал нь танин мэдэхүй, ухамсараар бус тэмцэл, эсэргүүцлийн үр дүнд биелэлээ олсон юм.
- . БНСУ-ын ардчилсан үзэл баримтлалын хөгжлийн үе шат бүрт эрх баригчидтай тэмцэн тулалдахад заримдаа ялагдаж байсан ч тэмцлээ үргэлжлүүлж, маш олон хүмүүс дахин дахин золиослогдож байсан юм.
- . Дарангуйллын эсрэг тэмцэлд оролцогчдын ихэнх нь тийм ч сайн зохион байгуулагдаагүй жирийн ард иргэд байсан юм. Тэд эрх баригчдын хууль бус үйлдлийг тэвчилгүй ардчиллын төлөөх тэмцэлд сайн дураараа оролцож байсан юм.
- . Ардчиллын тэмцэл тулалдаан үргэлжлэх явцдаа нэг хүний удирдамжаар яваагүй учраас хэн нэгэн онцгой хүн, баатар төрөөгүй юм.
- . БНСУ-ын ардчилсан хөдөлгөөн ардын хувьсгал биш юм. Хувьсгалт үзэл
- . баримтлал ч байхгүй, авторитар дэглэмийн эрх баригчид, дарангуйллын эсрэг тэмцэл байсан юм (안병욱, 2010:30-32).

Ган Бён Иг нь 1987 оноос хойш улс төрийн ардчиллын талаар “нэгд, тэмцэл ба харилцан тохиролцох арга замаар шилжсэн, хоёрт ардчилсан үзэл баримтлалын эсрэг бүс нутгийг хэт онцлох үзэл, гуравт улс төрийн намуудын тэгш бус байдал, дөрөвт тодорхой зорилгогүй шинэчлэлд анхаардаг УИХ, тавд доороос гарсан ардчилсан хөдөлгөөн” хэмээн дүгнэж байна (강병익, 2004). Жон Сан Ху нь ард иргэд ба иргэний эрхийн талаас дараах тайлбар өгч байна. Тэрээр 1980-аад онд гарсан хоёр том ардчилсан үйл хэрэг болох 1980 оны Гуанжүгийн ардчилсан хөдөлгөөн, 1987 оны 6 сарын ардчиллын төлөөх тэмцэл нь ард олны эвсэн нэгдэх хүч болон үзэл хандлагад том өөрчлөлтийг авчирсан юм. Энэ нь 1960-аад оны үеэс эхэлсэн ард иргэдийн үзэл хандлагын өөрчлөлт үр дүн байсан (정상호, 2007) ба иргэний нийгэм байгуулагдах, нийгмийн үйл ажиллагаанд идэвхийлэн оролцох нөхцлийг бүрдүүлсэн гэжээ.

Нөгөө талаас БНСУ-ын ардчиллыг сөргөөр дүгнэж байгаа судлаачдын хувьд 1987 оны тэмцэл ардчилсан үзэл баримтлалд аюултай байдлыг авчирсан юм. Тухайлбал, И Гуан Ил нь БНСУ-ын ардчилал бол либерал үзэлтэй улс төрийн хүчний хувьд амжилттай боловч эсрэгээрээ аюултай байдлыг авчирсан тал ч байна хэмээн радикал тайлбар өгч байна (이광일, 2007).

Либерал үзэл баримтлалтай улс төрийн хүчний хувьд 6 сарын ардчиллын төлөөх тэмцэл амжилттай дууссан гэж үздэг. Одоогийн ерөнхийлөгч Ну Мү Хён ч гэсэн тийм дүгнэлт хийж байгаа бөгөөд ардчилсан хүчний хүсэл шаардлага биелсэн хэмээжээ. Гэвч үнэндээ 6

сарын ардчилсан тэмцлийн шаардлага биелсэн бус цэргийн дарангуйлагчид ба либерал үзэл баримтлалтай улс төрийн хүчний харилцан тохиролцоогоор 6.29 ардчиллын тунхаг биелсэн чөлөөт сонгуулиар засгийн газар болон УИХ-ыг байгуулах, улс төрийн эрх чөлөө биелсэн явдал байсан юм. Өнөө үед тэд ардчилсан үзэл баримтлалыг цааш хөгжүүлэх, улс төр, эдийн засаг, нийгмийн бүх салбарт дэлгэрүүлэх хүсэл сонирхол үгүй болж байна гэсэн шүүмжлэл бий.

Сун Хо Чөл-ийн үзэж буйгаар ардчилал улс төрийн хувьд амжилттай болсон ч эдийн засаг, нийгмийн хувьд ухарсаар байна (손호철, 2004:25). Тэрээр “БНСУ-ын эдийн засаг, нийгмийн ардчилсан үзэл баримтлал нь анхан шатандаа байна гэж хэлэхээс өөр аргагүй. Дэлхий даяар эдийн засгийн ширүүн өрсөлдөөн дунд хүн амын нийгмийн хамгааллын зардлыг нэмэгдүүлж байгаа боловч үндэсний жилийн орлогоор бодвол маш бага хэмжээтэй байна. 1997 оны дэлхийн эдийн засгийн хямралын үед Ким Дэ Жүн ерөнхийлөгч АНУ-ын шинэ либерал бодлогыг ямар ч шүүмжлэлгүй хэрэгжүүлснээр баян, ядуугийн ялгаварлал улам хурдацтай нэмэгдсэн. Эдийн засаг, нийгмийн ардчилсан үзэл баримтлал иргэдийн аж амьдралыг сайжруулах бус доройтуулсаар хэмээжээ.

Дүгнэж хэлэхэд эрдэмтэн судлаачид БНСУ-ын ардчиллын тухай ямар үзэл баримтлалтай байгаагаас шалтгаалж өөр өөр дүгнэлт хийж байна. Хэдийгээр эсрэг үзэл баримтлал эрдэмтдийн дунд байгаа ч 1987 оны 6 сарын ардчиллын төлөөх тэмцэл улс төрийн харилцан тохиролцоо тайван аргаар ардчилал биелсэн нь тодорхой түүхэн үйл явдал мөн. Үүнээс хойш 1993 оны 2 сар хүртэл БНСУ-д ардчилалд шилжих үе шат эхэлсэн бөгөөд өнөөдрийг хүртэл тогтвортой бэхжиж, бат тогтож байна гэж дүгнэж болно. Харин бүрэн төгс ялсан ардчилал гэж дэлхийн хаана ч үгүй бөгөөд үзэл баримтлал заримдаа урагшилдаг, заримдаа ухрах үе ч байдаг учраас дүгнэхэд амаргүй юм.

Өдгөө тус улсад ардчилал бат тогтож байгаа боловч үзэл баримтлалыг чанарын хувьд улам гүнзгийрүүлэх, бүх ард олон, иргэний нийгмийн сайн дурын оролцоог нэмэгдүүлэх, улс төрийн төдийгүй эдийн засаг, нийгмийн талбарт ардчиллыг бүрэн өрнүүлэх зэрэг шийдэх ёстой асуудал, даалгавар олон байна.

## **(2) БНСУ-ын ардчилсан үзэл баримтлалын даалгавар**

1987 оны 6 сарын тэмцэл амжилттай болсны дараа 1993 оны 2 сар хүртэл ардчилалд шилжих цаг үе дууссан хэмээн үздэг. Үүний дараагаас өнөөг хүртэл үзэл баримтлал бэхжих, бат тогтох үе шат явагдаж байна. Өнөөдөр тулгамдсан ямар асуудал байна вэ? Энэ тухайд Ким Сөн Жү судлаач ардчилсан үзэл баримтлалыг ухраадаг зайлшгүй шийдэх ёстой дөрвөн чухал даалгавар байна гэж үзсэн. Тэрээр Солонгосын ардчилал нь хүнд хэцүү нөхцөл байдал, тэмцэл тулааныг маш олон удаа даван туулсан гэж дүгнэсэн байдаг (김성주, 2006).

## Хүснэгт 22. БНСУ-ын ардчиллын үзэл баримтлалын даалгавар

| Даалгавар                            | Тайлбар                                                                                                                                                                                                                                                 |
|--------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Үзэл баримтлалаа хэт хатуу баримтлах | - Радикал & консерватив, зүүний & баруун үзэл болж хуваагдах дихотоми үзэл баримтлал<br>- Үзэл баримтлалаар хуваагдаж тэмцэлдэх                                                                                                                         |
| Улс төрийн намуудын хуваагдал        | - Эрх баригч ба сөрөг хүчин, намуудын доторх хагарал<br>- УИХ ба засгийн газрын хоорондын тэмцэл<br>- Ард түмэн улс төрд итгэлгүй, нийгмийн тогтворгүй байдал үүсэх                                                                                     |
| Эдийн засаг ба нийгмийн туйлшрал     | - Эдийн засгийн хөгжлөөс шалтгаалж ард олны амьдрал улам бүр хуваагдсаар байна.<br>- Баячууд улам хөрөнгөжих, ядуу, дундаж давхрагынхан улам бүр ядуурсаар байна.<br>- Нийгэмд хагарал, маргааныг үүсгэх<br>- Улс үндэсний тогтворгүй байдал гүнзгийрэх |
| Бүс нутгийн хэт хуваагдмал байдал    | - БНСУ-ын улс төрд хамгийн сөргөөр нөлөөдөг асуудал<br>- Бүс нутгийн хөгжил, амьжиргааны түвшний ялгаа<br>- Үндэсний эв нэгдэлд маш сөргөөр нөлөөлөх<br>- Бүс нутгийн хоорондын хагарал                                                                 |

БНСУ-ын улс төрийн хувьд хамгийн том асуудал нь ерөнхийлөгчийн засаглалыг өөрчлөх, бүс нутгаар улс төрийн намуудыг шинэчлэх юм. Өнөөдөр хүртэл маш олон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд төдийгүй улс төрийн намууд нь авторитаризмын хаан шиг хэт эрх мэдэлтэй байдаг ерөнхийлөгчийн засаглалыг өөрчлөх цаг аль хэдийнээ болсон гэж үзэж байна. 1987 оны ардчилсан тэмцлээс хойш таван жилд нэг удаа сонгогдох боломжтой асар их эрх мэдэлтэй ерөнхийлөгчийн засаглал өнөөдрийг хүртэл өөрчлөгдөөгүй юм.

Юун Ги Сөг нь улс төр, засаг захиргааны хэлбэрийг өөрчлөх нь хамгийн том даалгавар хэмээн үзэж байна (윤기석, 2010). Тэрээр улс төрийн засаглалын хамгийн том бэрхшээл бол эртний үеийн хаан мэт ерөнхийлөгчийн маш хүчтэй эрх мэдэл бөгөөд нэг удаа сонгогдох боломжтой учраас хариуцлагатай байдал алдагдаж байна хэмээн шүүмжилсээр байна. Нийгэм, ард түмний улс төрийн хандлага, оролцоо ихээр өөрчлөгдөж байгаа боловч төрийн эрх барих систем өөрчлөгдөхгүй байна. Төрийн эрх барих систем нь хуучинсаг үзэл баримтлалтай байгаа учраас засаглалын бүтцийг өөрчлөх нь өнөөдрийн маш чухал даалгавар болсон. Хэт эрх мэдэлтэй ерөнхийлөгчийн засаглалын алдаа дутагдлыг арилгаж ардчиллын үзэл баримтлалыг нэг шат дээшлүүлэх, үндсэн хуульд өөрчлөлт оруулснаар нэг хүнд хэт төвлөрсөн эрх мэдэлтэй одоогийн засаглалыг шинэчилж төрийн эрх мэдлийг хуваах ба тэнцвэртэй болгох хэрэгтэй байгааг тэрээр онцолсон (윤기석, 2010:310) байдаг.

Жон Хүн судлаач ч мөн адил өмнөх ерөнхийлөгчид болон засгийн газрууд нь улс үндэстнийг захирах хүч чадал маш сул байсан гэж үздэг. Үүнээс болж ардчилсан үзэл баримтлалын хөгжил дэвшилд маш том саад тотгор учирсан хэмээн дүгнэжээ (정훈, 2007). Түүнчлэн засаглалын эрх мэдлийг өөрчлөхөөс гадна бүс нутгаар хэт хуваагдан тэмцэлдэж байгаа улс төрийн намуудыг ч шинэчлэх, дотоод ардчиллыг бий болгох ёстой гэж И Жөн Жин судлаач үзэж байна (이정진, 2010). Тухайлбал улс төрийн намуудад дотоод ардчиллыг

хэрэгжүүлж бодлого, шийдвэр гаргах үйл явцад ардчилсан, ил тод байдлыг өргөжүүлэх, нэр дэвшигчийг шударга зарчмаар сонгох, сонгууль бүрийн дараа бий болсон бүс нутгаар хэт хуваагдах байдлыг арилгаж, төрийн бодлогоор өрсөлдөн ялалт байгуулах системийг бий болгох төдийгүй намуудын доторх бүлэглэл, хагарал, гишүүд болон ард түмний хоорондын харилцаа, мөнгөөр нэр дэвшигчийг сонгох асуудлыг засах шаардлагатайг судлаачид хэлсээр ирсэн юм. Ган Вон Тэк ч гэсэн 1987 оноос хойш улс төрийн том асуудал бол бүс нутгаар хуваах систем гэж үзээд “Өнөөдрийг хүртэл сонгууль болгонд хэт нутгархаж, бүс нутагт давамгай байр суурьтай байгаа намаас өөрийг сонгохгүй байгаа учраас шинэ улс төрийн хүчин гарч ирэх ямар ч боломжгүй” гэжээ (강원택, 2017). Гу Сөн Гюү нь хэт нутгархах, бүс нутгаар хуваагдах үзэл хандлагыг арилгахын тулд намын жагсаалтаар буюу пропорциональ төлөөллөөр сонгогдох гишүүний тоог нэмэхээр сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах ёстойг онцолсон юм (고선규, 2010).

БНСУ-ын ардчилалд өөр чухал даалгавар нь улс төрийн хөгжил дэвшлийг эдийн засаг, нийгмийн салбаруудад өргөжүүлэн тэлэх асуудал юм. Өөрөөр хэлбэл, ардчилал гэдэг нь зөвхөн улс төрийн бус эдийн засаг, нийгмийн бүх салбарт хэрэгжиж, шинэчлэлийг хийснээр бодит болох ёстой. Эдийн засгийн ардчилал гэдэг нь бүхий л аж ахуй нэгж, хувийн хэвшил, компаний үйл ажиллагаанд шингээж тэр хэрээр ард түмний амьжиргаа дээшилж илүү чанартай болох, орлогын ялгаа хэт зөрүүгүй, баялагийг тэгш хуваарилах бодлого ч зүй зохистой, нийгмийн хамгааллын хөтөлбөр арга хэмжээг сайжруулах замаар баян, ядуугийн ялгааг арилгах арга зам юм (좌승희, 2012:2).

Сун Вон Гөн судлаачийнхаар эдийн засгийн талбарт ч асуудал их байгаад дараах тайлбар өгч байна (송원근, 2016). Тэрээр үзэхдээ өнөөдрийг хүртэл БНСУ-ын эдийн засаг том пүүс компани болон гадаад экспорт, аж үйлдвэр төвтэй бодлогоор тэлж байсан гэжээ. Цаашилбал орлогийн тэгш бус байдал, компаний чадавхид хүч тэнцвэргүй байдал үүссэн бөгөөд эдийн засаг том пүүс компанид хэт төвлөрөх, тендерын шударга бус байдал газар авсан гэжээ. Дээрх нөхцөл байдлаас шалтгаалж хүн амын орлогын хэмжээ ч тэгш бус, хөдөлмөрийн зах зээл хэт хуваагдаж ядуурал ихсэх томоохон асуудалтай нүүр тулж байгаа хэмээжээ. Үүгээр зогсохгүй үндэсний аж үйлдвэрийн хамтын ажиллагаа, том пүүс компани, жижиг дунд үйлдвэрийн шударга бус харилцаа нь эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж байгааг тэмдэглэжээ.

Судлаач Ким Хо Ги БНСУ-ын ардчиллын үзэл баримтлалын хөгжил зөвхөн улс төрийн талбарт бус эдийн засаг, нийгмийн бүхий салбарт өргөжих ёстойг мартаж болохгүйг мөн анхааруулж байна (김호기, 2007:160). Өмнөд, хойд хэмээн хуваагдсан хоёр Солонгосыг нэгтгэх, хойд Солонгосын цөмийн зэвсгийн асуудал нь ардчилсан үзэл баримтлалын хөгжилд учирч буй саад бэрхшээл байна. Яг энэ үзэл санааг Ким Ён Тэ судлаач дэмжиж “Хойд Солонгосын цөмийн зэвсгийн асуудал нь БНСУ-ын ардчилсан үзэл баримтлалын гадаад байдлыг маш хурдацтай өөрчилж тогтворгүй байдлыг үүсгэж байна” хэмээсэн бол (김영태, 2008:279-280) Ан Бён Ёг Хойд Солонгостой холбоотой асуудлыг ардчиллын үзэл баримтлалтай шууд холбоотойг онцлоод “БНСУ нь Хойд Солонгосыг дайсан гэж үзэж үндэсний аюулгүй байдлаар шалтаглан ард түмэнд улс төрийн дарамт шахалт үзүүлэх, энх тайвныг алдагдуулж байна. Олон улсын хэмжээнд ч хоёр Солонгос дайн мөргөлдөөн гаргах болно

гэсэн үзэл хандлагаас ардчилал бий болох боломжгүй” гэжээ (안병욱, 2013).

Цаашид ч ардчилсан үзэл баримтлал бат тогтохын тулд маш олон асуудал, бэрхшээлтэй нүүр тулна гэдгийг ийнхүү олон судлаач тэмдэглэжээ. Энэ нь өмнө дурьдсанчлан нэгд, улс төрийн хувьд нэг хүнд хэт эрх мэдлийг олгосон ерөнхийлөгчийн засаглалыг өөрчлөх цаг болсон юм. Хоёрт, улс үндэстнийг мөхөөх хэт нутгархах, бүс нутгаар хуваагдах үзэл бодол, улс төрийн намуудын дотоод ардчилал, сонгуулийн системийн өөрчлөлт ч маш чухал. Гуравт, ардчиллыг зөвхөн улс төрийн салбарт бус эдийн засаг, нийгмийн бүхий л хүрээнд өргөжүүлэн тэлэх ёстой. Дөрөвт, нийгмийн хуваагдал, орлогийн тэгш бус байдал, ядуурал, бүс нутгийн хөгжлийн ялгаатай байдал тулгамдаж байна.

Ардчилсан үзэл баримтлалын хөгжил дэвшилд тулгарч буй гадаад нөхцөл байдлын хамгийн том бэрхшээл бол Хойд Солонгосын асуудал гэдгийг судлаачид онцолж байгааг дээр өгүүлсэн. Өнөөг хүртэл хоёр Солонгосын дайн бүрмөсөн дууссан бус түр зогссон байдалтай байгаа бөгөөд цөмийн зэвсгийн асуудал Өмнөд Солонгос улсын ардчилал, үзэл баримтлалын хөгжилд тогтворгүй байдлыг үүсгэж болзошгүйг судлаачид анхааруулсаар байгааг энд дахин тэмдэглэж байна.

### **(3) БНСУ-ын ардчилал, үзэл баримтлалын ирээдүй**

БНСУ-ын ардчилал, үзэл баримтлалын хөгжилд шийдэх ёстой олон асуудал байгаа боловч ардчилал тогтвортой байна хэмээн үзлээ. Өмнөх хэсэгт үзсэнчлэн улс төр, эдийн засаг, нийгэмд тулгамдсан засаглалын байдал, намуудын дотоод ардчилал, хэт нутгархах, бүс нутгаар хуваагдсан байдал, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, сонин хэвлэлийн эрх чөлөө, эдийн засгийн ардчилал зэрэг асуудлыг цаг алдахгүйгаар зүй зохистой шийдвэл ардчиллын ирээдүй гэрэл гэгээтэй болно хэмээн таамаглах боломжтой байна. Сун Хо Гөн нь Солонгос улсын ардчиллын 35 жилийн түүхийг дүгнэж “Азид хамгийн ардчилсан үзэл баримтлалаар хөгжсөн улс бөгөөд дэлхийг гайхуулсан манай улсын эдийн засгийн хөгжлийг бусад улс үндэстэнд үлгэр жишээ болгох боломжтой байна. Бүх дэлхийд ардчиллын итгэл найдварыг төрүүлэх улс” хэмээн тэмдэглэжээ (송호근, 2021).

Ким Жон Хүн нь ардчиллын 20 жилийн түүхийг судалж ирээдүйд иргэний нийгмийн оролцоо шууд ач холбогдолтой гэжээ (김정훈, 2007). Тэрээр “Солонгосын ардчилал өнөөдөр тойргийн эргэх зам дээр зогсож байна. Учир нь нэг шат дээшлэх үү эсвэл хуучиндаа буцах уу гэдэг нь IMF дэлхийн эдийн засгийн хямралын үед ч хүчирхэгжиж байсан иргэний нийгмийн хүч, илүү тодорхой яривал радикал үзэлтэй ард түмний хүчээс шууд хамаарч байна” гэжээ.

Ха Сон Сү нь “Ард иргэд өөрсдийн амьдралд шууд нөлөөлөх улс төрийн үйл ажиллагаанд хууль ёсоор, идэвхтэй оролцож гол эзэн болох үүрэг хариуцлагыг үргэлж хүлээж хэрэгжүүлэх үед жинхэнэ ардчилсан үзэл баримтлал бий болно” хэмээн иргэдийн хариуцлага, оролцоог чухалчилсан байна (하승수, 2007:262). Пак Сөн Вуон болон олон судлаачид ирээдүйн талаарх судалгаа хийж, УИХ болон орон нутгийн засаг захиргааны үүрэг, хариуцлагын талаар дараах тайлбар өгч байна (박성원&10인, 2022:160). Тухайлбал, УИХ ард түмний итгэлийг сэргэхийн тулд хүсэл сонирхлыг илүү анхааралтай сонсож харилцааг бэхжүүлэх, нийгмийн асуудлыг шийдэхийн тулд бодитой үр нөлөө үзүүлэх ёстой. Тэгэхгүй

бол улс төрд итгэх ард түмний итгэл улам сулрах болно. Орон нутгийн засаглал, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг сайжруулахын тулд засгийн газар ба тэдгээрийн үүрэг хариуцлагын зааг хязгаарыг сайтар тогтоож улсын төсвийг зөв хуваарилах хэрэгтэй байна. Орон нутгийн асуудалд нутгийн өөрийн удирдлага бие даасан шийдвэр гаргах, инноваци загварыг бүтээхийн тулд санхүү төсвийн харилцааг шинэчлэх хэрэгтэй гэжээ.

Им Хён Жин нь 21-р зууны БНСУ-ын улс төрийн шинэ загвар бол хамтран засаглах хэмээн онцлож байна (임현진, 2021:179). Тэрээр засаг захиргаа, иргэний нийгэм, зах зээл хоорондоо хяналттай, тэнцвэртэй харилцаанд тулгуурлан хамтран ажиллах хэрэгтэй. Хамтрахгүй бол улам тогтворгүй болж байгаа даяаршилын хүчтэй давалгаанаас гарах боломжгүй. Улс үндэсний асуудлыг зохицуулагч болох засаг захиргаа, шүүмжлэгч тал болох иргэний нийгэм, баялаг бүтээх зах зээл гэсэн гурван хүчин тэгш эрх мэдэлтэй хамтрагч байх ёстой. Тэргүүн эгнээнд явах удирдах эрх мэдэл, иргэний нийгмийн хянан шүүмжлэх чадвар, зах зээлийн өрсөлдөх чанар хамтдаа нэгдэх үед үндэсний асуудал, маргааныг засан шийдвэрлэх боломжтой болно. Өнөөдөр ардчилсан үзэл баримтлалыг тогтвортой хөгжүүлэхийн тулд засаг захиргаа, ард түмэн нэгдэж улс орноо хөгжүүлэх хүсэл зорилгоор хамтрах ёстой. Үзэл бодлоор, эрх ашгаар, бүс нутгаар, хүйс ба насны ялгаатай байдлаараа хуваагдвал хөгжил дэвшлийг таамаглах боломжгүй болно. Эрх баригчид, сөрөг хүчин, зүүний болон барууны үзэлтнүүд, зах зээл ба иргэний нийгэм, ажил олгогчид ба хөдөлмөрчид зэрэг улс үндэсний дотоод бүхий л хүчнүүд хоорондоо тэмцэн маргалдах, шүүмжлэх, гадуурхах бус сайн хамтран ажиллах хэрэгтэй гэдгийг дахин дахин онцолж байна. Ингэж улс үндэстний бүх хүчин эвсэн нэгдэж, хамтран ажиллах, хүчээ оролцуулах үед БНСУ-ын ардчиллын үзэл баримтлалын ирээдүй гэрэл гэгээтэй, итгэл найдвартай болно гэж таамаглаж болно.

### **Бүлгийн дүгнэлт**

Энэ бүлэгт БНСУ-ын ардчиллын түүхийн эхлэл болсон 4.19-ний хувьсгал, 5.18-ны Гуанжугийн ардчилсан хөдөлгөөн, 1987 оны 6 сарын ардчиллын төлөөх тэмцэл эдгээрийн үр дүнд цэргийн дэглэмийг нураасан үйл явдлууд, ардчилалд шилжих шилжилт түүнд тулгарсан бэрхшээл, ардчилал бат бэхжин тогтоход нөлөөлсөн хүчин зүйл, улс төр, эдийн засаг, нийгмийн салбаруудад хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, оюутны хөдөлгөөн, ардчиллын төлөөх нам бус хүчнүүд, нийгмийн дундаж давхрага болон шашныхны оролцоо тэмцлийн тухай авч үзлээ. Тэдний тэмцлийн түүхээс харвал эдгээр дөрвөн хүчин нэгдэж, хүчирхэгжсэнээр урт удаан оршин байсан авторитар цэргийн дэглэмийг унагаж, ард түмний шууд оролцоотой сонгуулиар ерөнхийлөгчийг сонгох, нийгэм эдийн засаг, улс төрийн салбарын шинэчлэл хийх, ардчилсан тогтолцоот улс орон болох замыг тавьж, зорилгодоо хүрчээ. Энэхүү тэмцлийг түүхэндээ ардчиллын түүхэн эргэлтийн цэг байсан талаар судлаачид хүлээн зөвшөөрч, олон зуун хүний амь нас золиос болсныг судалсаар байна. Өдгөө БНСУ ардчилал бат тогтсон улс орон хэмээгдэж байгаа ч ирээдүйд хийх ёстой зүйл байгааг ч онцолсон юм. Үүнд нэгд, улс төр, эдийн засаг нийгэмд тулгамдсан засаглалын байдал, хоёрт, намуудын дотоод ардчилал, хэт нутгархах, бүс нутгаар хуваагдсан байдал, гуравт, ард иргэдийн болон иргэний нийгмийн оролцоо, хэвлэлийн эрх чөлөөг нэмэгдүүлэх, дөрөвт, ард түмэн болон засаг захиргааны нэгдэл нягтрал хэмээн хэд хэдэн даалгавар байгаа нь Монгол улсын хувьд ч ижил төстэй байна.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **МОНГОЛЫН АРДЧИЛЛЫН ТУХАЙ СУДАЛГАА**

#### **4.1 Монголд ардчилал эхэлсэн түүх ба шилжих үйл явц**

1911 оны үндэсний эрх чөлөөний, 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалтын үр дүнд Монгол Улс тусгаар тогтнолоо олж сэргэн хөгжих шинэ үе эхэлсэн юм. Ардын хувьсгалын ялалтаас хойш социалист нийгмийн байгууллагаар замнаж ирсэн манай улсын хувьд 1990 оны чөлөөт зах зээлд шилжиж ардчилал, хүний эрх, эрх чөлөөт нийгмийн байгуулалд шилжсэн маш их өөрчлөлт гарсан түүхийг туулж байна. Өнгөрсөн хугацаанд бий болсон ардчилсан систем, түүний харьцангуй нээлттэй байдлын үр дүнд улсын салбарт олон шинэчлэл хийгдсэн төдийгүй улс төрийн систем нь зарим талаараа гүнзгий хуваагдалтай байна.

1990 оноос хүний эрх, эрх чөлөө, ардчиллыг дээдлэх, зах зээлийн эдийн засгийг тууштай баримталж, нэг намтай авторитар улс төрийн тогтолцооноос олон намтай, ардчилсан сонгуультай нээлттэй улс төрийн тогтолцоог сонгоод 30 гаруй жилийг үдэж байна. Монгол улс тухайн үеийн гадаад, дотоод нөхцөл байдлаас улбаалан ихээхэн бартаатай, ээдрээтэй замыг туулж, ЗХУ-аар манлайлуулсан социалист системд багтаж, Зөвлөлт маягийн нийгмийн байгууллыг Монгол оронд “хуулбарлан” байгуулах, Зөвлөлтийн гадаад бодлогын чиг шугамыг гуйвалтгүй “аялдан дагах” замаар дэлхийн социалист улсуудтай өргөн харилцаж (Хайсандай. Л, 2003), хамтран ажилласаар ирсэн юм. Энэ хугацаанд буюу 1921 оноос хойш цор ганц коммунист нам нийгмийг дангаар захирч байсан БНМАУ-д 1990-ээд оны эхэн үеэс ардчилал өрнөсөн нь маш том хөгжлийн шинэ үеийг авчирсан билээ.

Монгол улс бол 1990 оны ардчиллын үйл явцаас өмнө БНМАУ, ЗХУ-тай ах дүү социалист хамтын ажиллагаатай улс байлаа. 1980-аад оны эцэст дэлхийн социалист систем хөгжлийн хувьд мухардалд орж “Престройка”-г хийх нөхцөл бүрдсэн билээ (Д.Наранцэцэг & М.Шолпан, 2009). ЗХУ-ын дотоодод өрнөсөн энэхүү үзэл санаа нь бусад социалист орнуудад нөлөөлсний нэг нь Монгол улс байсан юм. 1987-1989 оны заагт Монголын нийгэм, улс төрийн амьдралд өөрчлөлт, шинэчлэлийн уур амьсгалыг авч ирсэн бөгөөд юуны өмнө намын зохион байгуулалт, үзэл суртлын шинэчлэл, нам өөрийгөө шинэчлэх, улс төр, эдийн засгийн систем, оюун санааны хүрээнд хийгдэх шинэчлэл нь ардчилалд тулгуурлах хэрэгтэй гэсэн байр суурийг илэрхийлж байжээ.

1990 оноос хойш Монгол улс нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны амьдралын язгуур өөрчлөлтүүд нь мөн чанар, агуулга, зорилго, гарч буй үр дүн тулгарч буй асуудал, бэрхшээлээрээ Монголын нийгмийн түүхэнд тэр бүр тохиолдож байгаагүй шинэ өвөрмөц онцлогтой, нэн ээдрээтэй түүхэн том үйл явц байсан (А.Жамбал, 2010) гэдгийг судлаачид тэмдэглэдэг. Түүнчлэн эдгээр өөрчлөлт нь эрс буюу хувьсгалт, аажим буюу хувьсгалын шинж хосолсон, бүтцийн, нийгмийн үйл явцын, үүргийн ба сэдлийн гүн гүнзгий өөрчлөлтүүд байсныг судалж илэрхийлсээр байгааг онцлох хэрэгтэй.

М.С.Горбачевийн өөрчлөн байгуулалтыг Монголд ардчилсан хувьсгал гарах шууд шалтгаан болсон хэмээн үздэг хэсэг нэлээд байдаг ч зөвхөн ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалтын нөлөөгөөр тайлбарлах нь өрөөсгөл гэдгийг онцлон тэмдэглэсэн олон судалгаа байна. 1990-1992 он хүртэл БНМАУ нь дэлхийн социалист хамтын нөхөрлөлийн гишүүн, коммунист намаар (МАХН) удирдуулсан социалист байгуулалтай улс байсан ба Монголтой тогтоосон харилцаагаа чухалчлах арга ухаанаа олоогүй, тэр хэрээр “хөсөр хаягдсан” шинэ Монгол улсын шинэ гадаад бодлого аргагүйн эрхэнд Хятад, Америк, Япон зэрэг олон шинэ түнш орон руу хандсан “олон тулгуурт” гадаад бодлогод шилжихэд анхны ерөнхийлөгч П.Очирбат, анхны ардчилсан эвслийн Засгийн газар, Ерөнхий сайд Д.Бямбасүрэн, П.Жасрай, анхны Улсын Бага Хурал, анхны УИХ түүхэн үүрэг гүйцэтгэсэн (Баярхүү. Д, 2023) байна. Ийнхүү өнгөрсөн 70 жилийн хугацаанд Монголчуудын хувьд Орос оронтой илүү дотно харилцаатай явж ирсэн түүхтэй бөгөөд ардчилалд шилжсэн эхний он жилүүдэд хоёр улсын харилцаа нэлээд суларсан ч Монголчуудын хувьд ОХУ нь илүү эерэг дүр төрхтэй байсаар байна (Хатанболд. О, 2023).

Улс төр судлаачид 1990 оны ардчилсан хувьсгал үүсэхэд гадаад болон дотоод хүчин зүйл нөлөөлсөн хэмээн үздэг байна. Судлаачдын бүтээлээс харахад гадаад хүчин зүйл нь шийдвэрлэгч ач холбогдолтой байсан, дотоод хүчин зүйлийг нээх хаалтыг нь авч хаяхад нөлөөлсөн бөгөөд өөрийн дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр үндэсний өнгө аястай явагдсан (Тамир. Ч, 2013) хэмээн дүгнэжээ. 1990 оноос хойш Монгол улсын гадаад дотоод орчинд эргэлтийн шинжтэй өөрчлөлтүүд гарч ардчилал, зах зээлийн эдийн засгийн замыг эргэлт буцалтгүй сонгон авч, гадаад бодлого ч үзэл сурталжсан хэв загвараас ангижирч үндэсний эрх ашгийг дээдэлсэн прагматик шинж чанартай болсон (Шүрхүү. Д, 2000) хэмээх судлаачийн дүгнэлт бий.

### **(1) Монголд Ардчилал бий болоход нөлөөлсөн гадаад нөхцөл байдал, хүчин зүйл**

Барууны улс орнуудын улс төр, нийтийн удирдлагын үзэл санааны түүхээс: Үүнийг дан ганц ЗХУ-д гарсан өөрчлөн байгуулалтын үзэл санаатай холбон үзэх нь өрөөсгөл юм. Барууны улс орнуудад төрийн захиргааны салбарт гарсан парадигмын өөрчлөлтийн нөлөөгөөр дэлхийн улс орнуудад давалгаалсан ардчилал, хүний эрхийн тухай ойлголт газар авч нийгмийг өөрчлөх суурь болсон хэмээн үзэж болно. 1980-1990 оны үеэс дэлхий дахинаа тэр дундаа барууны улс орон Англи, АНУ, Австрали, Шинэ Зеландад төрийн захиргаа, улс төрийн шинжлэх ухааны зааг ялгааны талаар ихээхэн ярих болж, уламжлалт бюрократ тогтолцоо шүүмжлэлтэй тулгарах болсон юм. Барууны гэгдэх улс орнуудад хувийн салбарын менежментийн зарчмуудыг төрийн захиргаанд нэвтрүүлэх шинэтгэлийг хийж, төрийн албыг уян хатан, үр ашигтай болгох, өрсөлдөөний зарчим, гүйцэтгэлийн менежмент, нийтийн шинэ засаглал, улсын салбарын шинэчлэлийн тухай парадигм хүчтэй эхэлсэн. Улсын салбарын менежментийн онол (New Public management theory), Улсын салбарын үйлчилгээний онол (New Public service theory) зэрэгт үндэслэсэн шинэ давалгаа хөгжингүй орнуудад бий болж, хэтэрхий хүнд байсан төрийн салбарын үр ашиггүй санхүүгийн зардал, амжилт бага гүйцэтгэлийг шүүмжилж, нийгмийн үнэт зүйлсийг нийгмийн бүх гишүүдэд бий болгохын төлөөх бодлого шийдвэр гаргах арга замыг судлах шинжлэх ажил ихээр хийгдэх болсон. Барууны улс орнуудад засгийн газрын үйл ажиллагаанаас илүү иргэдийн оролцоо ба сэтгэлгээгээр үйл ажиллагаа явуулах, ардчиллын зарчимд суурилсан улсын үйлчилгээг хэрэгжүүлэх хэрэгтэй төдийгүй нийтийн эрх ашиг, засаглалын явц, иргэдийн

ойлголтыг өргөжүүлэх зэрэг ардчилсан бодит үйл ажиллагааны төлөө байх хэрэгтэйг чухалчлах болсон. Энэ үзэл баримтлал нь дэлхийн бусад улс орнуудад шинэ эрин үеийн өөрчлөлтийг авчирсан юм. Үзэл санааны энэхүү өөрчлөлт давалгааны нөлөөгөөр социалист систем аажмаар унах нөхцөл бүрдсэн билээ.

Ялангуяа эрдэмтэн Вудро Вилсон (Woodrow Wilson) тэртээ 1885 онд “Congratational Government”, “The Study of Administration” бүтээлүүддээ ерөнхийлөгчийн засаглалын асуудалтай тал, парламентийн улс төрийн удирдлага, нийтийн удирдлагад ноёрхсон парламент төвтэй засгийн газрын тогтолцоог шүүмжилж байснаас улбаалсан төрийн захиргаа буюу нийтийн удирдлагын орчин үеийн онолын хөгжил хүчтэй өрнөж дэлхий дахинаа түгэж байв. Авилгад автсан чадваргүй улс төрөөс нийтийн удирдлагыг тусгаарлах, улс төр болон нийтийн удирдлагын салбарыг бие даасан байлгах санал бодолтой хүчтэй хэвээр XX зуунд хүрсэн билээ.

Хамгийн гол нөлөөлөл бол ах дүү найрамдалт харилцаатай, хойд хөрш ЗХУ-ын уналт ба задрал байв. 1917 оны их хувьсгал ялсанаар ЗХУ социалист орнуудыг бүрэн тэргүүлэх хэмжээнд хүрсэн ч яваандаа нийгмийн тогтолцооны талаарх хэт зүүний онол, бодлогоо улс орнуудад тулган хүлээлгэснээр социалист орнуудад төдийгүй ЗХУ-ын дотоодын нийгэм-эдийн засагт гүн гүнзгий зөрчлийг бий болгожээ. Монгол улсын хөгжлийн шинэ сонголтын он жилүүд 1990-2000 бүтээлд социалист системийн орнууд нийгэм-эдийн засгийн бүхий л салбартаа тооны хойноос хөөцөлдөж байсан нь өнгөн дээрээ хөгжлийн өндөр хурдыг илэрхийлж байсан ч цаанаа хямралыг улам бүр гүнзгийрүүлсэн юм. Ард түмний аж байдлыг дээшлүүлэх, хүний оюун санааны хэрэгцээг хангах дээр дэвшил гаргах боломжийг алдагдуулж байлаа.

Нэг намын системтэй, захиргаадалтын эдийн засагтай ЗХУ-д жам ёсны өмчтэй байх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх хэрэгждэггүй, коммунист үзэл суртлыг хэт баримтласнаас хүний эрх эрх чөлөөг боогдуулах, шинэ шинэлэг зоригтой санаачлагууд гарахаа больж, улс ардын аж ахуйг хөгжүүлэх гол түлхэц, техник, технологи аажмаар хоцрогдолд орж, өргөн хэрэглээний бараа таваар хомсдосноор ЗХУ-ын эдийн засаг ихээхэн хоцрогдох болсон юм. Монгол улсын хувьд олон арван жил зөвхөн ЗХУ-ыг түшиглэж, улмаар түүний байгуулан “тэргүүлсэн” социалист системд багтаж ирсэн нь түүхэн цаг үе, түүний өвөрмөц гадаад хүрээллээс үүдэн нөхцөлдсөн бөгөөд ... 1980 оны эцэс, 1990-ээд оны эхэн үеийн хүн төрөлхтний түүхэнд эргэлт авчирсан хоёр Герман нэгдсэн, социалист систем хүчирхэг ЗХУ өөрөө задарсан, дорнод Европын социалист орнууд ардчилсан, чөлөөт хөгжлийн замыг сонгон, урд хөрш БНХАУ-д Дэн Сяопины реформ амжилттай хэрэгжсэн үйл явц Монгол улсыг тойрч өнгөрсөнгүй дайрч ирэв хэмээн Л.Хайсандай судлаач тэмдэглэжээ (Хайсандай. Л, 2013). Тэрээр энэ үйл явц нь Монгол улсын гадаад орчноор хязгаарлагдсангүй, дотоод орчин ч асар их өөрчлөгдсөнийг онцолж, эдийн засгийн хувьд чөлөөт зах зээлд шилжих чиг шугам төрийн бодлогын үндэс болж, коммунист үзэл суртлыг нэгмөсөн халав хэмээжээ.

## **(2) Монголд Ардчилал бий болоход нөлөөлсөн дотоод нөхцөл байдал хүчин зүйл**

1992 оны 1.13-ны өдрийн Монгол улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 14 зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгарлаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” хэмээн заасан ба “Эх орондоо хүмүүнлэг,

ардчилсан нийгмийн цогцлоон хөгжүүлэх”-ийг эрхэм зорилгоо болгосон билээ. Шинэ Үндсэн хууль батлагдаж, үүний дагуу улс төрийн тогтолцоо солигдсоноор олон ургальч үзэл санаа, эдийн засгийн хувьд чөлөөт зах зээлд шилжих бодлого төрийн үндэс болж коммунист үзэл суртлыг нэгмөсөн халав хэмээн тухайн үеийн судлаачид онцлон тэмдэглэж байв. Социалист системд багтаж дэлхийн улс орнуунаас тусгаарлагдаж, гуравдагч хөрш хэмээх ойлголтоос хол хөндий явсан улсын хувьд бусад улс орнуудын хөгжлийн нийтлэг чиг хандлагаар хөгжих, нээлттэй шинэ бодлого хэрэгжүүлэх шаардлага үүссэн юм. Л.Хайсандай судлаачийн өгүүлсэнчлэн Монгол улс ардчилал, чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжих замд эргэлт буцалтгүй орж, улс үндэснийхээ эрх ашгийн үүднээс нээлттэй гадаад бодлого явуулж эхэлснийг дэлхийн улс орнууд, олон нийт тун нааштайгаар угтан авч, талархан дэмжсэн юм. Өдгөө 2025 оны байдлаар Монгол улс НҮБ-ын гишүүн дэлхийн 192 оронтой дидломат харилцаатай, 32 оронд Монгол улсын элчин сайдын яам, 50 хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, Өргөмжит консул 78, НҮБ, түүний төрөлжсөн болон ОУБ-ын Монгол улс дахь суурин төлөөлөгчийн 14 газар үйл ажиллагаа явуулж (Гадаад харилцааны яамны цахим, 2025) байна.

Түүхийг эргэж харвал, 1989 оны 12 сарын 10-ны өдөр нийслэлд С.Зоригоор удирдуулсан Монголын ардчилсан Холбоо “Хүүхэд залуучуудын соёлын төв”-ийн гадаах талбайд анхны цуглаан болж Монголд олон намын улс төрийн систем тогтох, хүний эрхийг дээдлэх, бүх нийтийн сонгуулийг 1990 оны эхний хагас жилд багтаан явуулах, улс төрийн хэлмэгдэгсдийг цагаатгах, хэвлэлийн эрх чөлөөг баталгаатай болгох зэрэг 13 зүйл заалт бүхий шаардлагыг тавьснаар Монгол улсад Ардчилсан хувьсгал эхэлсэн хэмээн үздэг.

МоАХ-ны улс төрийн шаардлагуудыг нам, төрийн удирдлагууд хүлээж авахгүй байсан тул МоАХ дөрөв дэх цуглаанаа 1990 оны 1.21-нд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан юм. Энэ цуглаанаар залуучууд Үндсэн хуулиас МАХН-ыг нийгмийг удирдан чиглүүлэгч гэсэн томъёоллыг хасаж хэмжээгүй эрхийг зогсоох, хэвлэлийн эрх чөлөөт байдлыг бий болгохыг шаардсан билээ. Энэ үеэр 1990 оны 2.18-ны өдөр Монгол улсын 16 аймаг, 3 хотоос 611 төлөөлөгч, 200 зочин цуглаж МоАХ-ны анхдугаар Их хурлыг зохион байгуулж, Монголын Ардчилсан нам байгуулагдсан ба уг хурлын үйл явцыг гадаадын 30 гаруй сэтгүүлч, телевиз, радиогоор орон даяар шууд дамжуулж байжээ. Их хурлаас БНМАУ-ын МАХН-ын Улс төрийн товчоо, Сайд нарын зөвлөл огцрох, АИХ-ыг тараах шаардлагыг тавьж байв.

Улс даяар байгуулагдсан МоАХ-ны салбар зөвлөл, МоАХ, АСХ, ШДХ, МОХ зэрэг 4 холбооны дэмжигч 100 мянган залуучуудын нэгдсэн цуглаан 1990 оны 3 сарын 04-ны өдөр зохион байгуулагдаж, БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдэд удаа дараа тавьсан шаардлагын хариуг өгөхийг, намын үйл ажиллагааг төрөөс тусгаарлахыг шаардсан юм. Улмаар эрх баригч нам, төрийн удирдлагаас хариу өгөөгүй учраас 1990 оны 3.07-ны өдөр МоАХ-ны арван гишүүн улс төрийн өлсгөлөнг зарласан ба 3.08-09-ны өдрүүдэд нам төрийн удирдлагатай хэлэлцээр хийн зөвшилцөлд хүрч МАХН-ын Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох болсныг намын тэргүүн Ж.Батмөнх мэдэгдсэн.

Намууд хоорондоо зөвшилцөх ажил 1990 оны 3.10-нд шуур үргэлжилсэн бөгөөд улс төрийн нам, холбоод хамтарсан мэдэгдэл гаргаж, эх орон, улс үндэстнийхээ эв нэгдэл, эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, тэгш эрх, харилцан хүндэтгэл, хүч үл хэрэглэх зарчим баримтлах, улс төрийн тулгамдсан асуудлаар харилцан зөвлөлдөж тохиролцоонд хүрэхийг эрмэлзэнэ гэдгээ

зарлан тунхагласан юм. 1990 оны 3.21-23-ны өдөр БНМАУ-ын АИХ-ын ээлжит бус 8 дугаар чуулган хуралдаж 1960 оны 7.06-ны өдөр батлагдсан гуравдугаар Үндсэн хуулийн “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төр, нийгмийг удирдан чиглүүлэгч бол бүхнийг ялагч Марксист-Ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгодог Монгол Ардын Хувьсгалт Нам мөн” хэмээх заалтыг хассан байна (Хуулийн цахим сайт, 2025).

Ийнхүү 1960 оны 7.06-ны өдөр батлагдсан гуравдугаар үндсэн хуулийн 10 дугаар бүлгийн 94 дүгээр зүйлд “ Коммунизмын үед төрийн зарим үүрэг мөхөх тутам тэр үүргийн тухай Үндсэн хуульд бичигдсэн зүйлс хүчингүй болж байна. Социализм, коммунизм байгуулах гол зэвсэг болсон төр байх хэрэгцээгүй болж, түүнийг хөдөлмөрчдийн коммунист эвлэлээр сольсон цагт БНМАУ-ын Үндсэн хууль халагдана” хэмээх заалт байсан ч 1992 оны 1.13-нд БНМАУ-ын АИХ-аар парламентийн засаглалтай Бүгд найрамдах улсын шинэ үндсэн хуулийг 6 бүлэг 70 зүйлтэйгээр баталж чадсан. Шинэ Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлийн 2 дугаарт Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн хэмээн заалт оруулж, төрийн сүлд, туг, далбаа, тамга дууллыг шинэчлэх, хориглосон байсан шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсах, цуглаан хийх эрх чөлөө, сүм хийдийн үйл ажиллагаа, үндэсний цөөнх эх хэлээрээ суралцах боломжийг олгосон байдаг (6 бүлэг, 50 зүйлтэй анхдугаар Үндсэн хуулийг 1924 оны 11. 26-ны өдөр Улсын анхдугаар Их хурлаар баталсан юм. Засаглалын хэлбэр нь Хэмжээт эрхт хаант засаглал байсан бөгөөд тэргүүлж байсан Богд Жавзундамба хутагт хаан тамгыг Засгийн газар шилжүүлэх залж хадгалах тухай заалт оржээ. Харин Монгол Улсын хоёрдугаар Үндсэн хуулийг 12 бүлэг, 95 зүйлээр 1940 оны 6.30-ны өдөр Улсын УИХ Их Хурлаар баталсан юм. Засаглалын хэлбэр нь авторитари байсан бөгөөд нэгдүгээр зүйлд Бүгд Найрамдах Монгол Улс бол эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан цаашид нийгэм журамд давшин орохын учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүхий хөдөлмөрчин (малчин, ажилчин, оюутан) ардын тусгаар тогтносон улс мөн болно хэмээжээ).


Улмаар 1990 оны 7.22-29-нд анхны чөлөөт ардчилсан сонгууль болж, төрийн эрх барих дээд байгууллагаа өөрсдөө сонгосон билээ. Шинэ Үндсэн хуульд заасны дагуу хэвлэлийн чөлөөт байдал, олон намын тогтолцооны үндэс суурь тавигдаж, Монголын Ардчилсан Намаас гадна Монголын Социаль демократ нам, Монголын Чөлөөт хөдөлмөрийн Нам, Монголын Үндэсний дэвшил нам зэрэг улс төрийн намууд байгуулагдан сонгуульд оролцож байлаа. Монгол улсад анхны чөлөөт ардчилсан сонгууль ийнхүү өрнөж, анхны санал хураалтаар 430 тойргоос МАХН-343, МоАН-23, МҮАН-7, МСДН-4, МЧХН-1 суудал авч 51 нь нам бусчуудаас сонгогдсон юм. АИХ-ын чуулганаас байнгын ажиллагаатай парламент Улсын Бага хурлыг сонгож, 50 суудлаас МАХН-31, МоАН-13, МҮДН-3, МСДН-3 суудлыг тус тус авч байв.

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн хэмээн зааж, мөн хуулийн 20 дугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална”, 30.1-т “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн” хэмээн тус тус хуульчлан баталгаажуулсны дагуу УИХ-ын болон ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн жил тутам нэг удаа зохион байгуулж ирсэн билээ.

1993 онд Үндсэн хуульд нийцүүлсэн анхны ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулсан

бөгөөд нийт долоон удаа ээлжит сонгууль явагдсан байна. Энэ хугацаанд явагдсан сонгуульд Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-31.4-т заасны дагуу УИХ-д суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлэн иргэд шууд сонгох эрхтэйгээр санал өгч, нийт сонгогчийн олонхийн санал авсан нэр дэвшигчийн Ерөнхийлөгчөөр сонгогдсон хэмээн баталгаажуулдаг. Энэ зарчмын дагуу 7 удаагийн сонгуулийн дүнд МАН-аас нэр дэвшигч 1997, 2001, 2005 онуудад ялалт байгуулж байсан бол АН-аас нэр дэвшигч 1993, 2009, 2013, 2017 онд ялалт байгуулж байжээ. 2020 оны 6.9-нд ерөнхийлөгчийн ээлжит сонгууль зохион байгуулагдахаар товлөгдсон ба мөн л нөлөө бүхий МАН, АН, УИХ-д суудал бүхий ХҮН гэх намаас тус бүр нэр дэвшигчид өрсөлдсөн байна.

Зураг 3. Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2021 он (хувиар)



Эх сурвалж: <https://ikon.mn/n/11pi> Судлаачийн нэгтгэснээр

БНМАУ-ын АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1990 оны 9.3-9 хооронд чуулж, БНМАУ-ын анхны Ерөнхийлөгчөөр П.Очирбатыг сонгожээ. 1992-2025 он хүртэл хугацаанд Монгол улсад нийт долоон удаагийн сонгуулиар зургаан ерөнхийлөгч сонгогдсон байна.

Хүснэгт 23. Монгол Улсын Ерөнхийлөгчид (хугацаа ба харьяа намаар)

| № | Ерөнхийлөгчийн нэр | Хугацаа                  | Дэвшүүлсэн нам |
|---|--------------------|--------------------------|----------------|
| 1 | П.Очирбат          | 1992.09.03-1997.06.20    | АН             |
| 2 | Н.Багабанди        | 1997.06.20-2001.06.24    | МАН            |
| 3 |                    | 2001- 2005.06.24         | МАН            |
| 4 | Н.Энхбаяр          | 2005.06.24-2009.06.18    | МАН            |
| 5 | Ц.Элбэгдорж        | 2009.06.18-2017.07.10    | АН             |
| 6 | Х.Баттулга         | 2017.07.10-2021.06.25    | АН             |
| 7 | У.Хүрэлсүх         | 2021.06.25- одоог хүртэл | МАН            |

Судлаачийн нэгтгэснээр

Монгол улсын Ерөнхийлөгч бол Монгол Улсын төрийн тэргүүн бөгөөд Үндсэн хуулийн дагуу УИХ-д суудалтай улс төрийн нам, эвслээс нэр дэвшүүлж, бүх ард түмний сонгуулиар шууд сонгогддог. Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл учраас Ерөнхийлөгчөөр сонгогдсон хүн аливаа улс төрийн намын харьяаллаас татгалзаж, үндэсний эрх ашгийг дээдлэх ёстой.

Монгол улс нэг намын тогтолцооноос олон намын тогтолцоонд шилжих үйл явц хүчтэй өрнөж, улс төрийн намыг ардчилах, намын ажилд иргэдийн шууд оролцоо, хяналтыг

нэмэгдүүлэх нь тогтолцооны хувьд том сорилт байсан юм. Монгол улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байх ба дөрвөн жил тутам сонгон байгуулсан эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар дамжуулан төрийн үйл ажиллагаанд оролцох эрхээ эдэлдэг. 1990 оноос хойш 1992, 1996, 2000, 2004, 2008, 2012, 2016, 2020, 2024 онуудад нийт есөн удаагийн УИХ-ын сонгууль явагдсан байна. 2020 оны 6 сард зохион байгуулагдсан ээлжит сонгуульд МАН-76 суудлаас 62 суудал (81.6), АН 11 суудал (14.5), Бие даан нэр дэвшигч 1 суудал (1.3), “Та бидний эвсэл” 1 суудал (1.3), Зөв хүн электрат эвсэл 1 суудал (1.3) авч хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлж байна (Хүснэгт 24).

Хүснэгт 24. 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн дүн (намуудын авсан суудлын тоо, хувиар)

| Нам эвсэл            | 2020 он |        | Нам эвсэл                | 2024 он    |       |
|----------------------|---------|--------|--------------------------|------------|-------|
|                      | Суудал  | Хувь   |                          | Суудал     | Хувь  |
| МАН                  | 62      | 81.6%  | МАН                      | 68 (50+18) | 54%   |
| АН                   | 11      | 14.4 % | АН                       | 42 (26+16) | 33.3% |
| Бие даан нэр дэвшигч | 1       | 1.3 %  | ХҮН                      | 8 (2+6)    | 6.3%  |
| Та бидний эвсэл      | 1       | 1.3 %  | Үндэсний эвсэл           | 4 (0+4)    | 3.2%  |
| Зөв электрат         | 1       | 1.3 %  | Иргэний зориг ногоон нам | 4 (0+4)    | 3.2%  |
| Нийт                 | 76      | 100%   | Нийт                     | 126        | 100%  |


<https://www.gec.gov.mn/>

1992-2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийн дүнг харвал нийт есөн удаагийн сонгуульд МАН 2012 онд хамгийн багадаа 32.6 хувийн саналыг авч байсан бол 2020 онд нийт сонгогчдийн 81.6 хувь, 2024 онд 54 хувийн саналыг тус тус авч Засгийн газар байгуулах боломжтой болсон байна. Харин улс төрийн намын гол намын нэг болох АН-ын хувьд 2000 онд хамгийн бага 13.4 хувийн саналыг авсан бол 1996 онд хамгийн өндөр буюу 47 хувийн саналтай, 2024 онд 33.3 хувь болон өссөн үр дүн гарсан билээ.

2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийн систем өөрчлөгдөж, 126 гишүүнтэй байгуулагдсан нь улс төрийн түүхэнд онцлог явдал байсан. 2023 онд Үндсэн хуульд өөрчлөлт оруулсныг дагалдуулан УИХ-ийн сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлтөөр 126 гишүүний 78-ыг мажоритар аргаар, 48-ыг хувь тэнцүүлсэн төлөөлөх пропорциональ аргаар буюу сонгуулийн холимог тогтолцооны зэрэгцээ хувилбарыг хуульчилсан. Улмаар 2024 оны 6 сарын 28-ны өдөр явагдсан сонгуульд нийт 19 нам, 2 эвсэл оролцож, 1341 нэр дэвшигч өрсөлдсөн нь ардчилсан сонгуулийн түүхэнд хамгийн олон хүн нэр дэвшсэн сонгууль болон тэмдэглэгджээ.

Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн 2.089.939 сонгогчийн 1.448.300 нь буюу 69.4 хувь нь саналаа өгсөн нь 2020 оны сонгуулийн ирцээс (энэ үед сонгогчдын 73.64 хувь нь сонгуульдаа оролцсон байна) буурсан 70 хувьд хүрээгүй сонгууль болжээ (МУ-ын СЕХ, 2025). Сонгуулийн үр дүнд бүрэлдсэн 126 гишүүний 32 нь буюу 25.4 хувь нь эмэгтэй гишүүн байгаа нь дэлхийн дундаж болох 27 хувьд ойртсон, Ази тивийн улсуудын парламентад эмэгтэйчүүдийн эзлэх 22 хувийн дунджаас харьцангуй өндөр үзүүлэлт байгааг (ННФ, 2024) онцолж байв.

Зураг 4. 1994-2024 оны УИХ-ын сонгуулийн үр дүн



<https://ikon.mn/n/11pj> Судлаачийн нэгтгэснээр

2016 оны сонгуулийн дүнд МАН УИХ-ын 76 суудлаас 65-ыг авсанаар мөн олонхи болж Засгийн газрын байгуулан Монгол Улсад хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлсэн бол 2024 оны ээлжит сонгуулиар хамтарсан Засгийн газраа байгуулах эрхтэй болж, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Сонгуулийн системийн хувьд холимог, мажоритар, пропорциональ системийг ашиглаж ирсэн бөгөөд сонгуулийн өмнөх жилээс ямар систем илүү тохиромжтой талаарх хэлэлцүүлэгийг өрнүүлсээр байна.

Түүнчлэн 2020 оны 10.15 өдөр явагдсан аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн дүнгээр нийт 45 суудлын 34-ыг МАН, АН-8 суудал, ХҮН-3 суудал авсан. Нийслэл Улаанбаатар хотод есөн дүүргээс найман дүүрэгт нь МАН олонхи болсон бол орон нутгийн 21 аймгийн наймд нь АН олонхи болжээ.

Улс төрийн тавцанд ийнхүү МАН, АН хоёр нам ээлжлэн засгийн эрхийг барьж, төрийн чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн боловч “улс төрийн түвшний шинэчлэл дуусаагүй, улс төр, төрийн захиргаа хоёр хоорондоо хэрхэн харилцаж, бие биедээ хяналт тавих тогтолцоо бүрдэж төлөвшөөгүй” хэвээр байна хэмээн судлаач Л.Бархас нар тэмдэглэж байна.

Нэг намын тогтолцооны үед эрх баригчдын ганц айдаг зүйл нь үндэсний үзэл байсан (Лхагваа. т, 2019) бөгөөд ардчилсан хувьсгалын үр нөлөөгөөр бий болсон хамгийн том ололт нь Монгол улс, уламжлал, соёл, түүхийн талаарх үндэсний үзэл сэргэж, улмаар ардчилал өөрөө амьдрах нөхцөл, тусгаар тогтнолын баталгаа болсон хэмээн түүхийг бүтээгчид, судлаачид онцолдог билээ.

*Шигтгээ: 1921 оноос хойш Монгол Улсад дэлхийн коммунист хөдөлгөөний салиггүй бүрэлдэхүүн хэсэг хэмээн өөрийгөө тунхагласан ганцхан МАХН оршин тогтнож байсан. Үүнээс өөр үзэл бодлыг хяхаж хавчин 1990 онтой золгосон. Монгол улсад өөр нам, нэгдэл бий болох нь байтугай шүүмжлэхийг хориглодог байлаа. Нэг ёсондоо Монголын нийгэм үнэндээ мухардалд орчихсон үе. Онол үзэл суртал, үйл ажиллагааны хэв маяг нь бүхэлдээ цаг үеэ нэгэнт өнгөрөөсөн. Ямар нэг өөрчлөлт хийхээс өөр аргагүй байсан үед юм. Ингээд ардчилсан хувьсгал бий болж үүссэн. Улс орон, хүн*

*ардаа бодьё гэвэл 1980-аад оны төгсгөл гэхэд ардчиллаас өөр зам, сонголт байгаагүй. Чухам энэ л намайг, миний нөхдийг ардчилсан сонголт хийхэд хүргэсэн шалтгаан болсон юм. Бидний хэсэг нөхөд 15 эрдэмтэн МАХН-ын доторх шинэчлэлийн хөдөлгөөнийхөн болон уламжлал шинэчлэлийн жигүүрийнхнээс ардчилалд оруулах хувь нэмэр нь үнэндээ намаа шинэчлэх асуудал байв. Гэтэл нам маань өөрчлөн байгуулалтыг залж чиглүүлэх нь бүү хэл, шинэчлэлд саад хийж, хойрго хандаж байлаа. Шинээр үүссэн ардчилсан нам, хөдөлгөөнүүдийг хүлээн зөвшөөрөх нь бүү хэл, хууль бус гэдэг катигорт оруулсан хэвээр байв. Энэ үед бид бослого гаргасан юм. Цоо шинэ онол, үзэл баримтлал дээр тулгуурласан намын дүрэм, мөрийн хөтөлбөрийг боловсруулж, намын онц их хурал хийж, хүлээж авахыг шаардсан. Үүгээрээ бид 1990 оны ардчилалд хувь нэмэр оруулсан юм. Сүхбаатарын талбайд болсон цуглаан, өлсгөлөн ардчилсан хувьсгалын оргил цэг байв. Миний хувьд институтэд байхдаа түүхийн цагаан толбыг арилгах ажилд оролцож явсан, энэ нь түүх, нийгмийг үзэх үзэл санааг шинэчлэх оролдлогууд байсан юм.*

*(Монгол улсын гавьяат багш, доктор Ph.D, профессор Т.Лхагваагийн ярилцлагаас)*

Улс төрийн тогтвортой байдлыг дэлхийн өрсөлдөх чадварын эрэмбээс харвал ихээхэн ач холбогдолтой хэмээн үзэж байна. Энэхүү судалгаанд дэлхийн 67 улсыг хамруулсан бөгөөд эдийн засгийн тамир тэнхээ, бизнесийн байгууллагын ашигтай ажиллагаа, засаглалын үр ашиг, дэд бүтэц гэсэн үндсэн дөрвөн хүчин зүйлийн 336 шалгуур үзүүлэлтээр харьцуулалт хийхэд Монгол улс 61-т эрэмбэлэгдсэн ажээ.

Өрсөлдөх чадварын эрэмбийн хувьд аялал жуулчлалын орлого өссөн, засгийн газрын төсвийн ашиг 1.79-өөс 2.5, нэг хүнд ногдох ДНБ 3.62-оос 5.88, оюуны дайжилт 2.53-аас 2.33 болж буурсан, эдийн засгийн тамир тэнхээ бүлгийн хувьд 9.58 оноогоор өсөж 42 дугаар байрт эрэмбэлэгдсэн нь өмнөх оныхоос 18 байраар, засаглалын үр ашгийн бүлгээр өнгөрсөн жилээс 6.7 оноогоор өсөж, 58-аас 53 дугаар байранд 5 эрэмбээр урагшилсан зэрэг эерэг өөрчлөлт гарчээ.

Гэсэн хэдий ч 2030 он хүртэл Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, зорилгуудыг хэрэгжүүлэх арга зам, тэдгээрийг үнэлж дүгнэснээр институтын тогтолцоог хүчирхэг, боловсронгуй болгохын тулд одоогийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай хэмээн үзсэн. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг байгуулж, яамдын чиг үүргийг шинэчлэн, нэгдсэн зохицуулалтыг бий болгох нь цаашдаа улс төрийн тогтвортой байдлыг хангах, төрийн алба тогтворгүй, бодлогын залгамж алдагдах сөрөг нөлөөлөл гарч байгааг арилгах тэр дундаа төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх, үр дүнд суурилсан хяналтыг сайжруулах шаардлагатай байгааг салбарын судлаачид онцолж байна.

*Шигтгээ: Өнөөдөр ардчиллын тухай ойлголт хүмүүсийн дунд ямар байна вэ гэвэл аливаа зүйлийг боддог, ялгаж ойлгодог хэмжээний хүмүүс бол цаад учрыг нь ойлгож байгаа юм. Эргэе, буцья, болохоо байчихлаа гэж байгаа хүн ер нь тааралдаагүй шүү өнөөдрийг хүртэл. Хүмүүс яагаад дургүй байна вэ гэвэл анхнаасаа зорьсон тэр үзэл санаа гажчихсан. Ардчиллын гажилтыг анхны сонголттой нь хольж хутгаад байгаа зүйл харагдаад байна. Эрх мэдэлдээ хатаж явсан тэх хэсэг өргөн түмнээ биш, өөрийгөө бодож, албан тушаал эрх мэдлээ зөвхөн өөртөө зориулж ирснээрээ хүн ард улс түмнээ хорлож ирсэн гашиун түүх бий. Ардчилал ард түмэнд бүхнийг*

*олж авч болох бүгдийг өгсөн. Ардчилал асар том боломж бий болгосон. 1990 оноос хойш Монгол орон оршин тогтнож, цэцэглэн өнгө орж, дээшилж яваа нь ардчиллын ололт, ардчиллын үр дүн, гавьяа гэж боддог.*

*(Монгол улсын гавьяат багш, доктор Ph.D, профессор Т.Лхагваагийн ярилцлагаас)*

1980-аад оны эхээр Монгол орны нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд ЗХУ бусад социалист орны нэгэн адил гүнзгий хямрал үүсч, Монгол улс дэлхийн хөгжлийн нийтлэг хандлагаас улам бүх хоцорч, ЗХУ-ын улс төр, эдийн засгийн стратегийн хүчтэй нөлөөнд ороод байлаа. Энэ үеүдэд бий болсон хэт төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн хуурамч таваарын аж ахуйн тооцооны уг чанар нь болох улс ардын аж ахуйн засгийн бүтцийн болон түүнээс урган гарсан мөнгө, санхүү, зээлийн тэнцвэрт бус харьцаа, өртэйгээр хөгжих үзэл баримтлал, буруу хэрэгжүүлсэн хувилбар, ганц орноос хэт хамаарсан байдалд хүргэсэн бодлого зэрэг нь Монгол улсын эдийн засгийг гүн хямралд оруулсан, хөгжлийн түвшинг доогуур хоцронгуй болгосон ба эдийн засгийн бүтэц нь:

- Түүхий эдийн чиглэлтэй;
- Боловсруулах үйлдвэр ашигтай хөгжөөгүй;
- Машин химийн үйлдвэр бий болоогүй;
- Нийгмийн хэрэглээ хуримтлалын хэмжээнээс их;
- Эдийн засгийн гадаад хямралтай;

Техник технологийн түвшин ихээхэн доогуур байсан нь хөгжлийн буурай байдлыг илэрхийлэх үзүүлэлт юм (Лувсандорж Ш, Галиймаа Н, Ганболд Д, бусад, 2019).

#### **4.2 Монгол улсад ардчилал баттай тогтох нь**

Монгол улсад өрнөж байгаа ардчилалын үйл явц нь дэлхийн бусад улс орон, бүс болон үндэсний хэмжээнд томоохон сорилтуудтай тулгарч байгаа түгээмэл үзэгдлээс гадна үлдээгүй, сорилт бэрхшээлээс ангид байгаагүй гэдгийг судлаачид тэмдэглэж байна. Манай оронд өрнөсөн сайн засаглал, ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн олон судалгаануудаас харвал манай ардчиллын хөгжилд бий болж буй хүндрэл, бэрхшээлүүд дэлхийн бусад орнуудынхтай ерөнхий хандлага төстэй боловч нэлээд өвөрмөц онлогтой байна (Чулуунбаатар. Г, Батсүх. Ш, Ганцоож. Б, 2021:64).

Монгол улс 2003 онд ардчиллыг шинээр сэргээн тогтоосон орнуудын олон улсын 5-р бага хурлыг эх орондоо зохион байгуулж, 2005 онд УИХ “Монгол Улсын МХЗ-2015”-ыг батлах тухай тогтоол гаргахдаа үндсэн найман зорилгоос гадна хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх, авилгын эсрэг тэмцэхэд чиглэсэн Мянганы хөгжлийн ес дэх зорилгыг нэмж баталжээ (Чулуунбаатар. Г, Батсүх. Ш, Ганцоож. Б, 2021:64).

Аливаа оронд ардчилал хэрэгжихдээ:

1. Ардчиллын үзэл санааг хүлээн авч дэлгэрүүлэх;
2. Улс төрийн шинэ ардчилсан бүтцийг бий болгох;
3. Ардчиллын хөгжлийн эдийн засгийн таатай нөхцөл бүрдүүлэх;
4. Иргэдийн оролцоо, иргэний нийгмийн зохистой төлөвшлийг хангах;
5. Иргэдийн улс төрийн боловсрол, соёлыг төлөвшүүлэх гэсэн цогц үйл ажиллагаа шаарддаг хэмээн Фрэнсис Фукуяама арга зүй аргачлалын онолын үндсийг боловсруулсан юм.

Ш.Содном, Ц.Ганболд, Ё.Довчин нарын судлаачдын үзэж буйгаар Монгол улс ардчилалд шилжээд олон жилийн нүүрийг үзэхдээ улс төрийн ардчиллын зарчмууд, үнэт зүйлсийг өөрийн орны хөрсөнд нутагшуулан соёолуулах талаар бас чиг чамгүй ажил амжуулсныг тэмдэглэх хэрэгтэй (Содном.Ш, Ганболд.Ц, Довчин.Ё, 2009) хэмээжээ. Түүнчлэн Д.Бумдарь, С.Мөнхбат нарын судлаачид дээрх дүгнэлтийг зөвшөөрч ардчилал бол үнэхээр иргэний нийгмийн тогтолцоо, иргэдийн улс төрийн оролцоог хангах, эрх зүйт төрийн төлөвшүүлэх эхлэлийг тавьсан бөгөөд олон намын систем, сонгуульт ардчилал, парламентат ёс бодит биелэлээ олж олон ургальч үзэл дэлгэрсэн хэмээн онцолжээ. Цааш нь иргэдээс улс төрийн дэглэм, систем, улс төрд хандах хандлага, чиг баримжаа өөрчлөгдөж, Монголчуудын улс төрийн үйл байдал, оролцоонд гүнзгий өөрчлөлт орсон ба ардчилал Монголд бодитой биелэлээ олсон том амжилт (Мөнхбат С, Бумдарь Д, Мэндхүү Г, 2016) хэмээн үзжээ. Нөгөөтэйгүүр Монголын ардчилал, төлөөллийн сорилт ба шууд ардчиллын боломж судалгаанд улс төрийн нам, улс төрийн харилцаанд үүсэж буй сорилт, бэрхшээлийн үр дүнд нь улс төр, эрх чөлөөний анархи байдал, шударга ёсны алдагдал, ёс суртахууны уналт, нийгмийн давхраажсан бүтцийн гаж гэж нэрлэж болох үйл явц гэх мэт бодит байдал бий болон үргэлжилж байгааг онцолжээ (Чулуунбаатар. Г, Батсүх. Ш, Ганцоож. Б, 2021:64).

Д.Ганбат судлаачийн үзэж байгаагаар ардчиллын агуулга, зорилгод монголчуудын дийлэнхи итгэсэн хэвээр байгаа ба ардчилал, зах зээлийн эдийн засаг нь Монголын хөгжлийг тодорхойлох ёстой гэдэгт эргэлзэхгүй, итгэл бүхий байна. Монгол улс сонгуульт ардчиллын хүрсэн түвшингээс ахиж нягтрал бүхий ардчиллыг бий болгохын тулд анхаарах асуудал байгааг ялангуяа ардчиллын чанарын түвшинд ахиц гарч буй тухай ярих хараахан болоогүй байна хэмээжээ. Тэрээр либерал ардчиллын үнэт зүйлс төлөвшлөө олсоор байгаа боловч нэлээд хэсэг нь Монголд хөгжөөгүй хэвээр, ялангуяа процедурын хэмжүүр болох авлигын хяналт, хэвтээ хариуцлагын тогтолцоо болон эрх зүйт ёс дутмаг байна. Иргэдийн эрэлт хэрэгцээ, санаа тавьж байгаа зүйлийг төр засаг нь анхааралдаа авч хариуцан гүйцэлдүүлж, хэрэгжүүлдэг байхыг олон нийт хамгийн их үгүйлж байна. Одоогийн байгаа байдал нь ардчилсан бус арга барил давамгайлсаар байгааг харуулна. Өрсөлдөөнт сонгуулийн системийг улам хөгжүүлэх, бохир улс төрөөс зайлах, сонгогдсон улс төрчдийн авлигад автах явдлаас сэргийлэх хуулийн хамгаалалт үгүйлэгдэнэ. Сонгуулийн компани ажлын санхүүжилтийн хатуу чанд зохицуулалтыг боловсруулах, хүний эрхийг хамгаалах гол цайз болох шүүхийн салбарыг улс төрийн нөлөөллөөс ангижруулах, хараат бус байх дархлаа, чадамжид олон нийт итгэхгүй хэвээр байгаа нь ноцтой үзэгдэл юм. Харилцан уялдаатай шийдэгдэх учиртай эдгээр тулгамдсан асуудал нь ардчиллын легитим байдлын төлөвшилд шууд нөлөөлөх ба шийдэгдсэнээр ардчиллын чанарт ахиц гарах урьдчилсан нөхцөл болох хамааралтай (Ганбат Д, 2023) хэмээн өгүүлж байна.

#### **4.3 Монголын ардчилалд нөлөөлсөн хүчин зүйлс**

##### **(1) Оюутнуудын хөдөлгөөн**

Монголын ардчилсан хувьсгалын гол хүчин нь тухайн үед гадаад болон дотоодын их дээд сургуульд сурч байсан оюутан залуус байсан билээ. Европын посткоммунист орнуудад сурч, ажиллаж амьдарч байсан хүмүүс Минскээр дайрч гардаг, оюутан залуус улс төр их ярьж, тэр дундаа ЗХУ-д М.С.Горбачёвийн эхлүүлсэн өөрчлөн байгуулалт, ил тод байдал, олон ургальч үзлийг Монголд авчирсан, эхлүүлсэн улс (Тойн Бат-Эрдэнэ Д, 2008:38-39) хэмээн түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. ЗХУ-д өрнөсөн “Өөрчлөн байгуулалт” (Престройка) нь Зүүн

Европ дахь үйл явдлын нөлөө Монгол улсад нэвтэрч, төр засгийн үйл ажиллагааг шүүмжилсэн үзэл санаа сонсогдох болсон юм. Ийнхүү 1989-1990 оны ардчилсан хувьсгалын үед их дээд сургуулийн оюутнууд Монголын улс төр, нийгмийн шинэчлэлийн хөдөлгөөнийг урагшлуулахад гол хүч байв. Түүхэн нөхцөл байдал нь өмнөх хэсэгт дурьдсанчлан нэгд, Монголын улс төр, нийгмийн орчин нөхцөл, хоёрт, ЗХУ болон бусад социалист орнуудын нийгэм эдийн засгийн өөрчлөлтийн нөлөө, гуравт, Монголын залуучуудын сэтгэл зүй, хүсэл эрмэлзэл байв.

Оюутны хөдөлгөөн үүсэх болсон шалтгаан нь нам төвтэй нийгмийн хязгаарлалтууд байсан бөгөөд үүнийг дагаад иргэдийн үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, хүний эрхийн зөрчил, хомсдол болон улс төрийн олон үзэл баримтлалт орон зай үгүйлэгдсэн байдал болжээ хэмээн үзэж болно. Монголын сэхээтнүүд, их дээд сургуулийн багш, оюутнуудад шинэ үзэл санаа хүчтэй нөлөөлж, эрх чөлөөг эрэлхийлэх үндэс суурь бүрдсэн юм (Баабар, 1999). Монгол улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж “Монголчуудын дунд улс төрийн шинэчлэлийн тухай яриа зөвхөн түүхч, философичид гэлтгүй, энгийн залуус, оюутнуудын хүрээнд ч өрнөх боллоо” (Элбэгдорж Ц, 1998) хэмээн бичиж байв.

Оюутнуудын дунд төр, намын хяналтыг эсэргүүцэх, нийгмийн шударга ёс, үг хэлэх эрх чөлөөг шаардах үзэл санаа газар авахад гадаад улс орнуудад сурч байсан олон оюутнууд ч нөлөөлсөн юм. Олон нийттэй нээлттэй харилцах орон зай, үзэл бодлоо чөлөөт хэлбэрээр илэрхийлэх байдал дутагдаж байсан тул тэдний хувьд иргэний дуу хоолой болох нь хувь хүний эрх, улс орны ирээдүйтэй холбоотой асуудал болсон ба шүүмжлэлт сэтгэлгээ, эрх чөлөөний эрэл хайгуул эхэлсэн юм. Хөдөлгөөнийг удирдан манлайлагч оюутнууд нь дөнгөж их сургууль төгссөн залуу сэхээтнүүд байсан ба ихэнх нь 20-иод настай, гадаад харилцаа, философи, эдийн засаг, түүх, сэтгүүл зүйн чиглэлээр суралцаж байжээ.

1989 оны сүүлчээр гудамж талбайд тухайн үеийн засаг төрийн бодлоготой үл нийцэх үзэл санаа бүхий ухуулах хуудас мэр сэр наах, монголчууд бид улс төр, оюун санааны олон зуун жилийн хүлээсээс ангижирч эрх чөлөө, сайн сайхан амьдрал, шударга ёсны төлөө тэмцэлд шулуудах цаг болсон хэмээн уриалж байв. Үйл ажиллагаагаа далд хэлбэрээр явуулдаг улс төрийн бүлэглэлүүдээс гадна ил тод, улс төрийн амьдралд идэвхитэй оролцох сонирхол бүхий залуучууд бие даан бүлэг, клуб байгуулж, улс төрийн сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж эхэлсэн байна. Үүнд:

- Ардчилсан Социалист Хөдөлгөөн (1989 оны 12 дугаар сар): Оюутан, багш профессор, сэхээтнүүдийн хамтарсан хөдөлгөөн байлаа.
- Улс төрийн “Шинэ үеийн залуусын холбоо”, Залуу Монгол, Хүний эрхийн клубүүд оюутны дунд байгуулагдаж байв.
- УБДС-ийн оюутнуудын “Цагийн толь”
- Монголын үйлдвэрчний эвлэлийн Соёлын төв ордны улс төр сонирхогчдын “Орчлон” клуб
- “Ертөнц” маргааны клуб
- Залуу эдийн засагчдын клуб
- Дэвшилтэт залуучуудын клуб гэх мэт байгуулагдаж олон түмний дунд ялангуяа залуучуудын дотор идэвхитэй үйл ажиллагаа явуулж байв.

1989.11.26-нд “Залуу уран бүтээлчдын II зөвлөгөөн” гэдгийг МАХН-ын Төв Хорооноос зохион байгуулсан байна. Зөвлөгөөнд оролцсон залуучууд “сэхээтний төөрөгдлөөс” хойш хэн ч зориглон хэлж байгаагүй хурц шүүмжлэлийг өрнүүлжээ. Залуучууд тэндээс гараад тусдаа хуралдсан ба хэд хоног цугларалт хийсний үр дүнд “Монголын ардчилсан холбоо” хэмээх олон нийтийн байгууллагыг байгуулжээ. Удирдагчаар нь 27 настай МУИС-ийн багш С.Зориг сонгогдсон юм. Үүнээс дараа 1989.12.07-ны өдөр Ховд хотод оюутан багш нар жагсан Улс төрийн товчоо огцрох шаардлага тавьж байжээ. Цуглаан Монгол орны энд тэндгүй өрнөж, олон нийтийн сайн дурын холбоо, нэгдлүүд үүсэн татан оролцсон хүмүүсийн тоо хэдэн мянгад хүрсэн юм.

1989.12.10-ны Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан Сүхбаатарын талбайд зохион байгуулсан цуглаан бол ардчиллын эхлэлд тооцогддог байна. Энэ жагсаалд МУИС, УБИС-ийн оюутнууд голлох үүрэгтэй оролцож “хэвлэлийн эрх чөлөө”, “улс төрийн шинэчлэл”, “залуу үеийн дуу хоолойг сонс” гэх мэт уриаг хашгирч байсан талаар түүхэн баримтад тэмдэглэгджээ (Монголын үндэсний архив, 1990).

*“Бид намын заавраар биш, иргэний ухамсраар жагсаж байна. Энэ бол эхлэл”*

*(МУИС-ийн оюутан Эрдэнэбат,  
1989 онд архивлагдсан аудио бичлэгээс)*

1990.03.07-ны өдөр Ардчилсан холбооны арван гишүүн өлсгөлөн зарласан юм. Тэдгээрийн дотор оюутан, залуу үеийн төлөөлөл зонхилж байжээ. Жишээлбэл өлсгөлөнд оролцогчдын дийлэнхи нь 20-30 насны залуучууд байсан ба МУИС, Политехникийн дээд сургуулийн оюутан, төгсөгчид байв. Тэд өлсгөлөн зарлаж, нойргүй хонох, тайван суулт хийх, тунхаг бичиг гаргах зэрэг тэмцлийн хэлбэрүүдийг сонгосон нь Монголын ардчилал цус урсгаагүй тайван замаар хэрэгжих үндэс болсон юм. Энэхүү үйл явдал олон нийтийн анхаарлыг төвд орж, засгийн газарт улс төрийн дарамт үзүүлсэн бөгөөд 1990.03.09-нд БНМАУ-ын Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон билээ (Төрийн төв архив, 1993).

МУИС-ийн оюутнууд “Үнэн” сонины эсрэг нийтлэлүүдийг хуулбарлан гаргаж, нийтлэл, зураг, өгүүлэл бичих, тараан уншуулах ажлыг хийж байлаа. Радио, самбар дээр “Ирээдүй биднийх”, “Нэг нам-нэг үзэл бодол биш” гэх мэт уриа лоозонг оюутнууд анх санаачилсан. Дээрх түүхэн баримтуудад эмэгтэй оюутнууд ч идэвхтэй оролцож жагсаалын үеэр илтгэл тавьж, хүний эрхийн тухай мэдэгдэл унших, өлсгөлөнд нэгдэн үзэл бодлоо илэрхийлж байсан юм.

МУИС, УБИС, ПДС-ийн оюутнууд дундаас “Шинэ үеийн залуусын холбоо”, “Ирээдүйн төлөө” зэрэг бүлгүүд байгуулагдаж Ардчилсан Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон ба тэд тэмцлийн стратеги боловсруулах, уриа лоозон гаргах, мэдэгдэл, тунхаг бичиг бичиж, нийлүүлэх, иргэдийг цуглаанд уриалах, мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулалттайгаар хийж байв.

Дээрх бүх үйл явцын үр дүн улс төрийн системийн эргэлт болж 1990.03.09-нд БНМАУ-ын Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорч, төрийн эрх мэдэл ард түмэнд шилжсэн, 1990.05 сард Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрсөн, 1990.07 сард Монгол Улсын анхны олон намын, чөлөөт, өрсөлдөөнт сонгууль зохион байгуулагдсан үр дүн гарчээ.

Оюутнуудын оролцоо нь иргэн төвтэй нийгмийн төлөвшил, төрийн хяналттай биш нийгмийн хяналттай засаглалын эхлэлийг ийнхүү тавьсан юм. Үүгээр дамжуулан залуучууд улс төрийн идэвхийг шинэ шатанд гаргасан ба олон нийтэд нийгмийн эрх тэгш байдал, эрх чөлөөний үнэ цэнийг таниулж, иргэний оролцоог бий болгосон. Эдгээрээс 1990 оны үйл явцын туршлагаас харвал ардчиллыг гагцхүү улс төрийн эрх чөлөө гэж ойлгохоос гадна иргэний хариуцлага, оролцоо, хуулийн засаглал гэсэн ойлголтыг оюутнууд ойлгож, залуу үеийн манлайлал оролцоо нь ардчилсан тогтолцооны чухал нөлөө үзүүлдэг хүч гэдгийг нотолсон юм. Судлаач Баабар “Хэрэв оюутнууд 1990 онд дуугүй байсан бол Монгол ардчилсан болох байсан уу? Энэ асуултын хариу нь үгүй л байх байсан” (Баабар, 1999) хэмээн тэмдэглэж байжээ.

Өнөө үеийн оюутан залуучуудын улс төрийн оролцооны талаар шүүмж багагүй байна. Тэд хэдийгээр ардчилсан нийгэмд өсөж сурч байгаа ч иргэний оролцооны түвшин бага, тухайлбал УИХ, Ерөнхийлөгчийн болон орон нутгийн сонгуулийн ирц, оролцооноос харагддаг ба энэ нь томоохон сорилт болж байна.

## **(2) Нам бүс ардчилсан хүчин**

XX зууны эхэнд Монгол улс нэг биш хэд хэдэн нам байх бололцоог тэр үеийн эрх баригч улс төрийн нам үгүйсгээгүй бөгөөд хэрэг дээрээ олон намын тогтолцоо бүхий ардчилсан тогтолцоог хүлээн зөвшөөрч байсан үзэл санаа өвлөгдсөөр 1990-ээд онд шинээр үүссэн улс төрийн нам, хөдөлгөөнийг хууль ёсны эрх баригч улс төрийн хүчний хувьд хүлээн зөвшөөрч, анхнаас нь яриа хэлэлцээрт орж, хамтран ажилласнаар эрс өөрчлөлтийн төлөө тэмцлийн янз бүрийн хэлбэрүүдийг нийгэм, улс орныг бүхэлд нь хамарсан хурц хямралд хүргэхгүйгээр орчин үеийн ардчилсан хэв шинжид оруулах үйл явцыг бий болгосон (Чулуунбаатар. Г, Батсүх. Ш, Ганцоож. Б, 2021:64) хэмээн улс төр судлаачид үзжээ.

1980-аад оны эхэн үеэс эхэлсэн өөрчлөн байгуулалтын үзэл санаа Монгол улсад хүчтэй өрнөж байлаа. Тухайлбал 1980-аад оны дунд үеэс нам засгийн төв хэвлэл “Үнэн” сонин, “Намын амьдрал” сэтгүүлүүдэд нийгмийн тогтолцоог боловсронгуй болгон өөрчлөх, ардчилал, ил тод байдлыг дэлгэрүүлэн хөгжүүлэх, үзэл бодлын чөлөөт байдлыг хааж хязгаарласан байдлыг халах зэрэг үзэл санааг далд болгоомжтой байдлаар хөндсөн нийтлэлүүд гарах болсон юм. Энэ байдал нь олон нийтийн санаа бодол, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж, нийгэмд бүтээлч сэтгэлгээ, өөрчлөлт шинэчлэлийн үзэл санаа, уур амьсгал идэвхитэй сэргэхэд нөлөөлсөн гэдгийг судлаачид мөн онцолсон байдаг.

1988 онд анхны хагас нууц дугуйлангууд байгуулагдсан билээ. Э.Бат-Үүлээр удирдуулсан “Шинэ эрин” нууц бүлгэм шөнийн цагаар Улаанбаатар хотын гудамжаар ухуулах хуудас наасныг Нийгмийг Аюулаас Хамгаалах яам (НАХЯ) илрүүлсэн ч сануулга өгөөд салж байсан талаар олон ном зохиолд үлдсэн байна. Сэтгүүлч дуучин С.Цогтсайханы “Хонх” хамтлаг байгуулагдаж тухайн үедээ залуучуудын хамгийн дуртай хамтлаг болж, нийгмийн төрөл бүрийн бугшмал асуудал, улс төрийн дэглэм, дарангуйллын эсрэг нийгмийн дуу хоолой болж байлаа. Ардчиллыг тогтооход “Хонх” хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгийг үүсгэн байгуулагч Н.Энхбаяр өгүүлсэн байдаг.

*“Хонх” хамтлагийг санаачлан байгуулсан Цогтсайхан бол тэр үеийн нийгмийн хайрцагт баригдчихаад байсан хүмүүсээс шал анги, чөлөөт сэтгэдэг байсан учраас түүний зохиосон дуу хүмүүст маш хурдан хүрсэн, Анхны тоглолтын үеэр олон асуулт асуусан. Тэр үеийн хүмүүсийн ярьж болдоггүй сэдэв байлаа.*

*(“Хонх” хамтлагийн дуучин Н.Энхбаярын ярилцлагаас)*

“Монголын ардчилсан хувьсгалын дуучид” хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн “Хонх” хамтлаг бол ардчиллын үйл явцад урлагаар дамжуулан хувь нэмрээ оруулсан түүхэн чухал соёлын төлөөлөл юм. Тэдний үүрэг нь зэвсэг барин тэмцэх бус, харин урлаг тэр дундаа дуугаар нийгмийг сэрээж, уриалж, нийгмийн ухамсарт нөлөөлсөн юм. Учир нь Хонх хамтлагийн уран бүтээл нь тухайн үеийн нэг намын дарангуйлал, коммунист засаглалыг шүүмжилсэн, хүний эрх, эрх чөлөө, үнэт зүйлсийг илэрхийлсэн уран сайхны агуулгаар ардчиллыг дэмжсэн, олон нийтийн оюун санаанд үнэ цэнийг суулгаж чадсан (Гомбосүрэн Д, 2015) илэрхийлэл дүүрэн байсан билээ.

Хонх хамтлагийн уран бүтээлд “Хонхны дуу”, “Сэрэх цаг болсон”, “Чиний төлөө” зэрэг олон дуу нь залуусын ухамсарт өөрчлөлт хийх цаг болсныг ойлгуулж, иргэн төвтэй үзэл баримтлалыг дэмжиж байсан юм. Өөрөөр хэлбэл Хонхны дуу гэдэг нэр томьёо нь сэрэх, сэрэмжлэх, дуудлага гэсэн утгыг агуулж, хөдөлгөөний соёлын бэлгэ тэмдэг болсон юм. Түүнчлэн Сүхбаатарын талбайн жагсаал, өлсгөлөн зарлах үед ч тоглож, ард олон дэмжлэг үзүүлэн дарангуйллын үед ил тод улс төр ярих боломжгүй ч урлагаар дамжуулан илэрхийлэл болж байлаа. Хонх хамтлаг нь Монголын ардчилсан хувьсгалын соёл, оюун санааны хүч болж нийгмийн сэтгэл зүй, иргэдийн ухамсрыг сэргээж, итгэл найдварыг өгч, тэмцлийн шинэ хэлбэрийг бий болгосон юм. Хонх хамтлаг зөвхөн улс төрийн уриа бус, сэтгэл хөдлөлийн нөлөөлөл бий болсон нь тэдний оруулсан үнэтэй хувь нэмэр төдийгүй “урлаг бол нийгмийн сэтгэл зүйн хувьсгалын хамгийн хүчтэй хэлбэр” болохыг тод харуулсан гэж судлаачид үздэг (Бат-Орших Н, 2009).

Нөгөөтэйгүүр 1990.03 сараас Монголын тогтмол хэвлэлийн түүх өөрчлөгдөж нийгмийг сэрээсэн сэтгүүлчид “Шинэ толь”, 04.6-7-нд шилжих шөнө “Ардчилал” сонины анхны дугаар мэндэлж байжээ. Дугааруудад сонины бодлого, зорилго, байр суурийг тодорхойлсон ямар нэгэн өгүүлэл нийтлээгүй ч үзэл бодлын чөлөөт индэр байх эрмэлзэлтэй байсан. Ардчилал сонин бол итгэл үнэмшлээрээ эвлэлдэн нэгдсэн хүмүүс, хувь хүн ч гэсэн тогтмол хэвлэл эрхлэн гаргаж болох юм байна гэдэг санаа сэдэл, эр зоригийг нийгэмд өгч, 1990-ээд оны сонины шинэ завалгаа эхлэхэд хамгийн их нөлөөлсөн хэвлэл (Галаарид Б, 2015) хэмээн үнэлсэн юм.

Монголын шинэ үеийн улс төрийн түүхэнд онцгой байр суурийг эзэлдэг Залуу уран бүтээлчдын улсын II зөвлөгөөн 1989.2 сарын сүүлээр хуралдаж, өөрчлөлтийн үйл явцыг эрчимжүүлэхийн тулд улс төрийн шинэ байгууллага байгуулах санал гаргаж, МоАХ-г бий болгосон юм.

Нийслэл Улаанбаатар хотын дараа ордог, дэлхийд Уулын баяжуулах үйлдвэрээрээ эхний аравт жагсдаг томоохон үйлдвэр бүтээн байгуулалтыг өрнүүлж байгаа Эрдэнэт хотод 1989.12.04-нд хөдөлмөрчин олны тайван жагсаал болсон бөгөөд “Эрдэнэтээс Оросын цэргийн ангийг гаргах, Тосон Заамарын алтны уурхайг ашиглахгүй байх, Эрдэнэт

үйлдвэрийг үндэсний болгох, баригдаж буй Эсгий, эсгий гутлын үйлдвэрийг барихгүй байх, Мод дамжуулах үйлдвэрийг нэн даруй хаах” гэсэн шаардлагыг Намын төв хорооны 5-р бүгд хуралд илгээж хэлэлцүүлж байжээ.

Улс төрийн анхны байгууллагыг 1989.12.10-ны өдөр анхны улс төрийн цуглаан дээр зарласнаас эхлэн Монголын ард түмний улс төрийн идэвх урьд өмнө байгаагүйгээр сэргэн тоталитар дэглэмийн эсрэг олон түмний тэмцлийг зохион байгуулалттай хэлбэрт оруулан манлайлах зорилгоор эвсэл, холбоод дараалан байгуулагдсан юм. Үүнд 1989.12.28-нд Ардчилсан социалист хөдөлгөөн, 1990.02.16-нд Шинэ дэвшилт хөдөлгөөн, Эвийн холбоо нэгдэж Шинэ дэвшилт холбоо, 1990.03 сарын эхээр Монголын оюутны холбооны онц IY бага хурлаар оюутны байгууллага бие даасан улс төр, олон нийтийн байгууллага болсон тухайгаа зарласан байна. Ийнхүү Монголын нийгэмд “Дөрвөн хүчнийхэн”, “Ардчилсан хүчнийхэн” хэмээн нэрлэгдсэн улс төр-олон нийтийн байгууллагын үндсэн цөс бүрэлдэж, цаашдаа Монголын Ногоонтны холбоо, Үйлдвэр үйлчилгээний хоршоодын холбоо, Монголын Сүсэгтний холбоо, Монголын малчин тариаланчдын холбоо, Монголын Ажилчны нэгдсэн холбоо зэрэг олон арван олон нийтийн байгууллага байгуулагдаж Монголын ардчиллын үйл явцад оролцох болсон юм. Монголын ардчилсан холбоо байгуулагдсанаас хойш 2 сарын хугацаанд таван удаагийн цуглаан зохион байгуулагдаж 60 гаруй мянган хүн оролцож байжээ. МоАХ нь 80 шахам салбар зөвлөлийг байгуулж, 30 гаран мянган гишүүнтэй болсноор өргөжиж, жагсаал цуглаан зохион байгуулах, өргөх, шаардах бичиг барих зэрэг идэвхитэй ажиллаж эхэлсэн юм.

Монголын иргэдийн оролцсон улс төрийн ардчилсан хөдөлгөөн нь улс төрийн реформ, эрх чөлөө, ардчилал, либерал үзэл баримтлалын төлөө жагсаал цуглааныг санаачлан гардан хэрэгжүүлэгч бүлгэм, клубүүдээс эхлэлтэй бөгөөд улмаар улс төрийн нам болон өргөжсөн байдаг. 1992-1997 оны хооронд ардчилсан шинэ Үндсэн хуулинд иргэний нийгэм байгуулах явдлыг эрхэм зорилго болгон дэвшүүлж, олон улсын донор байгууллагуудын дэмжлэгтэйг төдийгүй дотоодын иргэний нийгмийн байгууллагууд улс төрийн төдийгүй ардчиллын суурь зарчим болох хүний эрх, эрх чөлөө, иргэдийн оролцоог хамгаалах, нийгмийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж, шашны сүм хийд, чөлөөт хэвлэл мэдээллийн байгууллагууд цэцэглэн хөгжсөн юм (Мягмарсүрэн Д, Төгөлдөр Я, 2023).

Үүнээс гадна 1990 оны ардчилсан хувьсгалд иргэний нийгмийн байгууллагын гүйцэтгэсэн үүрэг их юм. Зарим судлаачид коммунизмын уналт хийгээд ардчиллын давалгаанд нөлөөлсөн гол хүч бол иргэний нийгэм хэмээн үздэг (Kubik J , 2003) ба Монгол улсын хувьд ардчилалд шилжээд 30 гаруй жил болж байгаа хэдий ч засаглалыг бэхжүүлэх, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сайжруулахад иргэдийн болон иргэний нийгмийн оролцоо чухал хэвээр байна хэмээн судлаачид үзэж байна. Манай улсын хувьд иргэний нийгмийн хөгжил, ардчиллын бэхжилтэд чухал хувь нэмэр оруулах учиртай байгууллагууд нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн улс төрийн боловсролыг сайжруулахад манлайлан оролцож чадахгүй байгаа юм (Одгэрэл Б, Мөнхжаргал О, 2023).

### **(3) Нийгмийн дундаж давхрагынхан**

Монголын нийгмийн бүтцийн харилцаанд дундаж давхрагад сэхээтэн, багш, эмч, инженер, бага дунд шатны албан хаагчид, техникийн ажилтнууд, ажилчин, малчид тариаланчид байв. 1980-аад оны сүүл үед нийгмийн дундаж давхрагын нөхцөл байдлыг авч үзвэл төлөвлөсөн

төлөвлөгөөт эдийн засгийн хямрал, үнэ ханшийн өсөлт, хэрэглээний барааны хомсдолд өртөж, үзэл бодлоо илэрхийлэх боломжгүй, намын гишүүнчлэлгүй бол ажил албан тушаал ахих боломж хомс байлаа.

*Бид төрд ажилладаг ч хэлэх үггүй, шийдвэрт оролцдоггүй хүмүүс байсан. Энэ шударга бус явдлыг өөрчлөх ёстой гэж итгэсэн.*

*(ЭМШУИС-ийн багш асан Н.Цэцэгмаа. 1990 оны архивын материалаас)*

Монголчуудын хувьд 1988 оны сүүлчээр МАХН-ын Ү бүгд хурал хуралдаж, “Престройка” буюу өөрчлөн байгуулалтын үйл явцад сэргэсэн Монголын ард түмэн эрх баригч байгууллагын энэ хуралд ихээхэн найдвар тавьж байсан тухай Баабар “Монголчууд нүүдэл суудал” номондоо өгүүлжээ. Хурлын өмнө “Үнэн” сонинд ард түмнээс ирүүлсэн захидал хэмээн нам засгийн удирдагчдыг шүүмжилсэн олон захидал нийтлүүлжээ. Тухайн үед энэ сонин 180 мянган хувь хэвлэгдэж байсан түүх байна. Найдлага тавьж байсан намын бүгд хурал дээр энэ тухай огт яриагүй ч нийгмийн дунд тэсрэлт болсон юм.

Социализмаас ардчилалд шилжих үеийн нийгмийн бэлэн биш байдалд засгийн газраас авч хэрэгжүүлсэн өмч хувьчлал, эдийн засгийн эрс шинэчлэл зэрэг нь өмчийн талаарх ойлголтгүй нийгмийг баян ядуугийн хэт туйлд хуваах суурь болсноор өнөөг хүртэл улс төр, эдийн засгийн хэт тэнцвэргүй харилцаа бий болж ардчиллыг гажуудуулж байна хэмээн судлаач Ж.Төртогтох, Д.Хулан нар дүгнэжээ. Тэрээр эдийн засгийн хөгжил нийгмийн шинэ давхаргыг бий болгоно, энэ нь нийгмийн хөгжлийн үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөх буюу ардчилал хөгжинө. Өнөөдрийн ардчилал, улс төрийн соёлыг бэхжүүлэх асуудал нь ардчиллаас ухрах уу, урагшлах уу гэсэн сорилтыг бий болгож байна (Төртогтох Ж, Хулан Д, 2023) гэсэн байр суурийг илэрхийлжээ.

#### **(4) Шашны хүчин**

1989-1990 оны ардчилсан хувьсгалд Монголын нийгмийн олон салбараас тэр дундаа оюутнууд, их дээд сургуулийн залуу багш нар, сэтгүүлч зэрэг олон сэхээтнүүд нэгдэж, тоталитар дэглэмийн эсрэг эрх чөлөө, хүний эрх, олон ургальч үзлийн төлөө тэмцсэн билээ. Энэ үеийн сэтгэл зүйл гүнзгий нөлөө үзүүлсэн нэг гол хүч бол шашин, тэр дундаа Буддын шашин байсан. Буддын шашныхан зөвхөн сүсэг бишрэлийн хүрээнд бус, ёс суртахууны сэргэлт, хүний эрхийн үнэт зүйлсийн хамгаалал, түүх уламжлалын сэргэлт, соёлын дархлаа, төлөвшлийн үнэт суурь болж байлаа. Гэсэн ч түүхэнд шашин чанга хатуу бодлогын улс төрийн үзэл байдал, хязгаарлалт, дарамт шахалтанд байсан юм. Шашны үзэл сургаалийг “хоцрогдсон үзэл”, “ард түмнийг мунхруулагч хэрэгсэл” хэмээн үзэж 1937-1939 оны үед ул төрийн их хэлмэгдүүлэлтээр 700 гаруй сүм хийд устгаж, 30.000-40.000 лам, сүсэгтэн олон цаазлагдан хоригдсон (Монголын үндэсний архив, 1999) түүхтэй. Шашны үйл ажиллагааг төрийн зөвшөөрлөөр, хязгаарлагдмал хүрээнд явуулахыг зөвшөөрч Гандантэгчилэн хийд зэрэг сүмүүдэд маш бага тооны лам оршиж байлаа. Харин 1989.12 сард Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар шашин шүтэх, эс шүтэх эрх баталгаажсан юм.

Монголын ардчилсан хувьсгалд шашны байгууллагууд болон шашны зүтгэлтнүүдийн оролцоо бага ч тодорхой хэмжээгээр байсан. Тухайлбал 1989-1990 оны Гандантэгчилэн хийдийн албан ёсны төлөөлөгч зарим лам нар ардчиллын уур амьсгал оргилдоо хүрч байсан үед ард олны итгэлийг нийгмийн ухамсарт чиглүүлэхийг оролдож байв. 1990 оны эхний

жагсаал цуглааны дараа сүсэгтэн болон зарим лам нараас ардчиллыг дэмжиж буйгаа илэрхийлж байжээ. Тухайлбал, архивын зарим мэдээгээр Гандангийн лам нар жагсаалын үеэр иргэдэд энэрэл, эв нэгдлийн уриалсан ном уншлага хийж байсан түүх байна (Монголын үндэсний архив, 1990).

#### **4.4 Монгол улсын ардчиллын дүгнэлт, даалгавар ба ирээдүй**

Ардчилал, ардчилсан нийгмийн үзэл санаа өнө эртний түүхийн улбаатай ч улс төр, нийгмийн хөгжлийн бодит байдал болж амьдралд хэрэгжиж эхэлсэн үе нь XX зуунтай холбоотой талаар олон судлаачид бичсэн билээ. Харин Монголчуудын хувьд ардчилал дахь нийтлэг үнэт зүйлийг сонгоод 35 жилийг ардаа орхисон байна. 1990 оны эхээр өрнөсөн ардчилсан хувьсгал нийгэм, улс төр, эдийн засгийн амьдрал, ард түмний оюун санаа, сэтгэлгээнд эргэлтийн шинжтэй өөрчлөлтүүдийг авчирсан билээ (Мөнхбат С, Бумдарь Д, Мэндхүү Г, 2016).

Энэ хугацаанд социалист системд огт байгаагүй өмчийн олон хэлбэр шилжиж, хувийн өмч, хүний эрх чөлөөний тунхаглалыг хэрэгжүүлэхийн төлөө багагүй амжилтыг бүтээсэн билээ. Гэсэн хэдий ч захиргаадалтын нүсэр системийг халж, чөлөөт зах зээлийн тогтолцоонд шилжих шилжилтийн явц тийм ч амар хялбар биш байна. Судалгааны үр дүнгээс үзвэл Монгол улс олон улсын тавцан дээр Орос, Хятадаас өөр газрын сонирхол татахуйц газар зүйн болоод геополитикийн байрлал үгүй, гадаадын хөрөнгө оруулалт татахуйц эрдэс баялаг, зах зээл үгүй, төр засаг авилгалд идэгдсэн, төрийн бүтэц тогтоц нь оновчтой биш, улс төрийн намуудын аль нь ч төлөвшөөгүй, дэндүү бага зах зээлтэй, тархины зугатаалт эрчимтэй, боловсролтой нь гадагш дүрвэж, улс даяар өрнөж байгаа нүүдлийг зохицуулсан бодлого үгүй, засаг захиргааны нэгжийн бүтэц нь оновчгүй учир маш үрэлгэн, хуулийн орчин бүрэлдээгүй, нийгмийн дотор баян ядуу, сэтгэлгээний хувьд хот хөдөөгийн ялгаа ихэссэн гэх мэтээр дэндүү бараан үзүүлэлттэй байжээ. Үүнийг дагаад шилжилтийн, жижиг эдийн засагтай, буурай хөгжилтэй, эрх чөлөөний төлөө тэмцсэн, зовж зүдэрсэн, өнөө ч амаргүй зам, амьдрал туулж яваа монголчууд бидний хувьд нийгмийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал багагүй байгааг судлаачид тэмдэглэсээр (Баатар Ц, 2003) байна. Мөн судлаач Д.Түмэнжаргал, Г.Туяагэрэл нарын тэмдэглэснээр Монгол улс ардчиллын замд шилжсэнээр дэвшилттэй тал байгаа ч хойших хугацаанд үзэл баримтлалын ялгарал, хэт улс төржилт, ардчиллын хөгжилд, ардчиллын үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхдээ олон бэрхшээлтэй учирч байна. Ардчилал төлөвших болоогүй, бүрэн хэрэгжиж чадахгүй, засгийн газар олон солигдож, төрийн залгамж чанар алдагдаж байгаа нь ардчиллын хөгжилд ноцтой саад учруулж байна (Түмэнжаргал Д, Туяагэрэл Г, 2023).

Монголчуудын уламжлалт улс төрийн үнэт зүйлсийн нэг чухал зүйл бол уламжлалт нүүдлийн соёл, түүний онцлог мөн чанар юм. Эдүгээ цагт монголчуудын уламжлалт нүүдлийн соёл нь суурин соёлтой хүчтэй түрэлтэд орж, нийслэл Улаанбаатар хотдоо хүн амын бараг тал хувь нь ажиллаж амьдарсаар буй монголчуудын өнөөгийн улс төрийн хандлага, үндэсний үзлийн талаарх орчин үеийн сэтгэлгээний өөрчлөлт нь хувьсгалын сонирхолтой үедээ ороод тодорхой хугацаа өнгөрч (ШУА. Философийн хүрээлэн, 2022) буйг илтгэнэ.

2000 оноос эхлэн улс төрийн намууд үзэл баримтлалын ялгаагаа алдаж, хувийн бас бүлгийн эрх ашгийг чухалчилж, намууд төрийг албыг зарж, сонгуульд ялалт байгуулахын тулд

төрийн нөөц, хөрөнгийг ашиглах сонирхол илт ажиглагдах болсон (Гэрэлт-Од Э, 2020) нь Монгол улсын ардчиллын ирээдүйд аюул занал болж байгааг судлаачид анхааруулжээ. 2022 онд МУИС-ийн Улс төр судлалын тэнхим, Ардчилал судлалын төвийн хамтран гүйцэтгэсэн “Монголын улс төрийн хөгжил 1990 оноос хойш: үйл явц, харилцаа, хандлага” экспертийн судалгаанаас харвал улс төрийн намын үзэл баримтлал ялгаа, мөрийн хөтөлбөр, намуудын үнэт зүйлийг 7 оноогоор үнэлүүлэхэд 5 үзүүлэлтийн дундаж утга 2.38 байсан нь улс төрийн намуудын үйл ажиллагааны ардчилсан байдал алдагдсан, намууд үзэл баримтлалаа төдийлөн баримтлахгүй, ач холбогдол өгөхгүй (Мөнхбат С, Эрдэнэдалай Б, 2024) болсныг харуулж байна. Ардчиллыг хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд улс төрийн намууд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд сайн ажиллаж байгаа тохиолдолд олон талын ашиг сонирхлыг төлөөлөх, ардчилсан хариуцлагыг хөнгөвчилж өгдөг. Улс төрийн нам бодлогын ялгаатай байдлаараа өрсөлдөж чадахгүй байгаагийн улмаас иргэдийн улс төрийн сонголт мухардаж, клиенталист намыг хэв маяг, намын картельжилт уруу шилждэг ба улмаар ардчилсан зарчим алдагдаж популизм газар авахад хүрдэг (Төгөлдөр Я, Бумдарь Д, 2021). Энэ нь манай улсын хувьд ч ажиглагдаж байна (Баярбаатар Б, Д.Бумдарь Д, 2023) . Түүнчлэн 1990 оноос хойш 10 орчим жил өнгөрсөн тэртээх 2000 оны үед судлаач А. Жамбал “Нийгмийн хуучин социалист байгуулал нурж, үзэл санааны марксист чиг баримжаа, үнэт зүйл алга болсон хэрнээ тэдгээрийн оронд шинэ нийгэм, шинэ үнэт зүйл гүйцэд бүрэлдэн тогтож хараахан чадаагүй, хүсэж хүлээсэн үр дүнг өгөөгүй байна. ...Монголын нийгэм урьд өмнө тулгарч байгаагүй шинэ ээдрээтэй нөхцөл байдал, нарийн төвөгтэй зорилтуудтай тулгарч байгаагийн дээр тэдгээрийг ямар хэрэгсэл, хэлбэрээр яаж шийдвэрлэх талаархи чиг баримжаа, төсөөлөл, үзэл баримтлал төдийлөн тодорхой бус байна” хэмээсэн нь одоо ч хэвээр байгаа юм.

Монгол улс ардчилсан шилжилт хийснээр нийгмийн бүтцийн ба давхраажилтын тогтолцоо орвонгоороо өөрчлөгдсөн ба 1994 онд ажилгүйдлийн үзүүлэлт 8.7 хувь, 1996 онд 20 хувь хүрч байсан мэдээг Дэлхийн Банкнаас гаргаж байжээ. Түүнчлэн ядуурлын шугамнаас доогуур амьдарч байсан хүн ам 1992-1994 онд 16 хувиас 26.5 хувь болтлоо өссөн, хүн амын 36 хувь ядуу (Nixon, 2000) амьдарч байсан бол 2000-аад оны үед социологичид баялаг, орлого, хэрэглээний хуваарилалтад үндэслэн нийгмийн давхраажлын төлөв байдлыг тодорхойлж дундаас доогуур 50-51 хувь, ядуу 22 хувь, нийгмийн эмзэг маш ядуу бүлгийнхэн 3 хувийг эзэлж байгааг тогтоожээ. Өдгөө 2024 оны байдлаар ядуурлын түвшин 27.1 хувь, ажилгүйдлийн түвшин 5.2 хувьтай байна (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2025). Ардчиллын тогтворжилтыг эдийн засгийн хөгжилтэй холбон тайлбарлавал, эдийн засгийн өсөлт чинээлэг дундаж ангийг олноор нь төрүүлэх бөгөөд нийгмийн элит болон доод давхаргыг холбож, харилцааг зөөллөн ардчиллыг удаан хугацаанд тогтвортой байлгах чадвартай хэмээн Липсет үзсэн (КАС, 2025). Энэ утгаар нийгмийн дундаж давхрага байхгүй бол олигархуудын авторитар дэглэм эсвэл дарангуйлагч төрөх гарах аюултай юм.

### **Бүлгийн дүгнэлт**

Энэхүү бүлэгт хийгдсэн судалгааны ажлыг дүгнэвэл, агуулгын хувьд Монгол улсын ардчиллын түүх, шилжих үйл явц, нөлөөлсөн гадаад болон дотоод хүчин зүйлс, улс төрийн сонгууль, үр дүн, ардчилсан хувьсгалын цөм хүчин болох оюутны хөдөлгөөн, нам бус хүчний оролцоо, дундаж давхрага болон шашны зүтгэлтнүүдийн оролцоо, ардчиллын ирээдүй, даалгаварын талаар судалгааны болон архивын материал бүтээлүүдэд тулгуурлан

багтаалаа.

Монгол улс 1921-1990 оны ардчилсан хувьсгалт өөрчлөн байгуулалтын цаг үе эхлэх хүртэл ЗХУ-ын нөлөөнд ах дүү социалист хамтын ажиллагаатай улс байсан гэдгийг түүх харуулдаг. 1990 оны ардчилсан хувьсгал нь улс орны нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны амьдралд язгуур өөрчлөлтийг авчирсан ба энэ нь бүтцийн, нийгмийн үйл явцын, үүргийн, сэдлийн гүн гүнзгий шинэчлэл байсныг судлаачид онцолж байна. Монгол улсад дэлхий нийтийн төрийн захиргааны салбарт танигдсан улсын салбарын шинэ менежментийн парадигм, дотоодын хямралт нөхцөл байдлын нөлөөгөөр ардчиллын төлөөх чармайлт хүчээ авч, хаалттай нэг намын системтэй, тоталитар байсан улс үндэстний хувьд олон шинэ түнштэй болох, шинэ гадаад бодлого хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөний шинэчлэлтийг хэрэгжүүлсэн байдаг. Улс төр, нийгэм, эдийн засаг, боловсрол, соёл, шинжлэх ухаан, шашин гэх мэт бүхий л хүрээнд шинэ үндсэн хуульд зааснаар ардчилсан шударга ёс, эрх тэгш байдал, үндэсний эв нэгдлийг тунхагласан гэдгийг бүлгийн агуулга бүрэн илэрхийлж байна. Ардчиллын төлөөх оюутан залуусын, нам бус хүчнүүдийн, шашны зүтгэлтнүүдийн, нийгмийн дундаж давхрагынхны оролцоо Ховд, Эрдэнэт, Улаанбаатар зэрэг орон нутгуудыг хамарч, тэд тэмцлийн гол масс, хөдөлгөгч хүч нь байлаа.

Өдгөө Монголын ардчиллын тухай түүний шинж байдал, хөгжлийн талаарх судлаачдын үзэж буйгаар хуучин социалист системд байгаагүй өмчийн олон хэлбэрт шилжсэн, хувийн өмч, хүний эрх, эрх чөлөөний тунхаглалыг хэрэгжүүлэхэд багагүй амжилтийг бүтээсэн ч геополитикийн асуудал, төр засгийн авилгын нөхцөл байдал, төрийн бүтэц тогтолцоо нь оновчтой биш, улс төрийн намуудын төлөвшил тэр дундаа үзэл баримтлалын ялгарлаа алдсан бүлгийн эрх ашгийг чухалчлах үзэгдэл, тархины зугатаалт, нийгмийн дунд баян ядуугийн ялгаатай байдал нь ардчилалд ноцтой хохирол учруулж байна. Түүнчлэн ардчиллын тогтворжилтыг эдийн засгийн хөгжилтэй холбон авч үзвэл ядуурал 2024 оны байдлаар 27.1 хувьд хүрсэн ажилгүйдэл 5.2 хувьтай байгаа нь ардчиллыг бэхжүүлэхэд гол үүрэгтэй дундаж давхрагынхны хүч оролцоо, хариуцлагыг сулруулж байгааг анхааруулжээ. Товчхондоо бол ардчиллын шилжилтийн цаг үеүдэд цөм хүч болох оюутан, залуус, нийгмийн дундаж давхрага, цагаан захтнууд хамгийн чухал үүрэгтэй байсан ч 2000 оноос хойш эдгээр хүчний оролцоо багасаж, тэр хэрээр ардчилалд бэхжиж чадахгүй байна хэмээн дүгнэж байна.

## **ТАВДУГААР БҮЛЭГ.**

### **БНСУ-ЫН АРДЧИЛЛЫН ЗАМНАЛ, МОНГОЛ УЛСАД ӨГЧ БУЙ СУРГАМЖ**

#### **5.1 Монголын нийгэм, эдийн засаг, улс төр, соёлд үзүүлэх нөлөө**

Ардчиллын нөлөө нь тухайн улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн, соёл, боловсрол гээд бүхий л хүрээнд гарч буй чанарын өөрчлөлтийг бий болгодог юм. Ардчилсан тогтолцоо нь ил тод байдал, хариуцлага, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, иргэдийн идэвхи оролцоо, иргэний нийгмийн байгууллага, улс төрийн ухамсар, ёс зүйг нэмэгдүүлж, шинэ соёлыг бий болгодог учраас билээ. Ардчиллыг бэхжүүлэхэд илүү либерал бодлого хэрэгжүүлж, иргэддээ хариуцлагатай хандаж, хууль дээдлэх, эрх мэдлийн төвлөрлийг сааруулах, хүчтэй иргэний нийгэм болоод сайжруулсан эдийн засаг, улс төрийн гүйцэтгэлийг бий болгох нь чухал хэмээн Даймонд үзжээ. Тэрээр дэлхийн улс орнууд ардчиллыг өөр өөр хурдаар, өөр өөр арга зам хэлбэрээр хэрэгжүүлж байгаа ч эцсийн дүндээ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, иргэний эрх, үүрэг хариуцлагад төвлөрөх гэдэг утгаараа бүгд ижил (Diamond L, 1999) гэжээ.

Өдгөө Монгол улсын “гуравдагч хөрш”-ийн бодлогод хүндтэй байр суурийг эзэлж буй БНСУ, Монгол улстай эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд хамгийн ойрын харилцаатай, модернизацийг идэвхижүүлэн хөгжүүлэхэд нөлөөтэй улс орны нэг болсон. Түүхэнд хойд хөршийн нөлөө асар их байсныг үйл явдлууд харуулах бөгөөд Монгол улсын улс төр, нийгэм, эдийн засаг, соёл төдийгүй ард иргэдийн өдөр тутмын аж амьдралын хэв маягт ч энэ нь гүн бат шингэсэн байгаагаас харж болно. Харин 1990 оны ардчилал Монголын түүхийг эрс өөрчилж, зөвхөн хойд урд хөршөөс гадна Азидаа олон улс орнуудтай харилцаатай байх боломжийг нээсэн. 1990 оноос өмнө БНАСАУ-тай найрамдлын харилцаатай орны хувьд БНСУ-тай ч нээлттэй гадаад бодлогын харилцаатай болж, маш олон иргэд харилцан зорчиж, ажиллаж, сурч амьдарсаар олон мянган иргэдийн хамгийн ойр дотно улсын нэг болсон билээ.

1990-ээд онд Монгол улс нэг намын тоталитар дэглэмийг эсэргүүцэж ардчиллын замыг сонгохдоо Азийн бүс нутагт БНСУ-тай адил амжилттай шилжилт хийсэн улс орны нэг болжээ. Солонгос улсын жишиг, хөгжлийн туршлага Монгол улсад шууд ба шууд бус нөлөө үзүүлсэн нь дамжиггүй. Энэ хүрээнд хоёр орны ардчиллын хөгжлийн харилцан холбоог улс төр, нийгэм, эдийн засаг, үндэсний онцлог, соёлын суурьтай уялдуулж өргөн хүрээнд судлах шаардлагатай юм. Гэвч энэ нь зөвхөн нэг судалгааны ажлаар хязгаарлагдахгүй тус тусдаа судлагдахуунтай өргөн сэдэв болно. БНСУ-ын ардчилсан институцын шинэчлэл, олон нийтийн оролцоо нь шинээр ардчилалд шилжиж буй орнуудад ямар стратеги, сургамж өгч байгаа талаар судлаачдын байр суурь цөөнгүй (Kim Y, 2019) байна. Энэ талаарх судалгааны ажлыг тоймлон авч үзвэл дараах байдалтай байна.

#### **(1) Нийгэм, улс төр, эдийн засгийн салбарт**

БНСУ Монгол улсын “гуравдагч хөрш”-ийн хувьд хил залгаа хоёр хөршөөс гадна нийгэм, улс төр, эдийн засаг, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтад маш их хувь нэмэр оруулсаар ирсэн юм. Монгол улсын худалдааны Хятад, Орос, Японы дараа ордог 4 дэх түнш бөгөөд

нийт экспортын 1.6 хувь, импортын 7.1 хувь эзэлдэг ба манай улс молибдений хүдэр, баяжмал, мал амьтны үс, хялгас зэргийг голчлон нийлүүлдэг бол тус орноос газрын тосны бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараа, машин тоног төхөөрөмжийг импортолдог байна (Энхцэцэг С, 2017). Манай улсын хувьд Солонгосын шууд хөрөнгө оруулалт 1990 оноос хойш бөөний болон жижиглэнгийн худалдаа, зочид буудал, нийтийн хоол, хэвлэл, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай, газар тариалан, барилгын салбарт өргөжин тэлж байгаа бөгөөд буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл ч боловсрол, эрүүл мэндийн салбарт чиглэсээр байна. Өдгөө БНСУ-аас Монгол руу чиглэсэн мөнгөн гуйвуулгын дүнг харвал 2019 онд 120.400 мянган ам доллар байсан бөгөөд түүнээс хойш 3 жил дараалан буурч, харин 2023 оны байдлаар 40.384 ам доллар болж өссөн үзүүлэлттэй байна (Мөнхнасан Г бусад, 2024).


Монголд тархсан Солонгосын давалгаа үзэгдлийн нийгэм эдийн засгийн нөлөөний талаарх судалгааны ажлууд олон байна. Тухайлбал С.Мөнхжаргал судлаач Монгол дахь Солонгосын давалгаа үзэгдэл нь Монгол дахь Солонгосын талаарх ойлголтыг дээшлүүлж, хоёр улсын харилцан ойлголцлыг сайжруулснаар эдийн засаг, нийгэмд нөлөөлөхүйц үр дүнг авчирсан хэмээн дүгнэсэн байна.

## **(2) Шашин, соёл боловсролын салбарт**

1990-2010 оны үед БНСУ-ын засгийн газраас соёлын дипломат бодлогоор дамжуулан хуучин социалист орнуудтай найрсаг харилцааны сууриа бататган бэхжүүлэх зорилгоор соёлын хэлэлцээр байгуулах, соёл боловсролын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ихээхэн анхаарч иржээ. 1991 онд хоёр улсын хооронд “Эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Соёлын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр” хийгдэж, хамтын ажиллагааг Монгол дахь солонгос судлалыг дэмжих, солонгос хэл, соёлыг дэлгэрүүлэх, үүгээр дамжуулан улс орныхоо нэр хүнд, имиджийг өсгөх бодлогоо БНСУ хэрэгжүүлж байв. 2010 оноос хойш солонгос хэлний олимпиад, солонгос соёлын өдөрлөг, хэвлэл нөхөрсөг спортын наадам, аялал жуулчлал, урлагийн тоглолтууд өрнөж улмаар олон ангит кино бүтээл, К-поп дуу хөгжим зэрэг өргөн тархсан соёлын нөлөөллийг бий болсон юм (Оюунцэцэг Д, 2021). Монголчуудын Солонгос соёлыг хүлээн авч буй суваг нь хэвлэл мэдээллийн мэдээ нийтлэл бол харин солонгос соёлыг хүлээн авахад нөлөөлж буй хүчин зүйл нь соёлын контент, солонгос хоолны газар, солонгост ажиллаж амьдарч байгаа монголчууд хэмээн 630 оролцогчдыг хамруулсан судалгааны үр дүн гаргасан байна.

Шашны үзэл баримтлалын хувьд Монгол улсын үндсэн хуулийн есдүгээр зүйлд “Төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ хэмээн төр сүм хийдийн хоорондын харилцааг тусдаа байхаар заасан байдаг ба энэ утгаараа ардчилалд сүм хийдийн болоод шашны зүтгэлтнүүдийн оролцоо маш бага бараг байхгүй хэмээн үзэж болохоор байна. 2024 оны байдлаар Христын 229 сүм, Буддын 159, бусад шашны 34 сүм хийд, нийт 1853 лам санваартан байх бөгөөд 15-аас дээш настай хүн амын 59.4 хувь нь шашны ямар нэгэн итгэл үнэмжилтэй гэж бүртгэгджээ.

Зураг 5. Монгол дахь шашны сүм хийд ба итгэгчид (шашны үзэл баримтлалаар)



Эх сурвалж: <https://www2.1212.mn>

БНСУ-ын ардчиллын төлөөх тэмцэлд шашныхны оролцоо маш их байсныг бид өмнөх бүлгээс тодорхой мэдэж авсан билээ. Шашны үзэл баримтлал философи нь нийгмийн ухамсарын нэг том хүрээ бөгөөд энэ утгаараа хүн эрх эрх чөлөөг эрхэмлэдэг, шударга нийгэм, нийгмийн сайн сайхан байдал, ёс суртахууны төлөө байдаг тул нийгмийн ардчилал, түүний бэхжилтэд оролцоотой, хувь нэмэртэй байх нь чухал гэдгийг солонгосчуудын түүхээс харж болно. Ийнхүү ардчиллын бэхжилтэд оюутан залуус, иргэдийн хөдөлгөөнөөс гадна Христ итгэгчид ямагт тэргүүн эгнээнд явсан байна.

## 5.2 Ардчиллын гол хүчин болох оюутны хөдөлгөөний тухайд

Аливаа улс төрийн систем институцийн хувьд ардчилагдах нь өрсөлдөөнт сонгууль, олон намын системтэй болсноор эхлэнэ. Гэхдээ энэ институци нь улс төрийн системийг бүрэн ардчилалд хүргэхгүй гэдгийн судлаачид тэмдэглэж байна. Түүнчлэн жирийн иргэд ардчилал, түүний институцийн талаар ямар ойлголт бодолтой байгаа нь тулгуур хэмжүүр болно гэдэг нь ардчиллын онолын суурь ойлголт болсоор байна. Ардчилал жирийн иргэний амьдралд хүрч байж бүрэн төгс илрэлээ олох ба энэ нь ард иргэд ардчиллын талаар хэрхэн ойлгож төсөөлж байгаа ардчилалд шилжих үйл явц, хөгжилд оролцоо, дэмжлэг хэр байна, ардчиллын төлөөх хөдөлгөөн үйл ажиллагаанд биечлэн оролцохоор илэрнэ. Энэ утгаараа Солонгосын ардчилалд оюутан залуус, иргэдийн ардчиллын үйл хэрэгт хяналт тавих, дуу хоолойгоо хүргэх, гар бие оролцох, нэгдэл нягтрал, иргэний нийгмийн байгууллын хүчтэй байдал нь Монголын залуу үеийнхэнд ихээхэн нөлөөлж, ардчиллын талаарх ойлголтыг ч нэмэгдүүлж байгаа юм.

Улс төрийн системийн өөрчлөлт тэр дундаа сонгуулийн систем илүү ардчилагдсан эерэг өөрчлөлт гарч хууль тогтоох, шүүх эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэл, засаглалд тавин хяналт хэдийгээр сул хэмээн судлаачид үзэж байгаа ч БНСУ-ын ардчиллын шилжилт, баттай тогтоход дараах хүчин зүйлс нөлөөлсөн хэмээн судлаачид үзжээ. Үүнд:

- Оюутан залуусын нэгдмэл хүчтэй оролцоо
- Нийгмийн дундаж давхрагын хүчтэй оролцоо
- Шашны бүлгийнхний оролцоо буюу Христосын шашинтай хүмүүсийн эзлэх хувь өсөн нэмэгдсэн нь нийгмийн шударга байдалд идэвхийг нэмэгдүүлсэн.

- Нам бус хүчний нэгдэл нягтрал оролцоо
- Аж үйлдвэржүүлэлт хөгжсөн, дундаж давхрага, ард түмний хүсэл эрмэлзэл
- Эдийн засгийн үзүүлэлтүүд өсөн нэмэгдсэн.
- Ардчиллын төлөө бүхнээ зориулсан удирдагчид байсан нь энэхүү судалгааны өмнөх бүлгүүдээс тодорхой харагдаж байна.

### **(1) Солонгос болон Монгол дахь оюутны хөдөлгөөнийг харьцуулах нь**

Судалгааны гуравдугаар бүлэгт авч үзсэнчилэн оюутны хөдөлгөөн нь Солонгос, Монголын ардчиллын үйл явцад голлох, чиглүүлэгч үүрэг гүйцэтгэж байсан нь түүхэн үнэн юм. Их, дээд сургуулийн 20 гаруй настай залуу оюутнууд хүсэл тэмүүлэл, эрч хүчдээ хөтлөгдөн ардчилсан бус, ардчиллын эсрэг дарангуйлагч дэглэмийн эсрэг хүчтэй, нэгдсэн тэмцэл өрнүүлсэн билээ. Нийгмийн бодит байдал, ардчиллын эсрэг дэглэмтэй эвлэрэлгүй их, дээд сургуулийн оюутнууд улс үндэстэн, ард түмнээ ардчилалтай болгохын төлөө тууштай зүтгэж боссон. Энэхүү оюутны хөдөлгөөн нь олон иргэдийн дэмжлэг, идэвхтэй оролцоог авч, ардчилалд оролцохоос татгалзаж байсан иргэдийг урамшуулж, өдөөж, оролцох хүсэл зоригийг бий болгосон.

Солонгос, Монголын ардчиллын хөдөлгөөнүүдийн түүх, ардчиллын шилжилт ба нэгдэлд цөм хүчин хэмээсэн өмнөх бүлгүүдийн судалгаанд үндэслэн хоёр орны оюутны хөдөлгөөний ижил төстэй болон ялгаатай талуудыг харьцууллаа.

*Солонгос болон Монгол дахь хөдөлгөөнүүдийн ижил төстэй дараах гурван шинж байдал байна. Үүнд:*

1) Оюутан залуус иргэдийн хөдөлгөөн нь ардчиллын хөдөлгөөний цөм хөдөлгөгч хүч байсан.

Өмнө дурьдсанчлан 1960 оны 4.19-ний хувьсгалаас 1987 оны 6-р сарын Ардчиллын хөдөлгөөн хүртэл оюутнууд Солонгосын ардчиллын хөдөлгөөний тэргүүн эгнээнд тууштай манлайлж байв. Тэд бараг 40 жилийн турш Солонгосын ардчиллын хөдөлгөөний хөдөлгөгч хүч болж, заримдаа бие даан, заримдаа ардчиллыг дэмжигч бусад хүчинтэй хамтран тэмцэж байв. Үүний нэгэн адил Монголын их дээд сургуулийн багш, оюутны хөдөлгөөн 1989-1990 он хүртэл ардчиллын хөдөлгөөнд тэргүүний үүрэг гүйцэтгэсэн.

2) энэхүү хөдөлгөөн нь иргэдийн өргөн оролцоог өдөөн идэвхжүүлснээр ардчиллыг бодит болгож, зорилгодоо хүрсэн. Оюутнуудаас эхэлсэн ардчиллын хөдөлгөөнүүд эрдэм шинжилгээ, судалгааны эрэл хайгуулаас хальж, улс төрийн оролцооны хувьд олон нийтийн өргөн дэмжлэг, оролцоог авч эцсийн дүндээ ардчилалд хүрсэнээрээ ижил төстэй байлаа. Оюутны хөдөлгөөн иргэд, олон нийтийн дэмжлэг, оролцоог өргөнөөр авч чадаагүй байсан бол ардчилал хэзээ ч бүтэхгүй. Хоёр орны ардчиллын төлөөх хөдөлгөөнд иргэд, сэхээтэн, хөдөлмөрчид, шашны зүтгэлтнүүд, олон нийтийн идэвхтэй дэмжлэг, оролцоог бий болгосноор авторитар, тоталитар дэглэмийг унагаасан юм.

3) Ардчиллын дараа оюутны хөдөлгөөний удирдагчид улс төрд идэвхтэй оролцсон.

Тэд улс төрд олноороо оролцож, улс төрийн чухал үүрэг гүйцэтгэсэн.

Солонгост 1980-аад оны ардчиллын хөдөлгөөнийг тэргүүлж байсан оюутны хөдөлгөөний хүчнүүд буюу "386-р үе" улс төрд олноороо идэвхтэй оролцох болсон. 1996 онд буюу 32 настай Ким Мин Сеок 15 дахь удаагийн бүх нийтийн сонгуулиар Үндэсний ассамблейд орж

ирснээр 386 үеийнхний улс төрийн гараа эхэлсэн. Дөрвөн жилийн дараа буюу 16 дахь удаагийн ээлжит сонгуулиар эрх баригч Мянганы Ардчилсан нам болон сөрөг хүчин болох Үндэсний Их Нам "шинэ цус сэлбэх"-ийн төлөө идэвхтэй өрсөлдөж, түүнээс хойш 2004 оны 17 дахь сонгуулийн санал хураалт хүртэл 386 нэр дэвшигч, тэдний дотор Им Жон Сок, Сон Ён Гил, Ву Ин Хоунг Дексик, О Юн Хоунг Декси, О. Нам, Үндэсний Их Намаас Вон Хи Рён, Ким Ён Чун, О Се Хун нар улстөрчдийг ялж, Үндэсний ассамблейд орж ирсэн. Монгол Улсад 1989 оны арванхоёрдугаар сарын 10-нд МоАХ-ыг байгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн С. Зориг, Ц. Элбэгдорж, Э. Бат-Үүл, Р. Гончигдорж нар Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын сайд, Улаанбаатар хотын захирагчаар ажиллаж, Монголын улс төрийг нийгмээс салгахад чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Ц.Элбэгдорж нь Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Их Хурлын дэд дарга, УИХ дахь олонхийн бүлгийн дарга, гишүүнээр олон удаа ажиллаж байсан. Тэрээр 2009-2017 онд хоёр удаа Ерөнхийлөгчөөр улиран сонгогдсон түүхтэй.

*Солонгос болон Монгол дахь оюутны хөдөлгөөний ялгаа* - Ардчиллын хөдөлгөөний гол хүч болсон оюутны хөдөлгөөнд ижил төстэй зүйл байгаа ч ялгаа нь ч олон байна. Оюутны хөдөлгөөнүүд нь түүхэн болон орчин үеийн нөхцөл байдал, тэмцлийн зорилго, оюутны хөдөлгөөний үзэл суртлын нөлөө, үргэлжлэх хугацаа, арга барил, дэмжигч бусад хүчнүүдтэй хамтран ажиллах зэргээрээ эрс ялгаатай байгааг дараах хүснэгтэд тоймлон харуулав.

Хүснэгт 25. Солонгос болон Монголын оюутан залуусын хөдөлгөөн

| Ангилал                                      | БНСУ-ын оюутны хөдөлгөөн                                                                                                   | Монголын оюутны хөдөлгөөн                                                              |
|----------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------|
| Түүх ба цаг үеийн нөхцөл байдал              | 1948-1987 он<br>Урт хугацааны дарангуйлал ба цэргийн дарангуйллын 40 жил                                                   | 1924-1990 он<br>Коммунист-Социалист нэг намын дарангуйлал                              |
| Тэмцлийн гол талбар                          | Ардчиллын эсрэг, ардчилсан бус дэглэм                                                                                      | Монгол Ардын Хувьсгалт Нам Нэг намын дарангуйлал                                       |
| Үзэл суртлын нөлөө                           | Социализмын төрөл бүрийн урсгал чиглэлт үзэл баримтлал, дэвшилтэт үзэл санаа                                               | Өөрчлөлтийн төлөөх бодлого                                                             |
| Тэмцлийн үргэлжлэх хугацаа                   | 1960-аад оноос эхлэн 40 орчим жил үргэлжилсэн.                                                                             | 1980-аад оны дунд үеэс 1990-ээд оны эхэн үе хүртэл<br>Ойролцоогоор 3-4 жил үргэлжилсэн |
| Ардчиллын төлөөх хөдөлгөөний аргууд          | Төрөл бүрийн арга, тайван арга<br>Радикал жагсаал болон хүчирхийллийн арга зам                                             | Энх тайванч тайван арга зам, өлсгөлөн зарлах                                           |
| Бусад ардчиллын хөдөлгөөнтэй хамтран ажиллах | Төрийн бус ардчиллын хүчин, ажиллах хүчнийхэнтэй хамтран ажиллах<br>Дундаж давхарга болон шашны бүлгүүдтэй хамтран ажиллах | Оюутны хөдөлгөөн бол ардчиллын цорын ганц тэргүүлэх хүчин байсан.                      |

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэсэнээр

Солонгос, Монгол хоёр улсад ардчиллын хөдөлгөөнийг манлайлж байсан оюутны хөдөлгөөнүүд ижил төстэй зүйлээсээ илүү ялгаа их байх нь зүйн хэрэг болов уу. Altbach. P.G (1993) улс төрийн хүчтэй хандлагатай оюутны хөдөлгөөнүүд нь нарийн төвөгтэй, олон янз байдаг тул энгийн бөгөөд ойлгомжтой тайлбар өгөхөд хэцүү байдаг гэж үзсэн (Altbach, P. G., 1993).

Судалгаанд оролцогчдын үзэж буйгаар Монгол улсад 1990 оны ардчиллын төлөөх тэмцэл оюутан залуучуудаас эхлэлтэй боловч түүнээс хойш нийгэм, улс төрийн олон үйл явдалд тэдний оролцоо маш сул байгааг онцолж байна. Оюутны хөдөлгөөн тэмцэл нь өөрсдөд нь тулгарч буй асуудлаар тухайлбал, оюутны тэтгэмж, нийтийн тээврийн хөнгөлөлтийн хүрээнд л өрнөж байгаа хэмээжээ. Зарим оролцогчдын хувьд ардчиллын сүүлийн 10 жилд оюутан залуусын оролцоо сэргэж, төрийн захиргааны удирдлага, шийдвэр гаргагчид, улс төрчдийн шударга бус явдлыг шүүмжлэн дуу хоолойгоо илэрхийлэх болсныг дэмжиж байна.

### **5.3 Монголын ардчилалд өгч буй сургамж**

#### **(1) Иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог бэхжүүлэх**

Иргэдийн улс төрийн шийдвэрт нөлөөлөх боломжтой ба засаглалыг өөрсдийн оролцоотой өөрчилж, төрийн удирдлагад шахалт үзүүлэх, дуу хоолойгоо хүргэх, эсэргүүцэх жагсах мэтээр оролцооны хэлбэрүүдийг хэрэглэж болно гэдгийг ойлгосон хэдий ч өнөөгийн байдлаар хоёр улсын улс төрийн үйл хэрэгт иргэдийн оролцооны хамрах хүрээ, хүрч байгаа үр дүн ялгаатай байна.

БНСУ-ын оюутан, залуусын хөдөлгөөн, ард иргэдийн идэвхтэй оролцоо нь Монголын ардчилсан хувьсгалын үед залуусын тэмцэлд урам өгсөн. Олон намын тогтолцоо, иргэний нийгмийн байгууллагын хөгжлийн талаарх Солонгосын жишээ чухал нөлөө сургамжтай байна. Тус улсын иргэний нийгмийн байгууллагууд хүчтэй сөрөг хүчний үүргийг гүйцэтгэж, манлайлагчид нь их дээд сургуулийн профессорууд, мэргэжилтнүүд тэргүүн эгнээд явж байна. Монголд 1990 оны анхны ардчилсан хөдөлгөөнд багш, оюутан залуучууд хамгийн идэвхитэй оролцож байсан нь хожим ч энэ орон зай байх ёстой гэдгийг тэд ухамсарласан хэвээр байгаа. Гэсэн хэдий ч 1990 оноос хойш оюутан залуусын оролцоо суларч байгаа ч 2010 оноос хойш идэвхжих хандлагатай байна. Түүнээс гадна Монгол улсад өнөөг хүртэл улс төрийн нам гол байр суурьтай хүчин хэвээр байгаа бөгөөд иргэний нийгмийн байгууллагууд идэвхтэй оролцоотой гэхээсээ илүү хөндлөнгийн ажиглагч хэвээр манлайлал сул байсаар байна. Монголын үйлдвэрчний эвлэл гэх мэт цөөхөн тооны нам бус хүчин нийгмийн амьдралд нөлөөтэй байгаа нь хангалтгүй юм.

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны шинэчлэл, иргэд тэр дундаа залуучуудын улс төрийн оролцоо, сонор сэрэмж сайн, хуулиа дээдэлж, улс төрийн соёлын төлөвшил өндөр, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг баримтлан улс төрийн шийдвэр гаргалтыг олон нийтийн байр сууринаас гаргадаг гэх мэт сайн туршлага нь Монголын ардчиллын үйл явцад сургамж болно хэмээн судалгаанд оролцогчид үзэж байна. Гэсэн ч Монгол улсад 10 жилийн өмнөх байдалтай харьцуулбал ардчилалд хандах хандлага, сэтгэлгээ соёл сайжирч байгааг оролцогчид онцолж байна. 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш туулсан 30 жилийн эхний 10 жилд ойлголт, үзэл баримтлал, хандлагыг танин мэдэхүйн түвшинд байсан бол хоёрдугаар 10 жилд ардчиллын давуу тал болон сул талуудын ялгааг ойлгож, оролцох

нөлөөлөх үйл явц өрнөсөн, гуравдугаар 10 жилд улс орнуудын хөгжлийн сайн муу талыг ялгаж, үнэлж өөрчлөлт шинэчлэлт, ардчиллын үндсэн зарчмуудыг нийгмийн бүхий л салбарын хүрээнд шингээж өдөр тутмын аж амьдралдаа сэтгэл ханамжтай амьдрахын утга учрыг ойлгосон оролцооны үе хэмээн үзжээ.

## **(2) Улс төрийн хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх**

Шударга сонгууль ба институцийн шинэчлэл, улс төрч, шийдвэр гаргагчдын ёс зүйн хариуцлага бидэнд үлгэрлэл болж байна. Ардчилал нь зөвхөн жагсаал цуглаан, хөдөлгөөн бус, хууль засаглал, байгууллага, тогтолцооны эд эс бүрийг шинэчлэх үйл явц гэдгийг тус улсын туршлагаас суралцаж болно. Сонгуулийн ил тод байдал, хууль эрх зүйн баталгаажуулалт, шүүх парламентын бие даасан байдал, авилгын эсрэг хүчтэй тэмцэл, үл зөвшөөрөл нь ардчиллын тулгуур юм.

БНСУ-ын улс төрийн салбар дахь ардчилал, ард иргэдийн оролцоо болон хяналт, авилгын эсрэг арга хэмжээ, төрийн алба, үндсэн хуульт төрийн бүтэц зохион байгуулалт, сонгуулын тогтолцоо, улс төрийн нам, намын систем, иргэний нийгмийн байгууллагын нөлөө, иргэдийн улс төрийн оролцоо, эвлэлдэн нэгдэж буй байдал, нутгийн өөрөө удирдах ёс, шийдвэр гаргалт, хууль эрх зүйн хэрэгжилтийн талаарх мэдээлэл хангалтгүй, энэ талаарх ойлголтгүй байгаагаа судалгаанд оролцогчдод илэрхийлсэн. Хэдийгээр хангалттай мэдээлэлгүй боловч улс төрийн амьдрал, үйл явцын талаар дараах зүйлсийг сургамж болохуйц туршлага хэмээн үзэж байна. Үүнд:

БНСУ-ын улс төрийн амьдралд өрнөж байгаа томоохон жагсаал цуглаан, тэмцлийн үйл явц, түүхүүд, тэр дундаа цэргийн дэглэмийг эсрэг, ардчиллыг хамгаалахын төлөө жагсаалууд нь Монгол хүмүүсийн урам зоригийг сэргээх, нийгмийн оролцоо, ухамсарт шууд бусаар нөлөөлсөөр байна. Тухайлбал, 1960 оны 4.19-ний хувьсгалт хөдөлгөөнөөр анхны ерөнхийлөгийн дарангуйллын дэглэмийг түлхэн унагаж, улмаар ард иргэдийг хамарч улс даяар олон хотыг хамарсан үйл явдал, 1980 оны Гуанжугийн тэмцэл, 1987 оны 6 сарын бослого тэмцэл, орчин цагт ч өрнөж буй Пак Ин Хэ анхны эмэгтэй ерөнхийлөгч болон 2022 онд тангараг өргөж сонгогдсон Юн Сок Ёл ерөнхийлөгчийн огцруулалт зэрэг олон үйл явдал нь Монгол хүмүүсийн дэмжлэгийг хүлээж, ардчиллын төлөөх ойлголт, ухамсарт нөлөөлж буй юм.

БНСУ-ын ардчиллын үйл явц, түүний өнөөгийн байдал, нийгмийн бүхий л давхрага, оюутан залуусын оролцоо, төрийн бодлого шийдвэр гаргалт, төрийн өндөр албан тушаалтантай хариуцлага тооцох тогтолцоо зэрэг нь сурах ёстой сайн туршлага гэжээ.

Солонгос иргэд улс төрийн шийдвэрт нөлөөлөх боломжтой, улс төрчид болон удирдлагад шахалт үзүүлэн дуу хоолойгоо хүргэж, аливаа асуудлын эсрэг тэмцэх, иргэдийн оролцооны хэлбэр нь идэвхтэй байр суурьтай байгааг сайн тал хэмээн үзжээ. Тэд цэргийн дэглэмийг эсэргүүцэн асар их золиосоор ардчиллыг сонгосон нь үнэ цэнтэй бөгөөд ардчиллыг хайрлан хамгаалахаа мэддэг ард түмэн хэмээн үнэлж байна. Хоёр улсын хувьд соёл зан заншил, түүх, төрт ёсны уламжлал, хөгжлийн түвшин ихээхэн ялгаатай ч ардчиллын үзэл баримтлалыг тууштай дэмжих, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх эрмэлзэлээрээ адил төстэй болохыг онцолсон юм.

### **(3) Эдийн засгийн өсөлт ба ардчиллын тэнцвэрт байдлыг хөгжүүлэх**

БНСУ-ын түүх, хөгжлийн загвар нь эдийн засаг ба ардчиллын холбоо хамаарал маш чухал болохыг тодруулбал, эдийн засгийн өсөлт ба ардчиллыг бэхжүүлэх үйл ажиллагааг зэрэгцүүлэн хөгжүүлж болдогийг нотолгоо юм. Төр хувийн хэвшлийн хамтрал, аж үйлдвэрийн бодлого, боловсрол, технологийн хөрөнгө оруулалтад суурилсан хөгжил ардчиллыг дэмжих хөрс суурь гэдгийг түүхэн замналаас харж болно. Эдийн засгийн өсөлт, ил тод байдал, зах зээлийн тогтолцоо, хөрөнгө оруулалт татахад таатай нөхцөл, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, авилгыг бууруулах нь ардчилалтай орнуудад илүү боломжтойг баталсан жишээ ч олон байна. Улс орныхоо эдийн засгийг өсгөхөд Солонгос хүмүүсийн маш их хөдөлмөрч, арвигч хямгаач зан чанар ихээхэн нөлөөлж баялагийг бүтээсэн гэдгийг судлаачид тэмдэглэснийг энд мөн сайн сургамж хэмээн онцолж байна. Тухайлбал, Сингапурын ерөнхий сайд асан Ли Куан Ю “Солонгосчууд бол сүрдмээр улс. Үймж бужигнаж байхдаа ч өмнөө сөрөн зогсож байгаа цагаагийнхнаас ялгаагүй дэг журамтэй байдаг. Пластик бамбай барьж, пластик дуулга өмссөн цагдаагийнхан гладиаторуудыг санагдуулдаг. Солонгосын ажилчид, оюутнууд, гудамжинд цагдаагийнхантай мөргөлдөж байгаа нь яг дайн шиг харагддаг. Ер нь Солонгосчууд сэтгэлийн их хөдөлгөөнтэй, төр засагтай зөрчилд орвол эвээ олохыг хичээдэггүй, ямар ч саадыг тоохгүй эрчимтэй тэмцдэг хүмүүс шиг санагддаг. Солонгосчууд бол эрч хүчтэй, ажилсаг, шийдмэг, өндөр чадвартай, зорилго тэмүүлэлтэй ард түмэн” (Саранцэцэг Э., 2013) гэжээ.

Нийгмийн дундаж давхрага нэмэгдэх хэрээр иргэний нийгмийн байгууллагын оролцоо ч дагаад өсдөг. Иргэдийн аж амьдрал, нөхцөл байдал, нэг хүнд ногдох ДНБ хэмжээ, жилийн дундаж орлогыг нэмэгдүүлж байж тэдний ардчилалд оролцох оролцоо, ардчиллын хамгаалах ухамсар ойлголтыг сэрээж чадахыг тус улсын ардчиллын төлөөх тэмцэл, ард иргэдийн оролцоо одоо ч харуулсаар байгаа. Манай улсын хувьд иргэд идэвхигүй оролцоотой бүлэг мэт боловч ардчиллын шууд оролцооны хэлбэр болох цахим сувгаар үзэл бодлоо илэрхийлэх, манлайлал үзүүлэхэд илүү идэвхтэй байдаг сайн талтай. Гэсэн ч ардчиллын үйл явцад нийгмийн дундаж давхрагын иргэдийн оролцоо сул, төрийн албан хаагчид намжсан төрөөс хамааралтай тул ардчиллын үйл явцад төдийлөн оролцдоггүй хэмээн судалгаанд оролцогчид шүүмжилжээ.

### **(4) Боловсрол, ухамсар, ёс суртахууны үүргийг дээшлүүлэх**

Ардчилсан нийгмийн тогтвортой байдал нь иргэдийн боловсрол, ухамсар ёс суртахууны түвшингээс шууд хамаарна. Мэдээж боловсрол гэдэг нь хүний мэдлэг төдий бус, нийгмийн нэг гишүүний хувьд хариуцлагатай, шүүмжлэлт сэтгэлгээтэй, ухамсартайгаар нийгмийн амьдралд оролцох чадварыг хэлнэ. Харин энэ нь ёс суртахууны үнэт зүйлстэй холбогдож, ардчилсан нийгмийн тулгуур болдог билээ. Боловсрол мэдлэгийг зөв төлөвшүүлэх нь мэдлэгтэй сонголт, ухамсартай ёс зүйтэй эрх чөлөөг бий болгодог байна. Энэхүү мэдлэг ёс зүйтэй байдал нь иргэдийн эв нэгдлийг бий болгож, түүнийхээ хүчээр ардчиллыг эхлүүлж, бэхжүүлэх боломжтойг судалгаа, түүхэн үйл явдлууд харуулж байна.

Монголчууд ардчиллыг үнэт зүйлсээ болгож, шингээж чадаагүйгээс сонгосон зам өдгөө буруу эргэх шалтгаан болсон ба үг хэлэх, өөрсдийн эрх чөлөөг чухалчлахаас бус, хариуцлага, хууль дээдлэх ёс, бусдын эрх чөлөөнд халдахгүй байх, иргэд өөрсдөө оролцох

ёстойг төдийлөн ухамсарлаагүй, сэтгэл зүйн хувьд ардчилал гэдгийг хүлээн зөвшөөрсөн ч соёл, боловсрол, институтын хувьд төдийлөн бүрэн гүйцэд хүлээн аваагүй байна гэсэн байр суурийг судалгаанд оролцогчид илэрхийлжээ.

**Цаашид:**

Нэгд, Монголчуудын хувьд иргэдийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх нь чухал байна. Ардчиллыг амжилттай бэхжүүлэхэд иргэд зөвхөн сонгогч бус хяналт тавьдаг, оролцдог, иргэний нийгмийн үйл ажиллагаа хүчтэй байх ёстой.

Хоёрт, авторитар, тоталитар дэглэмийн хор нөлөөг ойлгосон мэдлэг ухамсартай байж авилгын эсрэг тууштай бодлоготой байх хэрэгтэй. Олон нийтийн авилгын эсрэг хариуцлага, ил тод байдлыг бэхжүүлэх нь ардчиллыг чанарыг сайжруулах үндэс юм.

Гуравт, Иргэдийн боловсрол, ёс зүй, нийгмийн ухамсар, соёл гэгээрэл нь ардчиллын суурь болохыг Солонгос улсын ардчиллын түүх харуулдаг. Монгол улсад боловсролыг ардчиллын үнэт зүйлстэй уялдуулах, боловсролын зэрэгцээ ёс зүй, нийгэм соёлын ухамсарыг дээшлүүлэх бодлого шаардлагатай байна.

Дөрөвт, Үндэсний эрх ашгийг намуудын эрх ашгаас дээгүүр тавьдаг ёс суртахуун, ухамсар, чухал болохыг БНСУ-ын түүхэн үйл явдлууд харуулж байна. Талцал, хэт нутгархах биш хэлэлцээр зөвшилцөл нэгдмэл байдал, эв нэгдэлд суурилсан улс төрийн соёлыг бий болгох хэрэгтэй.

Тавд, Иргэний нийгмийн байгууллага, тэдний үйл ажиллагаанд иргэд өөрсдөө оролцох нь ардчиллын эерэг өөрчлөлтийг авчрах гол хөшүүрэг, шалгуур тул тэдний улс төрийн боловсрол, соёл хандлагыг өөрчлөх хэрэгтэй байна. Энэ нь Монголд улс төрийн хямралт байдал, клиентализмыг зогсоох, ардчиллыг бэхжүүлэх үндэс болно.

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

1960-1980-аад оны үед цэргийн дэглэмд байсан БНСУ Азидаа ардчилалд амжилттай шилжсэн орны нэг төдийгүй ялангуяа 1987 оны тэмцэл өөрчлөлтийн эргэлтийн цэг байж, өдгөө тогтвортой ардчилал, өндөр хөгжилтэй эдийн засгийг хослуулж чадсан орон хэмээн үнэлэгддэг билээ. Монгол улсын хувьд ардчиллын замыг сонгох үедээ БНСУ-ын туршлагыг ойрхон бүс нутгийн амжилттай жишээ гэж үздэг бөгөөд өнөөдөр ч энэ туршлага сургамжийн чухал эх сурвалж хэвээр байна. Ардчилал гэдэг нь зөвхөн сонгууль бус иргэдийн амьдрал сайжрах бодит үр дүн байх ёстой, түүнчлэн эрх чөлөө бол эмх журамтай, хариуцлагатай байхыг хэлнэ хэмээн Сингапурын ерөнхий сайд асан Ли Куан Ю хэлсэн байдаг.

Энэхүү судалгааны ажилд БНСУ-ын ардчиллын шилжилт, бат суурьтай тогтох үйл явц Монголын ардчилалд хэрхэн нөлөөлж, ямар сургамж өгч буй талаар судлах зорилготой ба бид судалгааны ажилдаа ардчиллын шилжилт, бат тогтох бэхжихэд нөлөөлсөн түлхүүр хүчин зүйл болох оюутны хөдөлгөөн, ардчиллын төлөөх нам бус хүчнүүд, нийгмийн дундаж давхрага болон шашны зүтгэлтнүүдийн оролцоог авч үзлээ. Монголын ардчиллын шилжилт, бэхжилтэд БНСУ-ын туршлага сургамжийн талаар судлахдаа чанарын судалгааны арга болох бичиг баримтын шинжилгээ, тематик аргыг ашигласан ба нийт 25 хүнийг хамруулан ярилцлага авч үр дүнг шигтгэлээ.

Судалгаанаас харвал хоёр орны ардчиллын үйл явцад дээрх дөрвөн гол хүчин аль аль нь хувь нэмэр оруулсан нь түүхээс харагдах ч ялгаатай төдийгүй сургамжтай зүйл ч маш их байна. Үүнд:

Нэгд, Ардчилал нь ерөнхийдөө эдийн засгийн өсөлт, инноваци, нийгмийн сайн сайхан байдал, авилгыг бууруулах, иргэдийн оролцоонд эерэг нөлөө үзүүлдэг боловч эдгээр нөлөөллийн цар хүрээ, тууштай байдал нь улс орон бүрт өөр өөр байна. Ардчилал нь зөвхөн сонгуулийн тогтолцооны өөрчлөлт төдий бус хүний эрх, эрх чөлөө, нийгмийн шударга ёс, иргэний оролцоо зэрэг олон талд шинэчлэлийг бий болгодог билээ. Энэ үйл явцад оюутан залуус, нийгмийн дундаж давхрага, шашны зүтгэлтнүүд болон нам бус хүчний идэвхи оролцоо чухал байх бөгөөд манай улсын хувьд эдгээр гол хүчнүүдийн оролцоо сул байна. Хоёрт, Бүх улс оронд тохирсон нийгмийн хөгжлийн загвар байх боломжгүй ч ардчиллын үзэл баримтлал, зарчим, үнэт зүйлсийг бий болгоход улс төр, институтын төлөвшилөөс гадна эдийн засгийн хөгжил, иргэдийн боловсрол, ухамсар, ёс суртахууны төлөвшил чухал гэдгийг харж болно.

Гуравт, Эдийн засаг болоод ардчилал хоорондоо маш хамааралтай байна. Нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийг нэмэгдүүлэх, эдийн засгийн салбарыг тэлэх, тэр дундаа улс орны аж үйлдвэрийн салбарыг сэргээж, иргэдийн аж амьдралын дээшлүүлэхэд үүнийг дагаад иргэдийн идэвхи, иргэний нийгмийн байгууллагын оролцоо ч өсдөг гэдгийг түүхэн олон үйл явдлуудаас харж болно. Улс төр нь эдийн засгийн салбарыг орхигдуулалгүй үндэсний хэмжээний болоод жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлснээр хүн амын амьжиргааны түвшин нэмэгдэх юм. Үүнийг дагаад дундаж давхаргын эзлэх хувь өсөж, үр ашигтай зах зээл+ үр дүнтэй улс төр гэсэн дарааллаар ардчиллыг бэхжүүлэх боломжтой. Хүчтэй дундаж давхрага өсөн нэмэгдсэнээр ардчиллын талаарх ойлголт мэдлэг, ухамсар, ёс зүй, соёл гэгээрэл, улс орны эрх ашгийг нэн тэргүүнд тавьсан эв нэгдэл бий болж энэ нь ардчиллыг бэхжүүлэх хөрс суурь болдог гэдэг нь БНСУ-ын ардчиллын түүх тодорхой харуулж байна.

- Altbach, P. G. (1993). *학생운동의 이해를 위한 시각*, 김도종 편역, 『세계의 학생운동』, 서울: 도서출판 힘, 9쪽.
- Armstrong, C. K. (2002:3). *Korean Society: Civil Society, democracy and the state*. Routledge.
- Britannica. (2025 оны 02 20). <https://www.britannica.com/topic/democracy>.  
<https://www.britannica.com/topic/democracy>
- Cambridge Dictionary. (2025 оны 03 25). <https://dictionary.cambridge.org>.  
<https://dictionary.cambridge.org/dictionary/english/democratization>
- Diamond, L. (1999). *Developing democracy: Toward consolidation*. Baltimore: MD: Johns Hopkins University press.
- Dryzek, J. S. (2013:3). *Democratization as Deliberative Capacity Buildings*. Jean Crugel.; SAGE Publications.
- Hannes, B. Mosler. (2017:305). *The Quality of Democracy in Korea*. Palgrave macmillan.
- Kim Y. (2019). Participatory governnce in South Korea: Lessons for emerging democracies. *Korean Journal of Political Sciense*, 45-67.
- Kubik, J. (2003). *How to Study Civil Society: The State of the Art and What to Do Next*. Jan Kubik. Oxford.
- Lee Hyo-Bun. (2011). Effects of Democracy Movement in the Middle East on South Korea Security. *Association of International and Area Studies*, 127-148.
- Nicole Bibbins Sedaca. (2025 оны 02 23). <https://freedomhouse.org> "What Is Democracy, and Why Does Defending It Matter?" . <https://freedomhouse.org/article/what-democracy-and-why-does-defending-it-matter>
- Nixson. (2000). The Transition to a Market Economy: Mongolia 1990-1998. . *International Journal of Economic Development*.
- Peter Burnell & Lise Rakner. (2014:211). "Democratization", 『Politics in the Developing World』. Oxford University Press.
- Poul E. Sigmund. (1993:354). "Christian Democracy, Liberation Theology and Political Culture in Latin America", 『Political Culture and Democracy in Developing Countries』. Lynne Rienner Publishers.
- Seymour Martin Lipset. (2013:270). "Some Social Requisites of Democrcy: Economic Development and Political Legitimacy", 『Democratization』. Jean Crugel: SAGE Publications.
- T, J. Lah & Yijia Jing, Peter. T. Y. Cheung. (2017:62). *Public Policy and Administration an Era of Expansion – China, South Koream Hong Kong*. Routledge International.
- V-Dem. (2025). *Democracy report 2025* . University of Gothenburg.
- Whitehead, L. (2004:6). *Democratization*. Oxford University Press.
- Wolfgang, M. (2004). Embedded and Defective Democracies. *Democratisation* 11(5), 33-58.
- Wong, J. (2004:173). *Healthy Democracies*. Cornell University Press.

- Баабар. (1999). *Монголын нууц товчоо* – 2. Улаанбаатар: Nepko Publishing. .
- Баатар, Ц. (2003). *Глобалчлалын эриний Монголын эдийн засаг, нийгмийн өнөөгийн дүр төрх. Монгол улсын гадаад харилцаа*.
- Бат-Орших, Н. (2009). Ардчиллын дуучид-Хонхны тухай өгүүлэх нь. *Соёл судлалын бичиг*. №3, 44-50.
- Баярбаатар, Б, Д.Бумдарь, Д. (2023). Ардчиллын хөгжилд улс төрийн намын гүйцэтгэх үүрэг. *Политологи XXI. Эрдэм шинжилгээний бичиг №21(579)*, 180-192.
- Баярхүү, Д. (2023). Монгол Улсын гадаад бодлогын шинэчлэл. *Олон Улс Судлал Vol. 46 / No 116* /, <https://doi.org/10.5564/jis.v46i116.3302>.
- Болорсүх, Б. (2012 оны 04 06). <https://news.mn/r/102843/> Монголд ардчилал төлөвшөөгүй байна.
- Гадаад харилцааны яамны цахим: <https://www.consul.mn/>
- Галаарид, Б. (2015). “Ардчилал” сонин чөлөөт хэвлэлийн тогтолцоо бүрэлдэхэд хамгийн ихээр нөлөөлсөн хэвлэл болох нь. *МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг. ШУС,НУС. №16/438*.
- Ганбат, Д. (2023). Монгол дахь ардчилал ба түүний мөн чанар. *Политологи XXI. Эрдэм шинжилгээний бичиг №21(579)*, 30-37.
- Ганбат, Д. (2008). Ардчиллах үйл явц ба Монголчуудын үнэлэмж. *Шинэ толь* 61.
- Гомбосүрэн, Д. (2015). *Монголын орчин үеийн хөгжим ба нийгмийн шилжилт*. Улаанбаатар: Соёлын академи.
- Гэрэлт-Од, Э. (2020). Монгол Улсын намын эрх зүй ба намуудын байр суурь. *Улс төрийн намын улс төр, эрх зүйн шинжилгээ эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл* (хууд. 38). Улаанбаатар: МУИС, ХЗҮХ, Улс төр судлаачдын нэгдсэн холбоо.
- Жамбал, А. (2010). Монголын нийгмийн өөрчлөлтийг судлах асуудалд. *Политологи YI. Эрдэм шинжилгээний бичиг*.
- Наранцэцэг, Д & Шолпан, М. (2009). Перестройка”-гийн үзэл санаа Монголын ардчилсан хувьсгалд нөлөөлсөн нь. *Политологи IY Эрдэм шинжилгээгний бичиг № 297(50)*, 88-94.
- КАС. (2025). *Монгол дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990-1919)*. Улаанбаатар.
- Клима, М. (2017:19). *Тоталитар дэглэмээс гажуудсан ардчилал руу*. Улаанбаатар хот.
- Лувсандорж, Ш, Галиймаа, Н, Ганболд, Д бусад. (2019). *Монголын түүх*. Улаанбаатар: ШУТИС, Их сургуулийн сурах бичиг.
- Лхагваа, Т. (2019 оны 09 10). Ардчилсан хувьсгал “Мөсөн уул шиг чанга дэглэм”-ийг өөрчилж чадсан <https://atime.mn/view/article/?page=show&id=1067>.
- Монголын үндэсний архив. (1990). Гандан хийдийн бичиг баримт ба шашны эрх чөлөөний талаарх бичгүүд. Улаанбаатар.
- Монголын үндэсний архив. (1990 оны 12 10). Сүхбаатарын талбайн анхны жагсаалын баримт. Улаанбаатар.
- Монголын үндэсний архив. (1999). Шашны хэлмэгдүүлэлтийн баримт бичгүүд. Улаанбаатар.
- Монгол улсын хөгжлийн шинэ сонголтын он жилүүд 1990-2000. Улаанбаатар
- Мөнхбат, С, Бумдарь, Д, Мэндхүү, Г. (2016). Монгол дахь ардчилал: Иргэний улс төрийн

- оролцоо ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл. *Политологи № (13) 442*, 191.
- Мөнхбат, С, Эрдэнэдалай, Б. (2024). Монголын улс төрийн намын үзэл баримтлал, түүний хэрэгжилтийн зарим асуудал. *Политологи XXII. Эрдэм шинжилгээний бичиг №22(593)*, 70-81.
- Мөнхнасан, Г бусад. (2024). *БНСУ-ын гадаадаас авах ажиллах хүчиний бодлогын хэрэгжилтийн тухай судалгаа: Монгол ажилчдын жишээн дээр*. Улаанбаатар.
- Мягмарсүрэн, Д, Төгөлдөр, Я. (2023). Монголын иргэний нийгмийн хөгжлийн сорилт, бэрхшээл, боломж нөхцөл. *Политологи XXI. Эрдэм шинжилгээний бичиг №21(579)*, 48-59.
- ННФ. (2024). *Монгол Улсын Их Хурлын сонгууль 2024: Чөлөөт, шударга сонгуулийн зарчмуудтай холбоотой зарим анхаарал татсан асуудал ерөнхий тойм*. [https://forum.mn/uploads/users/3092/files/Erunhii\\_Toim.pdf](https://forum.mn/uploads/users/3092/files/Erunhii_Toim.pdf).
- Одгэрэл, Б, Мөнхжаргал, О. (2023). Иргэний нийгмийн байгууллагын ардчиллын бэхжилтэд үзүүлэх нөлөөлөл, чиг хандлага. *Политологи XXI. Эрдэм шинжилгээний бичиг №21(579)*, 60-69.
- Оюунцэцэг, Д. (2021). Монгол, БНСУ хоорондын олон нийтийн дипломат харилцаа: Монголчуудын солонгос улс, үндэсний талаарх имиж, ойлголт. *МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг*, <https://journal.num.edu.mn>.
- Саранцэцэг, Э. (2013). Бүгд Найрамдах Солонгос улсын дэглэмийн өөрчлөлт ба эдийн засгийн хөгжил. *Эрдэм шинжилгээний бичиг*, 251.
- Содном, Ш, Ганболд, Ц, Довчин, Ё. (2009). Монгол дахь ардчилагдах үйл явц ба сонгууль. *МУИС. Политологи сэтгүүл. №297(50)*, 6.
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. (2025). <http://www.1212.mn>. <http://www.1212.mn>
- Тамир, Ч. (2013). 1990 оны Монголын ардчилал: Гадаад хүчин зүйл, олон улсын харилцааны нөлөөлөл.
- Тойн Бат-Эрдэнэ Д. (2008:38-39). *Асар их үнээр олдсон Ардчиллын ололтоо хайрлаж яваарай*. Улаанбаатар.
- Төгөлдөр, Я, Бумдарь, Д. (2021). *Бодлогын намыг төлөвшүүлэх нь: 2021*. Улаанбаатар: Нээлттэй Нийгэм Форум.
- Төрийн төв архив. (1993 оны 03 09). Улс төрийн товчооны бүрэн бүрэлдэхүүн огцорсон тухай тэмдэглэл. Улаанбаатар.
- Төртогтох, Ж, Хулан, Д. (2023). Монголчуудын улс төрийн соёлд нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс. *Политологи XXI. Эрдэм шинжилгээний бичиг №21(579)*, 125-136.
- Түмэнжаргал, Д, Туяагэрэл, Г. (2023). Монгол улсын засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тогтвортой байдлын асуудал. *Политологи XXI. Эрдэм шинжилгээний бичиг №21 (579)*, 137-144.
- Хайсандай, Л. (2013). Дэлхий дахинд Монгол улсын эзэлж буй байр суурь. *Монгол улсын гадаад харилцаа, эдийн засаг*, 8.
- Хатанболд, О. (2023). Нэг бүс, нэг зам” санаачлагал ба Монгол улс: Шинжээчдийн судалгааны үр дүн. *Олон Улс Судлал Vol. 46 / No 116 /*, <https://doi.org/10.5564/jis.v46i116.3298>.
- Хуулийн цахим сайт. (2025 оны 05 30). <https://legalinfo.mn/api/front/cons-detail-1960.html>
- Чулуунбаатар, Г, Батсүх, Ш, Ганцоож, Б. (2021:64). *Монголын ардчилал: Төлөөллийн*

- ардчиллын сорилт ба шууд ардчиллын боломж. Улаанбаатар: КАС.
- ШУА. Философийн хүрээлэн. (2022). Зүүн Европын улс орнууд болон Монголын ардчилал: Ололт, амжилт, сорилт, бэрхшээл. *ОУЭШХ. Илтгэлийн эмхэтгэл*, (хуу 8-9).
- Шүрхүү, Д. (2000). Олон улс судлал XX зуун. *Олон улс судлал сэтгүүл*.
- Элбэгдорж, Ц. (1998). *Тэмцэл, итгэл, ялалт*. Улаанбаатар: Ардчилал хэвлэлийн газар .
- Энхцэцэг, С. (2017). БНСУ-ын улс төр, эдийн засгийн харилцааны онцлог. *МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг*, <https://journal.num.edu.mn/jir/article/view/2247/1969>.
- 강병익. (2004). 더 많은 민주주의를 위한 운동과 제도의 정치과정: 87년 이후 한국의 정치민주화 평가와 전망. *노동사회 통권 제88호, 한국노동사회연구소*, 11-14.
- 강원택. (2017). 87년 헌법 개헌 과정과 시대적 함의. *역사비평 2017년 여름호(통권 119호)* (хуудсд. 12-13). 역사비평사.
- 강원택. (2017). 헌법과 권력 구조. 『6 월항쟁, 촛불혁명, 한국 민주주의: 30 년의 넘나듦과 나아감: 6.10 민주항쟁 30 주년 기념 학술토론회』 (хууд. 21). 민주화운동기념사업회·한국민주주의연구소.
- 강정인 & 외 3인. (2010:12-39). *유럽 민주화의 이념과 역사*. 서울: 후마니타스.
- 고선규. (2010). 선거제도의 개혁과 정당정치의 공고화. 『다시 보는 한국 민주화운동: 기원, 과정, 그리고 제도』, *한국민주화운동기념사업회 4 월 혁명 50 주년 기념 총서* (хууд. 378). 한국정치연구회.
- 교육부. (2025 оны 02 23). <https://blog.naver.com/moeblog/220405717592>,
- 국가법령정보센터. (2025 оны 04 07). <https://www.law.go.kr/LSW/lsInfoP.do?lsiSeq=53087>
- 국가보훈부 국립 . (2025 оны 04 07). *5.18 민주묘지*. <https://www.mpva.go.kr/518/contents.do>
- 김국현. (1997:219). *한국의 민주화 이행과정에서 구조와 행위의 상호작용에 관한 연구*. 한국교원대학교 대학원 박사학위 논문.
- 김명배. (2012). 민주화와 기독교. *기독교사상 통권640호, 대한기독교서회*, 71-72.
- 김성수. (2003). 민주화 이행 과정에서 한국 중산층의 역할: 민주화운동 참여 동기에 대한 분석. *국제정치논총 제43 집 1 호, 한국국제정치학회*, 136.
- 김성수. (2004). 한국의 민주화 이행과정에 관한 연구. *한국시민윤리학회보 제17 집 한국시민윤리학회*, 61.
- 김성주. (2006). 민주화의 의미: 회고와 전망. *개혁시대 제8 권 제2 호(통권 제30 호), 한국사회발전시민협의회*, 16-17.
- 김영태. (2006). 한국 민주주의의 이행과 공고화 과정의 분석. *사회과학연구 제13 권 1 호* (хууд.

- 238-239). 동국대학교 사회과학연구원.
- 김왕식. (2008:33). *정치교육론*. 경기도 파주: 한국학습정보.
- 김용철. (2023). 광주항쟁과 한국의 민주화. *월간복지동향 제295호* (xuud. 38). 참여연대사회복지위원회.
- 김재민. (2017). 6월 민주항쟁과 인권. *경제와 사회 통권 114호* (xuud. 53). 비판사회학회.
- 김정훈. (2007). 민주화 20년의 한국 사회-기로에 선 한국 민주주의. *경제와 사회 통권74호*, 30.
- 김진. (2015). *중동 민주화 운동의 원인 분석을 통한 북한 체제 변화 가능성에 대한 연구*. 국방대학교 석사학위 논문.
- 김태룡. (2010). 한국의 민주화 과정과 시민사회. *한국가버넌스학회보 제17권2호*, (xuudcd. 79-80). 한국가버넌스학회.
- 김호기. (2007). “6월 민주항쟁 20년, 한국 민주주의 성장과 과제. *관훈저널 통권104호, 관훈클럽*, 157.
- 김호기. (2007). 87년 체제, 민주주의, 대통령선거”, 『6월 민주항쟁 20년, 한국 민주주의 성과와 과제』. *관훈저널 통권104호, 관훈클럽*, 165.
- 노컷뉴스, 2005년 5월 13일 기사. (2025 оны 04 07). <https://www.nocutnews.co.kr/news/55243>
- 동북아 역사넷. (2025 оны 04 07). <http://contents.nahf.or.kr/item/level.do?levelId=>
- 로버트 달, 김. 외. (2015:66). *민주주의*. 경기도 파주;; 동명사.
- 로버트 달, 조. 역. (1999:585). *민주주의와 그 비판자들*. 서울: 문학과 지성사.
- 문병주. (1996:211). *한국 민주주의로의 이행과 공고화, 1979~1994: 국가, 정치사회, 시민사회의 관계 및 내부동학을 중심으로*. 건국대학교 대학원 박사학위 논문.
- 민주화운동기념사업회. (2025 оны 04 07). <https://archives.kdemo.or.kr/>
- 민주화운동기념사업회, 한. (2010:394). *한국민주화운동사*. 경기도 파주: 돌베개.
- 박봉민&오현진. (2018). *한국 민주주의의 질- 민주화 이후 30년*. 서울: 박영사.
- 박성원&10인. (2022:160). *대한민국 미래전망 연구*. 서울: 국회미래연구원.
- 박현채. (1990:213-214). 4.19 *민주혁명과 이의 계승, 계간 사상 1990년 봄호*. 사회과학원.
- 사무엘 헌팅턴. (2011:149). *제3의 물결*. 경기도: 고양:인간사랑.
- 서윤교. (2018). 휘트먼의 민주주의 원리와 윤리적 사회주의에 대한 연구. *미국학 논집 50권1호*, (xuud. 67). 한국아메리카학회.

- 서중석. (2007). 천주교정의구현전국사제단의 출범 배경과 활동. *사람* 제27호, 백선사학회, 223.
- 손석춘. (2024:70). *민주주의 특강*. 서울: 철수와 영희.
- 손호철. (2003). 민주화 운동, 민주화, 민주주의-개념과 한국적 특성을 중심으로. *한국과 국제정치* 제19권4호(통권43호), 3-4.
- 송경재. (2023:836). 5.18 광주민주화운동의 헌법적 평가와 관련자 예우. *한국과 국제사회* 7권4호. 한국정치사회연구소.
- 송원근. (2016). 외환위기 이후 재벌정책 변화와 경제민주화 전망. 『한국의 민주주의와 자본주의의 불화와 공존』, 민주화운동기념사업회 기획(хуудсд. 190-191). 경기도 파주: 돌베개.
- 송호근. (2021). 한국의 민주화 35년: 경로 단절의 원인을 진단하다. 『시민정치의 시대: 한국 민주화 35년, '대권'에서 '시민권'으로』(хууд. 61). 경기도 파주: 나남출판.
- 쇠렌센. (1994:64-67). *민주주의와 민주화*. 서울: 풀빛.
- 신명순. (2016). 한국의 민주화와 민주화운동-성공과 좌절. *민주화운동기념사업회*(хууд. 5). 서울: 한울.
- 신정현. (1993). 제 3세계의 민주화 과정. *한국과 국제정치* 제9권1호, 106-107.
- 아리스토텔레스. (2024:218). *아리스토텔레스 정치학*. 서울: 현대지성.
- 안병욱. (2010). 한국 민주화운동에 대한 평가와 인식의 전환을 위하여. *역사와 현실* 제77호, *한국역사연구회*, 30.
- 안병욱. (2013). 한국 민주주의의 성찰과 전망. *역사와 현실* 제87호, *한국역사연구회*, 261.
- 앤드류 헤이우드, 조. 역. (2010:138-139). *정치학*. 서울: 성균관대학교 출판부.
- 열린국회정보 및 언론 자료를 토대로 필자가 직접 작성하였다. (2025 оны 04 10).  
<https://open.assembly.go.kr>.
- 오세연. (2014:307). *1960~1970 년 대학 학생운동 연구*. 서울대학교 대학원 박사 학위논문.
- 오스본. (2011:28-29). *처음 만나는 민주주의 역사*. 서울: 시공사.
- 우리역사넷. (2025 оны 04 07). [https://contents.history.go.kr/mobile/ta/view.do?levelId=ta\\_](https://contents.history.go.kr/mobile/ta/view.do?levelId=ta_)
- 유용태& 2인. (2020:19). *학생들이 만든 한국 현대사: 서울대 학생운동 70년, 제1권*. 경기도 파주: 한울.
- 유해신(2023). (2025 оны 04 11). “6월 민주항쟁과 기독교시민운동”, 기독교윤리실천운동.  
<https://cemk.org/31181/>
- 윤기석. (2010). 민주주의 공고화와 정부형태의 개혁. 『다시 보는 한국 민주화운동: 기원, 과정,

- 그리도 제도』, 한국민주화운동기념사업회 4월 혁명 50주년 기념 총서(хууд. 309). 한국정치연구회.
- 윤선자. (2001). 5.18 광주민주화운동과 종교계의 역할: 천구교회를 중심으로. *한국근현대사연구 제19집*, 44.
- 이광일. (2007). 6월항쟁 더 많은 민주주의의 좌절. 『한국 민주주의운동의 의미, 평가, 전망』, 민주화운동기념사업회·민주화를위한전국교수협의회·학술단체협의회 공동주최 세미나 자료집, (хууд. 76).
- 이삼열. (2017:65). *촛불시민혁명과 민주화의 과제*. 경기도 파주: 한울.
- 이세영. (2021). 1990년대 학생운동의 위기와 혁신의 모색-연세대학교 사례를 중심으로. *학림 제49권, 연세사학연구회*, 130-131.
- 이승만 대통령기념재단. (2025 оны 04 07). <https://rheesyngmanfoundation.or.kr>
- 이영애. (1990). 민주주의 원리의 재고찰. *한국정치학회보* 24권 2호 (хууд. 280). 한국정치학회.
- 이영제. (2010). 6월 항쟁과 민주주의 이행”, 다시 보는 한국 민주화운동: 기원, 과정, 그리도 제도. *한국민주화운동기념사업회 4월 혁명 50주년 기념 총서*(хууд. 151). 한국정치연구회.
- 이영제. (2021). 한국 민주화운동의 특징과 기념, 계승의 과제. *한국과 국제사회 제5권 6호* (хууд. 249). 한국정치사회연구소.
- 이정진. (2010). 정당정치의 민주화와 정당 개혁. 『다시 보는 한국 민주화운동: 기원, 과정, 그리도 제도』, 한국민주화운동기념사업회 4월 혁명 50주년 기념 총서(хууд. 349). 한국정치연구회.
- 이정희. (1999). 재야 정치집단의 민주화 운동: 정치 이데올로기, 중심세력, 정치권과의 관계를 중심으로. *카톨릭사회과학연구 제11권* (хууд. 170). 한국카톨릭사회과학연구회.
- 이종철. (2021). 독재정권의 체제 이행 조건과 상이성. *국방연구 제64권 1호* (хууд. 52). 국방대학교 안보문제연구소.
- 이준한. (2015:5). “중산층의 선택”, 민주누리. *Democracy v.1*(2015.6) 민주화운동기념사업회.
- 이창근&황수경. (2024:8). *한국의 중산층은 누구인가?* 세종: 한국개발연구원.
- 임혁배. (1999:7-17). *민주주의의 기본 원리와 정치개혁과제*. 한국개발연구원 연구자료.
- 임혁백. (1997:130). *비교시각에서 본 한국 민주주의의 공고화: 기회와 제약*, 국가 전략 3.1(97.2). 세종연구소.
- 임현진. (2021:179). *대한민국의 길을 묻다*. 서울: 백산서당.

- 장훈. (2007). 한국 민주화 20년의 성과와 과제. *관훈저널 통권104호관훈클럽*, 173.
- 전종익. (2020:20). 4.19 혁명과 1960년 헌법의 헌정사적 의의- 정치제도의 변화를 중심으로  
법사학 연구 제62호, 한국법사학회.
- 정다혜. (2021:206). 2000년대 학생운동의 새로운 정체성 모색과 운동의 다각화-연세대학교  
학생운동을 중심으로. *학림 제48권*. 연세사학연구회.
- 정상호. (2007). 시민과 시민권 관점에서 본 한국의 1987년 6월 민주항쟁. 『한국 민주주의운동의  
의미, 평가, 전망』,  
민주회운동기념사업회·민주화를위한전국교수협의회·학술단체협의회 공동주최 세미나  
자료집, (xuud, 94).
- 정소흔. (1998). 한국학생운동의 과제와 방향. 21세기 민주화와 통일을 위한 한국학생운동의  
과제와 방향 종합세미나(xuud, 85). 한국민주시민교육학회.
- 정승안&박수호. (2014). 1980년대 한국 불교사회운동과 사회발전: 부산지역 불교 활동가 구술을  
중심으로. *한국학논집 제55집, 계명대학교 한국학연구원*, 284.
- 정원규. (2002). 민주주의의 기본 원리. *철학 제71집*, (xuud, 172). 한국철학회.
- 정주신. (2022). 한국 민주화운동 과정에서 대학생의 역할: 부마민주항쟁을 중심으로. *한국과 세계  
제4권 제6호, 한국국회학회*, 199.
- 정태일. (2012:198). 1980년대 한국의 민주화운동과 정치구조의 변화. *한국동북아논총 제63호*.  
한국동북아학회.
- 정해구. (2010:36). 한국 민주주의의 전개와 그 특징, 다시 보는 한국 민주화운동: 기원, 과정,  
그리고 제도. *한국민주화운동기념사업회4월 혁명50주년 기념 총서*. 한국정치연구회 편.
- 정호기. (2013). 천주교회의 5월운동과 사회참여: 1980년대 전남지역 활동을 중심으로. *신학전망  
제182호, 광주카톨릭대학교출판부*, 8.
- 정훈. (2007). 한국 민주화 20년의 성과와 과제. 『한국 민주주의운동의 의미, 평가, 전망』,  
민주회운동기념사업회·민주화를위한전국교수협의회·학술단체협의회 공동주최 세미나  
자료집, (xuud, 183).
- 조원빈. (2018:257). “수평적 책임성과 민주주의의 질”, 『한국 민주주의의 질. 민주화 이후 30년』,  
서울: 박영사.
- 조인영, 오. (2018:66). “민주화 이후 한국 민주주의의 질: 제도 변화 및 민주주의 지표 분석”, 『한국  
민주주의의 질. 민주화 이후 30년. 서울: 박영사.
- 조현연. (2017:110). 민주화추진협의회회의 구성과 ‘저항, 선명 야당’의 성장 『6월 민주항쟁: 전개와

의의』. 경기도 파주: 한울사.

좌승희. (2012:2). *한국의 경제민주화*. 한국경제연구원 전자자료.

중앙선거관리위원회 사이버선거역사관. (2025 04 08). <https://museum.nec.go.kr>.

청와대 대통령 기록관 자료, 국가기록포털 자료. (2025 04 09). <http://18president.pa.go.kr>.

최동환. (2016:42). *민주주의*. 서울: 지혜의 나무.

최용섭. (1994:101). *한국 민주화운동의 좌절 요인과 극복방안에 관한 연구*. 서울대학교 대학원 박사 학위논문.

최진욱. (2018:195). *한국 민주주의의 질: 민주화 이후 30년*. 서울: 박영사.

최현명. (2001:13). *1970년대 재야 민주화운동 연구*. 이화여자대학교 석사 학위논문.

클라우스 폰 바이메. (2000:12-14). *탈사회주의 체제전환*. 서울: 서강대학교 출판부.

하승수. (2007:262). *지역, 지방차지, 그리고 민주주의*. 서울: 후마니타스.

한국기독교사회문제연구원. (1983:61). *1970년대 민주화운동과 기독교*.  
한국기독교사회문제연구원.

한국민족문화대백과사전. (2025 04 07). <https://encykorea.aks.ac.kr/Article/E0025902>,

한상진. (1986). 한국 중산층의 정치의식. *현대노사 제36권, 한국노동문제연구원*, 19-21.

한스 포어랜드. (2023). *민주주의*. 서울: 북캠퍼스.

행정안전부. (2025 04 07). *국가기록원*. <https://theme.archives.go.kr/next/>

J.린프 & A.드태판, 김. 외. *민주화의 이론과 사례: 이상과 현실의 갈등*. 서울: 삼영사.